

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 09-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
4 ДҮГЭЭР САРЫН 09-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2026 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7 – 159
1. <i>“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	8 – 14
2. <i>Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2026.03.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	14 – 88
3. <i>Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	88 – 101
4. <i>Санхүүгийн хоршооны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Б.Заяабал нар 2025.12.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	101 – 133
5. <i>Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 17 гишүүн 2025.11.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	133 – 159

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
4 дүгээр сарын 09-ний өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 67 гишүүн хүрэлцэн ирж, 53.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 02 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Чөлөөтэй: С.Амарсайхан, Б.Бат-Эрдэнэ, Х.Болормаа, Б.Мөнхсоёл, Ц.Сандаг-Очир, Н.Учрал;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, Х.Ганхуяг, Б.Жавхлан, Ж.Чинбүрэн, М.Энхцэцэг;

Тасалсан: Ж.Батсуурь, Х.Баттулга, Ц.Туваан;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан–58 минут, Д.Амарбаясгалан–46 минут, Ч.Анар–29 минут, Х.Баасанжаргал–13 минут, М.Бадамсүрэн–23 минут, Д.Батбаяр–04 минут, Д.Батлут–01 минут, Б.Батцэцэг–12 минут, П.Батчимэг–19 минут, Э.Батшугар–12 минут, Ж.Бат-Эрдэнэ–05 минут, Ж.Баярмаа–48 минут, Ж.Баясгалан–04 минут, Э.Болормаа–20 минут, Ш.Бямбасүрэн–34 минут, Ж.Галбадрах–12 минут, А.Ганбаатар–1 цаг 09 минут, Г.Ганбаатар–18 минут, С.Ганбаатар–31 минут, Д.Ганбат–26 минут, П.Ганзориг–07 минут, Т.Доржханд–3 цаг 10 минут, Д.Жаргалсайхан–2 цаг 09 минут, Г.Лувсанжамц–13 минут, П.Мөнхтулга–5 цаг 05 минут, Ц.Мөнхтуяа–17 минут, З.Мэндсайхан–10 минут, Ч.Номин–20 минут, Э.Одбаяр–42 минут, С.Одонтуяа–05 минут, Б.Пунсалмаа–26 минут, О.Саранчулуун–35 минут, Р.Сэддорж–51 минут, Б.Түвшин–3 цаг 51 минут, А.Ундраа–12 минут, Ч.Ундрэм–24 минут, Г.Уянгахишиг–3 цаг 10 минут, Б.Чойжилсүрэн–11 минут, Ө.Шижир–13 минут, Б.Энхбаяр–11 минут, Ж.Энхбаяр–1 цаг 00 минут, С.Эрдэнэбат–3 цаг 28 минут, Р.Эрдэнэбүрэн–04 минут.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Р.Батболд нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Нэг. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, мөн яамны Гэрээ эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Т.Ганбаатар, Гаалийн ерөнхий газрын Татварын орлогын газрын дарга С.Баярмаа, Гаалийн ерөнхий газрын Барааны ангиллын хэлтсийн дарга Ч.Чимгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин үг хэлэв.

Нэг.Байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтын “4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн” гэснийг “4 дүгээр сарын 20-ны өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	57
Татгалзсан:	30
Бүгд:	87

65.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2026.03.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга А.Бямбажаргал, Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх Т.Энхтүвшин, Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболд, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор О.Машбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, референт А.Амармэнд, Б.Баясах нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Л.Соронзонболд, Д.Бум-Очир, Л.Мөнхбаатар, Ж.Золжаргал, Б.Жаргалан, С.Зулпхар, Г.Очирбат, Д.Үүрийнтуяа,

А.Ариунзаяа, Х.Тэмүүжин, Э.Болормаа нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга А.Бямбажаргал, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор О.Машбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Энхтүвшин, М.Ганхүлэг, Х.Баасанжаргал, М.Мандхай, Ч.Лодойсамбуу, Х.Булгантуяа, Л.Энхнасан, Х.Тэмүүжин нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /13:11/

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 10 минут үргэлжилж, 13 цаг 12 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 06 минутад эхлэв.

Гурав.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, референт А.Амармэнд, Б.Баясах нар байлцав.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, П.Наранбаяр, С.Эрдэнэболд, Б.Баярбаатар, Ц.Баатархүү нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр, Б.Баярбаатар нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /14:32/

Дөрөв.Санхүүгийн хоршооны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Б.Заяабал нар 2025.12.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Санхүүгийн зохицуулах хорооны Хадгаламж, зээлийн хоршооны газрын дарга Ц.Алтантуул, мөн хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын дарга

Б.Долгорсүрэн, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, Хадгаламж, зээлийн хоршооны газрын ахлах зөвлөх Д.Соёлмаа, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирал Б.Ариунболд, мөн корпорацийн Даатгалын хураамж, хяналт шалгалтын эрсдэлийн удирдлагын газрын захирал Б.Амарбилэг, Ерөнхий эдийн засагч Б.Мөнхжаргал, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын Үндэсний холбооны Тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга Ц.Оюунцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт М.Мандхай нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Г.Хосбаяр, Б.Уянга, П.Сайнзориг, М.Ганхүлэг, Г.Очирбат нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Б.Заяабал, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Санхүүгийн зохицуулах хорооны Хадгаламж, зээлийн хоршооны газрын дарга Ц.Алтантуул нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /15:41/

Тав.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 17 гишүүн 2025.11.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, референт А.Амармэнд, Б.Баясах нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, О.Номинчимэг, Ж.Золжаргал, С.Зулпхар, А.Ариунзаяа, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /16:40/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Ч.Ундрам нарын урилгаар Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Хот тохижилтын газрын ажилчдын төлөөлөл, Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч, ажилтнуудын төлөөлөл, Монгол Улсын Их Сургуулийн Улс төр судлалын тэнхимийн нэгдүгээр түвшний оюутнууд, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, П.Ганзориг нарын урилгаар ХҮН намын дэргэдэх ХҮН академийн төгсөгчид, Нийслэлийн ерөнхий боловсролын 84 дүгээр сургуулийн 7 дугаар ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы урилгаар Ховд аймгийн иргэдийн төлөөлөл, Нийслэлийн ерөнхий боловсролын 48 дугаар сургуулийн 11-ийн “б” ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн урилгаар Дархан-Уул аймгийн 21 дүгээр цэцэрлэгийн багш, ажилчид, Орхон аймгийн “Yes Mongolia” төрийн бус байгууллагын гишүүд, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын урилгаар Төв аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн 12-ын “б” ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнийн урилгаар Булган аймгийн Бүрэгхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 1986 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 45 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 112 гишүүн ирж, 88.9 хувийн ирцтэйгээр 16 цаг 41 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
10 цаг 02 минут

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны ирцийг танилцуулъя.

126 гишүүнээс 67 гишүүн хуралдаан хүрэлцэн ирж, чуулганы хуралдааны ирц 53.2 хувьд хүрсэн байна. Тэгээд хуралдаанаа нээе. /алх цохив/

Хуралдааны эхэнд төрсөн өдөр нь болж байгаа гишүүдийн мэндчилгээг хүргэе.

Өнөөдөр 4 сарын 08-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар төрсөн байна.

Б.Баярбаатар гишүүндээ төрсөн өдрийн мэндчилгээг нийт Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс хүргэе. /алга ташив/

Улсын Их Хурлын гишүүн Ринчендоржийн Батболд 4 сарын 09-нд төрсөн байна.

Р.Батболд гишүүндээ төрсөн өдрийн мэндчилгээг нийт гишүүдийнхээ өмнөөс хүргэе. /алга ташив/

Ингээд 2026 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэндээ танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт нь, “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

“Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээг батлах тухай” Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолыг Засгийн газар 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдөр яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг явуулна.

Хоёрдугаарт нь, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэхийг хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2026 оны 3 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн асуудал байгаа.

Гуравдугаарт, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Дөрөвдүгээрт, Санхүүгийн хоршооны тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслөөр хэлэлцэх эсэх явуулна.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Б.Заяабал нарын гишүүд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн.

Тавдугаарт, Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 17 гишүүн 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Ийм асуудлыг хэлэлцэнэ. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг. “Тогтоолд нэмэлт оруулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**
/Засгийн газар 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна.

П.Сайнзориг гишүүнийг индэрт урьж байна.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжин, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Тогтоол төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед хуралдаанд оролцсон гишүүд газрын тосны бүтээгдэхүүнд ногдуулах импортын барааны гаалийн албан татвар нь 2026 онд төвлөрөх орлогын хэмжээнд нөлөөлөх эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн тогтоолын төсөлд дагаж мөрдөх хугацааг энэ оны 4 дүгээр сарын 01-ний өдөр гэж тусгасан нь хууль буцааж үйлчлэх онцгой нөхцөл үүсэх эрсдэлтэй тул уг хугацааг өөрчлөх саналыг хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар тогтоолын хэрэгжих хугацааг 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр гэж өөрчлөх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

С.Бямбацогт: П.Сайнзориг гишүүнд баярлалаа.

Та бүхэндээ ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ажлын хэсэг.

Гонгорын Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Чулууны Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын

дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Гэрээ эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Сангидоржийн Баярмаа Гаалийн ерөнхий газрын Татварын орлогын газрын дарга, Чойдоржийн Чимгэрэл Гаалийн ерөнхий газрын барааны ангиллын хэлтсийн дарга. Ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Нэрсийг оруулъя.

Нэг л нэр ирсэн юм байна. Тийм ээ. Нэрээ өгсөн зарим гишүүд ирцдээ ороогүй байгаа юм байна шүү. Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгээс тодорхой асуулт асуумаар байдаг.

Яагаад гэвэл хангалтын асуудал дээр зөвхөн төмөр замаар нийлүүлэх тухай асуудал байгаа.

Тэгэхээр жишээ нь баруун бүс ч юм уу, зүүн бүс ч юм уу авто замаар шатахуунаа импортолдог бүсүүдийн хангалтын асуудалд хоцрогдох нөхцөл байдалд ороод байна л даа.

Манай баруун бүсийнхэн ихэнхдээ “Газпром нефть” компаниас шатахуунаа аваад, тэгээд Бийскт буулгаад Бийскээсээ наашаа Цагааннуурын боомтоор ихэвчлэн импортолж Ховд, Говь-Алтай хүртэл аймгуудыг, Увс мэдээж Баян-Өлгий рүү хилийнх учраас орно.

Тэгээд эд нарын шатахууны хангалтын асуудлыг шийдвэрлэдэг.

Энэ хэлэлцээрийн дагуу зөвхөн төмөр зам гээд заахаар авто замын боомтоор шатахуун импортолдог тэр аймгуудын хангамжийн асуудал заавал Улаанбаатараар тойрч очсон өндөр үнэтэй шатахууныг хэрэглэх нөхцөл байдалд ороод байна.

Тийм учраас анхны хэлэлцүүлэг нь явж байгаа. Яг үүгээр авто замаар гэж ороогүй бол Их Хурлын дарга тодорхой чиглэл өгөөд энэ дээр төмөр зам болон авто замаар гэж тодорхойлж өгөхгүй бол баруун бүсийн шатахууны хангамжийн асуудал хүнд байдалд орох нь байна шүү. Энэ дээр тодорхой мэдээлэл өгнө үү?

С.Бямбацогт: Г.Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Б.Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт, баруун бүсийн 5 аймаг баруун талаасаа нийлүүлэгддэг.

Улсын Их Хурлын тогтоол дээр заавал “боомт” гэж орох шаардлагагүй. Зөвхөн “төмөр зам” гэж заахгүй байгаа.

Засгийн газрын тогтоол гаргаад шийдвэрлээд явах боломжтой гэж бид үзэж байна.

Мөн баруун талаар “Газпром”-оос гадна “Роснефть” компани нийлүүлэлт хийгээд эхэлсэн. Нэлээн ажил болж байж, нэлээн яриа хэлэлцээ өнгөрсөн жилийн хугацаанд ярилцаж байгаад “Роснефть”-ийнхэн авто замаар тээвэрлэхийг зөвшөөрөөд баруун хилээр оруулдаг болж байгаа. Тийм.

С.Бямбацогт: Тодруулах уу? Тодруулахын өмнө гишүүд ээ, одоо санал хураалт явагдана. Энэ асуултын дараа. Өөр үг хэлэх гишүүн байхгүй. Чуулганы танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Санал хураалтдаа оролцох бэлтгэлээ хангана уу.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Энэ чинь соёрхон батална. Энэ чинь олон улсын хэлэлцээрт орж байгаа.

Тэгэхээр хэлэлцээртээ оруулах тухай асуудлаа бид хиймээр байна шүү дээ. Тэндээс хангамжийн асуудал Оросын тал танай Засгийн газар хэлэлцээрт байхгүй байна.

Тийм учраас төмөр замаараа л хангана гэж цаад тал нь ярина.

Тэгэхээр бид энд хэчнээн Засгийн газар шийдвэр гаргасан ч гэсэн хэлэлцээрээр байхгүй учраас авто замаар шатахууны хангамжийн асуудлыг шийдвэрлэхгүй гээд шийднэ шүү дээ.

Тийм учраас соёрхон баталж байгаа хэлэлцээрт нь хамгийн гол нь авто зам гэдгийг оруулах тэр чиглэлийг Их Хурлын дарга эндээс хоёрдугаар хэлэлцүүлэг дээр шийдвэрлэж өгөхийг хүсэж байна.

Чиглэл өгөөдхөөч.

С.Бямбацогт: Г.Дамдинням сайд хариулъя. Гонгорын Дамдинням сайд.

Г.Дамдинням: Б.Пүрэвдорж гишүүн ээ, нөгөө агаарын хөлгийн түлштэй холбоотой гэхээр Засгийн газар хоорондын хэлэлцээр биш. Энэ чинь манай дотоод асуудал шүү дээ.

Гаалийн албан татварын хувь хэмжээний эрхийг тогтоохыг Засгийн газарт даалгаж байгаа. Дотоод асуудал байхгүй юу. Тэр явж байгаа байхгүй юу.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Одоо Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

Зарчмын зөрүүтэй нэг л санал байгаа. Горимын санал байж болох билүү?
Г.Агар-Эрдэнэ дарга аа.

Д.Энхтүвшин гишүүн горимын саналаа хэлнэ үү, Та.

Д.Энхтүвшин: Асуудал нь өөрөө чухлыг ойлгож байгаа. Тэгэхдээ бид нарын Үндсэн хууль дээр хууль дээдлэх зарчим гэж байгаа.

Тэгэхээр хууль, оруулж ирсэн тогтоолын өөрчлөлт маань хэд хэдэн хууль зөрчиж байна л даа.

Нэгдүгээрт, хуулийн бүрдүүлбэр хангаж байгаа юун дээр Сангийн яамнаас Сангийн сайдын ирсэн бичиг дээр төсвийн зардал нэмэгдүүлэх, орлого бууруулах хэсгийг хянах ёстой байтал үүнийг хянасан, болсон гэхээр энэ бол төсвийн орлого бууруулж байгаа учраас Төсвийн тухай хуулиар жилийн дундуур хугацааг дараа жилээс мөрдүүлэх ёстой заалт байгаа юм.

Дээр нь цаашдаа ер нь татварыг Улсын Их Хурлын тогтоолоор олгоод байгаа энэ харилцаагаа өөрчлөхгүй бол бид чухал яаралтай гээд угаасаа хугацаа нь дууссан нь ойлгомжтой харилцаа. Тэгээд үүнийг дахиад тогтоолоор яваад байна.

Энэ нь өөрөө бид нарын Үндсэн хууль дээдлэх зарчим зөрчиж байгаа учраас ер нь энэ асуудлуудаа шийдэж явахгүй бол Улсын Их Хурал нь өөрөө хууль тогтоомж зөрчдөг.

Тэгээд тэрийг нь бүх институцууд дээрэлхэж загнадаг, дарамталдаг боллоо шүү дээ.

Тэгэхээр хэдүүлээ өөрсдөө хуулиа дагамаар байна. Тэгэхээр үүнийг хуульд нийцүүлж өөрчлөлт оруулахгүй бол хуульд нийцээгүй санал хураалт явах нь байна шүү. Эсрэг санал өгнө.

С.Бямбацогт: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүний хэлсэн саналыг эцсийн хэлэлцүүлэг дээрээ анхааръя.

Энэ тогтоол 1999 онд батлагдсан. Түүнээс хойш 20-иод жил явж байгаа. Тасралтгүй сунгаад явдаг тогтоол юм билээ.

Анх удаагаа орж ирж байгаа асуудал биш юм билээ гэдгийг гишүүддээ хэлье.

Ингээд зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтын бэлтгэлээ хангаагүй нэлээн олон гишүүн байна шүү. Санал хураалтдаа бэлтгэлээ хангахыг хүсье.

Э.Бат-Амгалан сайд сая байх шиг байсан. Танхимд 55 гишүүн байна. Бэлтгэлээ хангасан 40 гишүүн байна.

Тийм болохоор санал хураалтын бэлтгэлээ хангана уу. Би бас бэлтгэлээ хангаагүй байна шүү дээ.

Одоо бэлтгэлээ хангасан 55 гишүүн, бэлэн бус 31 гишүүн байна. Танхимд орж ирээгүй гишүүдийг урьж байна.

Ингээд бүртгэлийн санал хураалтыг явуулаадахъя. Бүртгэлийн санал хураалт. /алх цохив/

53 гишүүн, 61 хувьтай байна.

Өөр ирцдээ ороогүй. З.Мэндсайхан гишүүн бэлтгэлээ хангая, Б.Хэрлэн гишүүн, Ц.Мөнхтуяа гишүүн, Б.Найдалаа сайд.

Ингээд зарчмын зөрүүтэй саналыг Та бүхэнд уншиж танилцуулъя.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төсвийн байнгын хороо дэмжсэн.

1.Тогтоолын төслийн 2 дахь заалтын “4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн” гэснийг “4 дүгээр сарын 20-ны өдрөөс” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 87 гишүүн оролцсоноос 57 гишүүн дэмжиж, 65.5 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. /алх цохив/

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Дараагийн асуудалдаа оръё.

**Хоёр.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл
/Монгол Улсын Ерөнхийлөгч 2026.03.09-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/**

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2026 оны 3 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн төсөл байгаа. Хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Ажлын хэсгийг урьж байна. Хууль санаачилсан илтгэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Алтанхуягийн Үйлстөгөлдөр танилцуулна.

Индэрт урьж байна.

А.Үйлстөгөлдөр: Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгч Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгчийн хувьд төр, ард түмний итгэлцлийг бэхжүүлэх, эв нэгдлийг хангах Үндсэн хуулиар олгогдсон чиг үүрэгтэй байдаг.

Энэхүү чиг үүргээ хэрэгжүүлэх Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг санаачилсан билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно.

Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

Уг гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т Ерөнхийлөгч Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх, мөн зүйлийн 4-т Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг

огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргахаар зохицуулжээ.

Түүнчлэн Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ гэж 67 дугаар зүйлд Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно гэж тус тус заажээ.

Тэгвэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болох тухай 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтад Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т зааснаар гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн хэмээн заасан нь Үндсэн хуулийн 67 дугаар зүйлийн “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно.” гэсэн заалттай зөрчилдөж, энэ шийдвэрийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх эсэх тухай асуудлыг тавихаар зохицуулсан байна.

Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуулийг зөрчсөн нь Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар түүнийг эгүүлэн татах үндэслэл болох бөгөөд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт энэ тухай гаргасан Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн бол түүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ гэжээ.

Гэтэл Их Хурлын гишүүн Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаар гаргасан Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх, хэлэлцэн шийдвэрлэх эрхгүй байгаа бөгөөд 67 дугаар зүйлд зааснаар Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болж, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татахаар байна.

Мөн зүйлд уг гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна гэсэн заалтыг шүүхээс хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ хэмээн заасан.

Энэхүү Үндсэн хуулийн зарчим ёсоор иргэд төрийн эрх барих дээд байгууллагын үйл ажиллагаа, ард түмний элчийн хувьд Улсын Их Хурлын гишүүний ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд, цаашлаад сонгож байгуулсан төлөөлөгчийн байгууллагын гишүүнийг Үндсэн хууль, бусад хууль

зөрчсөн тохиолдолд бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болох буюу эгүүлэн татах үндэслэлийг тодорхой болгохыг шаардах болсон.

Үүнтэй холбоотой Монгол Улсын Их Хурлын тухай хуульд Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болох буюу эгүүлэн татах үндэслэлийг тодотгох шаардлага тулгамдаж байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын Үндсэн хуульт байгууллыг бататган бэхжүүлэх тухай 3.3.1 дүгээр зүйлийн 3.3.1.1-д Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон төрийн удирдлагын болон байгууламжийн хэлбэр, төрийн эрх мэдлийн хуваарилалт, ардчилал, эрх зүйт ёс, үндэсний эв нэгдлийг хангах зарчмыг тууштай хэрэгжүүлнэ гэж заасан нь уг баримт бичгийн 1.1.4-т заасан хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд суурилсан нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа мөн гэдэг заалтыг хангах чухал арга зам болно.

Иймээс Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуулийг зөрчсөн гэж Үндсэн хуулийн цэц дүгнэсэн болон гэмт хэрэг үйлдсүүнийг нь шүүх тогтоосон бол эгүүлэн татаж хууль зүйн болон ёс зүйн хариуцлага хүлээлгэх явдал парламентын ардчиллыг бэхжүүлэх, Үндэсний аюулгүй байдлыг хангахад тулгамдсан асуудал болсоор байна.

Энэхүү хуулийн төслийн зорилго нь өргөсөн тангаргаасаа няцсан, ард түмний элчийн хувьд төлөөлөх, хууль тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэхдээ Улсын Их Хурлын ээлжит чуулганы хуралдааны 30-аас дээш хувьд хүрэлцэн ирээгүй болон санал хураалтад биечлэн оролцоогүй, гишүүний ёс зүйн дүрмийг ноцтой болон удаа дараа зөрчсөн, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татаж хууль зүйн хариуцлагыг тодорхой, ил тод, үр нөлөөтэй болгох замаар Үндсэн хуульт байгууллыг бататган бэхжүүлэх, Үндэсний аюулгүй байдлыг хангахад оршино.

Хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурлын гишүүн ардчилсан ёсны зарчмын дагуу ард түмнээс олгосон мандатыг хүндэтгэхийн сацуу Үндсэн хуулийг зөрчсөн, гэмт хэрэг үйлдсэн, ёс зүйн ноцтой зөрчил гаргасан тохиолдолд эгүүлэн татах тухай Үндсэн хуулийн зохицуулалтыг амьдралд хэрэгжүүлэх, парламентын засаглалыг бэхжүүлэх, улс төрийн намыг хариуцлагатай болгох, төрийн үйл ажиллагааны тэгш байдал, хууль дээдлэх зарчмыг хангахад онцгой ач холбогдолтой юм.

Санаачилсан хуулийн төслийг дагалдах хэлбэрээр Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, мөн хуулийн төсөл батлагдсантай холбоотойгоор “Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулсан.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан журмын дагуу Засгийн газарт хүргүүлж санал авсан бөгөөд Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд дурдагдсан асуудлыг хүлээн авч төсөлд тусгасан.

Уг хуулийн төсөлд Монгол Улсын Ерөнхийлөгчид ямар нэгэн бүрэн эрх олгосон зүйл байхгүй болно.

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарлаа хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: А.Үйлстөгөлдөр даргад баярлалаа.

Төслүүдийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа танилцуулна.

Индэрт урьж байна.

А.Ариунзаяа: Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2026 оны 3 дугаар сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцүүлээ.

Хууль санаачлагч өргөсөн тангаргаасаа няцсан, ард түмний элчийн хувьд төлөөлөх хууль тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэхдээ Улсын Их Хурлын ээлжит чуулганы хуралдааны 30-аас дээш хувьд хүрэлцэн ирээгүй болон санал хураалтад биечлэн оролцоогүй, гишүүний ёс зүйн дүрмийг ноцтой болон удаа дараа зөрчсөн Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татаж хууль зүйн хариуцлагын тодорхой, ил тод, үр нөлөөтэй болгох замаар Үндсэн хуульт байгууллын бататган бэхжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Мөн хууль санаачлагч хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурлын гишүүн ардчилсан ёсны зарчмын дагуу ард түмнээс олгосон мандатыг хүндэтгэхийн сацуу Үндсэн хууль зөрчсөн, гэмт хэрэг үйлдсэн, ёс зүйн ноцтой зөрчил гаргасан тохиолдолд эгүүлэн татах тухай Үндсэн хуулийн зохицуулалтыг амьдралд хэрэгжүүлэх, парламентын засаглалыг бэхжүүлэх, улс төрийн намыг хариуцлагатай болгох, төрийн үйл ажиллагааны тэгш байдал, хууль дээдлэх зарчмыг хангахад эерэг нөлөө үзүүлнэ гэж үзсэн байна.

Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын d.parliament.mn цахим системд байршуулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед–

- Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа ёс зүйн зөрчлийг зөвхөн жагсаалтаар сонгогдсон гишүүдэд хамаатуулсан шалтгаан, ёс зүйн ноцтой зөрчил гэдгийг хэрхэн ойлгох,
- Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа ёс зүйн зөрчлийг хэрэгжүүлэх практик жишээ,
- Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар ёс зүйн зөрчил, ёс зүйн ноцтой зөрчлийг хэрхэн ойлгох,
- Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн Хуулийн төсөл Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан хууль санаачлах хүрээ хязгаартай нийцэж байгаа эсэх,
- Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн сахилгын зөрчил, ёс зүйн ноцтой зөрчлийн ялгаа,
- Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар Хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө санаачлаад явах боломжтой байсан эсэх талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир парламентыг тогтворгүй болгох эрсдэлтэй талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татсан тохиолдолд үйлчлэх зохицуулалт,
- Улсын Их Хурлын гишүүн Э.Одбаяр ёс зүйн зөрчилд юуг хамааруулж тооцох, Үндсэн хуулийн цэцэд ёс зүйн асуудал хамаардаг эсэх,
- Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ хуулийн төсөл хэт субъектив байдлаар хэрэгжих эрсдэлийн талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал хуулийн төсөл танилцуулсан албан хаагчид улс төрийн намын албан тушаал эрхэлдэг эсэх,
- Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг тангаргаасаа няцсан асуудлыг Үндсэн хуулийн цэц тогтоохоор тусгасан шалтгаан, ёс зүйг үндэслэн гишүүнийг эгүүлэн татах нь хэр үндэслэлтэй талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед–

- ▶ Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа жагсаалтаар сонгогдсон гишүүдийг ялгаварлаж авч үзсэн нь энэ хуулийн төсөлд цаг үеэ олоогүй, Улсын Их Хурлын тухай хуулийн 44.1.11 дэх заалт, 41.2 дахь хэсгээр хориглосон асуудлыг хуулийн төсөл болгож жилд 40-өөс дээш цаг тасалсан бол хариуцлага тооцохоор зохицуулсан асуудлыг тусгасан Ёс зүйн дэд хороо гишүүдэд ялгамжтай хандаж ажилладаг талаар;
- ▶ Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа хуулийн төсөлд хиймэл оюун ухаанаар шинжилгээ хийлгэхэд намын удирдлага өөрт нь улс төрийн хувьд санал нийлээгүй гишүүнийг субъектив үндэслэлээр эгүүлэн татах санал гаргаж болзошгүй зэрэг эрсдэлүүдийг дурдсан талаар;
- ▶ Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар ёс зүйг хуульчилж болно.

Гэхдээ бүрэн хуульчлах боломжгүй. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд төрийн улс төрийн албан хаагчдын ёс зүйг ёс зүйн дүрмээр зохицуулахаар заасныг боловсронгуй болгох, Улсын Их Хурлын гишүүнд чуулганы хуралдаан дээр хэлсэн үгийнхээ төлөө хариуцлага хүлээхгүй байх зарчимтай уялдуулах шаардлагатай.

Гишүүдийг тойргоос, жагсаалтаар сонгогдсон гэж ялгаатай авч үзэж байгааг эргэж харах, парламентын дархлааг алдагдуулах нөхцөл байдал үүсгэхгүй байх, парламентын ардчиллын 5 үндсэн шалгуурыг алдагдуулахгүй байх талаас нь анхаарах шаардлагатай талаар;

- ▶ Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу хуулийн төсөлд заасан ёс зүйг барьж, парламентын ардчилалд халдах эрсдэлтэй.

Гишүүд хэн нэгнийг гүтгэсэн бол хуулийн дагуу шүүхийн журмаар шийдэх боломжтой.

Хуулийн төсөл нь сөрөг үр дагавартай байгаа талаар;

- ▶ Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ Ерөнхийлөгч гүйцэтгэх засаглал шиг мөрийн хөтөлбөртэй байх нь зохимжгүй.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд аудит оруулж, гурван институтийн хурлыг зохион байгуулдаг болгох, Ерөнхийлөгчийг парламентаас сонгодог болох хуулийн өөрчлөлт хийх, Ерөнхийлөгчийн Тамгын газрын албан хаагчдыг нам бус болгох, Үндсэн хуулийн цэц болон бусад байгууллагууд парламент руу халдсан асуудлыг авч үзэх ёстой зэрэг асуудлаар;

- ▶ Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал хуулийн төслийг өргөн барих, хэлэлцэж байгаа процесс нь Үндсэн хуулийн зөрчил үүсгэж, бүрэн эрхээс хальсан хууль өргөн барьсан нь институц хоорондын хяналт тэнцлийг

алдагдуулж байгаа талаар, шинэ улс төрийн намууд бэхжих, парламентын ардчиллыг энэ хуулиар үгүй хийх эрсдэлтэй.

Монгол Улсын Ерөнхийлөгчид олгогдсон Улсын Их Хурлыг тараах эрх мэдэл нь зөвхөн Ерөнхийлөгчийн засаглалтай болон хаант засаглалтай улсад байдаг эрх мэдэл бөгөөд хуульд хориг тавих, шүүгч нарыг томилох зэрэг олон эрх мэдэлтэйн улмаас манай улсын парламентын тогтолцоо байнгын сорилттой тулгарч байгаа талаар, ард түмнээс сонгогдсон 126 гишүүний асуудлыг ард түмнээс сонгогдоогүй Үндсэн хуулийн цэцийн 9 гишүүн шийдэж, шийдвэрийг Улсын Их Хурал хэлэлцэхгүй гэж тайлбарлах нь зохисгүй талаар;

- ▶ Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал Үндсэн хуульд Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах хоёр тохиолдлыг тодорхой заасан ба эгүүлэн татах үндэслэлтэй эсэх талаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргадаг.

Харин Улсын Их Хуралд эгүүлэн татах шийдвэр гаргахгүй байх тохиолдолд процессыг нь тодорхой болгох шаардлага байгаа боловч өргөн барьсан хуулийн төсөл энэ процесстой холбоогүй, субъектив байдлаар Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах эрсдэлтэй талаар;

- ▶ Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нийгмийн хүлээлт болон Улсын Их Хурлын үйл ажиллагаанд дүгнэлт хийж, хуулийн төслийг хэлэлцэх ёстой талаар үг хэлсэн болно.

— Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 66.7 хувь,

— Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 66.7 хувь,

— Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 66.7 хувь,

— “Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 66.7 хувь нь—

-үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, “Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Аюушийн Ариунзаяа гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Ч.Ундрам нарын урилгаар Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Хот тохижилтын газрын ажилчид, Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч, ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ ажлын амжилт хүсэж, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс хүсэн ерөөе. /алга ташив/

Одоо ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Алтанхуягийн Үйлстөгөлдөр Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Алтангэрэлийн Бямбажаргал Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, хууль зүйн ухааны доктор, Отгонбаярын Машбат Хууль зүйн ухааны доктор, дэд профессор, Төмөртоогоогийн Энхтүвшин Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх, Жаргалсайханы Мөнхболд Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга, хууль зүйн ухааны доктор. Ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон намын бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. /алх цохив/

Нэлээд олон гишүүд асуулт асуухаар нэрс ирсэн байна. Ирцийн дарааллаар асуулт асуух гишүүдийн нэрс эрэмбэлэгдэж байгаа. Хамгийн эхэнд ирсэн Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр би яагаад хамгийн түрүүн асуугаад байна гэхээр би 8 цагт ажилдаа ирээд 8.50-д ирцдээ ордог.

Тэгэхээр энэ бол хариуцлага юм. 2016 оноос хойш 10 жил Их Хурлын гишүүн хийхдээ би нэг ч удаа чуулган тасалж үзээгүй. 2-хон удаа 2016 онд хоцорсон. Аавдаа загнуулсан. Түүнээс хойш хоцроогүй.

Тэгэхээр ер нь хариуцлагатай байх тухай асуудлыг энэ хуулиар ярьж байгаа юм. Ерөнхийлөгч 20-иод хоногийн өмнө Ховд аймагт иргэдтэй уулзалт хийгээд, тэр уулзалт дээрээ энэ хуулийнхаа агуулгыг яриад, тэгээд ард иргэдийг дэмжиж байна уу гээд, дэмжиж байгаа нь гараа өргө гэсэн. Тэр зааланд байгаа хүмүүс эрийтэл гараа өргөж байна лээ. Тэгээд босоод хараарай гээд эргээд харахад үнэхээр бүгд эрийтэл гараа өргөсөн. Эсэргүүцэж байгаа хүн байна уу гээд. Нэг ч хүн байхгүй.

Тэгэхээр Их Хурлын гишүүн хүн бол тэр ард иргэдээсээ сонгодог.

Тийм учраас тийм олон иргэдийн хүлээлттэй байгаа энэ хуулийг дэмжих ёстой гэж би бодсон. Яагаад гэвэл энэ бол дараа дараагийн иргэд дээрээ очиж сонгогдоход чухал гэж би үзэж байгаа.

Тэгэхээр ер нь Үндсэн хуульд Их Хурлын гишүүнийг эргүүлэн татах тухай асуудал байдаг. Энэ бол өнөөдөртөө амилахгүй явж байгаа.

Гэхдээ энэ хуулиар зөвхөн “гишүүнийг эгүүлэн татах тухай” асуудал ярьж байгаа.

Тийм учраас хэлэлцүүлгийн явцад яг тэр Үндсэн хуульд байгаа Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Их Хурлын дарга болон гишүүн гэж байгаа. Бүгдийг нь оруулаад хэлэлцүүлээд явах нь зүйтэй гэж би үзэж байгаа.

Энэ хууль батлагдах юм гишүүд илүү хариуцлагатай болно л гэж би бодож байна. Ингэсний үр дүнд парламентын нэр хүнд өснө. Иргэдийн итгэл нэмэгдсэнээр парламентын дархлаа илүү сайжирна л гэж би үзээд байгаа юм.

Тэгээд зарим хүмүүс энэ хуулийг эсэргүүцээд байгаа юм л даа.

Тэгэхээр би цаашдаа ерөөсөө хариуцлагагүй байна, аль эсвэл хулгай хийнэ гэж бодоод байгаа юм уу, яагаад байгаа юм. Би ерөөсөө ойлгохгүй байна. Хууль хойшоо буцаж үйлчлэхгүй. Өөрөөр хэлбэл урд талын өш хонзонгоор хэн нэгний асуудлыг чирч оруулж ирж хэлэлцэхгүй гэсэн үг байхгүй юу.

Үүнийг яг энэ хууль хэлэлцэх явцад протоколд бүрэн тусгаж, аль эсвэл заалт болгож оруулах хэрэгтэй.

Тэгээд ч парламентаар урьдын асуудлыг өш хонзонгийн маягаар оруулж ирэх юм бол энэ парламентаар давахгүй.

Тэгээд ч ер нь манай парламентын гишүүд гурван давхар дархлаа бүхий хамгаалалтад байдаг хүмүүс шүү гэдгийг хэлье.

Ер нь энэ хуулийг мэдээж тодорхойгүй асуудлаар энэ парламентын гишүүдийг татаж явах ийм зүйлүүд бас байгаа. Тэрийгээ бид яг энэ хэлэлцэх эсэхийг нь дэмжээд яг энэ парламентынхаа дархлааг илүү сайн болгох тэр зүйлүүдийг нь оруулаад ярилцаад явж болно л гэж би үзэж байгаа юм.

Бусдаар бол юу байдаг юм энэ хуулийг унагаах юм бол тийм ээ, энэ парламент цаашдаа ерөөсөө л ингээд нэг тийм хариуцлагагүй, иргэдийнхээ итгэлийг хүлээж чадахгүй, нэг тийм дураараа байна гэсэн ийм л агуулгыг бий болгох гээд байна шүү дээ.

Тийм учраас Та бүхнийг энэ хэлэлцэх эсэхийг нь дэмжээд тэгээд хэлэлцүүлгийн явцад тодорхой асуудлуудтайгаа энэ парламентын дархлааг хамгаалах, илүү хариуцлагыг нэмэгдүүлэх энэ бүх зүйлүүдийг бүгдийг нь хийгээд явъя гэсэн ийм саналтай байна.

С.Бямбацогт: Асуулт асуусангүй. Саналаа хэллээ.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Улсын Их Хурлын үйл ажиллагааг сайжруулах, хариуцлагатай болгох энэ чиглэлээр дэмжиж байгаа. Үүнийг сайжруулах орон зай бидэнд маш их байгаа юм.

Гэхдээ энэ өргөн барьсан хуулийн төслийн 9.1.6 дээр Улсын Их Хурлын гишүүдийг хоёр ангилалд жагсаалтын гишүүдийг нь ард түмний биш намын элч төлөөлөгч гэсэн агуулгаар зүйл, заалт орж ирсэн байна л даа.

Тэгэхээр Үндсэн хуулийг уншаад үзэхээр 3 дугаар зүйл дээр “засгийн эрх ард түмний мэдэлд байна.”, 21.2 дээр Улсын Их Хурлын гишүүдийг иргэд чөлөөтэй шууд сонгох талаар, 23.1 дээр Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч байна гэх мэтчилгээр гээд энэ зүйл, заалтуудын агуулгаас харахаар сонгогч сонгож байгаа болохоос биш нам сонгоогүй.

Хэрвээ намын жагсаалт хаалттай жагсаалт байгаад, өөрөөр хэлбэл ил зарладаггүй, тэгээд саналаа нам нь аваад, тэр санал дээрээ хуваарилалтаа тааруулаад жагсаалтаа өөрөө хэнийгээ тавихаа мэддэг ийм систем байсан бол болж байна.

Гэтэл энэ агуулгаар харахаар хэрвээ саяын өөрчлөлтийг оруулна гэвэл энэ Үндсэн хууль дээр нэлээн олон өөрчлөлтүүд оруулж байж хийхээс өөр аргагүй байдал харагдаж байна.

Тэгээд ер нь эргээд бодоход 2022 оны 8 сарын 25-нд Үндсэн хуулийн өөрчлөлт оруулсан. Тэгээд энэ өөрчлөлтөөр ер нь бодоход Улсын Их Хурлын ард түмний илж байх орон зайг хумьсан өөрчлөлт байсан юм байна гэж харж байна.

Тэр давхар дээлтэй холбоотойгоор. Одоо бүгдээрээ давхар дээлтэй болсон. Өмнө нь дөрөвний нэг нь л болдог байсан бол бүгдээрээ давхар дээлтэй болсон. Одоо кабинетын зарчмаар гээд ард түмний төлөөлөгч байх эрх нь 20 гаруй гишүүн хязгаарлагдаж байна.

Дээр нь одоогийн байдлаар ил жагсаалтын гишүүдээ зарлаад сонгуульд орж байгаа ч гэсэн яваандаа үүнийг хаалттай болгоод, нам нь мэддэг болох ийм орон зай байсан юм байна гэж одоо харагдаж байна.

Тэгэхээр 48 дээр 20 хэдэн гишүүн гэхээр бараг 70 гишүүн нь ард түмний элч биш, намын юм уу, Засгийн газрын элч төлөөлөгч шиг энэ парламентад суудаг болох нь. Өөрөөр хэлбэл 76 гишүүн маань 126 биш агуулгаараа 56 болж багассан иймэрхүү дүр зураг харагдаж байна.

Тэгэхээр энэ өөрчлөлтийн хувьд бас энэ өөрчлөлтийг хийсэн, тухайн үед Монгол Ардын намын дарга байсан, Ерөнхий сайд байсан Л.Оюун-Эрдэнэ тэргүүтэй улс төрийн намын манлайлал үзүүлж гэж ярьж байсан. Хийсэн байгаа.

Тэгэхээр энэ өөрчлөлт бидний Үндсэн хуулийн суурь зарчим, 2024 онд ч гэсэн бид ийм зарчимтай байгаагүй. Энэ эрх мэдлийн чинь уг сурвалж ард түмэн гэдэг ийм агуулгаар бид Үндсэн хуулиа ярьж байсан.

Гэтэл 2026 онд энэ зарчмаасаа 2022 онд хийсэн өөрчлөлтийн цаад агуулга нь Улсын Их Хурлын эрх мэдлийг ард түмнээс холдуулах гэсэн ийм агуулгатай харагдаж байна.

Тэгэхээр одоо жишээлбэл Л.Оюун-Эрдэнэ гишүүний хувьд ч гэсэн тухайн үед өөрөө эрх мэдэлтэй байхдаа шал өөр юм ярьдаг байсан.

- Улсын Их Хурал Засгийн газрын хуулийн нэгж шиг байсан.
- Бүх хуулийг яаралтай, шуурхай гэж оруулж ирдэг байсан.

- Эсрэг дуугарсан зарчмыг өөрийнх нь дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийнхөө эсрэг яваад байгааг нь сайн санаж хэлэхэд түүний эсрэг дайрдаг, давшдаг, өөрийнхөө охин компаниараа дамжуулж хэвлэл мэдээллээр дайрдаг иймэрхүү үйлдлүүд хийдэг байсан.

Одоо ингээд дүр нь байр нь солигдоод ирэхээрээ энэ асуудлуудыг цаана нь байсан уг зүйлүүдийг нь гаргаж ирж байна.

Тэгэхээр 9.1.6 дээр оруулж ирж байгаа Улсын Их Хурлын гишүүнийг “намын элч болгох” гэж байгаа энэ заалттай эвлэрч чадахгүй.

Тэгээд ийм заалт хэрвээ орвол жагсаалтаар дэвшсэн гишүүний хувьд би бол энд байх шаардлагагүй гэж бодож байгаа.

Асуулт байхгүй. Үг хэллээ.

С.Бямбацогт: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн үг хэллээ.

Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя.

О.Номинчимэг: Ер нь хэрэгцээ шаардлага байх ёстой, байгаад байна гэдэг дээр бүгд санал нэгдэж байгаа.

Улсын Их Хурал, Улсын Их Хурлын гишүүд хариуцлагатай байх ёстой. Ард түмнийг төлөөлдөг энэ үүргээ чин шударгаар хэрэгжүүлдэг байх ёстой. Авлига, албан тушаал, энэ асуудлаас хол байх ёстой. Бүгд мэдэж байгаа.

Тэгээд одоо манай Улсын Их Хурал дотор байдаг энэ Ёс зүйн дэд хороо гэдэг механизм өөрөө ажиллахгүй байгаа учраас, дээр нь энэ хариуцлага тооцдог механизм сул байсан учраас үеийн үед энэ асуудал яригдаад байгаа.

Тэгээд миний хувьд урьд нь байр сууриа илэрхийлсэн. Би энэ хуулийн заримтай нь санал нийлээд, заримтай нь үнэхээр санал нийлэхгүй байгаа юм.

Ялангуяа Улсын Их Хурлын гишүүн болоод ард түмнээс мандат аваад ирсэн бол чуулган, хуралдаа суудаг байх, саналаа өгдөг байх асуудал. Энэ бол хамгийн анхан шатын үүрэг. Олон улсын жишиг нь ч тийм.

Халтмаагийн Баттулга гэдэг хүн хойд бүсээс сонгогдоод, би чуулганд хэдэн удаа харснаа үнэхээр санахгүй байна. Манай Байнгын хороонд нэг ч ирдэггүй.

Тэгтэл Австралид хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2 сараас дээш чуулган, хуралдаа ирэхгүй хөөдөг. Суудал нь хүчингүй болдог.

Латвид хуралдааныхаа талаас нь илүү суухгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр суухгүй бол хөөдөг. Суудлыг нь хүчингүй болгодог. Ийм сахилга бат наанаасаа хэрэгтэй байна. Тэгэхгүй бол хэдэн, яах вэ, залуу гишүүд нь энд кнопчин болоод л, та нар түүгээр учрыг нь олчихно биз гээд хэдэн ах нар өөрсдөө орчхоод бүгдээрээ л яваад өөрсдийнхөө хувийн ажлыг хөөцөлдөөд явдаг шүү дээ. Үнэн. Энэ дээр сахилга бат байх ёстой. Дэмжиж байгаа.

Гэхдээ энэ хууль дээр бас асуудал байна.

Нэгдүгээр асуудал. Та бүхэн энэ хуулийг парламентын дархлааг бэхжүүлэх ач холбогдолтой. Тэгээд сахилга бат муу байгаа учраас нэр хүнд унаж байна гэдэг асуудлыг нь зөв тодорхойлсон байна.

Гэхдээ шийдэл чинь залхуу байна. Яагаад залхуу, хамгийн амархан аргыг сонгов гэхээр Та бүхэн ерөөсөө хүнтэй зууралдаад байна. Яагаад энэ асуудал үүсээд байгаа, гажуудаад байгаа, парламентын нэр хүнд унаад байгаагийн суурь асуудал руу ерөөсөө чиглэсэн юм алга.

Тэгээд сонгогдож орж ирсэн хүнтэй нь зууралдаад, тийм ёс зүйгүй, хариуцлагагүй, ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргадаг хүмүүсийг нэр дэвшүүлж сонгодог систем рүү ерөөсөө орохгүй байна.

Тийм л юм бол энэ чинь хамгийн гол асуудал улс төрийн намд асуудал байгаа шүү дээ.

— Улс төрийн намд нь ямар хариуцлага үүрүүлэх юм.

— Улс төрийн намын дотоод ардчилал нь яах юм.

— Улс төрийн нам ийм юм хариуцлагагүй, ёс зүйгүй, болохгүй бүтэхгүй байгаа хүнээ нэр дэвшүүлээд байх юм бол үүнийг яах юм.

Тэгээд юу улс төрийн намд нь өгч байгаа хариуцлага нь ерөөсөө харагдахгүй. Наана нь гарч ирж байгаа хүнтэй нь зууралдсан хууль байна гэж хараад байгаа юм.

Тэгээд улс төрийн намд нь хэрвээ хариуцлага хүлээхээр бол бас гаргалгаанууд байгаа шүү дээ.

Ёс зүйн зөрчил хэд хэдэн удаа гаргасан, сахилгын шийтгэл авч байсан хүмүүсээ тэгвэл улс төрийн нам нэр дэвшүүлдэггүй байх хэрэгтэй шүү дээ.

Тийм юм байхгүй шүү дээ. Тэгээд л нэг өнгөрсөн болоод л, янз бүрийн асуудал холбогдож байсан хүмүүсээ дэвшүүлээд л гараад ирдэг шүү дээ.

Ингээд л парламентын чинь нэр хүнд унаад байна.

Хоёрдугаар асуудал. “Тангаргаасаа няцсан” гэдэг асуудлыг Та нар тангаргаасаа няцсан тэгээд татна гэдэг маш ерөнхий юм хэлээд байгаа юм. Тодорхой бус. Би үүнийг Байнгын хороон дээр асуусан. Тодорхой бус юмнуудыг чинь араар үүнийг буруугаар зэвсэг болгон ашиглах ийм орон зай нээх гээд байна. Энэ дээрээ Та бүхэн маань юу бодов гэсэн.

Тэгээд би дахиад асууя. А.Бямбажаргал хуульчаа гэх үү, А.Бямбажаргал.

Тэгээд би санаачлагч нь биш ээ. Ерөнхийлөгчид уламжилъя гээд байхгүй. Өөрөө энэ хуулийг бичсэн юм бол эзэн болоод хариулчхаарай гэж нэгдүгээрт хэлмээр байна.

“Тангаргаасаа няцсан” гэдгийг юу гэж ойлгох юм бэ?

Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гарсан гээд байгаа. Тангаргаасаа няцсан гэдгийн агуулгыг Та бүхэн юу гэж харж оруулж ирсэн бэ гэдгийг тодорхой хэлээд өгөөрэй.

Ингээд хариулахдаа би бас нэг юм анхаараасай гэж бодож байна. Дэгийн хуулиар Та энэ чуулганд худал мэдээлэл өгч болохгүй шүү. Хариуцлага хүлээдэг юм шүү. Зөв, үнэн мэдээлэл өгөөрэй гэдгийг... /минут дуусав/

С.Бямбацогт: Алтангэрэлийн Бямбажаргал. Ажлын хэсгийн гишүүн хариулъя. 4 дүгээр микрофон. Индрийн.

А.Бямбажаргал: Улсын Их Хурлын эрхэм гишүүдэд энэ өглөөний мэндийг хүргэе.

О.Номинчимэг гишүүний асуултад хариулъя.

Та ганц тодорхой асуулт асуулаа. Би тодорхой хариулахыг хичээе.

Юун түрүүн 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, энэ танхимд 11 сарын 14-ний өдөр баталж байсан. Би үүний гэрч болж явж байсан.

Тэгээд энэ нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд олон зүйлүүд орсны нэг нь 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт нэмэлт орсон байгаа юм. Нэмэлт орсон байгаа юм.

Тэр нь ямар нэмэлт вэ гэхээр “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж, Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно.” гэдэг ийм заалт.

Өөрөөр хэлбэл 1992 онд Монгол Улсын Үндсэн хууль батлагдахдаа гишүүнийг эгүүлэн татах үндэслэлд энэ агуулга байхгүй байсан.

Гэхдээ байхгүй байсан гэж шууд хэлж болохгүй. Яагаад гэвэл гишүүн Үндсэн хууль зөрчсөн эсэх, мөн түүнийг эгүүлэн татах эсэх үндэслэл байгаа эсэх асуудлаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 1992 оноос өнөөг хүртэл энэ асуудлыг шийдвэрлэх эрх нь Үндсэн хуулийн хяналтын объект буюу хууль зүйн хэллэгээр тэгж нэрлэдэг.

Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт байж ирсэн юм. Байж ирсэн юм.

Үүгээрээ би юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр ер нь “эгүүлэн татах” гэдэг энэ асуудлыг чинь гипотезыг (hypothesis) нь энэ 29.3 дээр нэмж өгсөн юм. Нэмж

өгсөн юм. Ямар нөхцөлөөр вэ. Хууль зүйн хэллэгээр бол гипотез гэдэг маань нөхцөл заасан хэсэг.

Ингэж нөхцөл заахдаа тангараасаа няцсан гэдэг ийм нөхцөлийг заасан. Энэ бол нэлээн, таны хэлж байгаа магадгүй үнэн байх. Их ерөнхий том нөхцөл. Том нөхцөл.

Хуулийн төсөлд энэ агуулгыг яаж тодруулсан юм бэ гэвэл Улсын Их Хурлын гишүүний өргөсөн тангараг, Та бүхний гишүүн болоод бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргийн энэ хэсэгт уг хуулийн 2 дугаар зүйлд байгаа “ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж” гэдэг ийм зүйлийг нэмж байгаа юм. Хуулийн төслийг. Нэмж байгаа юм.

Одоо харин ёс зүйн хэм хэмжээ гэдэг дотор нь юу орох юм бэ гэдэг асуулт дахиад мэдээж хэрэг үүнээс үүдэж гарна.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд “хууль тогтоох хүрээ хязгаарыг тогтооно” гэдэг ийм агуулгатай бас 26 дугаар зүйлийн 3 дахь зүйлд нэмэлт, өөрчлөлт орсон.

Монгол Улсын Ерөнхийлөгчид Үндсэн хуулиар хууль санаачлах эрх нь нээлттэй. Гэхдээ энд нэг зүйлийг зарим талаар бид бүхэн дутуу хараад байгаа юм шиг байгаа юм. Хуульчид маань ч гэсэн энэ дээр анхаараасай гэж.

Өөрөөр хэлбэл ярьж байсан зүйл маань томъёолж баталсан хууль хоёрынхоо... /минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулъя. 4 дүгээр микрофон.

А.Бямбажаргал: Баярлалаа. Юуг вэ гэхээр хууль санаачлах эрхийн хүрээ хязгаарыг хуулиар тогтоож байгаа хууль маань Улсын Их Хурлын тухай хууль.

Улсын Их Хурлын тухай хууль. Та бүхэн санаж байгаа байх. 2020 онд батлаад тухайн үед Монгол Улсын Ерөнхийлөгч хэсэгчилсэн хориг тавьж уг хоригийн дагуу хоригийг авч уг хуулийг засахдаа Монгол Улсын Ерөнхийлөгч хууль тогтоох хүрээ хязгаар нь Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 4-ийг баримтална гэж заасан.

4 маань юуг заасан юм бэ гэхээр тодорхой бүрэн эрхийг нэмж олгож болохгүй л гэдэг агуулга байгаа.

Хууль зүйн хувьд хууль санаачлах энэ эрхийн хүрээ хязгаар одоогоор ийм л хэмжээнд байгаа гэдгийг нэгдүгээрт би дахиад сануулах гээд байгаа юм.

“Тангаргаасаа няцсан” гэдэг энэ агуулга маань тэгэхээр яаж явж байгаа вэ гэхээр энэ хуулийн төслийг дагалдах тогтоолын төсөлд Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг шинэчлээч ээ. Ёс зүйн дүрмийг шинэчлээч ээ.

Та бүхэн бас дурдаад байгаа. Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн хүрээнд... /минут дуусав/

С.Бямбацогт: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн нэмэлт асуулт. 1 минут.

О.Номинчимэг: Өөрийн чинь Байнгын хороон дээр өгсөн хариулт, өнөөдөр чуулгандаа өгсөн хариулт хоёр тэнгэр газар шиг зөрж байна.

Өөрөө надад Байнгын хороон дээр Үндсэн хуулийн цэц 1994 оноос хойш Улсын Их Хурлын тангаргаасаа няцсаныг шийдэж ирсэн. 1992 оны Үндсэн хууль байсан юм гээд хэвнэг ярьж байсан. Тийм биш шүү дээ.

Чи худал мэдээлэл өгөөд явж байсан шүү дээ. Байнгын хороон дээр.

1992 оны Үндсэн хууль дээр “тангаргаасаа няцах” гэдэг үг байгаагүй. 29.1 дээр “өөр албан тушаал эрхэлсэн бол” гэдгээр л энэ дээр хоёр асуудлаар цэц дүгнэлтээ хийгээд зөрчсөн байна, зөрчөөгүй гэсэн.

Тэгтэл та нар миний асуултад 1994 оноос хойш байгаа юмыг Та нар өөрсдөө харчхаач дээ гээд даапаалаад сууж байсан шүү дээ.

Та Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга. Хариуцлагатай албан тушаалтан. Та худал мэдээлэл хэвнэг яриад сууж байна. Та өөрөө ёс зүйн хариуцлагагүй юм биш үү. Та энэ ажилдаа... /минут дуусав/

С.Бямбацогт: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултаа нэмээд асууя.

О.Номинчимэг: Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр очоод ингээд худлаагаасаа яриад сууж байдаг юм биш биз дээ гэж би бүр санаа зовж байна. Айж байна.

2019 онд тэгвэл энэ тангаргаасаа няцна гэдгийг үгийг оруулахдаа хууль тогтоогчид тэгвэл ямар үзэл санаагаар оруулж байсан юм гэдгийг Та протоколоос нь тэгвэл яагаад оруулаад энд хэлэхгүй байгаа юм?

Одоо бид Үндсэн хуулийн цэцийн 9 хүнд тэрийг тодорхойлох эрхийг энд өгнө гээд сууж байгаа юм уу? Үндсэн хуулийн цэц үнэнийг хэлэхэд улс төрийн нөлөөллөөс ангижраагүй байгаа шүү дээ. Бид бүх жишээг нь харж байгаа.

Тэгээд бид тэр 9 хүнд энэ ард түмний төлөөлөл болсон мандатыг хүчингүй болгох агуулгыг тодорхойлох эрхийг зүв зүгээр бланкаар нь өгнө гээд орж ирж байгаа юм уу? Болохгүй шүү дээ.

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон. Алтангэрэлийн Бямбажаргал. Ажлын хэсгийн гишүүн хариулья.

А.Бямбажаргал: О.Номинчимэг гишүүний асуулт асуултад нь хариулья. Баярлалаа.

Юун түрүүн би хуулийн төслийн үзэл баримтлалыг агуулгын хувьд хэлэлцэх эсэх асуудал дээр би энд ажлын хэсгийн гишүүний хувиар тайлбар өгч оролцож байгаа.

Уг хуулийн төслийн үзэл баримтлал ёсоор Монгол Улсын Үндсэн хуулийн 1992 онд байсан утга, өгүүлэг, агуулга, санаа, түүнийг хэрэгжүүлэх процедуртай холбоотой асуудлыг тодруулах хуулийн зохицуулалт уг хуулийн төсөлд тусгагдсан. Уг хуулийн төсөлд тусгагдсан.

Түүнээс биш Үндсэн хуулийн одоогийн үйлчилж байгаа дэг журмаас гадуурх ямарваа нэгэн зүйл энд огт тусгагдаагүй.

Хоёрдугаарт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 1992 оноос хойш эдүгээг хүртэлх шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн 7 дүгнэлт байна.

Уг 7 дүгнэлтийн хүрээнд Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2.3... /минут дуусав/

С.Бямбацогт: Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуултаа асууя.

Л.Соронзонболд: Улсын Их Хурлын гишүүдийг ёс зүйтэй, хариуцлагатай байхыг бол иргэд сонгогчид шаардаж байгаа. Хариуцлага тооцож эхлэхийг ч өнөөдөр шаардаж байгаа нь бол үнэн.

Ерөнхийлөгчөөс бас яг энэ агуулгаар хуулийн төсөл өргөн барьсан байна.

Би энэ дээр зүгээр нэг асуулт байгаа нь Улсын Их Хурлын тухай хуулийн 36.1 дээр Улсын Их Хурлын үйл ажиллагаа, дэгтэй холбоотой хуулийн төслийг зөвхөн Улсын Их Хурлын гишүүн өргөн барина гээд заасан байдаг.

Тэгэхээр одоо Ерөнхийлөгчийн өргөн барьсан байгаа энэ тангарагтай холбоотой агуулгын хэсэгт оруулж байгаа өөрчлөлт Улсын Их Хурлын гишүүнийг бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө татах энэ асуудал маань Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон дэгтэй холбоотой асуудал мөн үү, биш үү гэдэг дээр надад хариулт өгөөч ээ гэж асуух гэсэн юм.

С.Бямбацогт: 4 номерын микрофон. Алтангэрэлийн Бямбажаргал. Ажлын хэсгийн гишүүн хариулья.

А.Бямбажаргал: Л.Соронзонболд гишүүний асуултад хариулъя.

Нэг талаасаа ийм эргэлзээ, зарим нэг хуульчдын маань ч гэсэн үзэл бодол, санаа нийгэмд хэлэлцүүлэг явж байх шиг байна.

Үндсэн хуулийн эрх зүйн хувьд нэг ийм зарчим барьдаг юм. Эрх зүйн онолын хувьд “иерархи” (hierarchy) гэж бид нэрлэдэг. Тэр маань юу вэ гэхээр дээд эрэмбийн хэм хэмжээ. хоорондоо өрсөлдөх хэм хэмжээ байвал тэр хоёр хэм хэмжээний хувьд дээд эрэмбийн хэм хэмжээг нь барих гэдэг онол зарчим байдаг.

Тэгээд би яагаад үүнийг тодотгож хэлж байгаа вэ гэхээр таны хэлж байгаа үнэн.

36.1.1, 36.1.3 дугаар зүйл, заалтуудыг. Би Ерөнхийлөгчтэй холбоотой хэсгийг хэлж байгаа юм. Эдгээр хоорондоо Ерөнхийлөгчийн хувьд энэ хуулийг санаачлах хязгаар байхгүй байгаа. Нэг.

Хоёрдугаарт, Та бүхэн санаж байгаа бол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хууль гэж бас хууль Монгол Улсад үйлчилж байсан.

Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийг тодорхой зүйлүүдийг нь Улсын Их Хурлын тухай хуульд нэгтгэж нэг хууль болгосон. Нэг хууль болгосон.

Энэ Ерөнхийлөгчийн санаачилж байгаа утга агуулгын хүрээнд, хуулиар юуг хязгаарласан бэ гэхээр Улсын Их Хурлын үйл ажиллагаа таслал дэгтэй холбоотой харилцаа. Дэг бол угаасаа дэгийн хуулиар тусдаа зохицуулагдана.

Улсын Их Хурлын үйл ажиллагаа гэдэг энэ хүрээнд. Би яагаад гишүүний эрх зүйн байдлын хуулийг танд сануулж байгаа вэ гэхээр гишүүний бүрэн эрх, баталгаа, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулж ирсэн юм билээ.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлын тухай хууль маань өөрөө бас дотроо бүлгүүдтэй. Энэ бүлгүүдийн хүрээнд үйл ажиллагаа тусдаа бас нэг үйл ажиллагаа гээд тийм тодорхой харилцааг зохицуулсан зүйлүүд бий.

Бүтэц, зохион байгуулалт гэх мэтчилэн ийм агуулгаар.

Тэгэхээр хууль зүйн талаасаа харвал түрүүн би танд хэллээ. Ерөнхийлөгчид энэ асуудалтай холбоотойгоор санаачлах хүрээ хязгаарт хэрэвзээ энэ хүрээ хязгаарт багтсан, багтаагүй гэдэг асуудал гарвал дахиад хууль зүйн ямар маргаан үүсэх вэ гэхээр Ерөнхийлөгч энэ санаачлах эрхийг нь эдлүүлсэн үү, эдлүүлээгүй юу гэдэг бас хууль зүйн асуудал үүсэх юм билээ. Үүнийг бид бүхэн харгалзах ёстой байх.

Тангараг гэдэг зүйл мэдээж хэрэг гишүүний бүрэн эрхтэй холбоотой. Бүрэн эрхийн баталгаатай холбоотойгоор бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ тангараг өргөж байгаа. Тангаргийн агуулга бол “тангаргаасаа няцах” гэдэг агуулгатай уялдаатайгаар Улсын Их Хурлын гишүүний дэг, хуралдааны үйл ажиллагаатай холбосон зохицуулалтуудад энэ дагалдах тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулаач ээ гэдэг агуулгаар бас тогтоолын төсөл энэ хуультай хамт санаачилсан гэдгийг би хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Дуламын Бум-Очир гишүүн асуултаа асууя.

Д.Бум-Очир: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Маш сонирхолтой, бас анхаарууштай, бас нэлээн нягт нямбай хандмаар ийм сонирхолтой хуулийн төсөл орж ирлээ.

Тэгээд гишүүд олон талаас нь өөрсдийн байр сууриа илэрхийлж санал санаачилгаа хэлж байна. Байр сууриа илэрхийлж байна. Зүйн хэрэг.

Тэгээд энэ асуудал орж ирж байгаад их баяртай байна. Сая Л.Соронзонболд гишүүн миний өмнө хэллээ.

Ард иргэдийн бидэнд тавьж байгаа шаардлага гэж ойлгож болох юм.

Тэгээд үзэл баримтлалын хүрээнд энэ хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж би хувь гишүүнийхээ хувьд үзэж байгаа юм.

Тэгээд үүнийгээ би ямар шалтгаанаар ингэж үзэж байгаа вэ гэдгээ тайлбарлая.

▷ Нэгдүгээрт, бид хэлэлцүүлгийн дунд хоёр зүйлийг хольж яриад байгааг ялгаа заагийг нь гаргавал зүгээр байна.

Юу вэ гэхээр манай Ч.Лодойсамбуу гишүүн уг нь Байнгын хорооны хурал дээр ялгааг нь бараг хэлээд өнгөрсөн.

Энэ “ёс суртахуун” болоод “ёс зүй” гэдэг хоёр хоорондоо маш их холбоотой.

Гэхдээ яг нэг зүйл биш. Заримдаа ялгаа зааг нь гардаг ийм хоёр зүйл байгаа юм.

▶ “Ёс суртахуун” гэдэг бол -хувь хүний дотоод хэм хэмжээ юм.

Өөрөөр хэлбэл тухайн хувь хүн би хувьдаа юуг зөв, буруу гэж бодож байгаа тухай асуудал, тухайн хүний итгэл үнэмшил энэ дээр маш чухал байдаг.

▶ “Ёс зүй” гэдэг бол -нийгэм, эсвэл мэргэжил танаас, чамаас шаардаад

байгаа тийм хэм хэмжээ юм.

Тийм учраас нийгэм дээр, одоо жишээ нь

- ▷ багшийн ёс суртахуун,
- ▷ эмчийн ёс зүй,
- ▷ мэргэжлийн ёс зүй,
- ▷ бизнесийн “ёс зүй” –

-гэдэг ийм ёс зүйн дүрмүүд байгууллагуудад байгааг бид бүгдээрээ мэдэж байгаа. Яг манай Их Хурал дээр ч гэсэн Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм байгаа.

Ингээд үзэхээр “ёс зүй” гэдэг маань илүү дүрэм, журам болоод бичигдсэн зүйлийг “ёс зүй” гээд.

Тухайн хүн дотроо, дотооддоо итгэж үнэмшиж байгааг нь илүү “ёс суртахуун” гэдэг юм байна.

Энэ бол философид олон зууны туршид судлагдаад ирсэн зүйлийг ярьж байгаа юм шүү. Миний зохиосон зүйл биш.

Дараагийн нэг зүйл юу гэхээр дараагийн түвшний “ёс суртахуун”, дараагийн түвшний “ёс зүй” хэзээ хуульчлагддаг юм бэ гэдэг ийм асуудал байна.

Энэ бол ёс суртахууныг бүхэлд нь хуульчлах тухай асуудал биш. “Ёс суртахуун” нийгмийн хэрэгцээ шаардлага бүрдсэн үед хуулийн зарим зүйл, заалт болж ордог ийм хэрэгцээ шаардлага байдаг юм байна.

Жишээ нь, нийгэмд ноцтой хор уршиг учруулах эрсдэлтэй үед. Би 5 зүйлийг дурдъя.

- ▷ Нийгэм өргөн олноороо зөвшилцөл бий болгосон үед;
- ▷ Хүний эрхийг хамгаалах шаардлагатай үед;
- ▷ Хувь хүний ухамсар хангалтгүй үед;
- ▷ Албадлага шаардлагатай болсон үед;
- ▷ Нийгмийн хөгжлийн үр дүнд –

-ёс зүйн асуудлыг хуульчилж оруулж ирдэг.

Өөрөөр хэлбэл зөвхөн дүрэм, журам биш бүр хуулийн заалт болгодог ийм зүйлс байдаг юм байна.

Ингээд үзвэл өнөөдрийн бидний ярьж байгаа энэ асуудал маань нийгэмд олноороо зөвшилцөөд, тодорхой хэмжээгээр хэрэгцээ шаардлага үүссэн асуудал

учраас хуулийн хэмжээнд яригдаж орж ирж байна гэж би хувьдаа ойлгож байгаа юм.

Гэхдээ бүгдийг нь хуульчилсан хэрэг биш шүү дээ.

“Ёс зүй, “ёс суртахуун” гэдэг зүйлийг “ба”, “бэ”-гүй бүгдийг нь хуульчилсан хэрэг биш. Тодорхой зүйл, заалтуудыг хуульчлах гэж байгаа.

Гэхдээ бүр яг тэрийгээ. Хууль санаачлагчид хэлж байсан. Ёс зүйн дүрмээ шинэчлэхдээ нарийн тодорхой зааж өгөөч ээ гэсэн. Энэ нь Их Хуралд болоод Их Хурлын гишүүдэд тэр орон зайг нь үлдээж өгч байгаа хэрэг болов уу гэж би хувьдаа ойлгож байгаа юм.

Энэ утгаараа аваад үзэх юм бол энэ хууль өөрийн гэсэн тодорхой сөрөг болоод, эерэг талтай байгаад байна.

Би эерэг талуудыг нь дурдаж харахыг хүсээд байна. Энэ нь юу гэхээр өнөөдрийн бидний энэ унасан байгаа парламентын, Их Хурлын гишүүдийн нэр хүндийг өсгөж өгөхөд,

- төр нь төр шиг байх,
- Их Хурал нь Их Хурал шиг байх,
- Их Хурлын гишүүн нь Их Хурлын гишүүн шиг байх –

-ийм хэм хэмжээг тодорхой хэмжээгээр бүрдүүлж өгөхөд ашиг тустай болов уу гэж үзэж байгаа юм.

С.Бямбацогт: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? Санал хэллээ.

Лхагвын Мөнхбаатар гишүүн асуултаа асууя.

Л.Мөнхбаатар: Энэ хуулийн төслийн заалт бүрийг Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд нарийвчлан авч үзэх шаардлагатай байгаа нь гишүүдэд харагдаж байгаа байх гэж би үзэж байгаа юм.

Ер нь энэ хуулийн төслийг хэн санаачилсан, ямар агуулгатайгаас үл хамаараад Улсын Их Хурлын гишүүнийг эргүүлэн татах процессыг тодорхой болгох шаардлага байгаа.

Түүнээс гадна Их Хурлын гишүүдийн ёс зүйн асуудлыг ч гэсэн ярих шаардлага байна.

Би Монгол Ардын намын бүлгийн даргаар буюу олонхын бүлгийн даргаар ажиллаж байхдаа гишүүдийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах, идэвх оролцоог нэмэгдүүлэх үүднээс бүлгийн гишүүдийнхээ “Үнэлгээний журам” гэж гаргаад бас нэлээн асуудал болж байсан. Та бүхэн санаж байгаа.

Энэ журмаар ер нь–

- хуралдаа суухгүй,
- хууль санаачилдаггүй,
- тойрогтоо ажилладаггүй,
- гишүүний хуулиар хүлээсэн үүргээ биелүүлдэггүй –

-ийм тохиолдолд тодорхой үнэлгээ хийж, улс төрийн хариуцлага тооцдог, илүү улс төрийн намын бүлгүүд хариуцлагатай ажилладаг ийм механизмыг бий болгохыг зорьж байсан. Харамсалтай нь батлагдаагүй.

Хэрвээ энэ батлагдсан бол өнөөдөр Засгийн газар болоод төрийн тогтвортой үйл ажиллагаа ч гэсэн хэвийн явагдах, гишүүдийн ёс зүйн асуудал энэ хууль болтол яригдахгүй байсан болов уу гэж би бодож байгаа юм.

Энэ дээр харин хэд хэдэн зүйлүүд байна. Дэмжих шаардлагатай заалтууд байна. Мөн дэмжих боломжгүй ч заалтууд харагдаж байгаа.

Би хэд хэдэн зүйл дээр тухайлаад хэлье.

Энэ дээр тодорхой зүйлийг боловсронгуй болгох шаардлагатай гэдэг үүднээс гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхээр тогтоогдсон гишүүний асуудлыг оруулж ирэхэд процессын хувьд тодорхойгүй байснаас болоод тодорхой асуудлууд үүсэж байгаа.

Хуучин хуулиар нь Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч нь Байнгын хороо, чуулганд оруулж ирж танилцуулдаг байсан. Ингээд процесс явдаг байсан бол одоо энэ заалтыг нь орхигдуулснаас болоод хэн Төрийн байгуулалтын байнгын хороо болоод чуулганд оруулах нь тодорхойгүй болсноос болоод ойлгомжгүй байдал үүссэн. Үүнийг засаж байгаа юм билээ.

Тухайн шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дараа Улсын Их Хурлын даргад Дээд шүүхэд дамжуулан хүргүүлнэ. Ингээд шийдээд явна. Энэ бол боловсронгуй болгож байгаа зүйл мөн. Үүнийг ингээд дэмжээд явах нь зүйтэй.

Нөгөөтээгүүр “тангаргаасаа няцсан бол” гэж байгаа юм. Өргөсөн тангаргаасаа. Энэ бол 2019 оны орсон том өөрчлөлт. 29.3. Бүгд сая ярьж байна. Манай гишүүд ярьж байна. Энэ бол их чухал заалт байгаа юм.

Ер нь “тангараг” гэдэг маань юу юм бэ гэхээр энэ өөрөө хууль зүйн болоод эрх зүйн, мөн ёс зүйн маш том агуулгыг нь агуулсан зүйл. Нөгөө талаасаа энэ бол өөрөө тухайн албан тушаалтны бүрэн эрх хэрэгжиж эхлэх, энэ эрхийг нээж өгдөг зүйл шүү дээ.

Мөн дараагийн гишүүн нь тангараг өргөснөөр дуусгавар болж байдаг.

Сайд, Их Хурлын гишүүд, төрийн тусгай албан хаагч, шүүх, прокурор бүгд тангараг өргөдөг. Энэ бол өөрөө эрх зүйн үр дагавартай зүйл байхгүй юу.

Гэтэл энэ маань сүүлдээ хүндэтгэлийн, ёслолын шинжтэй арга хэмжээ болоод байгаа юм.

Тийм учраас энэ “өргөсөн тангаргаасаа няцах” гэдэг энэ зүйлийг илүү тодорхой болгох нь зүйтэй.

Гэхдээ энэ механизмыг нь хэрхэн яаж тодорхой болгох вэ гэдэг зүйлээ бид ярихгүй бол энэ өөрөө Үндсэн хуулийн цэц дээр ч гэсэн маргаан дагуулсан асуудал үүснэ. Үүнийг илүү тодорхой болгох гэдэг үүднээс зайлшгүй зүйл гэж би бодож байгаа юм.

Мэдээж ёс зүйг бол мэдээж хуульчилж болохгүй гэдэг зүйл байгаа. Энэ бол өөрөө онолын маргаантай сэдэв. Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг баталж байх үед ч гэсэн хууль болгож гаргая гэхэд хэлэлцүүлэг зохион байгуулж байсан. Ингэхэд ёс зүйг хуульчилдаггүй юм гэж хэлээд тухайн үед дүрмээрээ батлагдаад, Их Хурлын тогтоолоор батлагдаад явж байсан байх жишээтэй.

Тийм учраас энэ өөрөө онолын маргаантай сэдэв байгаа юм.

Дараагийн нэг асуудал байна. Ирцийн хувьд мэдээж ойлгомжтой. Төлөөллийн чиг үүргээ хэрэгжүүлэх үүрэгтэй. Нэг асуулт байгаа юм.

Үндсэн хуулийн цэц дүгнэлт гарган танилцуулснаар Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах тухай тогтоол батлагдсанд тооцох зохицуулалт тусгагдсан байна. Үүнийг уншаад би яг ийм агуулгаараа байна уу гэдэг дээр эргэлзээд байна.

Үндсэн хууль зөрчсөн эгүүлэн татах үндэслэлтэй талаарх Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал сонсох буюу танилцаад хэлэлцүүлэггүйгээр, мөн санал хураахгүйгээр тухайн гишүүнийг эгүүлэн татах асуудал явагдаж магадгүй байна. Энэ өөрөө ноцтой асуудал шүү. Энэ дээр тодорхой хариултыг авъя. Ийм зохицуулалт туссан байна гэж би эндээс уншаад ингэж хараад байна.

Тэгээд санал хураалт тодорхой агуулгаараа Их Хурал дээр биш цэц дээр санал хураалт чинь явагдах гээд... /минут дуусав/

С.Бямбацогт: Хариулъя. Хэн хариулах вэ? Отгонбаярын Машбат. Хууль зүйн ухааны доктор, дэд профессор, ажлын хэсгийн гишүүн хариулъя.

О.Машбат: Бид Үндсэн хуулиа харах юм бол Үндсэн хуулийн 29.3 дээр “Их Хурал түүнийг эгүүлэн татна.” гээд үүрэг болгосон заалт орсон байгаа. Нэгд.

Хоёрдугаарт нь, Үндсэн хуулийн 67 дугаар зүйл дээр “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно.” гээд заасан байгаа.

Тэгэхээр хэрвээ бид үүнийг одоогийн механизмаар. Тийм ээ. Их Хурлаар Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг хэлэлцээд эхэлбэл энэ чинь өөрөө 29.3-ыг нэмэх нь 67 дугаар зүйлийг зөрчсөн болж харагдах гээд байгаа юм.

Тэгэхээр энэ агуулгаар нь нийцүүлж томъёолж байгаа юм шүү гэж хариулъя даа. Тийм.

С.Бямбацогт: Лхагвын Мөнхбаатар гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаатар: Яг л миний асуусан агуулгаар орсон. Гармагцаа хүчин төгөлдөр болох ёстой. Хэлэлцүүлэггүйгээр шууд шийдэгдээд явахаар ингэж ойлгохоор хариулж байх шиг байна.

Ингэхээр бид Үндсэн хуулийн цэц маань ер нь ямар байгууллага вэ, хэрхэн бэхэжсэн бэ гэдэг асуудлуудаа гишүүд тал талаас нь бодох ёстой байх.

Нөгөөтээгүүр институцийн хувьд үүнийгээ хэрэгжүүлэх хэмжээнд бэхэжсэн үү, үгүй юу?

Нөгөөтээгүүр цэц бол улс төрийн шийдвэр гаргадаг нөхцөл бүрдэж болзошгүй гэдэг болгоомжлол гишүүдэд бас байгаа. Ийм олон асуудлуудыг бид давхар сайн ярилцах хэрэгтэй. Нэг.

Хоёрдугаарт, ер нь Улсын Их Хурал өөрөө гишүүдийнхээ асуудлыг хэлбэрийн хувьд биш илүү идэвхтэйгээр, оролцоотойгоор үүнийгээ шийддэг байх ёстой гэж би үзэж байгаа юм.

Энэ дээр илүү гишүүдийнх нь асуудал яригдаж байгаа учраас Их Хурал өөрөө энд идэвхтэй оролцох энэ бололцоо болоод энэ механизмыг бүрдүүлсэн зохицуулалт заавал байх ёстой шүү гэдгийг хэлье.

С.Бямбацогт: 4 номерын микрофон. Отгонбаярын Машбат. Ажлын хэсгийн гишүүн тодруулж, нэмэлт хариулт.

О.Машбат: Саяынх дээр нэмэх зүйл нь юу вэ гэхээр 66.2, 66.3 дээр билүү. 66.2 дээр байх. Наадах чинь 66.2-ын 3, 4 дүгээр заалтад байгаа тэр асуудлаар гаргасан цэцийн дүгнэлтийг Их Хурал хэлэлцэх эрхгүй гээд яг тэрний дараагийн заалтад нь 66.3 дээр байх аа, заасан байгаа.

Тэгэхээр хэрвээ дахиад энэ асуудлыг Их Хурлаар хэлэлцэх юм бол тэр нь өөрөө зөрчилтэй болж таарах гээд байгаа юм.

Тэгэхээр ерөнхийдөө энэ асуудлуудыг цөмийг нь Их Хурал дээр өөрсдөө нарийн хэлэлцэж дахин авч үзэх нь зүйтэй гэж Л.Мөнхбаатар гишүүний хэлж байгаа зөв л дөө. Үүнийг дахин хэлэлцэж ярилцах нь зүйтэй.

Ер нь яг... /минут дуусав/

С.Бямбацогт: Жаргалсайханы Золжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Золжаргал: Хуулийн төслийн зорилго нь дэмжихүйц гоё агуулгатай зарлаад, агуулга болон үр дүн нь эсрэг үр дүнд хүргэж болзошгүй байгаа учраас хэлэлцэхийг дэмжихгүй байгаа юм.

Улсын Их Хурлын гишүүдийг хариуцлагажуулах, эгүүлэн татах нөхцөл хэрэгтэй юу гэхээр хэрэгтэй. Хүн болгон л хэрэгтэй гэж хэлнэ.

Тэгээд Үндсэн хууль дээр ч тэр нөхцөл нь байдаг. Нөгөөхөө хэрэглэсэн тохиолдол байхгүй. Яагаад хэрэглэхгүй байгаа юм.

Үндсэн хууль зөрчсөн, шүүхээр гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон бол эгүүлэн татах үүрэгтэй. Тэрийгээ тэгээд хэрэгжүүлэе л дээ. Хэрэгжүүлэх гэхээр процесс нь байхгүй байгаа юм шиг байгаа юм.

Тэгэхээр тэр тохиолдолд 10 хоногийн дотор гэдэг юм уу, ингээд юунууд байдаг шүү дээ. Тэд хоногийн дотор хэлэлцэнэ, дуусна, шийдвэр гаргана, нээлттэй, хаалттай хэлэлцэнэ, ингэнэ тэгнэ гээд процессыг нь бичиж оруулж ирээд тэгээд хариуцлагажуулж болдоггүй юм уу.

Уриалга нь болохоор олон нийт ингээд бүгдээрээ хүлээж авахуйц, хариуцлагатай болгоё гэхээд үр дүнд нь нөгөө ард түмний төлөөлөл гэдэг Улсын Их Хурлыг чинь ард түмнээс нь холдуулаад, ард түмний элч Улсын Их Хурлын гишүүн бол намын багц, даргын командаар хөдөлдөг, хуруу дардаг машин болгох ийм эрсдэлтэй аваачмаар харагдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ рүү олон нийт анхаарлаа хандуулмаар байгаа юм.

Хоёр гол агуулга нь байгаа. Нэг нь жагсаалтаар сонгогдсон гишүүнийг ёс зүйн ноцтой алдаа гаргасан гэж үзэх юм бол нам нь санал гаргаад, тэгээд чуулганаар санал хураалгаад эгүүлэн татаж болно.

“Ёс зүй” гэдэг юмыг нам яаж тогтоох вэ? Нэг дүрэм бичнэ. Дүрмийг өөрчилж болдог. Бас яаж ч тайлбарлаж болно. Энэ хүн ёс зүйтэй хүн үү. Энэ ингээд нөхөдтэйгөө эсрэг санал ярьж байдаг. Ер нь ёс зүйгүй этгээд биш үү. Ингээд оруулж ирэх. Таалсан, таалагдахгүйгээр оруулж ирэх нэг асуудал үүсэж болох нь.

Хоёр дахь нь болохоор хэн нэгэн иргэн хэн нэгэн гишүүнийг ёс зүйн ноцтой алдаа гаргалаа гэж дүгнээд өргөдөл гаргана. Тэрийг нь Ёс зүйн дэд хороогоор

хэлэлцэнэ. Чуулганаар оруулна. Олонхын саналаар эгүүлэн татаж болно. Нэг хүн жишээлбэл тэр нэг гишүүн хулгайчийг хулгайч гэж хэлснийхээ төлөө энэ чинь хулгайч гэж хэлээд байна, ямар ёс зүйгүй этгээд вэ, монголын хөгжлийг гацааж байна гээд тэр нэг нөхөр өргөдөл бичээд дэд хороогоороо хэлэлцээд, энэ ёстой намын том ажил, нүүрсний юу гэдэг юм тэр нэг хулгай зэлгий, энээ тэрээ юм ингээд гай болоод байна шүү дээ.

Нэгэнт л олуулаа байгаа юм чинь энэ дээр нь үндэслээд зайлуулъя гээд шийдвэр гаргавал яах вэ? Зүгээр л жишээ шүү.

Тэгэхээр энэ бол ийм эрсдэлтэй хоёр зүйлийг нээж өгөх гэж байгаа учраас хариуцлагажуулах зөв зорилгын ард буруу үр дагаварт хүргэж болзошгүй гэж харагдаад байгаа юм.

Тэгээд хуулийн зохицуулалт бол нэг л ийм зүйл, заалтаар нь нааш цааш нь тайлбарлаад л ингээд байдаг нэг ийм хэрэгслээс илүүтэйгээр суурь ойлголт, парламентын нөгөө засаглалын суурь ойлголтоо бид анхаарах хэрэгтэй гэж бодож байгаа юм.

Тийм эрсдэлийг Та бүхэн харахгүй байгаа юм уу гэдэг асуултыг л асуумаар байгаа юм.

Тэр хариуцлагажуулах, эгүүлэн татах нөхцөлүүдийг процессыг нь тодорхой болгоод тэгээд оруулж ирж болдоггүй юм уу? Тийм хуулийг хэлэлцэхийг дэмжиж байна. Ийм эрсдэлтэй нөхцөлийг оруулж ирэхийг хэлэлцэхийг дэмжихгүй байгаа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гишүүн Алтангэрэлийн Бямбажаргал хариулъя. 4 дүгээр микрофон.

А.Бямбажаргал: Ж.Золжаргал гишүүний асуултад хариулъя.

Байнгын хороон дээр ч гэсэн Ж.Золжаргал гишүүн маань энэ утга санаагаа хэлсэн.

Гэхдээ нэг зүйлийг Ж.Золжаргал гишүүн маань хуулийн төслөөс уншихгүй байгаа юм шиг байгаа юм.

Эсвэл буруу уншаад байгаа юм шиг байгаа юм. Сая яг тэрийгээ хэллээ л дээ.

Юуг уншихгүй, юуг буруу уншаад байгаа юм бэ гэхээр Та хэллээ, сая. Хэд хэдэн зарчим бий.

Нэгдүгээрт, хамгийн түрүүн барьсан зарчим Үндсэн хуулийн нөгөө хязгаарлалтынхаа хүрээнд, хууль санаачлах эрхийнхээ хүрээнд санаачилж байгаа юм.

Улсын Их Хурлын үйл ажиллагаа, дотоод зохион байгуулалттай холбоотой, дэгтэй холбоотой энэ асуудлуудаар таны яг хэлээд байгаа энэ ноцтой зөрчил нь чухам юуг хамааруулах юм. Удаа дараад нь яаж тооцох юм. Аль нь ноцтой юм. Аль нь үгүй юм бэ гэдгийг нь дүрмээр шийдэх байдлаар нөгөө тогтоолын төсөл өргөн барьчхаад байгаа шүү дээ.

Нэгдүгээрт, үүнийг харах хэрэгтэй болж байгаа. Энэ дээр л нөгөө процессууд бичдэг юм л даа. Хууль зүйн утгаараа.

Хоёрдугаарт, хэрэв Улсын Их Хурлын гишүүн дараах 4 нөхцөл байдлаар Үндсэн хуулийн цэц рүү Улсын Их Хурал хүсэлт гаргах хэмжээний асуудлаас өмнө 2 том процесс байгаа шүү дээ.

Нэгдүгээрт юу вэ гэхээр хэрэв иргэн Улсын Их Хурлын дэд хороонд хандвал, Ёс зүйн дэд хороонд хандвал дэд хороо урьдчилан хянан үзнэ гэж байгаа юм.

Одоогийн зохицуулалтаар бүх ирсэн өргөдөл, гомдлыг хэлэлцэхээр байгаа юм.

Урьдчилан хянан үзнэ гэдэг чинь өөрөө процесс. Процессын утга агуулга. Үүнийгээ хаана бичих юм бэ гэхээр дэгийн хуульдаа, эсвэл тэр дүрэмдээ бичнэ гэсэн үг. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, хандсан өргөдлийг нь урьдчилан хянан үзээд хэлэлцэх үү, хэлэлцэхгүй юу гэдгээ шийдсэний дараагаар хороо маань бас нээлттэйгээр хэлэлцэнэ. Нээлттэй санал хураана. Шийдэх асуудал нь Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцэд хандах уу, эсвэл үгүй юу буюу хүсэлт гаргах уу, үгүй юу гэдэг асуудлаар чуулган руу оруулна шүү дээ.

Чуулган маань бас хэлэлцэнэ. Олонхоороо уг асуудлыг шийдээд. Энэ бол өөрөө ардчиллын зарчим маань ажиллаж байгаа юм. Их Хурал өөрөө өөрийнхөө асуудлыг өөрөө хэлэлцэж шийдэх энэ механизм ажиллаж байгаа юм.

Нөгөө талдаа Үндсэн хуульт ёсны механизм ажиллаж байгаа юм.

Тэр нь Үндсэн хуулийн цэц л дээ. Их олон хүмүүсийн санаа бодол дунд сонгогдоогүй хүмүүс энэ эрхийг шийдэх юм уу гэж ярьж байна лээ. Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим маань тийм шүү дээ. Энэ чинь. Ардчилсан ёсны зарчмыг нь энэ парламент хамгаалж, Үндсэн хуульт ёсных нь зарчмыг нь Үндсэн хуулийн хяналтын дээд байгууллага хангаж байгаа юм. Хангаж байгаа юм.

Тийм учраас энэ өөрөө дахиад Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар, эгүүлэн татах эсэх асуудлаар цэц маань дүгнэлт гаргана. Дүгнэлт гаргана.

Энэ дүгнэлтийг нь хэлэлцэж болохгүй гэдэг шийдвэр 1995 оны Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол дээр ч гэсэн тодорхой тусгагдсан юм билээ. Тухайн үед Их Хурлын хуулийн тодорхой зүйл, заалтуудаар хэлэлцэх агуулга байхад Ламжав гуай өргөдлийн дагуу хэлэлцээд одоогоос 31 жилийн өмнө шийдэж байсан юм билээ. Үндсэн хууль нь өөрөө бас тийм. 66.3 гэдэг заалт. Түрүүн О.Машбат доктор... /минут дуусав/

С.Бямбацогт: Жаргалсайханы Золжаргал гишүүн нэмж асууя.

Ж.Золжаргал: Би яг наад дүрэм гэдэг дээр бас болгоомжлоод байгаа байхгүй юу. Дүрэм гэдгийг бол зохиож болно, өөрчилж болно. Дүрэм дээр бичсэн юмыг янз бүрээр тайлбарлана.

Улсын Их Хурлын гишүүн ийм нэр хүндтэй албан тушаал хийж байгаа хүн учраас тэгээд бусдадаа болон иргэдэд хүндэтгэлтэй хандах ёстой. Ёстой юу. Ёстой ёс зүйн дагуу юу, дагуу.

Тэгтэл нөгөөх чинь нэг хулгайчийг хулгайч гэж хэлснээсээ болоод хүндэтгэлгүй хандлаа гээд асуудал үүсвэл яах вэ. Зүгээр фантаз юм. Ингэхээр тэрийг яаж ч эргүүлээд, яаж ч мушгиж явуулсаар байгаад улс төрийн арга хэрэгслээр эгүүлэн татах нөхцөлд хүргэж бол болзошгүй. Ингээд яваад байна.

Тэгээд яваад байхаар сүүлдээ нөгөө намын нэг цөөхөн хэдэн удирдлагаар л явдаг баахан мануухайтай гишүүдтэй Улсын Их Хурал болох юм бол олон нийт хүлээн зөвшөөрөгдөхгүй. Хүлээн зөвшөөрөгдөхгүй бол төр эзгүйрнэ. Олон жилийн дараа бол... /минут дуусав/

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гишүүн. 4 дүгээр микрофон. Нэмээд хариулъя.

А.Бямбажаргал: Ж.Золжаргал гишүүний асуултад би дутуу зарим нэгийг нь хариулсан.

Та сая хэллээ. Энэ дүрэм өөрөө юу байх юм бэ? Ноцтойд нь алийг нь оруулах юм бэ? Ёс зүйн зөрчилд нь алийг нь оруулах юм бэ гэдгийг нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурал маань өөрөө шийдэх. Энэ нь өөрөө хууль байх уу, дүрэм байх уу? Их Хурал өөрөө шийдэх ийм онцгой бүрэн эрхтэй.

Үүнийг нь буюу энэ зүйлүүдийг нь Ерөнхийлөгч бичээд ороод ирэх юм бол харин Та бүхний нөгөө дурдаад байгаа хууль тогтоох хүрээ хязгаар чинь энд харин жинхэнээсээ яригдана.

Хоёрдугаарт, түрүүн намын гэдэг асуудал ярилаа. Намын жагсаалт гэдэг энэ зүйл мэдээж хэрэг ярихаас гадна 2019 онд бид бүхэн бас Үндсэн хуульдаа намыг хариуцлагатай байх тухай зохицуулалтыг 19¹ гэдэг заалтаар нэмсэн юм.

Тийм учраас одоогийн хууль үйлчилж байгаа. Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэхэд Улсын Их Хуралд Улс төрийн намын тухай хуулиар ёс зүйн шаардлага хангасан нэр дэвшигчийг дэвшүүлнэ гэж бас оруулсан. Энэ одоо хүчин төгөлдөр үйлчилж байна.

С.Бямбацогт: Монгол Улсын Их Сургуулийн Улс төр судлалын тэнхимийн нэгдүгээр түвшний оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Ирээдүйд улс төрч болох гэж байгаа оюутнууддаа сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе. /алга ташив/

Маш чухал улс төртэй холбоотой асуудал ярьж байгаа. Сонирхож нэлээн суусан байх аа.

Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя.

Б.Жаргалан: Энэ завшаантай хэрэг боллоо. Ирээдүйн ажлын байртайгаа танилцаж байгаа улс төр судлалын оюутнууд маань яг чухал асуудал хэлэлцэж байхад орж ирж байна.

Энэ хууль бол ер нь цаашид парламент орших уу, эс орших уу гэдэг зангилаан дээр оршиж байгаа ийм хуулийн төсөл ороод ирсэн байж байгаа.

Тэгээд би нэг л юм хэлмээр байгаа юм.

Хүн болгон хийх ёстой ажлаа л хиймээр байгаа. Хийх ёстой ажлаа хариуцлагатайгаар хийх ёстой байна.

- Ерөнхийлөгч нь Ерөнхийлөгч шиг баймаар байна. Эв нэгдлийг хангадаг.
- Засгийн газар нь Засгийн газар шиг. Асуудлаа шийддэг.
- Улсын Их Хурал нь Улсын Их Хурал шиг байх ёстой.

Тэр нь юу вэ гэхээр ардчилсан тогтолцоогоо хамгаалах, парламентынхаа дархлааг хамгаалах, хууль тогтоох эрх мэдлийнхээ хүрээнд иргэдийнхээ аж амьдралд шаардлагатай хуулиудыг батлах.

Гэтэл манайд өнөөдөр бүх зүйл нөгөө хөлөөрөө толгой хийж байна гэдэг шиг л юм болоод байна. Яг хийх ёстой ажлаа бүрэн дүүрэн хийж байгаа хүн алга.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хүртэл Улсын Их Хуралд орж ирчхээд хууль тайлбарлаад сууж байгаа. Одоо энэ хуулиа батлуулж авчхаад Улсын Их Хурлын гишүүдэд “ёс зүй” заагаад суух юм байна л даа.

Тэгээд би энд Улсын Их Хурлын даргаар шинээр томилогдсон С.Бямбацогт даргад бүр тусгайлан хандаж хэлмээр байгаа юм.

Та Улсын Их Хуралд 5 удаа сонгогдсон. Энэ танхимд байгаа хамгийн туршлагатай парламентчдын нэг. Тэгээд таны анхны даргаар сонгогдоод хэлэлцүүлж байгаа хуулийн төсөл энэ болж байна.

Тэгээд энэ хуулийн төсөлд дотор гэдэс рүү нь орох юм бол асуудалтай зүйл маш их байна. Магадгүй авч болох ганц нэг зүйл байж болно.

Гэхдээ санаачлах явдлаасаа авхуулаад асуудал дагуулж байгаа юм.

Сая Байнгын хороон дээр ч гэсэн зөндөө яригдлаа. Үндсэн хуулийн 26.1-д хууль санаачлах эрхийн хүрээ хязгаарыг тодорхой тогтоогоод өгсөн байж байгаа. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36.1-д Их Хуралтай холбоотой асуудлыг Улсын Их Хурлын гишүүд зөвхөн санаачилна гэсэн байж байгаа.

Тэрийг нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн чинь ажлын албаны хүмүүс тэс хөндлөнгөөр өөрсдөө хууль тайлбарлаад Байнгын хороон дээр яриад байна. Та үүнийг Улсын Их Хурлын даргын хувьд зүгээр хараад сууж байж болох юм уу?

Улсын Их Хурлын даргын албан тушаалыг цөөхөн хүн хашсан байдаг. Тэгээд тухай бүр өөрсдийнхөө legасу-г бүтээж байгаа. Та бол 5 удаа сонгогдсон парламентчийн хувьд өөрийнхөө legасу-г яаж бүтээх нь вэ гэдэг чинь яг энэ эхний алхмаас чинь харагдах гээд байна.

Тэгээд би бол энэ хэлэлцэх эсэхээсээ авхуулаад л маш ийм маргаантай хуулийн төсөл орж ирж байгааг бид зүгээр ингээд юу ч болоогүй юм шиг хэн нэгнээр ёс зүйгээ заалгаад сууж баймааргүй байгаа юм.

Эгүүлэн татах асуудлыг процессжуулах шаардлага байгаа гэж үзэх юм бол тэр асуудлыг Улсын Их Хурлын гишүүд нь өөрсдөө санаачлаад оруулж ирж болно. Тэр асуудал бол нээлттэй. Шаардлагатай бол би ч гэсэндээ санаачлаад явж болж байна.

Миний бодол юу вэ гэхээр өнгөрсөн 36 жилийн хугацаанд маш их үнэ цэнээр хамгаалагдаж байгаа Монголын ардчиллыг, Монголын ардчиллын хувь заяа гагцхүү сонгогчдод л байх ёстой. Тэр эгүүлэн татах эрх зөвхөн сонгогчдод, зөвхөн иргэдэд байх ёстой л гэдэг байр суурьтай байгаа.

Тэгэхээр Их Хурлын дарга би танаас л асуухыг хүсээд байна л даа. Та энэ Улсын Их Хурлынхаа хувь заяаг цаашид ер нь яаж харж байгаа юм бэ?

С.Бямбацогт: Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар хууль санаачлагчаас асуулт асууж хариулт авах дэгтэй. Та мэдэж байгаа байх.

Их Хурлын гишүүдийн эргэлзээ, хууль санаачлах бүрэн эрхийн эрхийн хүрээ хязгаар, институц хоорондын зөрчил, бие биеийнхээ ажил руу ороод байгаа юм шиг гээд ойлголтууд явж байгаа учраас танд Улсын Их Хурлын Тамгын газар тайлбар өгүүлэх нь зөв байх.

Ер нь Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байгаа хуулийн төслүүд дээр Үндсэн хууль болон Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хуульд нийцсэн эсэх талаар санал, дүгнэлтүүд Улсын Их Хурлын Тамгын газраас гаргадаг.

Энэ бол хуулийн төслийн бүрдүүлбэр өргөн мэдүүлж Улсын Их Хурал хэлэлцүүлэх шалгуур, шаардлагыг хангасан эсэхийг нь хянадаг. Энэ хянагдсан байгаа.

Энэ хүрээндээ Үндсэн хууль болон Улсын Их Хурлын тухай хуулийн хүрээ хязгаарыг зөрчсөн, давсан хэн нэгэн Их Хурлын эрх мэдэл рүү, бүрэн эрх рүү халдсан зүйл байхгүй байна.

Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дэгтэй холбоотой, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг Улсын Их Хурал өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд шийдэх ёстой гэсэн тайлбарыг өгсөн.

Мөн өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн энэ хуулийн төсөл бол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхтэй холбоотой асуудал учраас энэ бол Хууль тогтоомжийн тухай хууль, Үндсэн хууль бусад хууль тогтоомжийг зөрчөөгүй байна гэсэн лавлагаа надад гаргаж өгсөн байгаа.

Тэгээд энэ дээр Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан тодорхой хариулт өгчих.

Яагаад гэвэл Их Хурлын олон гишүүдэд ийм эргэлзээ байгаа. Үндсэн хууль судлаач нар, мөн хуульч, эрх зүйчдэд иймэрхүү эргэлзээ иргэд, олон нийтийн дунд байгаа байх.

Тийм болохоор тодорхой тайлбар өгөх нь зөв байх.

Миний хувьд Та бүхэн мэдэж байгаа. Парламентад 5 удаа сонгогдоод 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийгээд ажиллахдаа парламентын засаглалыг бэхжүүлэх, парламентын нэр хүндийг яаж дээшлүүлэх вэ, ард түмнийг төрд итгэх итгэлийг яаж нэмэгдүүлэх вэ гэдэг дээр илүү анхаарч ажиллана гэж Та бүхэнд Их Хурлын даргад нэр дэвшиж байхдаа хэлж байсан байр суурь хэвээрээ. Энэ ч үүднээсээ урьд нь хандаж ирсэн. Одоо ч энэ байр суурьдаа байгаа. Цаашдаа ч энэ байр суурьдаа байх болно гэдгийг хэлье.

Л.Өлзийсайхан дарга.

Л.Өлзийсайхан: Б.Жаргалан гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хууль санаачлах эрхийн хүрээ хязгаарыг хуулиар тогтоохоор заасан байгаа. Үүнийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйл, мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлээр тус тус зохицуулсан.

Ингэхдээ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1-д Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой хууль тогтоомжийн төслийг зөвхөн Улсын Их Хурлын гишүүн санаачлах ба бусад хуулийн төслийг өргөн мэдүүлэх, Улсын Их Хурлаар хэлэлцэх, батлахдаа дагалдах хэлбэрээр Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой хууль тогтоомжийг өөрчлөхийг хориглоно гэж заасан байгаа.

Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн хуулийн төсөл нь Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй хамааралгүй, зөвхөн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхтэй, эрх зүйн байдалтай холбоотой асуудлыг хөндсөн байгаа.

Энэ нь Улсын Их Хурлын үйл ажиллагааны хуралдааны дэг болоод үйл ажиллагаанаасаа л тусдаа болно.

Нөгөө талаас Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар энэ хуулийн 36.1-д зааснаас бусад асуудлаар хууль тогтоомжийн төсөл санаачилж болно гэж, мөн 36.3-д Ерөнхийлөгч хууль санаачлахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг баримтална гэж тус тус заасан.

Тодруулбал Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36.1.1-д Улсын Их Хурлын гишүүний хууль санаачлах хуулийн хүрээ хязгаарыг 36.1.2-т Засгийн газрын санаачлах хуулийн хүрээ хязгаарыг тогтоосон.

Харин Ерөнхийлөгчийг хууль санаачлах замаар өөртөө Үндсэн хуулиар олгосон үндсэн бүрэн эрхээс гадуур тодорхой бүрэн эрх олж авахыг нь хязгаарласан ийм заалтууд байгаа юм.

Хоёр дахь асуултын хувьд Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд халдаж байгаа эсэх асуултын хувьд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 4.1-д Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хэн ч халдаж үл болно гэж заасан байгаа. Үүнд Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан 18 онцгой бүрэн эрхийг ойлгоно.

Ерөнхийлөгчөөс санаачилсан хуулийн төсөл нь эдгээр 18 онцгой бүрэн эрхтэй хамааралгүй. Эдгээр бүрэн эрхийн аль нэгийг нь хөндөөгүй байгаа тул

Улсын Их Хурал хууль санаачлах эрх бүхий субъектийн өргөн мэдүүлсэн төслийг дэгийн дагуу хэлэлцэн батлах нь хууль зөрчсөн асуудал биш юм.

Харин өргөн мэдүүлсэн төслийг хэрхэн өөрчилж батлах, эсхүл батлахгүй байх нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн асуудал юм.

Гуравт, холбогдох ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухайд бас хариулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан хуулийн төслийн танилцуулгыг Монгол Улсын Ерөнхийлөгч өөрөө, эсвэл түүний томил болсноор Тамгын газрын дарга, эсвэл зөвлөх нь хийнэ гэж, 31.6-д энэ хуулийн 31.1, 31.2-т заасан этгээд төслөө танилцуулах, үндэслэлээ тайлбарлахдаа төслийг боловсруулахад оролцсон холбогдох мэргэжилтэн шинжээчдийг төслийн хэлэлцүүлгийн бүх... /минут дуусав/

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон хариулчхаад дахиад тодруулах уу? Б.Жаргалан гишүүн ээ. Асуугаагүй юу?

Батбаярын Жаргалан гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалан: Юуны өмнө Улсын Их Хурлын Тамгын газар дээр ямарваа нэгэн тийм хууль зүйн дүгнэлт гарсан байгаа бол тэрийг бичгээр авах хүсэлтэй байна.

Хоёрдугаарт, саяын тайлбар хийж байгаа хүн дээр ч гэсэндээ яг түрүүний миний яриад байдаг хөл толгой нь алдагдсан байдал харагдаад байгаа юм.

Сая намар Үндсэн хуулийн цэц нь хүртэл оролцоод л Засгийн газар, Улсын Их Хурал бүгдээрээ бужигнаан дунд Монгол Ардын намын дотоод хэрүүл тэмцлийн улмаас асуудал үүссэн.

Тэгэнгүүт Үндсэн хуулийн цэцийн гишүүнийхээ ажлыг өгөөд Их Хурлын Тамгын газар ирж ажиллаж байгаа.

Тэгээд одоо энд ахиад хууль тайлбарлаад суугаад байгаа.

Тэгэхээр бид ерөөсөө хийх ёстой үүрэгт ажлаа хаана нь хэн ч хийхгүй байгаагийн л зовлонг амсаад байна.

Тэгээд С.Бямбацогт даргаас хүсэх зүйл нь юу гэхээр Та Улсын Их Хурлын даргын ажлыг нэр төртэй хийгээд тэгээд элдэв асуудалгүй л цөмөөрөө энэ бүрэн эрхийнхээ ард гармаар байх юм.

С.Бямбацогт: Хичээе. Тэгээд нэр төртэй хийх сэтгэл, бас туршлага, чадвар байгаа гэж өөрийгөө бодож байгаа.

Тэгээд Үндсэн хуульд заасан. Хүнийг ажил, албан тушаалаар нь ялгаварлахыг Үндсэн хуулиар хориглосон байдаг. Мөн өнөөдөр хаана хэн чадвартай хүмүүс ажиллах нь тухайн удирдлагын асуудал байсан байх.

4 дүгээр микрофон. Ажлын хэсгийн гишүүн хариулъя. 4 дүгээр микрофон.

А.Бямбажаргал: Баярлалаа.

Б.Жаргалан гишүүн тодорхой зүйл над руу чиглэж хэлсэн учраас би нэг хэдэн зүйл хэлье гэж бодлоо.

Юун түрүүн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуулиар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын хэрэгжүүлэх миний хуулиар хүлээсэн үүрэг бол гишүүдийнхээ бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахаар заасан.

Хоёрдугаарт, намайг ажлын хэсгийн гишүүнээр оруулсан. Би энэ үүрэгт ажлаа хийж байгаа гэж харж байна.

Тэгээд би Б.Жаргалан гишүүнд бас Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль Үндсэн хуулийн процессын эрх зүй гэдэг хичээл заасан юм. Заасан юм. Тэгэхдээ заахдаа манай гишүүн маань харин би өөрөө яг ёс зүйн их том алдаа гаргаснаа өөрөө энд хүлээн зөвшөөрөх ёстой юм байна гэж бодлоо.

Тэр юу вэ гэхээр хичээлдээ суугаагүй хүнээр дүнгээ гуйлгаж тавиулсан юм. Би бол эндээ ёс зүйн болон бусад хариуцлагаа хүлээхэд бэлэн байна.

Миний хичээлийг сонсоогүй учраас энэ хүн энэ Үндсэн хуулийнхаа ойлголт, агуулгыг мэдэхгүй учраас ингэж хэл... /минут дуусав/

С.Бямбацогт: Тийм. Ийм асуудал ярихгүй шүү. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуудал ярина. Тийм.

Ажлын хэсгийн гишүүд бас хэлж байгаа үгэндээ бас бодолтой хэлээрэй. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой. Тийм. Ярина шүү. М.Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

М.Ганхүлэг: Нэлээн нухацтай хандах ёстой асуудал байгаа юм.

Хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг дэмжихгүй байгаа. Ажлын хэсгийн гишүүд маань бүр сүүлдээ Их Хурлын гишүүд рүү хамааралгүй асуудлаар дайрдаг ийм байдал руу орлоо.

Янз бүрийн хэлбэрээр хуулийг тайлбарладаг ийм байдал руу орлоо. Бид дотооддоо өөрсдөө асуудлаа шийдээд явах бүрэн боломжууд байгаа гэж харж байгаа.

Монгол Улс одоогоор парламентын засаглалтай хэвээрээ байгаа болов уу гэж би бодож байна. Энэ бүхний цаана тодорхой нухацтай авч үзэхээр ийм асуудлууд байна гэж ингэж харж байна. Тодорхой институт парламентын бүрэн эрхэд халдаж байгаа ийм өнгө аяс байж болзошгүй байгаа учраас энэ хуулийн төслийг би дэмжихгүй байгаа.

Мөн дээрээс нь бид бүхэн 1992 оноос хойш шинэ Үндсэн хуулиараа 9 удаагийн сонгуулиар давхардсан тоогоор нийтдээ 446 хүнийг сонгосон байгаа. Парламентад.

Энэ хугацаанд бид парламентын бүрэн эрх, Их Хурлын гишүүний бүрэн эрхтэй холбогдолтой асуудлыг хэрхэн авч үзэж байсан юм бэ гэдэг дээр би тодорхой мэдээллийг гишүүддээ өгье.

Огт энэ асуудлыг ярьж хэлэлцэхгүй ирсэн зүйл алга.

— 1992 онд Дашийн Бямбасүрэн,
— 2012 онд Ухнаагийн Хүрэлсүх,
— 2018 онд Дорждугарын Гантулга,
— 2020 онд Долгорсүрэнгийн Сумъяабазар,
— 2023 онд Жамьянгийн Мөнхбат, Хишгээгийн Нямбаатар
-гээд Их Хурлын гишүүд өөрийн хүсэлтээр Их Хурлын гишүүнийхээ ажлуудаа өгч байсан байна.

Монгол Улсын Ерөнхий прокурор Улсын Их Хурлын гишүүнээс түдгэлзэх саналыг 16 хүн дээр оруулж ирсэн байна.

— 2007 онд Гомбожавын Занданшатар, Түнжингийн Бадамжунай,
Ухнаагийн Хүрэлсүх,
— 2018 онд Дакейн Мурат, Дорждугарын Гантулга,
— 2018 онд Ж.Батжаргалын Батзориг,
— 2019 онд Батбаярын Ундармаа, Дорждамбын Дамба-Очир, Лувсангийн Энхболд, Гомбожайн Солтан
-нарыг хэлэлцүүлэн түдгэлзэх шаардлагагүй гэж үзэж байсан.

Харин 1999 онд Дамдинсүрэнгийн Энхбаатар, Дашжамцын Баттулга, Саригийн Батчулуун,

— 2020 онд Нямтайширын Номтойбаяр,
— 2023 онд Төмөрбаатарын Аюурсайхан, Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ

-нарыг Улсын Их Хурлаас түдгэлзүүлэх нь зүйтэй гэж Улсын Их Хурлаас шийдвэрлэж байсан.

Хуульгүй байдаг юм уу, зохицуулалтгүй биш ээ гэдгийг эндээс харж болно.

Шинэ Үндсэн хуулийн нэмэлтээр чөлөөлж, түдгэлзүүлж байсан тохиолдлууд байгаа нь харагдаж байгаа.

Их Хурлын гишүүн түдгэлзүүлэх саналыг Ерөнхий прокуророос 16 хүний асуудлыг орж ирсний 6 гишүүнийг нь түдгэлзүүлж байсан байна.

Нийтдээ 22 хүний бүрэн эрхтэй холбогдолтой асуудлыг ярьж байсан байна.

Тодорхой процесстой холбогдолтой, илүү сайжруулах асуудлууд байгаа юу гэвэл байгаа. Ялангуяа 3 шатын шүүхээр шийдвэрлэсэн асуудлуудыг шийдэх шаардлагууд бидэнд тулгарч байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг заавал ч үгүй Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн Тамгын газар гэлгүйгээр өөрсдөө ажлын хэсэг юмнуудаа байгуулаад, дотооддоо энэ асуудлаа яриад явах нь зөв юм гэсэн ийм байр суурьтай байгаа гэдгийг илэрхийлье.

Ардчилсан парламентаа хамгаалах тал дээр Ардчилсан намынхан маань идэвхтэй оролцоно гэдэгт би уриалж байна.

Мөн энэ 126 гишүүнтэй шинэ парламентын гишүүд цаашдаа олон зуун жил парламентын засаглалтай байхын төлөө энэ асуудал дээр нухацтай хандахыг уриалж байна. Асуудлаа өөрсдөө дотооддоо шийдье гэсэн ийм байр суурьтай байгаа.

С.Бямбацогт: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуулт асуусангүй. Санал хэллээ.

Ажлын хэсгийн гишүүдэд би хууль уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын тухай хуулийн 21.31-д “чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаанаар хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн ийм заалт байдаг шүү.

Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандахыг Та бүхнээс хүсье.

Мөн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 9.16-д “тайлбар хийж, асуултад хариулж байгаа албан тушаалтан үнэн зөв мэдээлэл өгөх, асуултад товч, тодорхой хариулах үүрэгтэй бөгөөд гишүүн асуултын

хариултыг хангалтгүй, эргэлзээтэй гэж үзвэл тухайн асуултын хариуг хоёр хоногийн дотор бичгээр өгөхийг шаардах эрхтэй.” гэж.

Тийм болохоор Та бүхэн бас энэ Улсын Их Хурлын тухай болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг бүгд анхааралдаа авч хэрэгжүүлье. Мөн Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандъя.

Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, П.Ганзориг нарын урилгаар ХҮН намын дэргэдэх ХҮН академийн төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхний ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг нийт Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс хүсэн ерөөе. /алга ташив/

Сархадын Зулпхар гишүүн асуултаа асууя.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд, ажлын хэсгийн гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Бид их чухал хууль хэлэлцэж байна. Энэ хууль бол жишээ нь эрх бүхий субъектээс өөрөө санаачилсан хууль. Цаана нь бидний ойлгосноор хууль санаачлах нийгмийн хэрэгцээ шаардлага байна. Цаашлаад улс төрийн тийм шаардлага ч байгаа гэдэг ийм тайлбарууд хийгдэж байна.

Шаардлага дандаа байдаг. Нийгмийн тодорхой харилцааг зохицуулж болохгүй, нэг бол бүрэн зохицуулж болохоо байх юм бид хуулийг шинээр санаачилж оруулж ирж болдог. Нэг бол хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болдог энэ л процесс явж байгаа.

Гэхдээ хууль тогтоох эрх мэдэл дан ганц Улсын Их Хуралд өөрт нь байгаа. Энэ үүднээс хуулийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх нь бидний шинэ эрх мэдэл. Хэлэлцэх явцдаа ч гэсэн үүнийг бүрэн боловсронгуй болгох эрх мэдэл нь бидэнд байгаа. Бидэнд гэдэг нь Улсын Их Хуралд байгаа гэж байгаа юм.

Нөгөөтээгүүр засгийн болон төрийн эрх мэдэл бол ард түмнээс эхтэй. Тэр ард түмнээс эхтэй учраас ард түмэн тодорхой асуудлыг зайлшгүй шийдэх ийм шаардлага байна гэсэн саналаа тодорхой институцээр дамжуулж илэрхийлж байгаа тэр хүрээнд нь бид хэлэлцээд явах боломж бий гэдгийг энд хэлье.

Би А.Бямбажаргал, О.Машбат нараас, ажлын хэсгийн гишүүдээс их тодорхой асуулт асууя.

▷ **Нэгдүгээрт**, Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм бий.
— 2021 онд баталсан. Одоо бид үүнийг хэрэглэж байгаа.

▷ **Хоёрдугаарт**, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль бол бий.

— Өөрөөр хэлбэл ёс зүйг бид хуульчилсан шүү дээ. 2023 онд.

Тэгэхээр эдгээр хуулиудаар зохицуулж болохгүй байгаа тодорхой харилцаануудыг илүү зохицуулах боломж олгож байна гэсэн зүйлийг Та бүхэн хэлж байна.

Тэгэхээр энэ хуулийг бид баталснаар ямар ахиц дэвшил гарах юм бэ гэдгийг Та бүхэн дахиж нэг тайлбарлаж хэлээч ээ гэж байгаа юм.

Бид тал талаасаа үүнийг зөв ойлгож, зөв ойлголт авч байж цаашаа явах ёстой.

Хоёр дахь зүйл. Бид байнга ярьж байгаа. Улсын Их Хурлын гишүүд хоёр төрлийн халдашгүй эрхтэй.

- Нэг нь, абсолют халдашгүй эрх.
- Нөгөөх нь, хязгаарлагдмал халдашгүй эрх.

Абсолют халдашгүй эрхээ бид энэ танхимд эдэлнэ. Хэлсэн үг илэрхийлсэн байр сууриныхаа төлөө тухайн үед болон дараа нь хуулийн болон бусад хариуцлага хүлээдэггүй. Ингэж байж парламентын засаглал өөрөө тогтдог. Парламентын ардчилал өөрөө бэхэждэг.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор энэ хууль, энэ эрхэд нь халдах нөхцөл байдлыг үүсгэх үү, үгүй юу гэдгийг тодорхой хариулаач гэж байгаа юм.

Та бүхэн үүгээр олон жил судалгаа хийсэн, нарийн ширийн зүйлийг нь мэддэг улсууд учраас зориуд үүнийг асууж байна.

Нөгөөтээгүүр бас нэг чухал зүйл байна. Парламентын засаглалын бас нэг шалгуур нь олон намын тогтолцоо, олон ургалч үзэл байгаа.

Тэгэхээр үүнтэй уялдсан байдлаар ард түмэн эрхээ шилжүүлдэг. Төлөөллийн байгууллага болгож.

Тэгэхээр энэ хуулийг бид баталснаар ард түмний бүрэн эрх, төрийн эрх мэдлийг барих бүрэн эрхэд ямар нэгэн байдлаар сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсэх үү гэдэг үүнийг Та бүхэн хариулаад өгөөч ээ гэж байгаа юм. Баярлалаа.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Ажлын хэсгээс. Ажлын хэсгийн гишүүн Отгонбаярын Машбат хариулъя. 4 дүгээр микрофон.

О.Машбат: Нэгдүгээрт, ямар давуу тал, ямар эерэг нөлөө үзүүлэх вэ гэдэг асуулт байна.

Ерөнхийдөө бидний зорьсон санаа бол Үндсэн хуулийн “imperative” тэр заалтад 29 дүгээр зүйл, 66.3, 66.4, тэгээд 67 дугаар зүйлд нийцүүлж байгаа юм. Нийцүүлэхийг санаачилж байгаа юм.

Шийдэх нь Их Хурлын бүрэн эрх шүү дээ. Нэгдүгээрт тэгж хариулья.

Хоёрдугаарт нь, Улсын Их Хурлын гишүүний болоод ард түмний мандатад нөлөөлөх үү гэж асууж байна. Тийм ээ. Их Хурлын гишүүний мандатад нөлөөлнө гэж би бодохгүй байгаа. Зохицуулалт нь.

Яагаад гэхээр ерөнхийдөө эцсийн шийдвэрийг Үндсэн хуульд зааснаар дандаа хөндлөнгийн этгээд гаргадаг. Тэр нь Үндсэн хуулийн цэц л дээ. Сая асууж байхад ярьж байсан. Их Хурал өөрөө олонхоороо шийдэхийн тухай гэж жаахан буруу ойлголттой байх шиг байна.

Их Хурал олонхоороо цэцэд энэ үндэслэл байна уу, үгүй юу гэдгийг шалгуулах тийм хүсэлтийг л батлах ёстой. Эцсийнх нь шийдвэрийг цэц гаргана.

Чухамдаа тийм учраас олонх, цөөнхийн нөхцөл байдалд олонх нь өөрсдөө хүч түрж асуудлыг шийдэх, цөөнхийн гишүүдээ асуудалд оруулах энэ тэр гэсэн тиймэрхүү зүйлүүдээс сэргийлэхийн тулд Үндсэн хуулийн 66.2.4 рүү асуудлыг шилжүүлээд, тэгээд түүгээр шийдэхээр ийм л санал байх юм. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Цэндийн Баатархүү гишүүн асуултаа асууя.

Тодруулга. Сархадын Зулпхар гишүүн нэмэлт асуулт.

С.Зулпхар: О.Машбат докторт баярлалаа.

Би хоёр дахь асуултынхаа хариултыг аваагүй байгаа. Нөгөө халдашгүй байдалд нь “immunity” шүү дээ.

Энд хэрхэн нөлөөлөх вэ? Энэ чинь зөвхөн тэр Их Хурлын гишүүний “immunity” биш шүү дээ.

Парламентын өөрийнх нь халдашгүй байдал. Энэ дээр яах вэ гэж. Яг үүнтэй уялдсан байдлаар бас нэг зүйлийг би тодруулья.

Тэр таны өгч байгаа хариулттай холбоотойгоор. Хууль дээдлэх зарчим бид үйлчлэх ёстой. Төрийн үйл ажиллагаанд. Тэр нь тодорхой ижил статустай төрийн албан хаагч. Улс төрийн байна уу, захиргааны байна уу хууль болон тодорхой дүрэм, журмын өмнө эрх тэгш байх ёстой.

Тэгэхээр энэ жагсаалтын гишүүд дээр тусдаа нэг ийм зохицуулалт ороод ирсэн. Энэ зарчмынхаа зөрчөөд байгаа нөхцөл байдал үүсэж байна гэдгийг гишүүд ихэнх нь яриад байна шүү дээ.

Энэ дээр Та бүхэн судлаачдын хувьд ямар байр суурьтай байна аа?

С.Бямбацогт: 4 номерын микрофон.

О.Машбат: Их Хурлын өөрийнх нь мандатад шууд нөлөөлөх үү гэдэг асуудал байна. Би энд нөлөөлөхгүй гэж ойлгоод байгаа юм.

Яагаад гэхээр энд Их Хурал нь өөрсдөө нөлөөлөх гээд байгаа биш, эсвэл олонход нь, эсвэл цөөнхөд нь энэ асуудлыг өгч байгаа биш. Үүнийг хууль зүйн хувьд шийдэх бүрэн эрхтэй. Цэгц рүү асуудлыг өгч байгаа.

Ерөнхийдөө ардчилал дээр онол ярьсан болох болов уу. Ардчилал болоод хуулийн мэргэжлийн асуудал гэдэг энэ хоёрыг баланслах асуудал үндсэндээ яг Үндсэн хууль дээр тулгуурладаг шүү дээ. Тийм ээ.

Тэгээд ерөнхийдөө working гэх мэтчилгээр хүмүүс юу гэж байгаа вэ гэхээр ардчилал нь шийдэх ёстой. Парламент шийдэх ёстой. Гэхдээ тэр нь бол шүүхийн хяналтаас гадуур байж болохгүй гэдэг.

Чухамдаа тэр шүүхийн хяналт нь бол, Үндсэн хуулийн шүүхийн механизм бол Үндсэн хуулийн цэц байгаа.

Олонхоороо асуудлаараа шийднэ. Ардчилал нь байна. Гэхдээ тэр нь ямар нэгэн байдлаар гомдол гарвал, эсвэл эргэлзээ үүсвэл... /минут дуусав/

С.Бямбацогт: Сархадын Зулпхар гишүүн дахин нэмэлт 1 минут тодруулъя.

С.Зулпхар: Бид ингээд яг тал талаасаа яриад явж байгаа нь их сайн байна.

Энэ асуудал өөрөө их тийм нарийн судалж байж, тодорхой болгож байж шийдвэр гаргахгүй бол болохгүй тийм эргэлзээ төрүүлнэ.

Гэхдээ Та бүхний санаачилсан хууль дотор бол хоёр тодорхой асуудлыг бол бид шууд цааш нь аваад явах юм байна гэж ойлгож байгаа шүү дээ.

Тэр шүүхийн шийдвэр гарсан нөхцөл байдал болон хуралдаандаа ирэхгүй байгаатай холбоотой энэ улсуудад ногдуулах сахилга хариуцлагын асуудал. Энэ бол маш тодорхой.

Бусад хоёр зүйлтэй холбоотой бол бид нарийн ярих ёстой. Энэ ёс зүйн асуудал чинь өөрөө нарийн ярихаас гадна их тодорхой байж байж хууль болохгүй бол маргааш, нөгөөдөр нь хууль хэрэгжээд эхэлсэн чинь саяын нөхцөл байдлууд гарах вий л гэж байгаа юм.

Хууль дээдлэх зарчмаа зөрчсөн байж болохгүй.

Хоёрдугаарт, бидний гол зүйл Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын гишүүдийн абсолют халдашгүй байдал нь шүү. Би тэр хязгаарлагдмал халдашгүй байдлыг яриагүй. Иймд нөлөөлөх ёсгүй талаас нь бид ажиллах ёстой юм байна л гэж бодож байна.

С.Бямбацогт: Үг хэллээ. Цэндийн Баатархүү гишүүн асуултаа асууя. Алга байна.

Ганбатын Очирбат гишүүн асуулт асууна.

Г.Очирбат: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Би хуульч гишүүн биш. Энэ хуулийн төслийг Төрийн байгуулалтын Байнгын хороон дээр орж ирснээс нь хойш олон талын мэтгэлцээнүүдийг харлаа.

Тэгээд манай хуульч гишүүд ч гэсэн үзэл санаагаа нээлттэй илэрхийлж, мэтгэлцэж байна гэж харж байгаа.

Зүгээр ингээд хараад байхад хувь гишүүний бодол бол энэ их тийм явцуу, хэн нэгэн хүн рүү дайрсан, ялангуяа эмэгтэй хүмүүс рүү дайрсан ийм хуулийн төсөл орж ирж байгаа юм шүү. Одоо манай М.Нарантуяа-Нараа гишүүн, Ц.Мөнхтуяа гишүүн, Х.Баасанжаргал гишүүнийг хүртэл тэр хамаатан садантайгаа уулзахад гээд л ингэсэн. Х.Булгантуяа гишүүнийг гээд л.

Тэгээд энэ үндэслэл дээрээс наадах чинь орж ирж байгаа шүү дээ. Орж ирсэн шүү дээ.

Тэгээд одоо яах гэж байгаа юм. Энэ 126 гэдэг чинь бид чинь бас нэг ангийнхан. Иргэдээс өгсөн сонголтынхоо 4 жилийнхээ бүрэн эрхийг хамтдаа дуусгах ёстой. Анги дотор хэл амтай хүүхэд байдаг. Ууртай уцаартай хүүхэд байдаг. Муу сурдаг хүүхэд байдаг. Хичээлээ тасалдаг хүүхэд байдаг. Анги тэгээд л цуг төгсдөг шүү дээ.

Их Хурлын дарга аа, С.Бямбацогт дарга аа, Та парламентын засаглалаа хамгаалах хамгийн гол үүрэгтэй хүн. Бид танд тэгж итгэл найдвар өгсөн. Энэ дээр Та өөрийнхөө тодорхой байр суурийг илэрхийлээрэй.

Бид нар зүгээр байж байхад ангийнхаа охидуудыг зодуулаад байж чадахгүй шүү. Хэн ч байсан хамаагүй. Тэгээд л эмэгтэй гишүүд юм ярихаар л түрүүн багш байснаараа таны үгийг, таны лекцэд суугаагүй алдсанаараа одоо Их Хурлын гишүүнийг Та энд цоллоод сууж болохгүй байх. Энэ арай дэндэж байна. Таны хичээлд суух хүнгүй болох гэж байна шүү дээ. Яг энэ байдлаараа бол. Ингэж болохгүй шүү дээ.

Танд итгэдэг олон залуучууд байгаа, олон хуульч нар байгаа. Тэр олон хүмүүсийн итгэл, хүсэл мөрөөдөл, хувилж болох юмыг нь Та түрүүн ганцхан өгүүлбэрээр гишгээд хаялаа шүү дээ.

Тэгэхээр нэг юм хэлье. Энэ 126 гишүүнтэй парламент ялангуяа эрчүүд нь ангийнхаа хэдэн охидуудыг хамгаалж чадах байх гэж найдаж байгаа шүү.

Асуултдаа орьё. Гурван асуулт байна. “Ёс зүйн ноцтой зөрчил” гэдэг үгийг оруулж ирсэн.

“Ёс зүйн зөрчил” гэж юу юм, “ноцтой зөрчил” гэж юу юм бэ гэдгээ хуулийн төсөл дээрээ дагуулаад оруулаад ирэхгүй яасан юм бэ?

Тэгээд Их Хурал руу аваачиж орж ирээд нэг их сайхан мэтгэлцээн болгох гээд тараагаад талыг нь нэг цацдаг. Тийм л шударга юм оруулж ирэх гээд байгаа юм бол үүнийгээ давхар оруулаад ирэхгүй яасан юм. Эхний асуудал.

Хоёр дахь асуудал. Хуулийн төсөлд энэ Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах асуудлаар Улсын Их Хурал авч хэлэлцээд үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлт илгээх тухай заалт оруулж ирж байгаа юм байна. Энэ чинь өөрөө Үндсэн хуулийн 66.2.4-д заасан иргэн хүн өргөдөл, өргөдөл мэдээллээр шууд Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсэх эрхтэй. Энэ зүйл, заалттай зөрчилдөөд байгаа юм биш үү. Энэ дээр юу гэж бодож байгаа юм. Манай энэ хуулийн цэц өргөн барьж байгаа хүмүүс.

Мөн дээрээс нь Улсын Их Хурал нь иргэдээс өргөдөл, гомдол гаргахыг хүлээхгүйгээр өөрөө хүсэлт гаргаад Үндсэн хуулийн цэцэд хүргүүлэх. Энэ Үндсэн хуулийн боломжийг хязгаарлаад байгаа юм биш үү. Энэ дээр ямар тайлбар байна?

Хамгийн сүүлийнх нь. Тэр Байнгын хорооны мэтгэлцээгүйг хараад сууж байхад Монгол Ардын намын Бага хурлын гишүүн, дээрээс нь энэ удирдах зөвлөлд нь байдаг нөхдүүд байх шиг байна лээ.

Тан нар тэгээд яг ийм хуулийн төсөл оруулж ирэх байсан бол Ардын намын бүлэг рүү оруулаад л Их Хурлын дэгийн тухай хуулийг өөрчлөөд л болохоор л байсан шүү дээ.

— Чуулганы хуралдааны 30-аас дээш хувь ирээгүй бол.

— Санал хураалтад 30-аас дээш хувь биечлэн оролцоогүй бол гээд.

Энэ чинь дэгтэй л холбоотой асуудал шүү дээ. 1 минутаа нэмье.

С.Бямбацогт: Г.Очирбат гишүүнд нэмэлт 1 минут.

Г.Очирбат: Тэгээд Монгол Ардын намын Удирдах зөвлөлд байдаг Бага хурлын гишүүд нь Ардын намынхаа бүлгээр дамжуулаад Их Хурлын дэгийн тухай хуулийг өөрчлөөд болохоор л заалтууд байгаа шүү дээ.

Тэгээд ер нь Их Хурлын дарга аа, энэ 126 Их Хурлын гишүүд ээ, бид ер нь дараа дараагийн сонгуулийн үр дүнгээр дараагийн парламент бүрэлдэхэд Их Хурлын дэгийн тухай хуулиа өөрсдөө хамгийн түрүүнд батлах ёстой юм байна лээ шүү. Одоо бид урьдын батлаад өгсөн Дэгийн тухай хуулиар яваад байдаг.

Тэгэхээр дэгийн тухай хуулийг би Тамгын газар луу явж байгаа гэж харж байгаа шүү дээ.

Улсын Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хууль, Хяналт шалгалтын тухай хууль.

Тэгэхээр эхлээд үүнийг баталж байж явах ёстой юм билээ. Хэрвээ үүнийг баталсан байсан бол өнөөдөр ийм хэрүүл маргаан гарахгүй байсан. Бие бие рүүгээ чиглэсэн, Их Хурлын эмэгтэй гишүүдээ намнах гэсэн, хамгаалах хайрлах хүнгүй юм шиг ийм нэг сонин байдалтай орж ирж байна гэдгийг би энэ мэтгэлцээнүүдээс, хэлэлцүүлгүүдээс хараад байгаа шүү.

Тэгээд асуултдаа хариулаад авъя. Тэгээд тодруулъя.

С.Бямбацогт: Ангийн дарга шиг ангийн дарга байхын төлөө хичээнэ. Анги хамт олноо тэргүүний анги болгохын тулд зүтгэнэ. Тийм. 9 дэх удаагийн парламент, 15 дахь удаагийн ангийн дарга хийж байна.

Тийм болохоор ангиа бас нэг анги шиг байлгах, эв нэгдэлтэй, бие биеэ гэсэн сэтгэлтэй, ард түмэндээ хүндлэгдсэн, сахилга баттай, ёс зүйтэй, хариуцлагатай, алдаа дутагдал гарах юм бол дотроо асуудлаа шийддэг ийм анги байлгахын төлөө анхаарч ажиллана.

Энэ ч үүднээсээ Их Хурлын даргаар томилогдоод хамгийн анхны шийдэж байгаа асуудал бол парламентын 5 намтайгаа зөвшилцөөд Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг нэлээн эрчимтэй эхлүүлсэн байгаа.

Энэ ажил дээр Улсын Их Хурлын 126 гишүүнд албан ёсоор бичиг явуулсан.

- Явал энэ парламентаа парламент шиг болгох вэ,
- парламентынхаа нэр хүндийг яаж сэргээх вэ,
- төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллагадаа ард түмний итгэдэг итгэлийг яаж сэргээх вэ.

Ингэж байж төрд итгэх ард түмний итгэл сэргэнэ.

Үүнтэй холбоотой ямар засах, залруулах, сайжруулах, Улсын Их Хурлынхаа гишүүдийг сахилга баттай, хариуцлагатай, ёс зүйтэй, ард түмэндээ хүндлэгдсэн Их Хурлын гишүүд болгоход ямар асуудлууд шийдэх ёстой байна. Энэ дээр тодорхой саналууд өгөөч гэж бичиг явуулсан байгаа.

Г.Очирбат гишүүн ээ. Энэ дээр Та саналаа сайхан бичээд өгөөрэй. Зөвлөхөд чинь үүрэг өгсөн байгаа аж. Туслахад чинь бас үүрэг өгсөн байгаа. Зөвлөх, туслахуудаа ажиллуулаарай.

Улсын Их Хурлын Тамгын газраас цалин авдаг бүх хүмүүс энэ дээр санал өгөх чиглэлээ өгсөн байгаа.

Ингээд энэ бүгдийгээ бид энэ долоо хоногтоо нэгтгээд ирэх долоо хоногоос үндсэндээ Улсын Их Хурлын тухай болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиудыг сайжруулаад, парламентаа бас нэг парламент шиг болгохын төлөө, ангиа нэг анги шиг болгохын төлөө анхаарч байгаа шүү гэдгээ хэлье.

Ингээд ажлын хэсэг. Алтангэрэлийн Бямбажаргал хариулъя. 4 дүгээр микрофон.

А.Бямбажаргал: Баярлалаа. Г.Очирбат гишүүний асуултад хариулъя.

Юун түрүүн Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлд Үндсэн хуулийн цэцэд хэн хандаж болох юм бэ гэдэг харилцааг зохицуулсан байдаг. Хэн хандаж болох.

Иргэний “өргөдөл”, “мэдээлэл”-ээр буюу өөрийн санаачилгаар, мөн нэр бүхий байгууллага, албан тушаалтнууд “хүсэлт” гаргах боломжтойгоор заасан. Өөрөөр хэлбэл хэн хандах юм, ямар хэлбэрээр хандах юм гэж.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж “хүсэлт” гаргадаг нэг субъект өөрөө Улсын Их Хурал. Өөрөөр хэлбэл “өргөдөл”, “гомдол” чинь—

- ▶ ёс зүйн ноцтой зөрчил гаргасан эсэх асуудал,
- ▶ тангаргаасаа няцсан эсэх асуудал,
- ▶ хуралдаандаа оролцон, төлөөлөх чиг үүргээ хэрэгжүүлсэн эсэх асуудал,
- ▶ хууль тогтоох чиг үүргээ хэрэгжүүлсэн эсэх асуудал

-гэдэг энэ зүйлүүдээр энэ нь зөрчигдсөн байна гэж үзэх юм бол иргэн дэд хороондоо хандаад, дэд хороо нь асуудлаа урьдчилан хянан үзээд. Энэ чинь бүх асуудлыг хэлэлцэхгүй.

Урьдчилан хянаж үзээд, дэд хороо хуралдаад олонхоороо чуулгандаа уг асуудлаараа оруулаад нээлттэй санал хураалтаар. Үндсэн нэг ийм нээлттэй гэдэг ийм хоёр зарчим бариад байгаа юм.

Улсын Их Хурал уг асуудлаар ардчилсан зарчмынхаа дагуу парламент өөрөө хэлэлцээд, Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах уу, үгүй юу гэдэг асуудлыг шийдэж байгаа.

“Хүсэлт” гарвал Улсын Их Хурлын хүсэлтийг нь Үндсэн хуулийн цэцэд, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжоор шууд маргаан үүсгэж шийдвэрлэдэг. Шууд маргаан үүсгэж шийдвэрлэдэг.

Тийм учраас иргэний энэ Үндсэн хуулийн цэцэд “өргөдөл, мэдээлэл” гаргах энэ бүрэн эрх хэвээр хадгалагдаж байгаа. Өөрөөр хэлбэл зөрчилдөөгүй гэж нэгдүгээр асуултын хувьд.

Хоёрдугаарт, яагаад үүнийг ноцтой зөрчил гэдгийг бичиж оруулж ирээгүй юм бэ гэдэг зүйл байгаа. Энэ бол өөрөө Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх байгаа юм.

Өөрийнхөө асуудлыг өөрөө тогтоох бүрэн эрх. Дэгээ өөрөө тогтоох. Нөгөө хууль тогтоох хүрээ хязгаарын гэдэг энэ асуудлын хүрээнд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, дэгтэй холбоотой асуудал учраас үүнийг нь дагалдах тогтоолоор үүнийгээ шинэчлээч ээ гэдэг ийм агуулгаар хуулийн төсөлд бас тусгагдсан байгаа гэдгийг би Танд хэлэхийг хүсэж байна.

Мэдээж хэрэг Улсын Их Хурлын гишүүний мандаттай холбоотой асуудлын цаана мэдээж Улсын Их Хурлын дархлааны асуудал энд байна шүү дээ.

Тэгээд үүнээс үүдэлтэйгээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилж байгаа хуулийн утга агуулга бол Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 3-ын энэ дэг журам, 66 дугаар зүйлийн дэг журмыг л хэрэгжүүлэх энэ утга агуулгаар энэ зүйлүүдийг 2019 онд тухайлбал 29.3-ыг бичихдээ үүрэг болгосон хэм хэмжээгээр, заавал биелэгдэх хэм хэмжээгээр бичсэн юм билээ.

1992 онд бас мөн адил “императив” хэм хэмжээ гэж бид бүхэн үүнийг нэрлэдэг. Үүрэг болгосон ийм хэм хэмжээ байдлаар бичсэн учраас дээрх процессыг тодруулж байгаа юм. Процедур юм даа. Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой асуудал учраас.

С.Бямбацогт: Нийслэлийн ерөнхий боловсролын 84 дүгээр сургуулийн 7.2 ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Хүүхдүүддээ сурлагын өндөр амжилт хүсье. /алга ташив/

“А”, “Б” гэхээ больсон юм байна. Тийм ээ. Онц сураарай.

Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуултаа асууя.

Д.Үүрийнтуяа: Юуны өмнө яг асуулт дээр маань таарч орж ирсэн дүү нартаа сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт хүсье.

Хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудал дээр гишүүд олон талын байр суурь илэрхийлж, мэтгэлцэж байгаа нь энэ өөрөө парламентын зарчим. Олон талаас нь ярих нь ч зүйтэй гэж харж байгаа. Мэдээж энд асуудал байна гэж харж байгаа зүйл, заалтууд нэмэх, хасах, өөрчлөх зүйлүүд байж болно.

Ажлын хэсгийн хүрээнд бид үүнийгээ шийдэх бүрэн эрх нь парламентад өөрт нь байж байгаа.

Ер нь харин Улсын Их Хурлын гишүүдийн энэ хариуцлага–

- ажилдаа цагтаа ирдэг байх,
- чуулгандаа суудаг байх,
- ард түмнийг төлөөлөх үүргээ хэрэгжүүлдэг байх,
- хэлж байгаа үг, үйлдэл ёс зүйтэй байх–

-асуудал бол зайлшгүй тавих ёстой юу гэвэл тавих ёстой. Энэ зарчмыг дэмжиж байгаа.

Өнөөдөр бид парламентын дархлааны асуудлыг ярьж байна л даа.

Улсын Их Хурлын гишүүд дархлаатай байх ёстой гэж ярихаас илүү Улсын Их Хурлын гишүүд парламент өөрөө ард түмэндээ хүлээн зөвшөөрөгдөж, ард түмэндээ ёс зүйтэй, хариуцлагатай байгаа байдлаараа хүлээн зөвшөөрөгдөж байж энэ дархлааг бид биш, ард түмэн энэ парламентын дархлааг бий болгох байх гэж харж байгаа.

Тийм учраас бид ёс зүйн асуудлыг, хариуцлагын асуудлыг гишүүд маань өөрсдөөсөө эхлээсэй гэж би бодож байгаа юм.

Өнөөдөр Л.Мөнхбаатар дарга хэллээ. Үнэн шүү дээ.

Манай бүлэг дээр, Л.Мөнхбаатар даргыг бүлгийн дарга байхад–

- ажилдаа цагтаа ирж байна уу,
- хуралдаа цагтаа сууж байна уу,
- санал хураалтад оролцож байна уу,
- тойрог дээрээ ажиллаж байна уу

-энэ бүхнээр нь үнэлээд өгье гэхэд дэмжээгүй шүү дээ, бид.

Өөрсдөөсөө бол ер нь “ёс зүй” хариуцлагыг ярих их дургүй юм байна гэж би харж байгаа. Манай гишүүд. Бусдаас бид нэхэж чадаад байгаа.

Тийм учраас хариуцлагын тогтолцоо байх ёстой гэдэг дээр би олон гишүүдийг санал нэгдэж байгаа байх гэж бодож байна. Харин ажлын хэсгийн зүгээс гишүүдийн эргэлзээ төрүүлж байгаа, анхаарал татаж байгаа асуудлууд дээр яг тодорхой хариултуудыг зүй ёсоор өгмөөр байгаа юм.

Тэгээд хоёр асуулт байна.

▷ **Нэгдүгээрт, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах асуудал дээр.**

Өнөөдөр хууль эрх зүйн хувьд хүчин төгөлдөр мөрдөж байгаа зохицуулалтууд бий.

Энэхүү хуулиар яг энэ зохицуулалтын ямар асуудал нь орхигдсон байна гээд оруулж байгаа юм бэ? Түрүүн гишүүд асууж байсан. Процессын асуудал нь байгаад байна уу? Яг ямар асуудал нь орхигдсон гэж оруулж байгаа ялгаа нь юу вэ? Онцлог нь юу вэ?

Өнөөдөр яагаад Үндсэн хуулиар олгогдсон, Үндсэн хуулиар заасан байгаа эгүүлэн татах тухай асуудал дээр нь бид хэрэгжүүлж чадахгүй байгаа гол шалтгааныг хууль санаачлагчийн зүгээс юу гэж харж байгаа вэ гэдгийг тодруулъя.

▷ **Хоёрдугаарт, Үндсэн хууль зөрчсөн асуудал дээр.**

Ёс зүйн асуудлыг парламент дотроо яриад Ёс зүй, дэгийн хороогоороо яриад, парламентдаа яриад ингээд шийдэх юм байна гэж.

Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлыг Үндсэн хуулийн цэцэд хандвал цэц эцсийн шийдвэр гаргах гээд байна гэдэг ийм болгоомжлол, ийм байгаагүй гэдэг ийм зүйлийг яриад байна л даа. Энд өөрчлөлт орлоо гээд гишүүд яриад байна.

Тэгэхээр үнэхээр Үндсэн хуулийн зөрчил үүсгэх асуудал байгаа юм уу, үгүй юм уу? Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх юм бол парламент ямар ч шийдвэр гаргахгүй Үндсэн хуулийн цэцээр эцсийн шийдвэр гарах гээд байна гэдэг энэ болгоомжлол нь өнөөдөр хэрэгжиж байгаа юм уу, эсвэл энэ хуульд шинэ үзэл санаа болж орж ирсэн юм уу гэдэг дээр хариулт авъя.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Ажлын хэсгээс. Отгонбаярын Машбат. Ажлын хэсгийн гишүүн. 4 номерын микрофон.

О.Машбат: Гол шалтгаан нь юу юм бэ гээд. Одоо байгаа механизмаас юугаараа ялгаатай юм бэ гээд нэгдүгээр асуулт.

Одоо байгаа механизмаас юугаараа ялгаатай юм бэ гэхээр цэц жишээ нь дүгнэлт гаргавал, эсвэл шүүх эцсийн шийдвэрийг гаргасан байхад тэрийг заавал Их Хурлаар хэлэлцэх эрхтэй болоод байгаа юм.

Гэтэл 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр чинь юу гээд тавьсан байгаа вэ гэхээр үүнийг Их Хурал эгүүлэн татна гээд императив болчихоод байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл цэцийн шийдвэр шүүхийн шийдвэрийг Их Хурал уг нь дахин хэлэлцэх эрхгүй байгаа юм.

Тэр нь болохоор 66.3 дээр байдаг байх аа. Тийм ээ. Тэгээд тавьсан байгаа.

Тэгэхээр үүнтэй нийцүүлж байгаа л санаатай юм. Бусад бүх асуудлууд нь, жишээ нь—

- ▶ ёс зүйн хэмжээ ямар байх ёстой юм,
- ▶ ёс зүйн хэмжээ гэж юуг хэлэх юм,
- ▶ ноцтой гэж юуг хэлэх юм,
- ▶ олон давтагдсан гэж юуг хэлэх юм—

-гэдэг нь тэртээ тэргүй угаасаа Их Хурлын өөрийнх нь шийдэх ёстой асуудал.

Тэд нарыг бид жишээ нь оруулж болохгүй. Яагаад гэхээр зэрэг энэ чинь өөрөө Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой асуудал. Үүнийг Ерөнхийлөгч өөрөө оруулах юм бол энэ ёстой жинхэнээсээ Үндсэн хуульд зөрчил болох гээд байгаа юм.

Хоёрдугаарт нь, юу нь өөрчлөгдсөн юм бэ, 2019 оноос хойш гэсэн асуулт байгаа юм.

Юу нь өөрчлөгдсөн юм бэ гэхээр 29.3 дээр “Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хууль зөрчсөн нь эгүүлэн татах үндэслэл болно.” гэсэн үг нэмэгдсэн чинь 66.2.3 дээр Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай цэц дүгнэлт гаргана гэсэн энэ дүгнэлт чинь өөрөө Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл болоод байгаа юм.

Өмнө нь тийм байгаагүй. 2019 онд. Өмнө нь тийм байгаагүй учраас 7 удаа энэ асуудлыг хэлэлцээд бараг талд нь байх “Их Хурлын гишүүн Үндсэн хууль зөрчсөн байна” гэсэн дүгнэлт гаргасан юм билээ. С.Зориг, Д.Төрмандах, Ц.Нямдорж гээд.

Тэгсэн тэд нарыг хэчнээн гаргасан ч гэсэн тэд нарыг эгүүлэн татах үндэслэл болдоггүй байсан байгаа байхгүй юу. 2019 оноос өмнө. Тэгсэн чинь 2019 оноос хойш 29.3-д тэр өгүүлбэрийг нэмснээр эгүүлэн татах үндэслэл болчихоод байгаа.

Тэгэхээр тэрийг нь зохицуулах хэрэгтэй болчихоод байгаа юм.

Тэгээд дээрээс нь эргүүлэн татах татахдаа бүр Их Хурал дахин хэлэлцэх эрхгүй болчихоод байгаа байхгүй юу. 66.3 дээр.

Тэгээд ийм болохоор зэрэг энэ дээр нэг жаахан зохицуулалтууд хийх хэрэгтэй юм байна гэсэн ийм л санал байгаа юм. Баярлалаа.

С.Бямбацогт: Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн нэмэлт асуулт.

Д.Үүрийнтуяа: Тэгэхээр яг л энэ асуудал дээр хамгийн их эргэлзээ төрөөд хүмүүс, одоо ялангуяа манай Улсын Их Хурлын гишүүд эргэлзээд байгаа юм л даа. Бас асуултууд дээр ч гарч байгааг Та бүхэн анзаарч байгаа байх.

Тэгэхээр Үндсэн хуулиар зааж орж ирсэн энэ заалтуудыг процессын хуулиудаараа илүү тодорхой болгож байгаа гэдэг зүйлээ илүү их сайн ойлгуулах, тайлбарлах энэ гаргалгаа нь, хэрвээ буруу томъёологдсон бол энэ асуудлыг ярих ёстой байх гэж бодож байгаа.

Өнөөдөр Улсын Их Хурлын гишүүд ард түмнээс сонгогдсон ард түмний төлөөлөл. Бид 50, 60 мянган сонгогчдын санал авч орж ирсэн. Ард түмний үгийг энд бид хүргэх, төлөөлөх үүрэгтэй. Ард түмэн энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Улсын Их Хурлын гишүүдийн ёс зүйн асуудлыг, хариуцлагын асуудлыг ярьдаг байгаасай гэж хүсэж байгаа.

Тийм учраас миний хувьд энэ хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг нь дэмжээд цааш нь ажлын хэсэг хэлэлцүүлгийн явцад парламентын мэтгэлцээнийхээ зарчмаар асуудлуудаа ярих нь зүйтэй байх гэж бодож байгаа гэдэг саналаа хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Загджавын Мэндсайханы урилгаар Ховд аймгийн иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхнийхээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Баярлалаа. /алга ташив/

Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: “Түшмэд намайг яаж үздэг хамаагүй ээ, түмэн намайг яаж үздэг хамаатай.” гэж хэлсэн байдаг. Зүгээр ч нэг хэлсэн үг биш ээ. Бямбын Ринчен гуай.

Энэ өргөн барьсан хуулиар түшмэд буюу цэцийн 9 гишүүн шийдэх юм байна. Намын удирдлагад байгаа хүмүүс жагсаалтаар сонгогдсон гишүүдийн ёс зүйн асуудлаар татагдах эсэхийг шийдэх юм байна.

Энэ асуудлыг би Байнгын хороон дээр асуусан. Яагаад жагсаалтын гишүүдийг онцгойлж ёс зүйтэй байх ёстой гэдгийг тусгайлж заагаад байгаа юм бэ гэдгийг.

Миний хувьд Улсын Их Хурлын гишүүн бүр тойргоос сонгогдсон байна уу, жагсаалтаар сонгогдсон байна уу үл хамаарч адил ёс зүйтэй байх ёстой.

Намын мөрийн хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийн даргаар би ажилласан. 2024-2026 онд бид ялалт байгуулсан.

Энэ намынхаа мөрийн хөтөлбөр дээр 4.3.1 дээр сонгогчдын саналаар эгүүлэн татах эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэдэг ийм заалтыг оруулж байсан юм. Мэдээж гишүүд сахилга баттай, хариуцлагатай байх ёстой.

Тэгээд энэ өргөн барьсан хуультай холбоотой яг чуулганыхаа 30 хувьд нь заавал суусан байх ёстой, 30 хувьд нь саналаа өгсөн байх ёстой гэдэг энэ агуулгатай нь би санал нэг.

Ийм ч учраас тэр жагсаалтын гишүүдийг эгүүлэн татах гэсэн энэ хэтэрхий дөвийлгөсөн энэ заалтыг хэлэлцүүлгийн явцад засаж болох юм гэдэг үндсэн дээр бүлгийн дэд даргын хувьд бүлгийнхээ энэ шийдвэрийг дагаж дэмжиж явсан.

Өнгөрсөн намрын чуулганы хуралдааныг аваад үзэх юм бол бид 36 удаагийн чуулганы хуралдаан чуулсан. 30 хувьд нь гэх юм бол 26 чуулгад зайлшгүй оролцсон байх ёстой. Тийм ээ. 70 хувьд нь гэдэг чинь 36, 26.

26 удаагаас доош оролцсон гишүүд нийт энэ 126-аас 34 гишүүн 70-аас доош хувьд нь оролцсон байна. Энэ статистикаар.

Хамгийн сайн оролцсон, хамгийн муу оролцсон. Хамгийн муу оролцсон хүмүүс 36-аас 8-хан удаагийн чуулганд нь суусан 2 хүн байгаа. Би нэрийг нь нэрлээд яах вэ. 36 чуулганы 36-д нь суусан 3-хан хүн байгаа. Нэг нь Ц.Сандаг-Очир.

Гэхдээ 4 удаа хоцорсон. 4 удаагийн чуулганд. Энхбаярын Батшугар 9 удаагийн чуулганд хоцорсон. Мөн түүнчлэн Аюушийн Ариунзаяа. Би нэг ч удаа хоцроогүй.

Бид хариуцлагаа нэмэгдүүлэх ёстой юу нэмэгдүүлэх ёстой.

Герман жишээлбэл саналаа өгөөгүй бол 200 еврогоор торгодог. Хэн ч эгүүлэн татдаггүй. Энэ юунаас болж эгүүлэн татах вэ, юунаас болж зүгээр улс

төрийн дэмжлэг тухайн үедээ үзүүлэхгүй, бүлгээсээ гаргах, бүлгийн өмнөөс улс төрийн мэдэгдлийг хийх, Байнгын хороодод харьяалах гэх зэрэг дотоод үйл ажиллагаагаараа гишүүдийн сахилга хариуцлагаа ярьдаг болохоос биш ёст зүйгээс нь хамаарч эгүүлэн татдаггүй юм.

Манай үндсэн дүрмээр намын үндсэн дүрэм хүн болгонд нээлттэй байгаа. Бүх намуудын хөтөлбөрүүд нь нээлттэй байгаа.

Ер нь нам ёс зүйн ноцтой зөрчил гэж юуг үзэх вэ гэдгийг Та бүхэн маань анзаарч хараарай.

Би багшлаад байгаа хүмүүсээс бас нэг юм асуух гэсэн юм. Одоогийн байгаа Улсын Их Хурлын тухай хуулиар гишүүнд хориотой зүйл, 44 дүгээр зүйлд бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Байнгын, дэд, Хянан шалгах түр хорооны болон нэгдсэн хуралдаанд, эсвэл хуралдаанаас гадуур бусдыг гүтгэж доромжилж болохгүй гээд хориглосон хуулийн заалт байгаа.

Хэн нэгэн хүн гүтгэж доромжиллоо. Процесс нь яг юу байх вэ гэдгийг би үнэхээрийн хуульч биш учраас ойлгохгүй байна. А.Бямбажаргал багшийг яг яах ёстой вэ? Яавал... /минут дуусав/

С.Бямбацогт: Алтанхуягийн Үйлстөгөлдөр. Ажлын хэсгийн гишүүн хариулъя.

А.Үйлстөгөлдөр: Байнгын хорооны хуралдаанд А.Ариунзаяа гишүүнтэй яг энэ сэдвээр бүрэн хариулт өгч амжаагүй. Бид хоёр энэ талаар ярилцсан.

Юуны түрүүнд А.Ариунзаяа гишүүнд яг ийм чухал хамгийн их хүний сонирхож байгаа, дээрээс нь эргэлзээтэй үнэхээр ямар заалт юм бэ, үүний цаана юу агуулагдаж байна вэ гэдэг эргэлзээг тайлах гэж асуулт асууж байгаад баярлалаа.

А.Ариунзаяа гишүүн маань ер нь Их Хурлын гишүүд дотроо ирцийн асуудал дээр ч тэр, оролцоо хангаж байгаа асуудал дээр ч тэр, маш олон асуудал дээр дуу оролцоо сайтай. Ер нь гүйцэтгэл их сайтай гишүүн гэж би таныг үнэлдэг шүү гэдгийг давхар хэлмээр байна.

Тэгээд энэ дунд бид хоёрын ярьсан зүйлийг тодруулж ярьж байна л даа.

Энэ нэг ийм юм болсон юм. Энэ 2 дугаар заалт дээр одоо энэ жагсаалтын гишүүнийг тусад нь аваад үзсэн. Үүнийг намаас зөвхөн татах гээд үүнийг ингээд зохион байгуулалттайгаар бодоод сэтгээд хийсэн юм шиг харагдаад байх шиг байгаа юм.

Үүнийг яагаад тусад нь салгасан бэ гэдэг асуудал байгаа юм.

Энэ болохоор өмнө нь би нэг тодорхой бүрэн дурдаж чадаагүй байж магадгүй. Сонгуулийн холимог тогтолцоо, мажоритар тогтолцоо хоёрыг хамтад нь хольж болохгүй байгаа асуудал болоод байгаа байхгүй юу. Жишээ нь, тойргоос сонгогдсон гишүүн болохоор мандат нь өөрт нь хадгалагдаж байдаг. Яагаад гэхээр иргэд түүнд саналаа өгсөн байхгүй юу.

Жагсаалтаар сонгогдсон гишүүнд бид сонгуулиар нөгөө намыг дугуйлж саналаа өгсөн учраас мандат нь намд хадгалагдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр одоо нэг маш том жишээ би дурдаж, нэг сонирхолтой жишээ гэж хэлж болох юм. Хэрэв тухайн гишүүн намаа соливол яах вэ. Мандат нь өөрт нь хадгалагдах биш намд хадгалагдаж байгаа гэсэн ийм маргаан үүсэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр намыг хариуцлагажуулах ёстой юм байна. Намд хариуцлага өгөх ёстой юм байна гээд түрүүн О.Номинчимэг гишүүн хэлж байсан. Энэ намын асуудал дээр бид оролцох ёстой. Нам өөрөө хариуцлагаа хүлээх ёстой. Цаашид дараа дараагийн сонгуулиар нам жагсаалтад ямар гишүүн дэвшүүлэх дээрээ илүү хариуцлагатай болох ёстой юм байна гэдэг энэ аргументууд бүгд хоорондоо давхцаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр саналууд нэгдэж байгаа юм. О.Номинчимэг гишүүнтэй, А.Ариунзаяа гишүүнтэй.

Хамгийн гол нь энэ 2 дугаар заалтыг тусад нь аваад үзэж байгаа нь эргэлзээ төрүүлээд байгаа асуудал юм шүү. Түүнээс түрүүн А.Ариунзаяа гишүүний хэлж байгаа энэ дээр илүү их ажиллая, бүгдээрээ энэ дээр саналаа солилцёе, яавал илүү сайжруулах вэ гэдэг бүрэн нээлттэй. Үүнийг хууль санаачлагчийн үүднээс, ажлын хэсгээс тулган шаардаж байгаа асуудал байхгүй. Энэ бол ерөөсөө л хуулийг хэлэлцэх асуудал шүү дээ. Бүгдээрээ.

Тэгэхээр энэ дээр илүү сайн, илүү оролцоогоо хангаад явбал маш сайн болох байх гэж бодож байгаа.

Түрүүн А.Ариунзаяа гишүүн маань нэг зүйлийг дурдаж байна лээ. Тэр намын дүрмээр татах вий дээ гээд.

Х.Баасанжаргал гишүүн Байнгын хорооны хуралдаан дээр Та Удирдах зөвлөлийн гишүүн шүү дээ гээд хэлээд дурдаж байсан. Энэ нөгөө нэг... /минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулъя. 4 номер.

А.Үйлстөгөлдөр: Их Хурлын даргад баярлалаа.

Их Хурлын гишүүнийхээ ёс зүйн дүрмээр зохицуулагдаж байгаа учраас энэнд зориулж нам дүрэм гаргах, намын дүрэм энд хамаарахгүй.

Дээрээс нь, 2 дугаар заалт буюу хардлага үүсгээд байгаа энэ заалт дотор хэн нэгэн нам чинь өөрийнхөө эсрэг дуугарсан гишүүнийг намнах гээд л, татах гээд ч гэдэг юм уу эргэлзээ үүсээд байна шүү дээ.

Эсвэл өөрийнхөө бодлогыг намын бодлогоо дэмжсэнгүй.

Тийм учраас Та татагдах ёстой ч гэдэг юм уу ийм байдлаар тэр хүнд асуудал тавина гэвэл энэ боломжгүй. Яагаад гэхээр энэ заалт дээр бүр нарийн бичсэн байгаа. “Ёс зүйн ноцтой зөрчил” гэдгээр.

Тэгээд тэр “Ёс зүйн ноцтой зөрчил”-ийг нам гаргахгүй. Үүнийг Их Хурлын гишүүд Та бүхэн гаргана. Мөн үүнийг Их Хурлынхаа ёс зүйн дүрэмдээ өөрсдөө оруулж өгч байгаа.

Энэ ингээд бүрэн хамгаалалттай байхгүй юу. Хамгийн гол нь үүнийг тусад нь авч үзсэн гэж байгаа А.Ариунзаяа гишүүний аргумент бол зөв юм билээ. Үүнийг тусад нь гаргаад авангуут энэ дээр... /минут дуусав/

С.Бямбацогт: Аюушийн Ариунзаяа гишүүн нэмж асууя.

А.Ариунзаяа: Хуулиа унш гэж хэлээд. Тэр нь сэвэгдээд тэгээд буруу ойлголт төрүүлээд явсанд амьхандаа намайг магтаж уучлалт гуйж байгаа юм байна гэж хүлээж авлаа.

Миний асуулт Улсын Их Хурлын тухай хуулийн 44.1.11 буюу “бусдыг гүтгэж доромжлох нь хориотой” гэсэн заалтыг зөрчсөн хүнд яг өнөөгийн энэ хууль тогтоомжийн хүрээнд ямар гарц гаргалгаа, бид юу авч хэрэгжүүлэх ёстой юм бэ гэдгийг процессын хувьд би ойлгохгүй байгаа байхгүй юу.

Гүтгэн доромжлуулсан хүн шүүхэд хандах ёстой юм уу, эсвэл Улсын Их Хурлын тухай хуулийг энэ хүн зөрчсөн байна гээд цэц өөрөө шууд хүлээж аваад үүнийг хэлэлцэх ёстой юм уу?

Ийм заалт байсаар нь байтал, үүнийг зөрчсөн олон гишүүн байсаар нь байтал “ёс зүй” дээр дөрөөлж, өөр эмэгтэй гишүүд дээр дөрөөлж ийм хуулийг гаргаж ирж байгааг би зүгээр хувьдаа гайхаад байгаа юм.

Энэ заалтыг зөрчсөн бол яах ёстой юм бэ гэдгийг надаа тайлбарлаад өгөөч гэж асуугаад байгаа юм. Тийм.

С.Бямбацогт: 4 номерын микрофон. Ажлын хэсэг.

А.Бямбажаргал: А.Ариунзаяа гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг Монгол Улсын дээд шүүх гаргахаар заасан.

Улсын Их Хурлын тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг яах юм бэ гэдэг тайлбарыг “хэрэглэх” гэдэг агуулгаараа харвал Улсын дээд шүүх тайлбарлах ийм бүрэн эрхтэй.

Хуулийн төсөлтэй энэ асуудал маань яаж холбогдож байгаа вэ гэхээр А.Ариунзаяа гишүүн маань өөрөө асуухаасаа гадна хариулаад байгаа юм.

Юу гэж хариулаад байгаа вэ гэхээр энэ асуудлууд өөрөө цаашаа хэрхэн яаж–

- хэн тогтоох юм,
- яаж тогтоох юм,
- яаж хэмжих юм–

-гэдэг энэ асуудал өөрөө процедургүй л юм билээ л дээ.

Ганц үйлчлэх ёстой зүйл нь. Гэхдээ бас процедургүй гэж үзэж болохгүй. Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм.

- ➔ 2009 онд анх ёс зүйн дүрмийг баталсан.
- ➔ 2021 онд шинэчлэн баталсан.

Энэ ёс зүйн дүрмийг дагаж мөрдөж байгаа.

С.Бямбацогт: А.Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Яах вэ, яах вэ. Би уг нь зүгээр л энэ хуулийн заалтыг зөрчсөн бол хууль зөрчсөнд үзнэ. Тэгээд л тэр процессоороо явах ёстой, эсвэл хууль зөрчсөн бол өөрөө цаад агуулгаараа Үндсэн хууль зөрчсөнд тооцно гэдэг ч юм уу, нэг тийм л юм байх болов уу л гэж би бодоод байгаа байхгүй юу.

Тэгээд уг нь ингээд процесс нь хуулиар заагаад өгсөн байгаа асуудлыг яах ёстой юм бэ гэдгийг л асуугаад байгаа юм.

Гэтэл хуульд огт байхгүй юм шиг “гишүүд бусдыг гүтгэж доромжиллоо”, “жагсаалтаар сонгогдсон гишүүдийг ёс зүйн дүрмээр нам нь эргүүлэн татна” гэх зэрэг өөр хуульд угаасаа байгаа юмыг өөрөөр оруулж ирээд байгаад би их санаа зовоод байна л даа. Яах вэ, тэр яршиг давай больё.

С.Бямбацогт даргатай өчигдөр уулзсан. Би Үндсэн хуультай холбоотой л яриад л төөрөгдүүлээд байна л даа.

Тэгээд “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаалсан”, “тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол эгүүлэн татна” гэх зэрэг ийм асуудлууд байгаа учраас яг энэ заалт өөрөө “жагсаалтын гишүүд” дээр зөрчөөд байгаа юм шиг өчигдөр хэдүүлээ ярьсан учраас би танд тус болж энэ хуульд татгалз... /минут дуусав/

С.Бямбацогт: А.Ариунзаяа гишүүн үг хэллээ.

Энэ чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36.7-д “нэгдсэн хуралдаанд асуулт асууж, хариулт авах үйл ажиллагааг зөвлөлөөс тогтоосон хугацаанд багтаан зохион байгуулах ба шаардлагатай тохиолдолд хуралдаан даргалагч нэг цаг хүртэл сунгаж болно.” гэсэн байна.

Одоо 3 гишүүн асуухаар байгаа учраас. Асуултын цаг 2 цаг байсан. Дууссан. Одоо 3 гишүүнээр асуулт, хариултын цагийг сунгалаа. /алх цохив/

Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуултаа асууя.

Х.Тэмүүжин: Энэ богинохон хугацаанд уг нь 7 юм яримаар байна.

Эхнийх нь, энэ орж ирсэн хуулийн төсөл Хууль зүйн байнгын хороогоор орох ёстой байсан. Яригдаад асуугдаж байгаа асуултууд бүгдээрээ хууль зүйн салбарын нэлээн онолын нарийн юм яригдаж байгаа байхгүй юу.

Төрийн байгуулалтын байнгын хороогоор ороод эрх мэдэл хоорондын хэрүүл болоод дууссан.

Тийм учраас энэ дээрээ анхаараарай гэж хэлж байгаа юм.

Хоёрт нь, түрүүн Улсын Их Хурлын гишүүдээс цөөнгүй хүмүүс асууж байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга энд юу хийж яваа юм бэ гээд. Монгол Улсын Үндсэн хуулийн **Нэгдүгээр зүйл**-д “Монгол Улс бол тусгаар тогтносон бүрэн эрхт бүгд найрамдах улс мөн.” гэсэн үг байдаг юм.

Энэ “бүрэн эрхт” гэдэг шинжийг нэг зүйлээр илэрхийлдэг. Энэ бол парламент шийдвэр гаргах чадвараар илэрхийлдэг. Парламентын гишүүд шийдвэр гаргалтдаа оролцохгүй байвал бүрэн эрхт байдлаа эвдэж байна гэдэг үзүүлэлт байдаг.

Тийм учраас тэр талаасаа санаа зовж Үндэсний аюулгүй байдлын зөвлөл орж ирж байгаа юм байна гэж би хувьдаа бодоод байгаа юм.

Гуравт нь, энэ хуульд авах ч юм байна, авахгүй ч юм байна. Тэр дундаа Үндсэн хуультай зөрчилдсөн хоёр утга санаа байна. Маш том.

Нэгдүгээрт, Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Их Хурал нэг танхимтай, 126 гишүүнтэй байна гэсэн заалт байгаа.

Тэнд “Улсын Их Хурал тэдэн гишүүнтэй, бас намаас бүрдэнэ” гэсэн үг ерөөсөө байхгүй. Ард түмний мандат намд очдоггүй. Гишүүнд очдог. 196 гишүүнтэй байгаа шүү.

Энэ Үндсэн хуультай зөрчилдөж байгаа хамгийн гол агуулга бол ард түмний мандатыг нам руу шилжүүлэх гэж оролдож байгаа тэр заалт бол хамгийн аюултай заалт.

Ардын нам жагсаалтаар орсон намын гишүүдээ үгэндээ оруулахын тулд нам доторх асуудлаа одоо Үндсэн хуулийн зовлон болгож оруулж ирэхийг болих хэрэгтэй. Арай хэтэрч байна.

Гуравт нь, “Улсын Их Хурлын бүрэн эрхэд халдаад байгаа юм биш үү” гэдэг болгоомжлол байгаа юм.

Хууль зүйн техникийн хувьд халдсан 2 хууль орж ирсэн.

Улсын Их Хурал ямар шийдвэр гаргахыг Эрүүгийн процессын хууль болон Үндсэн хуулийн цэцийн хэрэг маргаан шийдвэрлэх хууль дээр бичсэн.

Ерөнхийлөгчийн ямар шийдвэр гаргахыг Улсын Их Хурлын дэгийн хууль дээр бичиж болох юм уу? Техникийн хувьд энэ бол бүр Үндсэн хуулийн хамгийн том зөрчил шүү дээ.

“Улсын Их Хурлын бүрэн эрх” гээд бичсэн байгаа, Үндсэн хууль дээр байгаа тэр зүйл, заалтуудыг ямар шийдвэр гаргахыг нь Улсын Их Хурлын хуулиас гадна бичих гэж оролдож байна.

- Засгийн газар ямар шийдвэр гаргахыг Шүүхийн тухай хууль дээр бичих үү.
- Эсвэл Улсын Их Хурлын тухай хууль дээр бичих үү.
- Ерөнхийлөгч ямар хууль гаргахыг бид орон нутгийн зохион байгуулалт, нутаг дэвсгэрийн хууль дээр бичих үү.

Энэ бол бүр хууль зүйн техникийн хувьд тэвчиж болохгүй алдаа.

Хийх ёстой юм байна. Энэ хууль Монгол Улсын Үндсэн хуулийн 29.3 дугаар зүйл болон 66 дугаар зүйлийг амилуулах гэж орж ирж байгаа.

29.3 дугаар зүйл дээр “тангаргаасаа няцалж Үндсэн хууль зөрчсөн бол” гэж үг 2019 онд Ардын намын олонх байхдаа баталсан. Энэ хуулийг амилуулах ёстой.

1992 оны Үндсэн хуулийн 66 дугаар зүйл одоо хүртэл өөрчлөгдөөгүй байгаа. Тэр 66 дугаар зүйл дээр 66.2.3, 66.2.4 хоёр дээр ямар албан тушаалтнуудыг Үндсэн хууль зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргах, ямар албан тушаалтнуудыг огцруулах болон эгүүлэн татахтай холбоотой Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргах тухай маш тодорхой бичсэн.

Хууль санаачлагчид дутуу оруулж ирсэн. Тэнд 5 албан тушаал байгаа. Тэр албан тушаалуудыг бүгдийг нь оруулж ирэх хэрэгтэй.

- Монгол Улсын Ерөнхийлөгч,
- Улсын Их Хурлын дарга,
- Ерөнхий сайд,
- Улсын Их Хурлын гишүүд.

Бүтнээр нь... /минут дуусав/

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Алтангэрэлийн Бямбажаргал. Ажлын хэсгийн гишүүн.

А.Бямбажаргал: Х.Тэмүүжин гишүүний асуултад хариулъя.

Ажил үүргээ хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор бас нэг жоохон сэтгэл хөдлөлийн шинжтэй юм болоод, зарим нэг зүйл хэлсэн. Би тэндээсээ уучлалт хүсэх ёстой гэж бодож байна.

Гэхдээ би хүсэх газраа хүснэ. Би тэгэхдээ өөртөө буруутгал өгч хэлсэн юм шүү. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ажлын хэсгийн гишүүний хувиар би таны хууль зүйн техниктэй холбоотой асуудлаар би зөрүүлээд танаас асуух гээд байгаа юм.

Хууль зүйн техникийн хувьд авч үзвэл зөвхөн энэ бүрэн эрхийг Их Хурал дээр бичдэг гэдэг ийм зүйл байхгүй шүү дээ. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Их Хурлын бүрэн эрхтэй холбоотой зүйлүүд зөвхөн Үндсэн хуулиас гадна Улсын Их Хуралд биш бусад хуулиудад байгаа.

- Тухайлбал, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын хуульд.
- Тухайлбал, Монголбанкны хуульд.
- Тухайлбал, Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуульд.

Эдгээр чинь өөрөө техникийн хувьд авч үзэх юм бол яг Х.Тэмүүжин гишүүний асуусан шиг оруулж ирсэн.

Улсын Их Хурлын тухай хуулийн одоогийн бүрэн эрх дуусгавар болгох заалтад хэзээ, ямар нөхцөлд бүрэн эрх дуусгавар болгох вэ гэдэг агуулга дээр

буюу энэ хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр энэ маань бас тусгагдаж байгаа юм. Тусгагдаж байгаа юм.

Үүний дагуу цэцийн процессын хуульд, иргэний, эрүүгийн процессын хуулиудад тусгагдаж байгаа юм.

Техникийн хувьд Ерөнхийлөгчийн бүрэн эрх ч тэр, Их Хурлын бүрэн эрх ч тэр зөвхөн нэг хууль зохицуулна гэж байхгүй шүү дээ. Тийм боломж ч байхгүй.

Хууль зүйн дэд акт гэж нэрлэдэг. Дэд акт дахиад л эрх хэмжээ, бүрэн эрхүүдийг шилжүүлдэг учраас энэ өөрөө хууль зүйн хувьд авч үзвэл хамгийн энгийнээр хэлэх юм бол хуулийг зөвхөн нэг хуулиар бүгдийг нь шийдэж болдоггүй.

Өөрөөр хэлэх юм бол хууль зүйн техникийн хувьд авч үзвэл дээрх хуулиуд биш бусад хууль тогтоомжийн хувьд бид цогц байж энэ чинь Монголын эрх зүйн тогтолцоо, Монголын хууль тогтоомж гэдэг ийм зүйл өөрөө бий болж байгаа юм.

Хоёрдугаарт, Ерөнхийлөгчийн хууль санаачлах бүрэн эрхтэй холбоотой асуудал. Түүрэн Та хэллээ. Монгол Улсын Үндсэн хуулийн дэглэмийн хүрээнд энэ асуудлууд өөрөө тодорхой болгох шаардлага байгаа учраас гарч ирж байгаа юм.

Процедур л даа. Процесс биш. Процесс гэдэг зөвхөн шүүхийн процессыг хэлдэг. Энэ процедурыг тодруулах үүднээс буюу энэ Үндсэн хуулийн дэг журмыг тодруулах үүднээс 29.3-ыг ч тэр, 66.2.3, 66.2.4. Мөн түүний дараа байж байгаа заалтуудыг амилуулах зорилгоор буюу 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2... /минут дуусав/

С.Бямбацогт: Х.Тэмүүжин гишүүн нэмэлт асуулт.

Х.Тэмүүжин: Маргаан шийдвэрлэх хууль дээр Улсын Их Хурлын парламентын бүрэн эрхийг бичсэн анхны улс болж түүхэнд үлдэх байх. Энэ бол мэргэжилтний хувьд маш том онигоо гэдгийг санах хэрэгтэй.

Хоёрт нь, би О.Машбатаас. Үндсэн хуулийн тухай тайлбаруудыг зүгээр сэтгэл хөдлөлөөр юм уу, хувийн бодлоороо хэлж болохгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн 29.3, Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2, түүний 3, 4, мөн 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг индэр дээрээс уншаадах даа. О.Машбат байна уу? Индэр дээрээс уншаадах даа.

Та хэдийн ярьсан үг дотор Үндсэн хуулийн үг, үсэг маш их засвартайгаар болон гажуу тайлбартайгаар хувийн бодлоор илэрхийлэгдлээ. Одоо яг цагаан дээр хараар бичсэн текстийг уншаадах.

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон.

А.Бямбажаргал: Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 3.

Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргана. 1, 2-т нь шийдвэрүүд байдаг.

Бидний яриад байгаа 2, 3 бол үйл ажиллагаа гэж бид тайлбарладаг юм.

66 дугаар зүйлийн 2.

66 дугаар зүйлийн 2-т юу гэж заасан бэ гэхээр Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараах маргаантай асуудлыг дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна гэж.

Цэцийн 1995 оны бас ийм дүгнэлт байдаг.

2.4.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх.

Яг тийм учраас цэцийн 1995 оны тогтоолууд л юм билээ л дээ. Хэдийг гэнэ ээ?

С.Бямбацогт: Х.Тэмүүжин гишүүн нэмэлт минутаа авах уу? Хариулъя. Минут дууссан. Дэгээрээ явъя.

Х.Тэмүүжин: Цагаан дээр хараар 1992 оны Үндсэн хууль. Сая уншлаа.

66.2.маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна.

Үндсэн хууль дээр байгаа “орүүлна” гэдэг үгийг Та хэд хууль дээрээ “таннилцуулна” гэж өөрчилж бичиж байна лээ.

66.3.энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргана.

Энд хүлээн зөвшөөрөх, зөвшөөрөхгүй Улсын Их Хурлын бүрэн эрх байхгүй юу. Тэр дээр байгаа дүгнэлт чинь цэцийн эцсийн шийдвэр ерөөсөө биш.

Байж байгаарай. Би цагаан дээр хараар бичсэн Үндсэн хууль уншиж байгаа.

— Үндсэн хуулийг Үндсэн хуулийн цэц ч тогтоохгүй,
— өөр хэн нэгэн хувь хуульч ч тогтоохгүй.

Цагаан дээр хараар... /минут дуусав/

С.Бямбацогт: Нэмээд хариулъя. 4 дүгээр микрофон. Ажлын хэсэг.

А.Бямбажаргал: Х.Тэмүүжин гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын Үндсэн хуулийн 1995 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн 02 дугаар тогтоол гэж би тогтоолын хянавал хэсгээс уншиж өгье.

Мөн хуулийн 66 дугаар зүйлийн 3-д энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол цэц дахин хянан үзэж шийдвэр гаргана гэсэн заалтаас үзэхэд Үндсэн хуулийн цэцээс 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан үндэслэлээр гаргасан дүгнэлтийг Улсын Их Хурал хянан хэлэлцэхгүй нь тодорхой байна гэж цэцийн тогтоол байгаа юм. Энэ эцсийн шийдвэр. 1995 оны тогтоол.

Хуулийг мэдээж хэрэг хууль зүйн техник талаас авч үзэх юм бол зөвхөн Үндсэн хууль байснаар биш. Үндсэн хуулийг чинь тайлбарлах цорын ганц эрх бүхий субъект бол цэц байх гэж ингэж харж байгаа. Үндсэн хуульд хяналт дээд хяналт тавих эрх бүхий субъект гэдэг агуулгаар.

С.Бямбацогт: Дэгээ сахицгаая. Х.Тэмүүжин гишүүн ээ, дэгээ сахъя. Та. Асуултаа гүйцэд хариулж байна. Асуултад хариулах ёстой.

Х.Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Ардчилал нуруу унаж байгааг бүгдээрээ нүдээрээ харж байна. Тийм үү. Бүгдээрээ үүнийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй шүү дээ.

Ямар нөхцөл байдалд байгаагаа бүгдээрээ хүлээн зөвшөөрье л дөө. Яагаад ингээд худлаа бүгдээрээ дүр эсгэцгээгээд байгаа юм.

Ардчиллыг зүгээр л төрийн эрх мэдлийг булааж авч эргүүлэхээ больсон. Яг ийм аргаар нэг нэгээр нь, чимх чимхээр нь, ямх ямхаар нь ингэж сулруулдаг ийм олон орны жишээг бид бүгдээрээ мэднэ шүү дээ. Туркийг, Оросыг.

Тэгэхдээ үүнд бүхэл бүтэн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл тэр чигээрээ оролцож явж байгаа нь бүр үнэхээр харамсаж байна.

Тэр дундаа хуульчид оролцож байгаад би бол бүр үнэхээр чин сэтгэлээсээ бас харамсаж байна. Хурлын тэмдэглэлд үүнийг тэмдэглэж үлдээх ёстой гэж би зориуд хэлж байна гэсэн үг.

Би нэг хэдэн асуултыг хожмын Үндсэн хууль судлаач, хожмын засаглалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэний нийгмийн байгууллагынханд, сэтгүүлчдэд зориулаад хэдэн асуултыг би зориуд энэ хурлын тэмдэглэлээр үлдээе гэж бодож байна.

Би өмнө нь энд сууж байгаа 5 хүний 2 хүнийг нь төрийн тусгай албан хаагч. Та хоёроос би улс төрийн биш хуулийн асуулт асууна.

Дунд нь сууж байгаа 3 хүн нэгэнт улс төрч учраас улс төрийн асуулт асууна гэж ингэж хил хязгаарыг гаргасан боловч харамсалтай нь Та хоёр өөрсдөө улс төрийн байр суурь илэрхийлж цэвэр улс төрийн ийм тоглолт руу орж ирлээ.

Тэгэхээр би үүнээс цааш энэ хил хязгаарыг өөрсдөө давсан учраас давахаас өөр аргагүй боллоо.

Нэгдүгээр асуулт. Хожмын Үндсэн хууль судлаачид минь энэ ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хуулийн төсөл барьж орж ирсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн өөрсдөө ёс зүйн шаардлагыг хангасан уу гэдэг дээр дүгнэлт хийгээрэй.

Тэр дундаа Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2 албан тушаалтан, төрийн тусгай албан тушаалтууд Ерөнхийлөгч, Их Хурал, Засгийн газар институт цоорондыг зохицуулж байх ёстой байгууллагын хүмүүс аль нэг талд нь гараад нөгөө талынхаа ардчиллын дархлааг сулруулаад сууж байгаад судлаачийн ёс зүйгээ давсан уу гэдэг дээр дүгнэлт хийгээрэй.

Хоёрдугаарт, улс төрийн намаас татгалздаг, тэр дундаа ард түмний эв нэгдлийг илэрхийлэх ийм хүний ажлын алба тэр чигээрээ нэг улс төрийн нам байж болж байгаа юм уу? Үүнд ёс зүйн дүгнэлт хийгээрэй.

Хоёр дахь асуулт. Ерөнхийлөгчийн хууль санаачлах эрх нь ямар нэг хэмжээ хязгааргүй байх ёстой юу гэдэгт судлаачид дүгнэлт хийгээрэй.

Тэр дундаа Үндсэн хууль Улсын Их Хурлын тухай хууль хоёр зөрчилдсөн учраас Үндсэн хуулиа илүү баримтална гээд энэ эрхийг ямар нэгэн хил хязгааргүй, ямар нэгэн улаан шугамгүйгээр, тэр дундаа парламент руугаа халдаж ингэж давж байгаа нь өөрөө зөв үү, үгүй юу гэдэгт дүгнэлт хийгээрэй гэж хүсье.

Гуравдугаарт, Ерөнхийлөгчийн өргөн барьсан хуулийг парламент хэлэлцэж эхэлснээрээ Үндсэн хууль зөрчсөн үү гэдэгт дүгнэлт хийгээрэй.

Их Хурлын Тамгын газрын дарга өнөөдөр хийсэн дүгнэлтэд хожмын судлаачид дүгнэлт хийгээд гаргаарай гэж хүсье.

Дөрөвдүгээрт, ингэж бид энэ хуулийг хэлэлцэж эхэлснээрээ хожим нь Ерөнхийлөгч дахиад ямар асуудлаар ямар хүрээнд дур зоргоороо аашилж, хэрхэн дур зоргоороо аашлахыг бол бид бол үнэхээр таашгүй боллоо. Тодорхой хэмжээнд хил хязгаар дотор барьдаг байсан, явдаг байсан энэ бүх юм өнөөдрөөс эхлээд ингээд эвдэгдлээ гэсэн үг.

Дөрөвдүгээрт, эрх мэдлийн хяналт, тэнцэл, парламентын дархлаанд энэ хуулийн төслийг өргөн барьсан процесс нь, агуулга нь нөлөөлсөн үү гэдэгт судлаачид дүгнэлт хийгээрэй.

Өнгөрсөн... /минут дуусав/

С.Бямбацогт: Нэмэлт асуулттайгаа дуусгая.

Х.Баасанжаргал: Нэмэлт 1 минутаа авъя.

Өнгөрсөн 30 жилийн алдаа дутагдлыг энэ удаагийн 126 гишүүн, тэр дундаа шинээр сонгогдсон 81 гишүүдээс ёс зүйн өндөрлөгийг нэхэж байгаад Та бүхэнд баярлалаа гэдгийг хэлье.

Өнгөрсөн 30 жил Та бүхэн ёс зүйн өндөрлөгт байсан бол өнөөдөр бид нарын амьдрал ийм гунигтай байх ёсгүй байсан. Та нар үүргээ биелүүлсэн юм уу.

Намайг нэгдүгээр ангид байхад энэ улс төрд байсан ах нар одоо болтол байж л байгаа шүү дээ.

Тэгчхээд өнөөдөр бид нараас ийм юм нэхэж байгаадаа Та нар өөрсдөөсөө ичээч. Та нар гол нь бид нарыг өөрсдийнхөө утсан хүүхэлдэй кноп болно гэж бодсон. Бид тэгээгүй. Бид тэгэхгүй. Та нарын алдаа дутагдлын хажуугаар дуугүй өнгөрөхгүй байгаа нь Та нарыг нойргүй хонуулж байгаа.

Тийм учраас бид нарт зориулж оруулж ирсэн хууль. Баярлалаа. /алга ташив/

Тэгээд. Хамгийн сүүлд нэг зүйлийг хэлье. Нэг голын усанд хоёр удаа орж болдоггүй. Нэг голын усанд хоёр удаа орж болдог... /минут дуусав/

С.Бямбацогт: Асуулт асуусангүй. Үг хэллээ. Одоо Энхбатын Болормаа гишүүн асуултаа асууя.

Э.Болормаа: 126 гишүүнтэй, 5 намын төлөөлөлтэй, холимог тогтолцоотой буюу жагсаалтын болон тойргийн гишүүдтэй энэ парламент бүрдэхээс өмнө 2009 онд Үндсэн хуулийн эрх баригч Бирагийн Чимэд гуайн хэлсэн үгийг би Та бүхэнд хэлье гэж бодож байна.

Улсын Их Хурлын гишүүд тухайн тойргоос илгээсэн ард түмний элч, ард нийтийн нийтлэг эрх ашгийн төлөө ажиллах ёстой.

Улсын Их Хурлын гишүүд Үндсэн хуулийн энэ зарчим, заалтаа биелүүлэхийн оронд нам талаасаа намын идэвхтэй гишүүн, төр талаасаа намын дуулгавартай зарц болсон байна.

Энэ нь Улсын Их Хурлын гишүүнээр дахин сонгогдох гэсэн атгаг намын элчүүд Улсын Их Хуралд ахархан санаа бодолтой нь холбоотой нь ажиг ажиглагддаг. Гай ч тарихгүй, гавьяа ч байгуулахгүй. Нам юу гэнэ түүнийг нь дагаад явж байдаг болжээ.

Сонгогдсон дээрээ ард түмнийхээ тусын тулд томоохон асуудал шийдэх юмсан гэсэн иргэний байр суурь, зориг тэдэнд дутагдаж байна гэж 2009 онд хэлсэн байгаа.

Үүний дараа бид 126 гишүүнтэй болж өнөөдөр жагсаалтын, тойргийн гэж ялгалгүйгээр энэ 126 гишүүн олон намын төлөөлөл нийт ард иргэдийнхээ элч төлөөлөл болсон байгаа.

Үүнийхээ ачаар парламент дээр маш сонирхолтой мэтгэлцээн өрнөж байна. Бид ардчиллыг ямар эрсдэлд орсон байна, яаж хамгаалах вэ гэдэг онол талаасаа, практик талаасаа хэлэлцэж байна.

Олон нийт “ёс зүй” шаардаж байгаа. Тэгэхдээ яг үнэндээ бид нарын хуралдаа сууж байна уу, ямар үг хэллэг хэлж байна уу биш шүү дээ.

Энэ авлига хулгайчдадаа хариуцлага тооцооч ээ гэдэг л “ёс зүй” шаардаж байгаа. Үүнийг дөрөөлөөд үгэнд нь орохгүй байгаа, дар гэсэн кнопыг нь дарахгүй байгаа энэ хүмүүсийгээ нухчин дарж тэгээд эргээд дараагийн Их Хурал юу болох вэ гэхээр гай ч тарихгүй, гавьяа ч байгуулахгүй, нам юу гэнэ түүнийг нь яваад дагаж байдаг л ийм л хэдэн нөхдүүд бүрдэнэ.

Тэгэхээр энд байгаа 126 өнөөдөр бид нэг түүх байгаагүй юм шиг, ирээдүй байхгүй юм шиг аашилж болохгүй. Би гишүүдтэйгээ, бусад гишүүдтэй ярьж байна. Үгүй энэ болохгүй гэсэн шүү дээ. Гэхдээ яах вэ чимээгүй дэмжихээс яах вэ дээ. Үгүй ямар дарамтад ороод байгаа юм.

Өөрийнхөө үзэл санаандаа үнэнч байж чадахгүй, эх орныхоо төлөө зоригтойхон дуу хэлээд дуугараад кнопоо дарж чадахгүй юм бол энд хэний төлөө суугаад байгаа юм.

Энэ А.Бямбажаргалаас айгаад байгаа юм уу. Дүн гуйсан болгонд нь дүн өгдөг. Өнөөдөр аягүй гоё бүр чухал юм сайхан хэллээ. Нийгэмд тулгамдаад байгаа энэ ёс зүйн зөрчилдсөн таны хичээлд суудаг, хичээл заадаг үеэс л эхэлж байгаа байхгүй юу. Их сургуулиудад багш нартаа авлига хээл хахууль өгч багшийнхаа хий гэснийг хийгээд, нэг юмыг нь орчуулж өгдөг, нэг юмыг нь хийж өгдөг, алив үүнийг яваад ир гэхээр яваад ирээд тэрнийхээ төлөө дүн гаргуулдаг. Та тэр дүнг нь гаргаж байсан нөхөр гэдгээ өөрөө өнөөдөр баталлаа шүү дээ.

Тэгээд ямар ёс зүйгүйгээр Улсын Их Хурлын гишүүн рүү дайрч байна.

Б.Жаргалан гишүүн бол "Айви Лиг" (Ivy League) их сургууль төгссөн хүн. Америкийн Нэгдсэн Улсад. Би бол хэзээ ч тийм үйлдэл гаргах хүн биш гэж бодож байна.

Таны хичээл аягүй бол авлига, хээл хахууль өгөхгүй, дүн гуйхгүй бол дүнг нь гаргадаггүй байсан тулдаа сурагч нар тийм нөхцөл байдалд очсон байх.

Тэгэхээр энэ асуудлыг, ёс зүйн асуудлыг шийдье гэвэл ийм залхуу дарангуйллын асуудал руу битгий аваач аа. Углуургаар нь ханд. Их дээд сургуулиудынхаа боловсролын чанартаа анхаармаар байна. Энэ социал орчиндоо анхаармаар байна.

С.Бямбацогт: Асуултаа асуух уу? Асуултаа асууя.

Э.Болормаа: Тэгэхээр энэ их дээд сургуулиудаа. Би өөрийнх нь хэлсэн учир би бүр тодруулаад энэ А.Бямбажаргал доктороос асууя гэж бодож байна.

Тэгээд хоёр хоногийн өмнө Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичиг гэдэг албан тушаалаа нуугаад судлаач доктор гээд ажлын хэсгээр орж ирж байсан бол өнөөдөр сайхан албан тушаалаа ил тод нээлттэй хэлсэнд баярлалаа.

Энэ хэлэлцүүлгийн үр дүнд таны “ёс зүй” нэмэгдэж байгаа юм шиг харагдаж байгаад баярлаж байна.

Сая нэг уучлалт гуйх гэж оролдоод уучлалт гуйв уу, яав. Нэг тэглээ. Та их сургуульд багшилж байхдаа хэдэн оюутнуудад дүнг нь гуйснаар нь гаргаж өгч байсан бэ? Таны ёс зүйг өнөөдөр би энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой учир, ноцтой ёс зүйн зөрчил гэдэгт энэ багтах уу? Таны томъёоллоор.

С.Бямбацогт: А.Бямбажаргал ажлын хэсгийн гишүүн хариулъя.

Хэлэлцэх асуудалтай холбоотой асуудлаар хариулна. 4 дүгээр микрофон.

А.Бямбажаргал: Э.Болормаа гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуульд заасан үндсэн бүрэн эрхийнхээ хүрээнд хууль санаачлах энэ эрхээ эдэлж Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачилсан.

Түүнийг дагалдуулж холбогдох хууль тогтоомжийн төслийг санаачилсан.

Би өнөөдөр ажлын хэсгийн гишүүнийхээ хувиар өнгөрсөн хугацаанд ч тэр надаас шалтгаалаагүй шалтгаанаар тэр миний ажил албан тушаалыг бол бичээгүй. Би тэрний төлөө хариуцлага хүлээхгүй байх.

Хуулиар хүлээсэн үүргээ би биелүүлж өнөөдөр энд ажлын хэсгийн гишүүнийхээ хувиар, дээр нь би хууль зүйн ухааны доктор хамгаалах гэж би нэг 20-оод жил зүтгэсэн. Тэрнийхээ хувиар орж ирсэн байгаа юм. Баярлалаа танд.

С.Бямбацогт: Тэр хэлэлцэх асуудалтай холбоогүй байна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Э.Болормаа гишүүн тодруулаад нэмэлт асуулт.

Э.Болормаа: Ерөнхийлөгч маань зөв зүйлийг санаж Улсын Их Хурал, парламент нийтээрээ бид “ёс зүй”, дэг журам илүү өндөр байгаасай, “ёс зүй” өндөрлөг байгаасай гэж бодож санаачилсан байх.

Хуулийг нь ажлын хэсгийнхэн Та бүхэн бичсэн байх. Маш залхуу шийдэл гаргаж ирсэн байна. Өнөөдөр дээрээс нь Та ингээд нэг бүрэн эрхийнхээ хүрээнд өргөн барьж байна гэтэл энд тантай л адилхан хууль зүйн Монголынхоо толгой болсон хүмүүс наадах чинь болохгүй гэдгийг хэлээд байхад ингээд л нэг муйхарлаад л байна л даа.

Тэгээд өнөөдөр би яагаад таныг ёс зүйгүйгээр таны ёс зүй яагаад энэ асуудалд хамаатай вэ? Улсын Их Хурлын дарга аа гэхээр энэ хүн ёс зүй гэдэг юмыг томъёолох гэж орж ирээд байна шүү дээ.

Ёс зүй гэдэг юмыг бидэнд томъёолох гэж. Тэгэнгүүтээ Та нар томъёолно гээд. Энэ тодорхойгүй байдал чинь нэг үл мэдэгдэх хүнд эрх мэдэл өгөх гээд... /минут дуусав/

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон. Ажлын хэсгийн гишүүн Алтангэрэлийн Бямбажаргал.

А.Бямбажаргал: Э.Болормаа гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын Үндсэн хууль 7 бүлэгтэй.

Гуравдугаар бүлэг. “**Монгол Улсын төрийн байгуулал**” гэдэг бүлэг байдаг. Энэ дотроо–

- ▷ **Нэгдүгээрт**, Монгол Улсын Их Хурал.
- ▷ **Хоёрдугаарт**, Монгол Улсын Ерөнхийлөгч.
- ▷ **Гуравдугаарт**, Монгол Улсын Засгийн газар.
- ▷ **Дөрөвдүгээрт**, Шүүх эрх мэдэл–

-гэдэг ийм заалтууд байдаг.

Монгол Улсын төрийн байгуулал өөрөө ийм байдаг учраас тэр эрх бүхий субъект энэ саналыг энэ эрхээ эдэлж орж ирж байгаа юм.

Эрхээ эдэлж орж ирж байгаа юм.

Тийм учраас Монгол Улсын Ерөнхийлөгч төрийн байгууллын хүрээнд багтаж байгаа учраас энэ хуулийн төслийг санаачилж орж ирж байгаа гэдгийг дахин хэлье.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хууль тогтоолын төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай, намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. /алх цохив/

Мэндбаярын Мандхай гишүүн үгээ хэлье.

М.Мандхай: Эрхэм Ерөнхийлөгч өө, эрхэм бизнес эрхлэгч иргэд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан энэ хуулийн төсөл батлагдах юм бол төрийн оролцоог багасгаж, хувийн хэвшлийн орчныг сайжруулах Засгийн газраас хэрэгжүүлж байгаа чөлөөлье зорилтыг хэрэгжүүлэх түүхэн боломжийг үгүй хийхээр байна.

Би бизнес эрхлэгч хувийн хэвшлийн салбараас гарсан хүний хувьд би бизнес эрхлэгчид анхаарал хандуулаач ээ гэж хүсэж байна.

Яагаад гэвэл бодит амьдрал дээр бизнес эрхлэгчид зөвхөн итгэж болох тэнцвэртэй төрийг хүсдэг.

Монгол төрийн бэлгэдэл болсон соёмбо тэнцвэртэй байх агуулгыг багтаасан, шингээсэн байдаг. Тэнцвэртэй байна гэдэг бол өөрөө тогтвортой хөгжлийн язгуур юм. Энэ хууль засаг төрийг энэ хууль засаг төрийн тэнцвэрийг сулруулж, цөөн хэдхэн даргын тохируураар, хэдэн дарга нарт аливаа хууль шийдвэр гаргах эрхийг төвлөрүүлэх эрсдэл рүү чирч байна гэж харж байна. Энэ бизнес эрхлэгчид бол зах зээлд сөрөг дохио өгч байгаа юм.

Өөрөөр хэлбэл хувийн хэвшил бизнес хийдэг жирийн иргэний өнцгөөс бол том ухралт болж байна гэж харж байна.

Өнөөдрийн Монголын нөхцөл байдлыг бид бодитоор харах хэрэгтэй. Бид хоёр том хөршийн дунд маш эмзэг нөхцөл байдалд оршиж байгаа. Ийм орчинд Монголын хамгийн том давуу тал юу юм бэ. Ерөөсөө л энэ бол энгийнээр итгэлцэл байгаа юм.

Хууль нь тогтвортой, ойлгомжтой, маргаан нь шүүхээр шударгаар шийдвэрлэгддэг энэ л итгэл байгаа юм.

Парламентын бие даасан байдал алдагдаж нэг удирдагчийг тойрсон тойрон хүрээлэл, тэдний гэр бүлсэг байдлаар асуудлууд шийдвэрлэх нь бизнесийн орчинд маш халтай. Гуравдагч хөршийн бодлогод сөрөг дохио очно. Монгол Улсад хөрөнгө оруулах сонирхолтой гуравдагч хөршийн бизнес, хөрөнгө оруулагч түншүүд Монголыг зөвхөн байгалийн баялгаар бус ил тод, хуульд суурилсан ардчилсан улсаар нь үнэлдэг.

Хэрэв тэдний парламентад итгэх итгэл сулрах юм бол бидний хувьд энэ стратегийн давуу талаа алдах нөхцөл байдалд ирж байна гэж харж байна.

Тиймээс энэ хууль батлагдах юм бол бидний зорьж байгаа, Засгийн газрын дэвшүүлж байгаа энэ бизнес хөрөнгө оруулалтын орчинд сөргөөр нөлөөлж, 30 жилийн хөгжлөөсөө ухрах ийм нөхцөл байдалд бид ирээд байгаа юм.

Эцэст нь хэлэхэд хөрөнгө оруулалтыг татах, бизнес эрхлэгчдийг зөвхөн итгэлцлээр татдаг гэдгийг дахин сануулъя. Ийм бизнесүүд нэг зүйлийг л асуудаг. Хууль журам маргааш өөрчлөгдөх үү, шударга байх уу, энэ тогтвортой төр нь байгаа юу гэдгийг л хардаг. Түүгээр ч хэмждэг байгаа.

Иймээс Ерөнхийлөгч өө, энэ хуулийн үзэл баримтлал нь Монгол Улсын илүү чөлөөт зах зээл бий болгож байна уу, эсвэл илүү таамаглахад бэрх орчин бүрдүүлж байна уу гэдэг дээр Та нэг эргэн харж нэг сайн дахин тунгаагаач ээ гэж хүсэж байна.

С.Бямбацогт: Мэндбаярын Мандхай гишүүнд баярлалаа. Ч.Лодойсамбуу гишүүн үгээ хэлнэ.

Ч.Лодойсамбуу: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Тэгээд энэ хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжихгүй гэж хэлж бол чадахгүй. Энэ хуулийн төслийг хэлэлцэх эрхгүй гэж хэлнэ. Монголын парламент. Монгол Улсын Их Хурлын гишүүд.

Яагаад гэвэл 800 жилийн тэртээгээс улбаатай Их эзэн Чингис хааны Их Хуралдайн зарчим “Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй” гэдэг энэ мэргэн ухаан өнөөдрийн парламентын ардчиллаар дэлхий нийтээр хэрэгжиж байгаа.

Монгол Улсын Үндсэн хуулиар Улсын Их Хурал бол ард түмнээс шууд эх сурвалжтай буюу ард иргэд нь төлөөллөөрөө дамжуулж төрөө барьдаг.

Энэ ард иргэдээс төрийг нь булааж авах гэж байгаа энэ үйлдлийг батлах нь битгий хэл хэлэлцэх нь өөрөө нүгэл гэж би үзэж байгаа. Нүгэл.

Хувь заяаны эрх, тийм эрх бид нарт байхгүй. Монголын парламент өнөөдөр бид нараар эхлээгүй. Монголын парламент өнөөдөр бид нараар дуусах гээгүй. Цаашаа зуу зуун жил үргэлжилнэ. Мянга мянган жил үргэлжилнэ. Өнөөдөр энэ Их Хурлын гишүүд зөвхөн энэ 4 жилийн эдлээд яваад өгөх хоноцын сэтгэлээр хандах эрх байхгүй.

Дараагийн парламентын гишүүддээ бид бүрэн бүтэн парламентыг, бүрэн бүтэн Үндсэн хуулийн засаглалыг хүлээлгэж өгөх үүрэгтэй.

Тийм учраас би Их Хурлын гишүүдээсээ уриалж гуйж байгаа юм.

Өнөөдөр ёс зүйн асуудал ярьж байгаа. Олон нийт “ёс зүй” шаардаж байна гэнэ. Олон нийт авлига хулгайчидтайгаа хариуцлага тооцохыг шаардаж байгаа. Өнөөдөр аль Их Хурлын гишүүнтэй авлига хулгайн асуудал яриад байгаа юм.

Энэ сайд нар чинь зуу зуун сая америк долларын хулгайн асуудал л хүртэл яриад байгаа биз дээ. Нэг нэгээрээ. Бие биеийгээ сайд нар. Сайд нар. Энэ хүмүүс яасан бэ. Монгол Улсад энэ хууль хэрэгжүүлдэг, сахиулдаг, мөрддөг энэ албад нь хаачсан бэ. Яагаад сайд нар хэрэг яриад байгаа юм бэ. Өнөөдөр Монгол Улсад хүчин төгөлдөр хуулиараа байж байгаа шүү дээ.

Прокурор нь оруулж ирлээ. Хэрэгт шалгах гэсэн юм. Түдгэлзүүлээд өгөөч ээ гээд. Түдгэлзүүлээд л явуулдаг.

М.Энх-Амгалан прокурор яг энд сууж байгаад Монголын төрөөс энэ парламентын танхимаас “Ёс зүй, шударга ёс” эхлэх ёстой юм гээд загнаад сууж байсан.

Өнөөдөр хаачсан бэ? Яагаад оруулж ирэхгүй байна вэ?

Оруулж ирэхгүй хэрэг нь олдохгүй бол хүнийг нь гаргаж ирж байгаад энэ таалагдахгүй байна, үүний хэлсэн үг таалагдахгүй байна, энэ чуулгандаа орж ирэхгүй байна гэж хэлээд ард түмнээс мандат аваад сонгогдоод ороод ирсэн хүний парламентын танхимаас хөөж гаргах хуулийг хэдүүлээ батлахгүй бол болохгүй гээд яриад сууж байгаа нь үнэхээр харамсалтай гэж хэлэхээс илүү харамсалтай байна.

Одоо байгаа хуулиа хэрэгжүүлээд, хууль сахиулаад хуулийг нь бүрдүүлээд явах бүрэн боломж байгаа. Заавал шинэ зүйл гаргаж ирж, шинэ хууль гаргаж ирж өш хонзонгоо авдаг энэ юу болж байгаа юм бэ.

Хэдхэн хүнд зориулаад, хэдхэн хүнийг энэ парламентын танхимаас ямар нэгэн шалтгаанаар хөөж гаргахын тулд хууль өргөн бариад тэрийг нь хэлэлцээд сууж байна гэдэг үнэхээр гутамшигтай санагдаж байна.

Дэндүү өндөр төлбөртэй зодооныг Монгол Ардын намынхан хийж байна. Ноёноосоо авхуулаад. Дэндүү өндөр төлбөртэй.

Энэ төлбөрийг дараа дараагийн үе үеийн парламентын гишүүд төлж дийлэхгүй шүү. Монгол Улс төлж дийлэхгүй шүү. Монгол Улсын тусгаар тогтнол энэ төлбөрийг чинь төлж дийлэхгүй шүү.

Тийм учраас өнөөдөр санал өгөх гишүүдийг манай Монголын ард түмэн харж яваа түүхэнд бичиж үлдээх хэрэгтэй. Баярлалаа. /алга ташив/

С.Бямбацогт: Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүнд баярлалаа.

Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн үг хэлнэ.

Х.Булгантуяа: Олон юм маш тодорхой болж байна.

Манай тэгвэл Улсын Их Хурлын дэгийн тухай хууль дахиад л Үндсэн хуулиа зөрчсөн хууль болж таарлаа.

Өнөөдөр Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга нь үгүй шүү дээ гэж хэлж байгаа ч гэсэн хууль санаачлах эрхийн хязгаар дээр, Улсын Их Хурлын тухай хууль дээр 36.1.1 дээр Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой хууль тогтоомжийн төслийг зөвхөн Улсын Их Хурлын гишүүн санаачилна гэж байгаа. Зөвхөн.

Тэгвэл бид эхнээсээ Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиасаа авхуулаад л дахиад л Үндсэн хуулийн зөрчилтэй дэгийн тухай хуулиар төдийгөөс өнөөдөр болтол явсан юм уу.

Дээрээс нь нэмээд Монгол Улсын Үндсэн хууль дээр Улсын Их Хурлын гишүүн гэж байгаа болохоос биш Улсын Их Хурлын тойргоос сонгогдсон гишүүн, жагсаалтаар сонгогдсон гишүүн гэж байхгүй.

Энэ хүмүүс бол ард түмний элч бөгөөд нийт иргэн улсын ашиг сонирхлын төлөө ажиллана гэсэн болохоос биш намынхаа төлөө ажиллана гэж байхгүй байгаа, даргынхаа төлөө ажиллана гэж байхгүй байгаа.

Бид олон асуудал дээр өнөөдөр ч биш үе үеийн парламент хоорондоо маргаж муудалцаж байсан зүйл зөндөө байгаа. Энэ ганцхан Монголд ч биш юм билээ. Дэлхийн олон парламент ингэдэг юм билээ. Яагаад гэвэл энэ олон салбарын хүмүүс, энэ олон намын хүмүүс, олон насны төлөөлөл, жөндөрийн төлөөллийн хүмүүс бид үргэлж нэг үзэл санаатай байна гэж байхгүй.

Та бүхэн тэгвэл энэ хуулиар бүгдийг нь Ардын намын төлөөлөгч байдаг юм уу, аль нэг намын төлөөлөгч байх ёстой гэж шахаж байна гэсэн үг шүү дээ.

Тэгээд яаж байгаа юм. Жагсаалтаар сонгогдсон гишүүн бол илүү өндөр ёс зүйтэй байх ёстой. Тойргоос сонгогдсон гишүүд арай бага ёс зүйтэй байх ёстой гэсэн ийм хуулийн зохицуулалтыг Та бүхэн маань хийж орж ирж байна шүү дээ.

Нөгөө талдаа бид сая намынхаа жагсаалт дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч, Ай Ти, цахимын төлөөлөл гээд ингээд оруулж ирсэн.

Үүнийхээ дараагаар энэ хүмүүс манай намын дарга, удирдлагуудтай, Засгийн газартайгаа санаа нийлэхгүй бол эгүүлэн татах үүд хаалгыг нь нээж байна. Бид нарыг өөрөөр хэлбэл сонгогчдыг хууран мэхэлж болно гэж хэлж байгаатай яг адилхан.

Энэ хүмүүсийн магадгүй нэр хүндээр бид бас санал авсан байх. Би бол тэгж боддог.

Дараа нь энэ хүмүүс орж ирээд олон зүйл дээр Д.Энхтүвшин гишүүн төсөв дээр, цахимын зарим нэг бодлого дээр Ч.Анар гишүүн гээд ингээд манай дарга нартаа үг зөрж байсан асуудлууд зөндөө байгаа. Тэгвэл үүнээсээ болоод эргүүлэн татах үндэслэл нь бий болж байгаа юм уу?

Нөгөө тал дээр Та бүхэн маань интернэт дээр ороод нэг хараад үзээрэй. Өнөөдөр ийм хуультай улс орнууд ийм байна гэнэ. **IDEA** (International Institute for Democracy and Electoral Assistance)-д ардчиллын олон улсын том судалгааны байгууллагаас гарсан юун дээр.

Перу, Венесуэль гэх мэтчилэн Латин Америкийн засаглалын хувьд маш тогтворгүй, дээрээс нь нэмээд дарангуйлал руу ерөнхийдөө шилжсэн ийм улс орнууд ийм хуультай байна.

Африкийн зарим улс орнууд байна. Уганда, Зимбабве гэх мэтчилэн. Та бүхний өнөөдөр жишээ гаргаж ярьж байгаа нь болохоороо Турк. Туркийг ардчиллын үлгэр жишээ улс гэж хэлэхэд бас хэцүү шүү дээ.

Европ гэхэд бараг Европт ийм хуультай улс орон их цөөхөн гэж байна. Герман гэхэд зөвхөн Баварын мужид нь, Канад гэхэд зөвхөн ганцхан муждаа иргэдийн хурлынхаа асуудал дээр эгүүлэн татах хуультай байдаг. Яагаад гэвэл үүнийг ард түмний сонголт гэж үргэлж хүндэтгэж хүлээн зөвшөөрдөг.

Өнөөдөр 2.2 сая сонгогчдын эрхийг манай дарга нарын томилсон 9 Үндсэн хуулийн цэцийн гишүүд шийдэхгүй.

Х.Тэмүүжин гишүүний түрүүний уурлаад байгаа нь тэр хүмүүсийн шийдвэр эцсийн шийдвэр гээд өнөөдөр ёс зүйн асуудлаар оруулаад л шийдэх юм байна л даа.

Өөрсдөө энэ шийдэж байгаа хүмүүс нь ч гэсэндээ ёс зүйн маш өндөрлөгт байгаа гэдэгт Та бүхэн маань итгэж байна уу?

Сая хоёр хоногийн өмнө Засгийн газрын Хэрэг эрхлэхийн дарга Б.Энхбаяр сайд хэлж байна лээ.

Эрдэнэтийн 49 хувь дээр цэц нь нэг дүгнэлт гаргасан, дээд шүүх нь, хоёр янзын шүүх нь хоёр өөр янзын дүгнэлт гаргасан, шийдвэр гаргасан. Үүнээсээ болоод бид хэрэгжүүлж чадахгүй байна гэж байна.

Тэгтэл Европ шиг шүүх засаглал нь тийм бие даасан чадвартай улс үүнийг хэрэгжүүлж чадахгүй байгаа... /минут дуусав/

С.Бямбацогт: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүнд баярлалаа. Лутаагийн Энхнасан гишүүн үгээ хэлье.

Л.Энхнасан: Нэрээ өгсөн гишүүд л үгээ хэлж байна. Тэгэхээр Д.Ганбат гишүүн ээ, үгээ хэлмээр байна.

Эрхэм гишүүд ээ, эрхэм дарга аа, энэ авлига хулгай зэрэг ноцтой зөрчилд холбогдсон гишүүдэд хариуцлага тооцохыг ёс зүйн шаардлага гэж үзэж байна. Үүнийг нийгэм ч хүлээж байна.

Тийм болохоор үүнтэй эргэлзэх зүйл байхгүй байна. Харин энэ хуулийн төслийг хэлэлцэх явцад зарим заалт нь тодорхой бус байна. Цаашид буруу хэрэглэгдэх ийм эрсдэлтэй байгааг анхаарах шаардлагатай байна. Ийм ч утгаар би энэ хуулийг дэмжихгүй байна.

Нэгдүгээрт, ёс зүйн ноцтой зөрчил гээд л ойлголтыг хуульд тодорхой заагаагүй байна. Нэг мөрөөр тусгаагүй. Энэ субъектив байна. Улмаар энэ улс төрийн зорилгоор ашиглах ийм эрсдэлтэй байна. Өнөөдөр бид сая ёс зүйн ноцтой зөрчил бол багш ингээд оюутандаа дүн тавьж болох уу гэдгийг ёс ярьж байна.

Хоёрдугаарт, ганц иргэний гомдлоор тулгуурласан Их Хурлын гишүүний асуудлыг Ёс зүйн хороод шууд шилжүүлэх ийм зохицуулалт орж байна. Энэ бол гишүүний бүрэн эрх, халдашгүй байдлын баталгаанд сөргөөр нөлөөлж байна гэж үзэж байна.

Жишээлбэл, М.Нарантуяа-Нара гишүүний асуудлыг нэг гишүүнийг нэг иргэний гомдлоор шууд хэлэлцэхэд болохгүй гэж бодож байна.

Гуравдугаарт, энэ хуулийн төсөл Үндсэн хуулийн суурь зарчимтай бүрэн нийцэж байгаа эсэхийг нягтлах шаардлагатай гэж үзэж байна. Энэ эрх зүйн тодорхой байдал, зөрчилгүй зохицуулалт хууль тогтоомжийн үндсэн шаардлага байдаг.

Энэ хуулийн төслийн 9.1.6-д жагсаалтаар сонгосон гишүүдийг нам, эвслийн байгууллагын саналын үндсэн дээр ёс зүйн ноцтой зөрчил гаргасан гэж үзэн эгүүлэн татах боломж олгож байна гэж харж байна. Энэ бол төрийн эрх мэдэл ард түмний мэдэлд байгаа гэсэн Үндсэн хуулийн 3.1-ийн заалтыг зөрчиж байна гэж харж байна.

Намын төв байгууллага бол ард түмний шууд сонгосон байгууллага биш. Ийм учраас Ерөнхийлөгчөөс энэ хуулиа эргүүлэн татна уу гэж хүсэж байна. Баярлалаа. /алга ташив/

С.Бямбацогт: Баярлалаа. Гишүүд хуулийн төсөлтэй холбогдуулж асуулт асууж, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэхийг дэмжих талаар санал хураалтыг 4 дүгээр сарын 10-ны өдрийн Баасан гарагт шилжүүлж санал хураана. 10.00 цагаас.

Мөн өнөөдрийн чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйл, 13 дугаар зүйлд заасны дагуу өнөөдрийн хэлэлцэх асуудлуудад 3 асуудал үлдсэн байгаа. Энэ бүгдийн санал хураалтыг бүгдийг нь маргааш өглөө 10.00 цагаас хураахаар хойшлуулж байна.

Асуудлаа л хэлэлцээд явна. Санал хураалтаа маргааш бөөнд нь 10.00 цагаас.

Бүлэгт үг гэж байхгүй. Завсарлагын үг байж болно. Бүлэгт үг гэж байгаа юм уу? Хуралдаан зохион байгуулах. Завсарлага авахтай холбоотой л гэж би ойлгодог. Аан? Завсарлага авах гэж байгаа бол үг байж болно. Тийм.

Үдээс өмнөх чуулганы хуралдаан. Завсарлага авахтай холбоотой л ярьж байна. Хуралдаан зохион байгуулах микрофондоо хэлээдэх. Г.Агар-Эрдэнэ дарга.

Бүлэгт үг гэж би мэдэхгүй дээ. Завсарлага авах л үг л байх. Тийм. Завсарлага авахтай л холбоотой үг байгаа. Хэлээдэх.

Г.Агар-Эрдэнэ: Тайлбараа хийе. Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд одоо энэ хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явагдаж байгаа.

Хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг дээр урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асуух, үг хэлэх гишүүдийн нэрсийг аваад, дэгийн дагуу зохион байгуулаад дууссан.

Одоо ямар нэгэн байдлаар нэмэлт үг хэлэх зохицуулалт байхгүй байгаа.

С.Бямбацогт: Санал хураалтыг хойшлуулсан. Маргааш 10.00 цагаас болгоод. Өнөөдөр үдээс өмнөх. Х.Тэмүүжин гишүүнд үг өгье.

Х.Тэмүүжин: Яг өнөөдрөөс эхлээд цөөнхийг байхгүй болтол ингэж хүчирхийлэх гэж байгаа юм уу?

Бүлэгт ямар ч нөхцөлд завсарлага авах эсэх шийдвэртэй холбогдуулж үг хэлэх эрх байгаа байхгүй юу.

Яагаад бүлэг үг хэлэх хэрэгцээ байгаа вэ гэхээр би хувь хүнийхээ хувьд Ерөнхийлөгчийн өргөн барьсан энэ хуулийг дэмжиж байгаа.

Гэхдээ Улсын Их Хурлын хэлэлцүүлэг хийх энэ журам чинь өөрөө болохгүй байна.

Монгол Улсын Их Хуралд байгаа 42 гишүүнтэй бүлэгт энэ хууль орж ирсэнгүй. Танилцуулагдсангүй. Ямар асуудлууд байгаа вэ гэдгээр бид ярих боломж олгосонгүй. Бид өнөөдөр нэг шийдвэр гаргахын тулд мэдээлэл авах хэрэгтэй байсан.

Улсын Их Хурлын гишүүн хуралдаа ирэхгүй байгаа, шийдвэр гарахгүй байгаа энэ асуудал дээр Улсын Их Хурлын юу гэдэг юм, парламентын бүрэн эрхтэй холбоотой асуудал нь өөрөө доголдож байгаа гэдэг асуудал дээр бид бүгд санал нэг байгаа. Ерөөсөө маргаагүй.

Үндсэн хуулийн цэцтэй холбоотой 66 дугаар зүйлийн хэсэг дээр байгаа зүйл, заалтыг амилуулах дээр санал нэг байгаа.

Гэхдээ Ардчилсан намын бүлэг юун дээр эргэлзсэн бэ гэхээр Ардын намынхны дотоод зодооноос болоод намын даргадаа эрх мэдэл төвлөрүүлэх гэж оролдож байгаа энэ оролдлого чинь сүүлдээ Улсын Их Хурал дахь цөөнхийг байхгүй болгох гэж байна шүү дээ.

Юуг “ёс зүй” мөн, бишийг чинь олонхоороо Та нар шийднэ. Цөөнхийн таалагдахгүй байгаа үйлдэл болгоныг Та нар ёс зүйн ёстой алдаа гэж үзнэ. Ёс зүйн дэд хороо чинь олонхоороо байж байгаа. Тэгээд дараа нь цөөнхийг дуртай үедээ ийм гомдол ирсэн учраас чамайг бүрэн эрхийг чинь түдгэлзүүлнэ, чамайг Улсын Их Хурлаас зайлуулна гэж олонхоороо шийдвэр гаргах гэж байгаа юм.

Парламентын олонход ийм эрх мэдэл байж болдоггүй юм. Хэмжигдэхгүй зүйлээр хэн нэгэн Улсын Их Хурлын гишүүнийг зайлуулна гэдэг бол цөөнхийн дуу хоолойг дуугүй болгоно гэсэн үг. Цөөнх яагаад энэ хууль дээр хамгийн их эргэлзэж эсэргүүцэж байгаа чинь ерөөсөө энэ. Яагаад парламентын олонх олонхын намын даргад эрх мэдлийг төвлөрүүлэх гэж байгаа юм.

Та нар нам доторх зодооноо Монгол Улсын Үндсэн хуулийн дэг журам, парламентын ардчиллаар тоглож шийдэж болохгүй шүү дээ.

Тэндээ шийддэг юм байгаа биз. Парламентын гишүүн Улсын Их Хуралд ирэхгүй ажлаа хийхгүй байна. Манай намд ч гэсэн тийм хүн байгаа. Тийм хүнд хариуцлага тооцъё. Зөв шүү дээ.

Ерөнхийлөгч тийм л санал гаргаж байна.

Шийдвэр гаргалтад оролцохгүй байна. Та нар. Хуруугаа уншуулчихаад алга боллоо. Улсын Их Хурлын гишүүний ажлыг хуруу нь хийдэг юм уу. Биеэрээ яриад саналаа өг. Зөв шүү дээ.

Би Ерөнхийлөгч энэ бодлогыг дэмжиж байна. Ардчилсан нам ч дэмжиж байна.

Гэхдээ “олсны үзүүрт үхэр” гэдэг шиг ард нь олонх дээрээ, намынхаа дарга дээрээ эрх мэдэл төвлөрүүлж аваад үүнийхээ дараа яах юм. Та нар дотроо хоёр, гурван хүн шийдэх байх. Дараа нь цөөнх рүүгээ орно шүү дээ.

Ардчилсан нам байнга цөөнх болгохгүй шүү. Дараа нь энэ хууль Та нарт үйлчилнэ. Дараа нь цөөнх болоод ирэхэд чинь ёс зүйн ноцтой доголдол гаргасан гээд бүгдийг чинь нэг нэгээр нь жиргээд Улсын Их Хурлаас хөөгөөд гаргана шүү дээ.

Олон ургалч үзэлтэй, олон намын тогтолцоотой парламентын системд бид парламентыг парламентаар нь байлгах ёстой шүү дээ.

С.Бямбацогт оо, Та ийм үүрэгтэй.

М.Нарантуяа-Нара гээд Улсын Их Хурлын гишүүн 8.3 хувийн саналаар Улсын Их Хурлын гишүүн болсон. 92 хувь нь энэ хүнийг дэмжээгүй шүү дээ.

Гудамжинд угаасаа энэ хүний ярьсан болгоны 92 хувь нь эсэргүүцэж байгаа шүү дээ.

Гэхдээ цөөнхийн дуу хоолойг 92 хувь нь амаа барьж болохгүй шүү дээ. Амыг нь барьж болохгүй шүү дээ.

Та бүхэн 36 хувийн саналаар Улсын Их Хуралд орж ирсэн шүү дээ. /минут дуусав/

С.Бямбацогт: Бүлгийн завсарлага авах талаар л бүлэг үг хэлэх ёстой. Тэгээд завсарлага авах талаар Та хэлсэнгүй.

Цаашдаа үүнийг анхаарах ёстой шүү. Бүлгийн дарга бүлгийг төлөөлнө. Бүлгийн дэд дарга төлөөлж болно. Гэхдээ бүлгийнхээ гаргасан нэгдсэн байр суурийг илэрхийлнэ. Хувь гишүүний байр суурь илэрхийлэхгүй.

Тийм болохоор танай бүлэгт хэдийд ч хуулиа хэлэлцэх бололцоо нээлттэй. Хэдийд ч завсарлагаа авч байгаад асуудлаа сонсох асуудал бүрэн эрхтэй, нээлттэй байгаа шүү.

Энэ боломжоо Та харин ашиглах үгээ зөвхөн өөрийнхөө үзэл бодлоо илэрхийллээ. Цаашдаа үгээ хэлэхдээ зөв илэрхийлж байгаарай.

Ингээд үдээс өмнөх чуулганы хуралдаан дууслаа. Үдээс хойш 14.00 цагаас хуралдана. /алх цохив/

ЗАВСАРЛАГА

Үдээс хойших чуулганы хуралдаанаа эхлүүлье.

Хэлэлцэх асуудал. Гурав дахь асуудал хэлэлцэнэ.

Гурав.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн
2025.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар танилцуулна.

Б.Баярбаатар гишүүнийг индэрт урьж байна.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ухнаагийн Отгонбаяр нарын 8 гишүүдээс 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх

эсэх асуудлыг Улсын Их Хурал 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж анхны хэлэлцүүлэг явуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тух тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явууллаа.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, У.Отгонбаяр нар хуулийн төсөлтэй холбогдуулан аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн 50 хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно гэснийг 30 хувь болгох, дагаж мөрдөх хугацааг 2026 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс болгож өөрчлөх зарчмын зөрүүтэй саналын томьёоллууд Байнгын хороонд ирүүлсэн.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулсан бөгөөд олонхын санал авсан аваагүйгээр нь бүлэглэн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Баярмагнайн Баярбаатар гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Нэлээн олон гишүүн асуулт асуухаар нэрс ирүүлжээ.

Ирцийн дарааллаар Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя. Б.Пүрэвдорж гишүүн алга байна.

Даваагийн Цогтбаатар гишүүн асуултаа асууя. Алга байна. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Энэ хуулийн өөрчлөлтөөр аймаг, нийслэлүүдэд давхар дээлтэй болох. Одоо засаг дээр бид Улсын Их Хурлын гишүүд Засгийн газрын

гишүүн давхар дээлтэй бүгдээрээ болдгийн жишээлбэл асуудлыг хангалттай харж байгаа.

Тэгэхээр яах вэ, аймгууд дээр аймаг, нийслэл, сум дээр давхар дээлтэй болох асуудлуудыг орж ирж байна. Одоогийн байгаа хуулиар сум дээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гуравны нэг нь төрийн захиргааны албан хаагч байж болохоор заасан байгааг өргөжүүлээд аймаг, нийслэл дээр. Тэгээд энэ хувийг нь 50 хувь. Дүүргийг бас нэмж байна.

1920-оод оны үед бичиж байсан зүйл уншиж өгье л дөө.

“Улсын эрх”. Цэвээн Жамсран гуайн. “Газар нутаг бүрд эрх биш олны сэтгэлийг хураасан, үнэнч шударга, сайн нэр гарсан хүмүүн нэгэн хоёрын зэрэг байх тул олны төлөөнөө илэрхийлэгчид олдохгүй хэмээн үл болмуй” гэж.

Тэгэхээр 100-аад жилийн өмнө жишээлбэл ингэж ярьж байсан байна.

Тэгэхээр одоо бид энэ давхар дээлтэй, иргэдийн Хурлын Төлөөлөгч, иргэдийн Хурал гэдэг нь өөрөө гүйцэтгэх удирдлага, аймгийн удирдлагуудтайгаа холилддог энэ юмыг улам ингээд дэвэргэх гээд байна.

Одоо жишээлбэл нийслэл дээр байгаа үйл явдлыг харахад ч гэсэн иргэдийн Хурал нь бие даасан үйл ажиллагаагаа явуулах ийм бололцоогүй болж байна. Шүүмжлэлтэй байр сууриас хандах бололцоогүй болж байна. Бүгдээрээ нэг ажил албан тушаал авсан. Амаа үдүүлсэн иймэрхүү байдалтай болж байна.

Улсын Их Хурал дээр ч бид харж байгаа. Засгийн газрын гишүүд нь Улсын Их Хурлын гишүүд 126 боловч бараг 20 гаран гишүүн нь Засгийн газрын гишүүн учраас иргэдийг төлөөлөх энэ эрхээ хязгаарлаад тодорхой хэмжээний байр суурь илэрхийлэх боломжгүй байгаа юм.

Тэгэхээр үүнийг одоо энэ хуулиар өргөжүүлж, аймаг, нийслэл дээр хүн олдохгүй байна гэхээр би гайхаад байгаа юм. Сум дээр ойлгож болж байна. 100 жилийн өмнө асуудалгүй болоод байсан юмыг заавал 50 хувь болгож. Тэгээд аймаг, нийслэл дээр хүн олдохгүй. Үүнийг ингэж өргөтгүүлэх нь буцаад л яг одоо жишээлбэл энэ нийслэл дээр болоод байгаа шиг энэ асуудлуудыг улам дэвэргэх.

Тэгээд ажил, албан тушаал өгөөд л иргэдийг төлөөлөх үйл ажиллагаагаа хэрэгжүүлж чадахгүй, дуу хоолойгоо илэрхийлж чадахгүй иймэрхүү нөхцөл байдал руу оруулах эрсдэл харагдаад байна.

Тэгээд яг энэ хууль санаачлагчдын зүгээс үүнийгээ яг нэг ойлготол тодорхой хэлээд өгөөч.

С.Бямбацогт: У.Отгонбаяр гишүүн. Ухнаагийн Отгонбаяр гишүүн асуултад хариулъя.

У.Отгонбаяр: Д.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Яах вэ, энэ хуульд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд сумын иргэдийн Хурлын Төлөөлөгчдийн гуравны нэг нь төрийн захиргааны алба хашдаг зохицуулалттай.

Тэгээд яах вэ, үүнийг зүгээр нэг бодож байгаад нийслэл, сум, дүүрэг гэж өргөжүүлж байгаа зүйл биш. Зарим газар нийслэлийн иргэдийн Хуралд дэвших хүн олддоггүй. Аль аль намаас. Ний нуугүй л хэлэхэд. Арай нэг боловсролтой, чадалтай, салбараа мэддэг тийм хүмүүс ний нуугүй хэлэхэд их хомсдоод байгаа юм.

Тэгээд нөгөө төрийн захиргааных нь ажил ч явдаггүй, иргэдийн Хурлынх нь ч ажил явдаггүй ийм нөхцөл байдал үүсээд байгаа юм билээ.

Тийм учраас үүнийг энэ хуулиар зохицуулалт хийж, нийслэл, сум, дүүрэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тодорхой хувь нь төрийн захиргааны алба хаших энэ боломжийг л нээж байгаа юм.

Энэ хууль батлагдсанаар маргааш шууд шат шатны иргэдийн Хурлын Төлөөлөгч нар автоматаар төрийн захиргааны албан хаагч болохгүй. Тухайн ажлын байран дээр сул орон тоо гарах ёстой. Тэгээд тухайн ажлын байранд чинь тавигдсан шалгуурууд байгаа. Тэрийг хангаж байгаа ийм л хүмүүс төрийн захиргааны алба хаших боломж бүрдэх юм.

Тэгээд зүгээр энэ боломжийг нь л нээж өгч байгаа юм.

Тэгээд ач холбогдол нь гэвэл цаашдаа шат шатны иргэдийн Хурлын байгууллага, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага чадавхжих боломж бүрдэж байгаа юм л гэж хууль санаачлагч нарын зүгээс үзэж байгаа. Баярлалаа.

С.Бямбацогт: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Би түрүүн зориуд Жамсрангийн Цэвээн гуайн улсын эрх гэдэг 100-аад жилийн өмнө энэ улсын нөхцөл байдлыг үнэлээд бичиж байсан үг, үсгийг уншиж өгсөн.

Гэтэл яах вэ одоо тэр байдал дээрдээгүй гэдэг бол бодит байдалд нийцэхгүй байх гэж бодож байна. Энэ илүү засаглал хоорондын хуваарилалт, хяналт тэнцлийг алдагдуулсан, үүнийг улам л дэвэргэсэн.

Улсын Их Хурал дээрээ байгаа, бүгдээрээ давхар дээлтэй болсон харилцааг одоо бүр орон нутаг руу оруулж эх замбарааг нь алдагдуулах гэж байгаа иймэрхүү л харилцаа харагдаж байгаа юм. Би саяын тайлбараас хангалттай тайлбар авч чадсангүй л дээ.

Тэгэхээр саяын байдлаар тайлбарлаж байгаа энэ хуулийн төслийг дэмжих боломжгүй юм байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Байнгын хорооноос нэмж хариулж болно. Мэргэжлийн Байнгын хороо. Хариулт байна уу? Б.Баярбаатар дарга. Гайгүй юу. Тийм ээ.

Тэгвэл Одсүрэнгийн Номинчимэг гишүүн. Алга байна. Нанзадын Наранбаатар гишүүн асуултаа асууя. Алга байна. Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн асуултаа асууя.

П.Наранбаяр: Баярлалаа.

Тэгэхээр энэ хуулийн төслийг нарийвчилж уншиж, үүнтэй холбоотой гарч болох үр дагавруудыг нэлээн нарийн харсан.

Суманд боловсон хүчин дутмаг учраас гуравны нэг гэсэн юм явж байгаа.

Гэтэл төрийн албаны мерит зарчим гэж байдаг. Төрийн албаны мерит зарчим бол “төрийн улс төрийн алба”, “төрийн захиргааны алба” хоёрыг маш сайн заагласан ийм л зарчим байгаа.

Тэгэхээр энэ зарчмыг ингэж эвдэж болж байгаа юм уу? Үүнийг асуумаар байна.

Хоёрдугаарт, ажил өгөөд амыг нь үддэг ийм л тогтолцоо яваад байна шүү дээ. Өнөөдөр нийслэл дээр юу болж байна. Ерөөсөө амаа үдүүлсэн хүмүүс.

Тэгэхээр “төрийн улс төрийн алба” нь тусдаа яваад улс төрийнхөө ажлыг сайн хийх хэрэгтэй. Захиргааны алба яг хуульд заасан Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-д заасан улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам эвслийн үйл ажиллагаанаас ангид байх гэсэн ийм зарчимтай нь энэ чинь зөрчилдөөд байна.

Макс Веберийн (Max Weber) боловсруулсан Төрийн албаны тухай онолын сонгодог онолыг чинь энэ чинь өөрөө эвдээд байна.

Түрүүн Д.Энхтүвшин гишүүн хэлж байна. 100 жилийн өмнө тэгж бичиж байсан. Энэ олон зарчмыг чинь энэ хууль өөрөө эвдээд байна гэдгийг л би хэлэх гээд байгаа юм.

Ер нь төлөөллийн, нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөгч хүн иргэдийн төлөөлөл байх ёстой.

Түүнээс биш төрийн захиргааны төлөөлөгч биш. Үүнийг хэрэгжүүлдэг хүн чинь Засаг дарга байж байгаа шүү дээ. Төрийн ч төлөөлөл, мөн нутгийн өөрөө удирдах байгууллагатай хамтран ажилладаг ийм хүн.

Тэгэхээр хуулийн шаардлагыг би олж харж чадахгүй байна. Яагаад вэ гэвэл энэ чинь бид ингээд харах юм бол аймаг, нийслэл, дүүрэг хүн ам ихтэй. Угаасаа ихтэй. Боловсон хүчин ихтэй ийм газрууд руу яах гэж оруулах гээд байгаа юм. Энэ шаардлага үнэхээр ийм байна гэдэг тоо баримттай хэлээд өгвөл бас болж байна.

Миний тооцож байгаагаар мянга орчим албан хаагчийн асуудал ярьж байна. Дүүргүүдийн, аймгуудын төлөөлөгч нар.

Тэгэхээр эдний 30-аас 50 хувь нь төрийн захиргааны алба хашаад эхлэх юм бол энэ болохгүй ээ гэж харж байна.

Бид 2022 оны 404 дүгээр тогтоолыг хармаар байгаа юм. Хэмнэлтийн тухай хуулиар явсан. Одоо төлөөлөгч нар урамшуулал авах ямар ч боломжгүй, ажил хийх боломжгүй болчихоод байж байгаа шүү дээ.

Энэ урамшууллыг харин сэргээх ёстой. Ажил хийснийхээ төлөө, хүн төлөөлж ажилласныхаа төлөө урамшуулал авч, тэгээд тэрийгээ өөрсдийнхөө үйл ажиллагаанд зарцуулах эрхийг нь өгөхгүй бол өнөөдөр бид энэ нутгийн өөрөө удирдах байгууллага руу орж ирэх хүнгүй болж байгаа чинь үүнтэй л холбоотой.

Тэгэхээр сонгуульт ажилтан ийм хүмүүст бид энэ урамшууллыг нь өгөх тал дээр, тэрийг нь ил тод өгөх ёстой. Ийм л хуулийн төслүүдийг санаачилж орж ирвэл сайн болохоос биш одоо ингээд ажилгүй болсон хүмүүсийг төрийн захиргаанд нь оруулж, цалингүй болсон хүмүүсийг тэндээс нь цалин авч өгнө гэдэг энэ логикийг би ойлгохгүй байгаа юм. Над шиг ийм бодолтой хүмүүсийг Та бүхэн бүр ятгаад, яг ийм учиртай юм гээд ятгаад өгөөч ээ. Тэгээд чадахгүй бол энэ хуулиа эргүүлээд татаач ээ л гэж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

С.Бямбацогт: Одоо хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явж байгаа. Хуулийн төслийг хэлэлцэх эсэх дээр дэмжих, дэмжихгүй талаар асуулт асууж, үг хэлэх.

Анхны хэлэлцүүлэг дээр Төрийн байгуулалтын байнгын хорооны хурлаар анхны хэлэлцүүлэг хийсэн, зарчмын зөрүүтэй санал гарсан талаарх санал, дүгнэлттэй холбогдуулж Төрийн байгуулалтын байнгын хорооноос асуух дэгтэй.

Тийм болохоор Төрийн байгуулалтын байнгын хороо даргагүй байгаа. Тэгээд Төрийн байгуулалтын байнгын хорооныхоо даргын асуудлыг яаралтай шийдмээр байна. Олонхын бүлэг энэ асуудалдаа анхааралдаа авна уу. Асуудлыг.

Төрийн байгуулалтын байнгын хороо даргагүй байгаа учраас сая Байнгын хорооны санал, дүгнэлтийг уншсан Баярмагнайн Баярбаатар гишүүн асуултад хариулъя.

Б.Баярбаатар: П.Наранбаяр гишүүний хэлж байгаа зарим зүйлүүд бас нэг талаасаа зөв.

С.Бямбацогт: Уучлаарай. Түр хүлээж байхгүй юу. Энэ мэндчилгээ дэвшүүлэхгүй бол хүүхдүүд.

Нийслэлийн ерөнхий боловсролын 48 дугаар сургуулийн 11-ийн “б” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүгдийнхээ сурлагад нь өндөр амжилт хүсье. Амьдралд нь аз жаргалыг хүсье.

Нийт Их Хурлынхаа гишүүдийн нэрийн өмнөөс. /алга ташив/

Онц сураарай. Тэгээд удахгүй төгсөх гэж байгаа юм байна. Хүссэн сургуульд ороорой. Баярлалаа. Та бүхэндээ.

Баярмагнайн Баярбаатар гишүүн асуултад хариулъя.

Б.Баярбаатар: Тийм. П.Наранбаяр гишүүний хэлсэн саналтай зарим талаар санал нийлж байгаа юм.

Үндсэндээ бид тодорхой түвшинд ухралт хийж байгаа юу гэвэл тийм. Тэгэхдээ өнөөдөр тэр цаг үеэ бодвол бид яг өнөөдрийн цаг үед тулгамдаж байгаа асуудал дээрээ өнөөдөр асуудал ярих ёстой.

Өнөөдөр Та Макс Веберийг эш татаж ярьж байх шиг байна. Улс төр мэргэжил юм гэдгийг.

Нөгөө талаар яг Макс Вебер дээр чинь улс төрчийг хоёр ангилсан байдаг. Тийм.

- Нэг нь, улс төрд амьдралаа зориулдаг.
- Нэг нь, улс төрөөр амьдралаа залгуулдаг

-гэж хоёр ангилсан байгаа.

Өнөөдрийн цаг үе дээр тухайн үед энэ нийслэлийн аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийг төрийн захиргааны албан хаагчдыг давхар хашдаггүй болгох ийм цаг үе дээрээ тухайн иргэдийн Хурлын Төлөөлөгч нар чинь тодорхой

түвшний бас нэг ийм тойрогтоо зарцуулах төсөв санхүү юмнуудтай байсан. Байсан.

Өнөөдөр энэ хурлын төлөөлөгч—

- цалин ч байхгүй,
- тодорхой түвшний үйл ажиллагааны төсөв ч байхгүй.

Мэдээж иргэдийн төлөөлөл мөн. Иргэдийн төлөөлөл тодорхой түвшинд тухайн орон нутгийнхаа хуралд асуудал дэвшүүлж оруулдаг эрх, үүрэгтэй байх ёстой гэж хардаг.

Тийм учраас өнөөдөр энэ цаг үед. Зүгээр Байнгын хороон дээр санал хураалтаар тэр 50 хувийг 30 хувь болгоё гэдэг санал унасан. Би энэ дээр харин тэр 50 хувь харин их байна. 30 хувь харин тодорхой түвшинд сумтайгаа адилхан байх ёстой гэдэг зарчмын байр суурь илэрхийлээд явсан гэдгийг Танд хэлье.

С.Бямбацогт: Ухнаагийн Отгонбаяр гишүүн нэмэлт хариулт. 1 минут.

У.Отгонбаяр: П.Наранбаяр гишүүний асуултад хариулья.

П.Наранбаяр гишүүний хэлж байгаа зарим зүйлтэй ний нуугүй хэлэхэд санал нэг байгаа. Таны санаа зовниж байгаа тэр мерит зарчим алдагдах вий гэдэг дээр бодоогүй биш бодож үзсэн.

Тэгээд миний түрүүний хэлээд байгаа энэ чинь боломжийг нь л нээж байгаа юм.

Түүнээс биш иргэдийн Хурлын Төлөөлөгч шууд дарга болно гэж байгаа зүйл огтоосоо биш. Тухайн хүн өөрийнхөө ажил мэргэжлээр мэргэшсэн салбартаа, мэргэжилтнээсээ эхлээд л ажиллах боломж нь нээгдэж байгаа юм.

Тэгээд би дахин давтан хэлэхэд иргэдийн Хурлын Төлөөлөгч нар шууд дарга болох тийм боломж угаасаа байхгүй. Тодорхой шалгууруудыг хангасан тийм л хүн төрийн захиргааны алба хаших боломж нь бүрдэж байгаа юм.

Энэ бол улсын хэмжээнд аймаг, сум, нийслэл, дүүргийн хэмжээнд... /минут дуусав/

С.Бямбацогт: Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн тодруулж асууя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр Та бүхэн яг энэ мерит зарчмын тал дээр надтай адилхан бодолтой байгаа юм байна гэж ойлголоо.

Яах вэ, боломжийг бий болгоно гэж яриад байна. Тэгэхдээ нэг ийм юм байдаг юм шүү. Майхны амаар нэг их хөөрхөн туулайн хамар ороод ирлээ гээд

оруултал тэмээ ороод ирдэг. Тэгээд майхныг эвддэг. Яг үүнтэй адилхан үзэгдэл үүснэ шүү.

Төрийн албаны тогтвортой байдал. 6 шинж чанарыг нь Макс Вебер хэлсэн юм шүү дээ.

Төрийн албаны тогтвортой байдал, залгамж чанар, удирдах удирдуулах ёс. Энэ бүх зүйлийг хэлсэн.

Төрийн захиргааны алба чинь улс төрийн албанаасаа ялгаатай.

Энэ Төрийн албаны тухай хуулийг 1994 онд гаргаснаасаа хойш энэ зарчмыг төлөө л явсан шүү дээ.

Тэгэхээр зэрэг энэ асуудал дээр яг би боловсон хүчин дутсандаа ингэж байна гэж бодохгүй байгаа. Харин төлөөлөгчийн ажиллах орчныг л би сайжруулах тал дээр л анхаарах ёстой.

С.Бямбацогт: П.Наранбаяр гишүүн үг хэллээ. Сүхбаатар Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Яах вэ, бид засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг ярихдаа ер нь агуулгыг цогцоор нь авч үзэх зайлшгүй шаардлага байгаа.

Жишээлбэл, бид ноднин–

- Хархорин төслийн тухай шийдвэр гаргасан.
- Хүннү хот гээд шийдвэр гаргасан.
- Майдар гээд нэлээн өмнө нь шийдвэр гаргасан.

Тэгээд маш олон цаасан дээр хотууд яриад байдаг. Дээрээс нь Хот, тосгоны хууль гээд явдаг. Үндсэндээ яг энэ дотор хоорондоо зөрчилтэй маш олон зүйлүүд байгаа юм.

Ерөнхийдөө хуулийн үзэл санааг дэмжиж байгаа. Яагаад гэхээр би Дархан-Уул, Төв, Сэлэнгэ аймгаас сонгогдсон гишүүнийхээ хувьд яг амьдрал дээр нь очихоор энэ төрлийн зохицуулалт шаардлагатай гэвэл шаардлагатай байдаг. Одоо яг үндэслэл нь ойлгож байгаа.

Зүгээр яг одоо бид нарт иргэдийн амьдрал дээр, яг орон нутагт ямар асуудал хэрэгтэй байна вэ гээд үзэхээр жишээлбэл Дархан-Уул аймгийн Ширээнурзуу гэдэг газар дээр амьдарч байгаа хүмүүс Сэлэнгэ аймгийн Сайхан сумтай газрын зөрчилтэй болдог. Жишээлбэл, энэ жил 01 сарын 01-нээс эхлүүлээд 4 сарын 01-ний хоорондох энэ 4 сарын хугацаанд жишээлбэл Дарханы статистикийг хэлэхэд тэнд нийтдээ үл хөдлөх хөрөнгө худалдаж авч байгаа хувь

хэмжээний 33 хувь нь Сэлэнгэ аймгийн регистрийн дугаартай хүмүүс үл хөдлөх авч байгаа юм.

Яг ингээд бодитой байдлаар гэхэд сум хоорондоо хилийн цэсийн асар их маргаантай, аймаг хоорондоо хилийн цэсийн маш их маргаантай асуудлууд байгаа.

Тэгэхээр хилийн цэс, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын асуудлыг ер нь ярихдаа. Энэ бол яах вэ нэг л заалттай зүйл байгаа шүү дээ. Хууль дээр өөрчлөлт орох гээд байгаа шүү дээ.

Ер нь том зургаар нь харах юм бид аль болохоор амьдрал дээр тохиолдож байгаа энэ олон сумд бөгөөд энэ олон аймгууд хоорондын хилийн цэсийн маргааны асуудлуудыг иргэддээ ээлтэйгээр шийдвэрлэх тэр зүйлийг бид бодох ёстой юм шиг байгаа юм. Нэг.

Хоёрдугаарт, энэ үндэслэл дээр байж байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагыг хэрэгжүүлэхэд төрийн байгууламжийн нэгдмэл байдлыг хангах, улсын болон орон нутгийн ашиг сонирхлыг хослуулах, нутгийн өөрөө удирдах байгууллага нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан шийдвэрлэх гэсэн ийм зайлшгүй шаардлагатай гэж харагдаж байгаа.

Энэ зүйл дээр иргэний тэр суманд, тэр сумын төвийн багуудад аж төрж амьдарч байгаа иргэний эрхийг хамгаалсан, тэнд байгаа оршин суугчдын гэх юм уу даа, эрхийг хамгаалсан энэ зохицуулалтууд, энэ шаардлага нь эхэндээ баймаар байгаа юм. Эхэндээ баймаар байгаа юм.

Өөрөөр хэлбэл төрийн үйлчилгээ иргэдэд саад багатай хүрч байх. Энэ үйлчилгээг нь хийж байгаа тэр дундын төрийн албан хаагчид юм уу, захиргааны албан хаагчдаа иргэдийн эрх ашгийг хамгаалахад хуулийн хүрээнд бүрэн дүүрэн ажиллах боломжоор хангахын тулд ийм зохицуулалт хэрэгтэй байна гэдэг үндэслэлийг хэлэлцүүлгийн явцад оруулж ирэх юм бол энэ бас их зөв болно.

Нөгөө талаас бид 2024 оны 11 сарын 28 шиг ч гэж санаж байна. Парламентын “Хүн төвтэй бодлого” гаргах ийм 5 шалгуурыг баталсан байгаа.

Тэгээд энэ төлөвлөгөөгөө Төрийн байгуулалтын байнгын хороогоор жил болгон оруулаад явж байгаа. Энэ жилийнх ороогүй явж байна. Одоо жишээлбэл. Өнгөрсөн жилийнх төлөвлөгөө нь ороод тэгээд хэрэгжилт нь дүгнэгдээгүй явж байгаа. Энэ жил нь ороогүй байгаа.

Тэгэхээр С.Бямбацогт дарга аа, парламентаас гарч байгаа хуулиуд маань яг тэр өмнөх батлагдсан “Хүн төвтэй байх” 5 шалгуураараа ингээд орвол ер нь хууль болгоны манлай дээр, магнай дээр нь, үндэслэл дээр нь хүний эрх, эрх чөлөөг хангах талаасаа бид асуудлуудыг тавьж өгөх нь их зөв суурь болоод

байгаа. Тэгж байж бид чинь энэ ардчилсан төр, парламентын ил тод, нээлттэй байдал, хүний эрхийг дээдэлсэн гэдэг зарчим маань явна.

Яг засаглалын механизмыг зөв үр дүнтэй явуулах талаас нь дэмжиж байгаа ч гэсэн түүний эцсийн очих цэг нь “хүний эрх” байна гэж үзэж байгаа.

Тийм учраас хууль санаачлагчдаас асуухад нь. 1 минут.

С.Бямбацогт: Анхны хэлэлцүүлэг явж байгаа.

Тийм болохоор Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууна. С.Эрдэнэболд гишүүнд 1 минут өгье.

С.Эрдэнэболд: Тийм. Тэгэхээр ерөнхийдөө би Хүний эрхийн дэд хорооны ажлыг хийж байгаагийн хувьд л асууж байна л даа.

Яг энэ хууль зайлшгүй батлагдах үндэслэл дээр тухайн орон нутагт байгаа хүний эрхийн төрийн үйлчилгээ авах ижил тэнцүү гараа, Үндсэн хуулийн эрхээ эдлэхэд ямар ач холбогдолтой талаас нь хууль санаачлагч нар байр сууриа илэрхийлнэ үү?

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхлангийн урилгаар Дархан-Уул аймгийн 21 дүгээр цэцэрлэгийн багш, ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүгдийнхээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг нийт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе. /алга ташив/

Баярмагнайн Баярбаатар гишүүн Төрийн байгуулалтын байнгын хороо. Дэгээрээ уг нь Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж л асуулт асууж, хариулт өгөх учиртай л даа.

Тийм болохоор Байнгын хороо л хариулах дэгтэй байгаа юм. Гишүүд асуулт асуухдаа Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуугаарай гэдгийг хэлье. Баярмагнайн Баярбаатар гишүүн.

Б.Баярбаатар: Хууль санаачлагчаас асуусан.

Тэгэхдээ манай хууль өнөөдрийн хэлэлцэгдээд Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн. Дэмжсэн үндэслэл дээр С.Эрдэнэболд гишүүний хэлж байгаа хүний эрх чиглэл талаас нь асууж байгаа.

Тэгээд ер нь хүний эрхийг дээдэлсэн хууль гэж харж байгаа. Нэг талаараа.

Өнөөдөр аймаг, нийслэлийн иргэдийн Хурлын Төлөөлөгчид нийтдээ 757 орчим байгаа. Үүний 50 хувь нь өөрөө төрийн албан хаагчийн төлөөллөөс бүрдэж орж ирсэн төлөөлөл байгаа учраас.

Аливаа хуулиудаа бид өнөөдөр Хүний эрхийн комиссоос тодорхой түвшинд санал авч, ирсэн саналыг нь хуулийн төсөлдөө тодорхой түвшинд тусгаж ямар нэгэн хүний эрхтэй зөрчилдөж байгаа эсэх талаар нь тодорхой дүгнэлтүүдийг авч энэ хуулийн төслүүд явж байгаа гэдгийг Танд хэлье.

С.Бямбацогт: Доржзодовын Энхтуяа гишүүн асуултаа асууя. Алга байна. Сархадын Зулпхар гишүүн асуултаа асууя. Алга байна. Цэндийн Баатархүү гишүүн асуултаа асууя. Алга байна. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн асуулт асууя. Алга байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя. Алга байна.

Байнгын хорооны санал, дүгнэлт танилцуулсан Баярмагнайн Баярбаатар гишүүн өөрөөсөө асуух нь хэрэггүй байх аа. Тэгье. Б.Баярбаатар гишүүн.

Б.Баярбаатар: Би хуулийн төслийг дэмжиж байгаа агуулгаар үг хэлье гэж бодсон. Тэгээд өнөөдөр нэрээ өгөөд.

Яах вэ, өнөөдөр бид Засаг захиргааны нэгжийн хууль, Төрийн албаны тухай хууль, Орон нутгийн сонгуулийн тухай хууль гэсэн энэ хуулиудын хоорондын уялдаа өнөөдөр алдагдсаны гор нь энэ байгаа юм. Өнөөдөр энэ орон нутаг бид ялангуяа алслагдсан аймаг, сум, сууринтай ийм газар нутагтай улс, нутгийн өөрөө удирдах ёс үйлчилдэг улс.

Тэгээд энэ дээр бид энэ орон нутаг эзэнтэй байх ёстой, удирдлагатай байх ёстой гэдэг агуулгаар.

Нэг талаараа зарим гишүүдийн хэлж байгаатай би санал нэг байгаа. Энэ юу вэ гэхээр өнөөдөр Засаг даргад хяналт тавьдаг байгууллага бол иргэдийн Хурал.

- Хурлын танхимд орохоороо Засаг даргынхаа үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгдөг.
- Тамгын газар дээр орохоороо Засаг даргынхаа удирдлага доор ажилладаг нөхцөл байдлыг л алдагдлаа гэж хэлээд байгаа.

Энэ нэг талаараа зөв. Тэгэхдээ бид аймаг, нийслэлийн иргэдийн Хурлын Төлөөлөгчдийнхөө үйл ажиллагаа явуулах нийгмийн баталгааг нь хангаж өгөх ёстой. Зайлшгүй шаардлага байгаа юм.

Өнөөдөр тулгамдаж байгаа асуудал мөн үү, гэвэл мөн. Орон нутгийн түвшиндээ. Өнөөдөр энэ хуулийг дэмжиж батлаад, цаашлаад дараа дараадаа

миний энэ хэлсэн энэ 3 хуулийн хоорондын уялдааг хангаж илүү боловсронгуй болгож, орон нутагт улс төрийн болон төрийн захиргааны албан хаагчид аль аль нь өнөөдөр энэ үйл ажиллагаа явуулах боломжийг, хуулийг бид цогцоор нь нэг харж, том зургаар нь харж баталж хуулийн нэмэлт, өөрчлөлтийг оруулах нь зүйтэй болов уу гэсэн ийм саналтай байгаа.

Орон нутгаар явахад өнөөдрийн энэ хуулийн төсөлтэй холбогдуулан иргэдээс олон саналууд гарч байсан.

Тэгээд энэ саналыг өнөөдөр би Байнгын хорооны зүгээс ч тэр, хувь гишүүнийхээ зүгээс тэр дэмжиж байгаагаа илэрхийлээд үг хэлье. Надад асуулт алга. Дарга аа.

С.Бямбацогт: Баярлалаа. Цэндийн Баатархүү гишүүн асуултаа асууя.

Ц.Баатархүү: Анхны хэлэлцүүлэг дээр У.Отгонбаяр гишүүнд би хэлж байсан.

Энэ хуулийг цогцоор нь санаачилж байгаа болон Улсын Их Хурлын гишүүдтэй нийлээд нэг мөсөн оруулаад ирээч ээ. Үндсэн хуулийн дараа орох орон нутгийн, нутгийн удирдлагын, засаг, захиргааны нэгжийн хамгийн том хууль.

Тийм учраас сайтар хэлэлцээд парламент нэг тийш нь гаргая гэдэг ийм саналыг хэлсэн. Энэ санал дээрээ би хэвээрээ байгаа гэдгээ албан ёсоор илэрхийлье.

Өнөөдөр нийслэл Улаанбаатар хотын 45 төлөөлөгчийн 40 орчим хувь нь Засаг даргын агентлаг, төрийн өмчит, орон нутгийн өмчит компанийн захирал болсон.

Иргэдийн Хурлын Төлөөлөгчид Засаг даргынхаа үйл ажиллагааг хуулийн хүрээнд төсөв, санхүүгийн хяналт тавих, иргэдээ төлөөлөх, иргэдийн дуу хоолой байх энэ боломж, энэ эрхээ алдсаар байна.

Ардчиллын хамгийн гол тулгуур нь нутгийн удирдах ёс байдаг.

Тэгэхээр иргэдийн Хурлын Төлөөлөгч нар дэвших хүн олдохгүй байна, төрийн захиргааны байгууллагад ажиллах хүн олдохгүй байна гэдэг бол асуудал биш. Асуудлын шалтгаан нь орон нутгийг бид хөгжүүлэх хэрэгтэй байна, орон нутгийг хөгжүүлэх бодлого гаргах хэрэгтэй байна.

Иргэдийн Хурлын Төлөөлөгчөөр ажиллаж байгаа тэр иргэдийн Хурлын хэлэлцэх асуудлыг өнөөдөр Улсын Их Хурал, тэр дундаа зарим тохиолдолд Засгийн газар булааж авчхаад байна шүү дээ.

Хороон дээр хорооны хурал болохоо байлаа. Хорооны хурал болохгүй байгаа учраас хорооныхоо Засаг даргад нийт нийслэлийн иргэд үнэлэлт дүгнэлт өгч чадахаа больсон. Монгол Улсын Үндсэн хууль энд зөрчигдөж байна.

Улаанбаатар хотын иргэд хорооны Засаг дарга сайн ажиллаж байна уу, муу ажиллаж байна уу гэдэг дүгнэлтээ өгч чадахгүй зөвхөн улс төрийн нам, хорооны удирдлагыг томилдог, хорооны иргэдийн нийтийн зөвлөл нь хуралддаггүй ийм байдалтай байна.

Энэ бол 2021 оноос хойш иймэрхүү байдал ажиглагдаж байна. Сая би Чингэлтэй дүүргийнхээ хороодоор явлаа. Иргэд эвлэлдэн нэгдээд хуралдаж, хотынхоо төлөвлөлтийг, хорооныхоо төлөвлөлтийг хэлэлцмээр байна гэсэн ийм шаардлагыг хэлж байна.

Тийм учраас би албан ёсоор хороодын хурлыг хийх, нэгжийн хуульд өөрчлөлт оруулах, Монгол Улсын Үндсэн хуулийг мөрдүүлэх, нийслэл Улаанбаатар хотын иргэдийн иргэдээ төлөөлөх тэр эрхийг хамгаалахын төлөө ажиллах болно гэдэг ийм л үгийг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

С.Бямбацогт: Үг хэллээ. Тийм үү. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Одоо Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураах ёстой. Зарчмын зөрүүтэй хоёр санал байгаа.

Тэгээд өнөөдрөөс Ардчилсан намын Үндэсний бодлогын хороо хуралдаж байна. Гишүүд маань хоёр талт хуралтай байгаа учраас санал хураалтыг хойшлуулъя. Маргааш 10.00 цагаас болгоё.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйл, 13 дугаар зүйлд заасны дагуу энэ хоёр санал хураалтыг маргаашийн 10.00 цагийн чуулган руу шилжүүлж байна. /алх цохив/

Дараагийн асуудалдаа оръё.

Дөрөв.Санхүүгийн хоршооны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Б.Заяабал нар 2025.12.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Санхүүгийн хоршооны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Б.Заяабал нарын гишүүд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн.

Хэлэлцэх эсэх асуудлыг шийднэ. Хэлэлцүүлэг явуулна.

Хууль санаачилсан илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Энэ хооронд Орхон аймгийн “Yes Mongolia” төрийн бус байгууллагын гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхний ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе. /алга ташив/

Баярлалаа. Д.Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Санхүүгийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын хамт санаачлан боловсрууллаа.

Санхүүгийн хоршооны тухай хуулийн төсөл нь 13 бүлэг, 93 зүйлтэй бөгөөд энэхүү төсөлтэй хамт Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Санхүүгийн хоршооны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус хамтатган боловсруулсан болно.

Хуулийн төслийг Дархан, Сэлэнгэ, Орхон, Булган, Дундговь, Дорноговь аймаг болон Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа хадгаламж, зээлийн хоршоонд болон иргэдийг оролцуулан хэлэлцүүлж, 2025 оны 7 сарын 30-ны өдрөөс хойш **d.parliament.mn** цахим хаягаар дамжуулан олон нийтээс санал авч ирүүлсэн саналыг хуулийн төсөлд тусгасан болно.

Монгол Улсад хадгаламж, зээлийн хоршоо 1996 оноос хойш байгуулагдаж түүхийн тодорхой үе шатуудыг давж өнөөдрийг хүрсэн байдаг.

Хадгаламж, зээлийн хоршооны тухай асуудал 2005-2006 онд хямралын хэмжээнд үүсэж, зохицуулалт хангалтгүй, иргэдийн хоршооны тухай мэдлэг муу

байснаас зарим хоршоодын үйл ажиллагаа ашгийн төлөө бус байх үндсэн зорилгоосоо гажиж банк, хөрөнгө оруулалтын сангийн шинжтэйгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, анх үүсгэн байгуулсан бүлэг этгээдүүдэд хоршооны удирдлага төвлөрснөөс олон гишүүн, хадгаламж эзэмшигчийн эрх ашиг хохирсон юм.

Энэ үйл явдал дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн хоршооллын нэр хүндийг Монгол Улсад унагасан ийм хор уршгийг авчирсан түүхтэй.

Үүссэн нөхцөл байдлыг засаж залруулах зорилгоор Улсын Их Хурлаас 2011 онд Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг баталснаар өнөөдрийн байдлаар Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль 15 жилийн хугацаанд хэрэгжиж байна. Энэ хуульд–

- 2015 онд Зөрчлийн тухай хууль баталсантай холбоотойгоор,
- 2022 онд Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулсантай холбоотойгоор,
- 2023 онд Зөвшөөрлийн хуульд шинэчилэн найруулсантай холбоотойгоор,
- 2024 онд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотой–

-хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор 4 удаа өөрчлөлт орсон байдаг.

Өөрөөр энэ хуульд өөрчлөлт шинэчлэлт хийгдээгүй байна.

Өнөөдрийн байдлаар манай улсад 172 хадгаламж, зээлийн хоршоо үйл ажиллагаа явуулж байгаагийн 53.5 хувь нь орон нутагт, 46.5 хувь нь Улаанбаатар хотод байна.

2025 оны байдлаар салбарын нийт хөрөнгө оруулалт 376.0 тэрбум төгрөгт хүрч, дотоодын нийт бүтээгдэхүүний 0.5 хувь, гол үзүүлэлт болох хадгаламж болон зээлийн дүн, банкны зах зээлийн мөн үзүүлэлтийн 0.8 хувьтай тэнцэж байна.

Манай улсад нэг зээлдэгчид ногдох дундаж зээл 10.3 сая төгрөг байгаа бөгөөд Улаанбаатар хотод 17.4 сая, орон нутагт 4.9 сая төгрөг байна.

Нэг хадгаламж эзэмшигчид ногдох дундаж хадгаламж 5.3 сая төгрөг бөгөөд тус үзүүлэлт нь Улаанбаатар хотод 7.5 сая, орон нутагт 2.9 сая байгаа юм.

Нийт гишүүд болох 77 мянга 155 иргэн байгаа нь эдийн засгийн идэвхтэй хүн амын 5.5 хувийг эзэлж байгаа бөгөөд Ази тивийн хувьд дундаж түвшинтэй ойролцоо, дэлхийн хэмжээний дундаж үзүүлэлтээс 5.7 хувь доогуур байна.

Монгол Улсын хүн амын 18-аас 64 насны 26 хүн тутмын нэг нь хадгаламж, зээлийн хоршооны гишүүн, 71 хүн тутмын нэг нь зээл авсан, 41 хүн тутмын нэг нь хадгаламж төвлөрүүлсэн байна.

Иймд өнөөдөр тасралтгүй хөгжиж байгаа зах зээлийн чиг хандлагад тохирсон зохицуулалтыг хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд бий болгох хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, гишүүдийн санхүүгийн хэрэгцээнээс гадна нийгэм, соёлын хэрэгцээг хангаж чадахуйц орчин үеийн хоршоодыг хөгжүүлэх олон улсын хандлагад нийцүүлэх шаардлага тулгарч байгаа юм.

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Санхүүгийн хоршооны тухай хууль нэртэйгээр өргөн барьж, энэхүү төсөл батлагдсанаар дараах үр дүнд хүрнэ гэж хууль санаачлагчийн хувьд үзэж байна.

1.Санхүүгийн хоршооны салбарын нэгдсэн дэд бүтэц буюу тогтворжуулалтын сан, хадгаламжийн даатгал зэрэг хамгаалалтын олон давхаргат тогтолцоог олон улсын түвшинд нийцсэн байдлаар үе шаттайгаар нэвтрүүлснээр салбарын нэгдсэн бодлого, удирдлагын хувьд төрд үүсэх дарамтгүйгээр санхүүгийн хоршооны удирдлагыг тогтвортой хөгжүүлнэ.

2.Санхүүгийн хоршооны засаглал, санхүүгийн тайлагнал, технологийн дэвшил, цахим шилжилттэй холбоотой өөрчлөлтүүдийг тусгаж, ашгийн төлөө бус, хуулийн этгээд байх нарийвчилсан зохицуулалтуудыг хийснээр санхүүгийн хоршооны зах зээлийн тогтвортой байдлыг хангах, зах зээлийн өсөлтийн нөхцөлийг бүрдүүлэх, гишүүн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах механизм боловсронгуй болно гэж үзэж байна.

3.Санхүүгийн хоршоогоор дамжуулан иргэдэд санхүүгийн боловсрол олгож, зөв дадал хэвшил суулгаснаар төв газраас алслагдсан орон нутгийн иргэдэд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, гишүүдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн хүн төвтэй хоршоодыг хөгжүүлж, сүүдрийн эдийн засагтай тэмцэхэд тусална.

4.Санхүүгийн хоршооноос үйлчилгээ авах шаардлагатай, боломжтой бүхий л хүнд хүрч үйлчлэхийг зорьдог гишүүдтэй ойр байгууллага хоршоо учраас үүнээс үүссэн ашиг тухайн орон нутагт гишүүдтэй үлдэж, орон нутгийг хөгжүүлнэ.

5.Санхүүгийн хоршоо нь гишүүдийн хэрэгцээг хангах зорилгоор бичил, дунд, жижиг, дунд бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээг орон нутагт хөгжүүлж, ногоон санхүүг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлснээр ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад байгаль орчныг хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулах юм.

6.Хуулийн төсөл батлагдсанаар санхүүгийн хоршооны үйл ажиллагаанд тавьж буй хяналт, шалгалтын үр нөлөө, эрсдэлийн удирдлагын тогтолцоог

сайжруулж, зохицуулалтын эрх зүйн орчин олон улсын жишигт нийцэж санхүүгийн салбарт бий болж байгаа хүндэрч болзошгүй эрсдэлүүдийг урьдчилан тооцох, түүнээс сэргийлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангаж салбарын хөгжлийг дэмжих таатай орчин бүрдэнэ гэж үзэж байгаа юм.

Мөн санхүүгийн хоршооны үйл ажиллагааны цар хүрээ өргөжиж, санхүүгийн шинэ үйлчилгээ бий болох, санхүүгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэх, гишүүн төвтэй зохицуулалтын орчин бүрдэх юм.

Санхүүгийн салбарын хөгжлийг эрчимжүүлж, цаашдын салбарын хөгжлийг дэмжсэн чухал арга хэмжээ болно гэж хууль санаачлагчийн хувьд авч үзэж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Санхүүгийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон түүнтэй хамт мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэн дэмжиж өгөхийг Та бүхнээсээ хүсэж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд танилцуулна.

Л.Соронзонболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Б.Заяабал нараас 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Санхүүгийн хоршооны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчдын зүгээс Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг шинэчлэн найруулж, Санхүүгийн хоршооны тухай хууль болгон баталснаар энэ салбарт гурван давхаргат хамгаалалтын тогтолцоог нэвтрүүлж, салбарын нэгдсэн дэд бүтцийг бий болгохоос гадна санхүүгийн хоршооны үндсэн зорилго болох гишүүдийнхээ эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах, гишүүдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн хүн төвтэй ашгийн төлөө бус хуулийн этгээд байх нарийвчилсан зохицуулалтуудыг нэвтрүүлж, зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, салбарын цаашдын өсөлтийг дэмжих эрх зүйн орчин бүрдэнэ гэж үзжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед–

- Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай энэ хууль хэрэгжсэнээр санхүүгийн хоршооны хэдэн төрлийн бүтээгдэхүүн бий болох, эдийн засгийн салбаруудад ямар нөлөө үзүүлнэ гэж харж байгаа талаар. Мөн санхүүгийн хоршоо нь банк болон банк бус санхүүгийн салбартай өрсөлдөх зохистой харьцааг хэд болно гэж харж байгаа талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Хуулийн төслийн талаар Монголбанк, арилжааны банк болон хадгаламж, зээлийн хоршоодын хэлэлцүүлэг хийж, санал судалгаа авсан эсэх, санхүүгийн хоршоодын нэгдсэн төв гэсэн нэр томъёоны талаар,
- Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг Санхүүгийн хоршоодын эрсдэлийн удирдлагын стандарт нь банк бус санхүүгийн байгууллагын болон банкны салбарын стандарттай хэрхэн нийцэж байгаа талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа Санхүүгийн зохицуулах хороо нь хадгаламж, зээлийн хоршоодын хадгаламж эзэмшигчдийг хамгаалах, зохистой харьцааг хянах тал дээр хэр хүртээмжтэй ажиллаж байгаа талаар. Мөн хуулийн төсөлд санхүүгийн хоршоо аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөгдөнө гэж заасан талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.2-т сумын насанд хүрсэн хүн амын 50-иас дээш хувийг гишүүнээр элсүүлсэн санхүүгийн хоршоонд орон нутаг хөгжүүлэх зориулалттай сан, ашигт малтмал ашиглах, хайгуул олборлолт хийх Аж ахуйн нэгжийн хандив, тусламжийн мөнгөн хөрөнгийг шилжүүлж, тухайн сумыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэж заасан талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д төлбөр тооцооны үйлчилгээг Монголбанкнаас зөвшөөрөл авсан тохиолдолд эрхлэхээр заасан байдаг бөгөөд төлбөр тооцоотой холбоотой үйлчилгээ эрхлэгч нь тодорхой хэмжээний хөрвөх чадвар болон төлбөрийн чадвартай байхыг шаарддаг тул санхүүгийн хоршоо, ялангуяа сумд үйл ажиллагаа явуулах санхүүгийн хоршоод энэ хэмжээнд ажиллаж чадах эсэх талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл нийслэлтэй холбоотой байгуулсан хадгаламж, зээлийн хоршооны талаар болон Санхүүгийн хоршооны тухай хуулийн төсөлд тусгасан татварын хөнгөлөлтийн талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцаануудыг зохицуулж байгаа заалтууд хоёрдмол утгатай байгаа талаар,

- Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг санхүүгийн хоршоо гэсэн хуулийн этгээдийн хэлбэр, түүнийг дагасан засаглалын асуудал, бусад орны жишээн дээрх хоршоо ашгийн төлөө болон ашгийн төлөө бус байх асуудлыг санхүүгийн хоршооны зохицуулалтад хэрхэн авч үзэж байгаа талаар болон зөвхөн гишүүддээ үйлчлэх ёстой санхүүгийн хоршооны үйл ажиллагааг санхүүгийн нийтлэг үйлчилгээ үзүүлдэг болгон өргөжүүлж байгаа талаар.

Мөн хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд тавих хяналтын талаар. Тухайлбал, хоршооны гишүүдийн санхүүгийн боловсрол дутмагаас шалтгаалж бусдын өмнө хариуцлага хүлээдэг асуудлуудыг анхаарах.

Иргэд санхүүгийн хоршоонд нэгдэж ашгийн төлөө бус хуулийн этгээд болох байдлаар санхүүгийн олон төрлийн үйлчилгээг үзүүлэх зах зээлийн хэрэгцээ шаардлагын талаар, санхүүгийн төрөлжсөн үйлчилгээг бусад мэргэжлийн оролцогч буюу банк бус санхүүгийн байгууллага болон банкнууд эрхлэх талаар.

Мөн хадгаламж, зээлийн хоршооны хэлбэрийг ашиглан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх асуудлыг хэрхэн хянах, энэ чиглэлээр ФАТФ-ын стандартыг хангаж байгаа эсэх талаар, ашгийн төлөө бус хоршоо зах зээлийн харилцаанд орж хөрөнгө оруулалт босгох, зээл авахад хүндрэлтэй байдаг бөгөөд эдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар гишүүд хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар байр сууриа илэрхийлж–

- ▶ Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай Санхүүгийн эрсдэлийг хамгаалах зохицуулалтуудыг тооцоо судалгаатай, илүү нарийн түвшинд дахиж боловсруулах талаар;
- ▶ Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.1.6 дахь заалтаар санхүүгийн хоршооноос бүх гишүүдийн хурлаар баталсан 3-аас доошгүй жилийн бизнес төлөвлөгөө шаардаж байгаа нь бодитой биш байгаа талаар;
- ▶ Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж нар хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа талаар тус тус саналаа хэлсэн болно.

Санхүүгийн хоршооны тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих талаар санал хураалт явуулахад Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Санхүүгийн хоршооны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Санхүүгийн хоршооны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт, өөрчлөлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Та бүхэнд.

Түндэвийн Жамбаажамц Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Цогтсайханы Алтантуул Санхүүгийн зохицуулах хорооны Хадгаламж, зээлийн хоршооны газрын дарга, Бархасын Долгорсүрэн Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын дарга, Жаргалсайханы Мөнх-Оргил Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Даваахүүгийн Соёлмаа Санхүүгийн зохицуулах хорооны Хадгаламж, зээлийн хоршооны газрын ахлах зөвлөх, Болдбаатарын Ариунболд Хадгаламжийн даатгалын корпорацын гүйцэтгэх захирал, Бадарчийн Амарбилэг Хадгаламжийн даатгалын корпорацын Даатгалын хураамж, хяналт шалгалтын эрсдэлийн удирдлагын газрын захирал, Банзрагчийн Мөнхжаргал Хадгаламжийн даатгалын корпорацын Ерөнхий эдийн засагч, Цогзолын Оюунцэцэг Монголын хадгаламж, зээлийн хоршоодын Үндэсний холбооны Тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга.

Ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Одоо Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. /алх цохив/

Гишүүдийн нэрс өгье. Нэрс орсон байна. Д.Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Байнгын хороон дээр асуултаа асуусан учраас саналаа ерөнхийд нь хэлье гэж бодож байна.

Тэгээд энэ хууль дээр тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг зохицуулж бүтэн заалтууд байгаа.

Тэгээд үүнтэй холбогдуулж нэр томъёоны хувьд–

- санхүүгийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл,
- хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл–

-гээд хоёр өөрөөр бичсэнийгээ нэг болгоорой гэдэг саналыг хэлсэн байгаа.

Дээр нь зөвшөөрөл авахад шаардлагагүй зүйлүүдийг, буцаагаад зөвшөөрөл олгох харилцаанд ач холбогдол багатай зүйлүүдийг шаардмааргүй байна.

Энэ дээр тухайн хадгаламж, зээлийн хоршооны, санхүүгийн хоршооны 3-аас доошгүй жилийн бизнес төлөвлөгөөний туршлага, төлөвлөгөө шаарддагийг шаардлагагүй зүйл гэж бодож байна.

Хэрвээ энэ хууль дэмжигдвэл энэ заалтуудад өөрчлөлт оруулаарай гэдэг саналаа хэлсэн байгаа. Тэгээд үүнийгээ чуулган дээр давтаж хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Санал хэллээ. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуултаа асууя.

Л.Соронзонболд: Өнөөдрийн байдлаар Монгол Улсад үйлчилгээ явуулж байгаа хадгаламж, зээлийн хоршоодын нийт хөрөнгө ойролцоогоор 380.0 орчим тэрбум төгрөг байгаа юм байна гэж харж байгаа.

Тэгэхээр энэхүү Санхүүгийн хоршооны тухай хуулийн төсөл хэлэлцэгдээд батлагдсанаар ер нь цаашдаа хадгаламж, зээлийн хоршоонд буюу санхүүгийн хоршоодын хөрөнгө ер нь ойрын 3 жилийн хугацаанд яаж өснө гэж харж байгаа вэ?

Тухайн санхүүгийн хоршооны үйл ажиллагаа талаас нь аваад үзэхээр хамгийн гол авчирч 3 том давуу талыг нь нэрлэнэ үү гэж асууя.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн хариулна.

Д.Үүрийнтуяа: Л.Соронзонболд гишүүний асуултад хариулъя.

Хадгаламж, зээлийн хоршоонд маань жил тутамдаа ер нь байгуулагдаж байгаа хадгаламж, зээлийн хоршоонд их тогтвортой байж ирсэн.

2014 онд нийслэлийн иргэдийн Хурал, нийслэлийн төсвөөс 14.5 тэрбум төгрөг гаргаж, 100 гаруй хадгаламж, зээлийн хоршоо байгуулсан. Тэр цаг хугацаанд харин их өндөр өсөлттэй байсан юм билээ.

Түүнээс бусад яг зах зээлийн механизмаараа, төр оролцоогүй байгаа цаг хугацаанд тусгай зөвшөөрлийнхөө хүрээнд үйл ажиллагаа ямар нэгэн байдлаар зөрчил гаргахгүй явж байгаа бол тогтвортой өсөлттэй явж ирж байгаа.

Тэгэхээр цаашдаа бид хадгаламж, зээлийн хоршоодыг илүү их олон тоогоор нэмэгдүүлэх гэхээс илүү бизнесийн зарчмаараа үйл ажиллагаагаа явуулж тэлэх боломжоор нь хангах эрх зүйн зохицуулалтыг оруулахыг хичээсэн.

Мэдээж хууль эрх зүйн хувьд гурван давхар хамгаалалтын тогтолцооны хувьд шалгуур шаардлагуудыг хангаж байж санхүүгийн эрсдэлгүй үйл ажиллагаа явуулах энэ үүргээ хэрэгжүүлж байгаа хадгаламж, зээлийн хоршоод зах зээлийнхээ зарчмаар өсөөд явах боломжтой гэж харж байгаа.

Хоёр дахь асуулт дээр ажлын хэсгээс хариулт өгөх нь зүйтэй байх.

С.Бямбацогт: Ажлын хэсэг. Хэн хариулах вэ? Түндэвийн Жамбаажамц Санхүүгийн зохицуулах хорооны дарга хариулна.

4 дүгээр микрофон. Индрийн.

Т.Жамбаажамц: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Л.Соронзонболд гишүүний асуултад хариулъя.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад 172 хадгаламж, зээлийн хоршоо Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа.

Ерөнхийдөө Дэлхийн хадгаламж, зээлийн хоршооны холбооноос гаргасан судалгаагаар дэлхийн нийт хүн амын 15-аас 20 орчим хувь нь санхүүгийн хоршоогоор үйлчилгээ авдаг ийм судалгаатай. Өөрөөр хэлбэл алслагдмал бүс нутагт санхүүгийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх онцлогтой байгаа.

Монгол Улсын хувьд нийт хадгаламж, зээлийн хоршоодын 55 орчим хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа. Түүнээс үндсэндээ 80 орчим хувь нь сумын төв дээр үйл ажиллагаа явуулж байгаа ийм онцлогтой байгаа.

Тэгээд Монгол Улсын санхүүгийн зах зээлийн хүртээмжид, ялангуяа орон нутгийн иргэд рүү чиглэсэн санхүү үйлчилгээ... /минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулъя. 4 дүгээр микрофон.

Т.Жамбаажамц: Үйлчилгээний хүртээмж нэлээдгүй нэмэгдэнэ гэж бид бүхэн харж байгаа.

Ялангуяа санхүүгийн хоршооны байрлалаар нь авч үзэх юм бол нийт орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хадгаламж, зээлийн хоршооны 50 орчим хувь нь баруун аймгуудад үйл ажиллагаа явуулж байгаа.

Тухайлбал, бид бүхэн баруун аймгуудад жишиг болсон санхүүгийн хоршооны жишгүүд бий. Ялангуяа Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд үйл ажиллагаа явуулж байгаа нэр бүхий 3 хадгаламж, зээлийн хоршоонд тухайн сумын идэвхтэй хүн амын 92 хувь нь санхүүгийн үйлчилгээ авч явж байгаа.

Тэгэхээр бид бүхэн энэ хуулийн төсөл ингээд хэлэлцэгдээд, дэмжигдээд, батлагдаад явбал бичил санхүүгийн институц маш найдвартай гурван давхар хамгаалалтын тогтолцоотой институц бий болсноор орон нутагт, алслагдсан бүс нутгуудад бичил санхүүгийн үйлчилгээг асар хямд зардлаар хүргэх боломжууд нэмэгдэнэ гэж харж байгаа. Баярлалаа.

С.Бямбацогт: Ганбатын Хосбаяр гишүүн асуултаа асууя.

Г.Хосбаяр: Энэ хуулийн төслийг ерөнхийд нь дэмжиж байгаа.

Өнөөдөр Монголын санхүүгийн салбарт мэдээж банк хамгийн том орон зайг эзэлж байгаа. Банк бусууд нэлээн олон бий болсон. Банк бусууд мөн л адилхан итгэлцэл татаад, бонд босгоод, мөн хүмүүсийн хэрэг санхүүгийн хэрэгцээг хангаад явж байна.

Санхүүгийн хоршооны тухай хууль хэрвээ батлагдаад хэрэгжээд явбал ер нь энэ санхүүгийн салбарт мөнгө нэг тийшээ төвлөрөх, нэг тал руу хэт төвлөрөх ч гэдэг юм уу, ийм эрсдэл гарах уу? Үүнийг Санхүүгийн зохицуулах хороо ер нь яаж харж байгаа вэ?

Ер нь өнөөдөр жишээлбэл 2025 оны нэгдүгээр улирлын статистикаар гэхэд Монголын банканд монголчуудын 22 их наяд төгрөгийн хадгаламж байна гэж статистик гарсан байсан.

Тэгэхээр ер нь банканд байгаа хадгаламжийн мөнгө, монголчуудын мөнгөний тодорхой хэсгийг нь бүтээн байгуулалтад, яг энэ улс орныхоо бодит дэд бүтцийн салбарт ч гэдэг юм уу, зарцуулах энэ чиглэлээр ер нь Санхүүгийн зохицуулах хороо бодож төлөвлөсөн зүйл байдаг уу?

Тэгэхгүй бол одоо магадгүй Санхүүгийн хоршооны тухай хууль хэрэгжсэнээр санхүүгийн үйлчилгээ ойртоод нэг талдаа иргэдэд тийм хүндрэл чирэгдэлгүй, хурдан шуурхай, найдвартай байдал бий болох ч гэлээ нөгөө талд нь хэрэглээг дэмжсэн, хэрэглээний эдийн засгийг улам хөхиүлэн дэмжсэн ийм зүйл болохгүй юу.

Тэгэхээр одоо яг энэ Санхүүгийн хоршооны тухай хууль хэрвээ батлагдвал ямар эрсдэл байх вэ. Мөн бүтээн байгуулалтад тодорхой хэсгийг нь бүр чиглүүлж зааж өгөх ийм зүйл байх уу гэдэг ийм асуултыг асууя.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн хариулъя.

Д.Үүрийнтуяа: Г.Хосбаяр гишүүний асуултад хариулъя.

Өнөөдөр хадгаламж, зээлийн хоршоо нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа энэ хоршоод маань гишүүддээ үйлчлэх ийм чиг үүрэгтэй ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа.

Зөвхөн зээл, хадгаламжийн үйл ажиллагаа явуулж байгаа гэсэн үг.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаараа хадгаламж, зээлийн хоршоонд дахиад 3 чиглэлээр үйл ажиллагаа явуулах боломжийг олгохоор хуулийн төсөлд тусгасан байгаа.

- Санхүүгийн түрээсийн үйлчилгээ.
- Даатгалын зуучлалын үйлчилгээ зэрэг.

Тэгэхээр ер нь илүү их тийм орон нутгийн хөрөнгө оруулалт руу чиглэх гэдэг талдаа хувь нийлүүлэгчдийн хөрөнгийг хөрөнгө оруулалт руу чиглүүлэх гэхээс илүү хувь нийлүүлэгчид буюу орон нутагт санхүүгийнхээ эх үүсвэрээр өөрсдийн боломж дүнгээр хоршиж нэгдээд, үүгээрээ хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгж бизнес эрхлэх, жижиг, дунд бизнес эрхлэх эх үүсвэр, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх том боломж болж байгаа.

Орон нутагт ялангуяа санхүүгийн хоршоо гэж нэрлэж байгаа хадгаламж, зээлийн хоршоодын гишүүд нь дан малчид байдаг. Ихэнх нь малчид байдаг.

Сүүлд “Шинэ хоршоо” хөдөлгөөн өрнөхөд малчид “Шинэ хоршоо” хөдөлгөөнд шинээр хоршооллуудыг үүсгэн байгуулсан байдаг.

Тэгэхээр цаашдаа төрийн зүгээс хоршоодод ямар нэгэн байдлаар хөдөлмөрөөрөө оршиж байгаа, газар тариалангийн юм уу, малчдын хоршоонд юм уу, ямар нэгэн дэмжлэг олгохгүйгээр санхүүгийн хоршоодынхоо үйл ажиллагаатай уялдуулаад өөрсдийнхөө дундаас босгосон хувь нийлүүлсэн хөрөнгөөрөө үйл ажиллагаа эрхлэх боломжийг нь дэмжих, санхүүгийн нэг хөшүүрэг, анхан шатын институцийнх нь үйл ажиллагааг хууль эрх зүйн хүрээнд өргөжүүлж дэмжиж өгч байгаа хэлбэр байгаа юм.

Өнөөдөр арилжааны банкууд дээр байгаа зээлийн эх үүсвэр, хадгаламж, Банк бус санхүүгийн байгууллагаар дамжаад, банк бус санхүүгийн байгууллага

нь хоршооны гишүүн болоод ингээд яг орон нутагт иргэдийн гар дээр очих ёстой тэр хямд өртөгтэй эх үүсвэр нь дундаа маш олон дамжлага дээр өртөг нэмэгдээд өндөр хүүтэй зээл болж хүрээд байгаа учраас энэ хуулийн зохицуулалтаар орон нутгийн болон салбарын хязгаарыг тогтоож өгснөөрөө энэ хямд өртөгтэй–

- зээлийн эх үүсвэр,
- хөрөнгийн эх үүсвэр,
- зах зээлийн эх үүсвэр нь–

-иргэдэд хүрэх боломжийг олгож өгч байгаа юм.

Тэгээд илүү их тэр эдийн засгийг тэлэх, эдийн засгийн өсөлт өрх бүрд орох бодлогыг хэрэгжүүлэхэд хамгийн хөшүүрэгтэй, хамгийн суурь хууль юм гэж бид үзэж байгаа гэдгээ хэлье.

С.Бямбацогт: Баярлалаа. Мэндбаярын Мандхай гишүүн асуултаа асууя. Тодруулах уу? Аан? Санхүүгийн зохицуулах хороо. Ажлын хэсгээс хариулья.

Т.Жамбаажамц дарга. 4 дүгээр микрофон.

Т.Жамбаажамц: Г.Хосбаяр гишүүний асуултад нэмэлт тодруулга өгье.

Ер нь эрсдэлээ юу гэж тооцож байгаа вэ. Эрсдэлтэй санхүүгийн институц үү гэж асууж байна.

Ерөнхийдөө санхүүгийн хоршоо бол хамтын удирдлагатай, гишүүддээ зөвхөн үйлчилдэг ашгийн төлөө бус гэдэг ийм онцлогтой.

Тэгээд бүх гишүүдийн хурлаас томилогдсон Хяналтын зөвлөл дотоод хяналтын үйл ажиллагааг явуулна. Түүн дээр нэмээд хөндлөнгийн аудитын байгууллага санхүүгийн аудитыг хийнэ.

Дээвэр төв хоршооны гишүүн учраас гишүүд үйл ажиллагаандаа хяналт тавина.

Санхүүгийн зохицуулах хороо хуульд заасан чиг үүргийн хүрээнд санхүүгийн зохистой харьцаа, төлбөрийн чадвар зэрэг санхүүгийн үзүүлэлтүүдэд хяналт тавиад явна.

Хуулийн төсөлд тусгагдсанаар албадлагын олон арга хэмжээнүүдийг Санхүүгийн зохицуулах хорооноос авах нөхцөлт удирдлага хийх, тодорхой албадлагын үйл ажиллагаа... /минут дуусав/

С.Бямбацогт: Мэндбаярын Мандхай гишүүн асуултаа асууя. Алга байна. Болдын Уянга гишүүн асуултаа асууя.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе.

Энэ хадгаламж, зээлийн хоршоотой холбоотой хуулийн төслийг дэмжиж байгаа.

Тэгээд ерөнхий гол зорилго нь өмнөх туршлагаа харж үзээд хадгаламж эзэмшигчдийнхээ эрх ашгийг хамгаалъя гээд 3 гол зүйлийг шийдэх гэж оролдож байгаа юм байна гэж харсан.

▷ **Нэгдүгээрт нь**, санхүүгийн хоршоодын цэвэр орлогоос байгуулдаг “нөөц сан” бий болгоё гэсэн байна лээ. Тийм ээ.

Тэгээд үүнийг дэмжиж байна.

▷ **Хоёрдугаарт нь**, санхүүгийн хоршоодынхоо мэргэжил, арга зүй, санхүү, янз бүрийн асуудал хэрэв тулгарах юм бол түүийг нь дэмжье гээд “тогтворжуулалтын сан” бий болгох гэж байгаа юм байна.

▷ **Гуравдугаарт нь**, “хадгаламжийн даатгал”-ын асуудлыг хөндөж оруулж ирж байгаа юм байна гэдгийг ойлгосон.

Тэгэхдээ нэлээн процессын шинж чанартай зарим зүйлийг Улсын Их Хурлын гишүүддээ одоо яг энэ чуулганы үзэж байгаа нийт иргэддээ танилцуулаад, нэмэлт байдлаар мэдээлэл өгөөч ээ гээд тодорхой хэдэн асуултуудыг асууя.

Энэ “нөөц сан” болон “тогтворжуулалтын сан”-д ингээд мөнгө байрших юм байна.

Тэгэхээр үүнийг менежментийг нь ер нь хэрхэн яаж хийх вэ? Зээл юм уу, эсвэл бусад хэлбэрээр бүтээгдэхүүн болон гарахгүй юм байна гэж ойлгосон.

Тэгэхээр ямар нэгэн байдлаар тухайн хоршоондоо дарамт энэ нь үүсэх үү? Ер нь яг менежмент нь яаж явах юм? Ямар тооцоо судалгаа байгаа вэ?

Энэ 2 сантай холбоотойгоор ойролцоогоор ямар хэмжээний, хэчнээн хэмжээний мөнгө хуримтлагдах ийм төлөвтэй байна вэ? Энэ дээр яг ямар тооцоолол, ямар үндэслэл гаргаж үүнийг хуулийн төсөлд суулгаж байгааг асууя.

Хадгаламжийн даатгалын хувьд 20 сая хүртэлх дүнгээр хамруулах тухай заасан байгаа. Тийм ээ?

Тэгэхээр хадгаламжийн даатгалын корпорац, одоо банкнуудын бас яг энэ даатгал нь 20 сая төгрөг гэж байгаа.

Тэгэхээр энэ яг ямар үндэслэлтэйгээр гаргаж тавьсан 20 сая төгрөг вэ? Хадгаламжийн даатгалын байгууллага энэ дээр яг ямар байр суурьтай байгаа вэ? Зүгээр банкууд бас яг адилхан ийм 20 сая гэсэн дүнг даатгалдаа авдаг бол яг тэрийг нь жишиг байдлаар авсан байгаа юу? Энэ дээр хариулт авъя.

Ингээд цаашаа уншаад явж байхад нэлээн процессын шинжтэй нарийн зохицуулалтууд байсан. Үүний нэг нь санхүүгийн хоршоог хамгийн багадаа 20 гишүүнтэй байна гэсэн байгаа.

Тэгэхээр энэ хувь нийлүүлэх хөрөнгийн тал дээр тэгвэл ямар нэгэн шаардлага байгаа юм уу? Бүгдээрээ жигд хөрөнгөө нийлүүлэх юм уу? Эдгээр асуултаас хариулт аваад тэгээд тодруулах бол тодруулъя.

Хууль санаачлагч Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуултад хариулъя.

Д.Үүрийнтуяа: Даатгалтай холбоотой асуудал дээр 2013 онд батлагдсан Банкн дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд банкн дахь хадгаламжийн даатгагдах дээд хэмжээг 20 сая төгрөг гэж заасан байдаг.

Нэгдүгээр шаардлага нь энэ. Хоёр дахь үндэслэл нь бид хадгаламж, зээлийн хоршооны өнөөдрийн байгаа гишүүдийн хоршоондоо хадгалж байгаа хадгаламж, зээлийн хэмжээнд хийсэн судалгаан дээр үндэслэсэн байгаа юм.

Нийт 45 мянга 775 хадгаламж эзэмшигчийн 93 хувь нь 10 сая хүртэл төгрөгийн хадгаламжтай байгаа 96 хувь нь 20 сая төгрөг хүртэл төгрөгийн хадгаламжтай байгаа. Өөрөөр хэлбэл яг хадгаламж, зээлийн хоршоонд хадгаламж байршуулаад тэндээс зээл авч байгаа гүйлгээний эргэлтийн дүн бага байгаа. Энэ бол яг орон нутгийн жижиг дунд, бизнес эрхлэгчдэд, ард иргэдийн санхүүгийн хэрэгцээнд тохирсон хэлбэр байгаа юм л даа.

Тийм учраас нийт хадгаламж эзэмшигчдийн 96 хувь нь 20 хүртэл сая төгрөгийн хадгаламж байршуулж байна гэдэг бол хадгаламжийн даатгалын даатгалд хамрагдах дүнг 20 саяар авад 96 хувь нь энэ даатгалд хамрагдах боломжтой гэж үзэж энэ судалгаан дээр үндэслэж, мөн хуулийн заалтыг үндэслэж 20 сая төгрөгийг тогтоосон байгаа.

Тэр нарийвчилсан сангуудын дүүргэлттэй холбоотой зохицуулалтууд дээр Санхүүгийн зохицуулах хорооноос хариулъя.

Ажлын хэсэг хариулъя. Гишүүний тоог мөн.

С.Бямбацогт: Ажлын хэсэг. 4 дүгээр индэр. Нэрээ хэлээд асуултад хариулъя.

Ц.Алтантуул: Ц.Алтантуул байна.

- Нөөцийн сантай холбоотой,
- Тогтворжуулалтын сантай,
- Хадгаламжийн даатгалын сантай холбоотой тодруулга хэлэхэд–

3 давхар хамгаалалтын тогтолцоог бүрдүүлснээрээ “нөөцийн сан” хадгаламж, зээлийн хоршоон дээрээ хадгаламж, зээлийн хоршооны алдагдлыг нөхөх зориулалтаар байгаа юм.

Энэ нь манай өнөөдрийн үйл ажиллагаа явуулж байгаа хадгаламж, зээлийн хоршоо дээр ч гэсэн нөөцийн сангаа байгуулаад явж байгаа. Олон улсын стандартын дагуу.

Дараагийн шат нь хадгаламж, зээлийн хоршоо өөрөө ямар нэгэн байдлаар эрсдэлд орох, дампуурлын аль нэг шинж тэмдэг илрэхэд урьдчилан бид үнэлж, энд нь аж ахуйн нэгж туслан зааварлах, дэмжлэг өгөх үйл ажиллагаа явуулах Тогтворжуулалтын сан байгаа.

Тогтворжуулалтын санг нэгдсэн дээвэр байгууллага дээр удирдаад хадгаламж, зээлийн хоршоо бүхэн жилийн хураамж төлөх байдлаар дүүргэж явах юм. Энэ шатлалыг бас өнгөрөөгөөд хэрвээ хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа сэргэхгүй үнэхээр дампуурах дээрээ тулах юм бол хадгаламжийн... /минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулъя. 4 дүгээр микрофон.

Ц.Алтантуул: Үнэхээр хадгаламж, зээлийн хоршоо дампуурах эрсдэл дээр очих юм бол хадгаламжийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох юм.

Үндсэндээ 2 дугаар шатын хамгаалалт болох “Тогтворжуулалтын сан” хадгаламж, зээлийн хоршоог өөрийг нь эрсдэлээс урьдчилан сэргийлэх, 3 дугаар шатны “Хадгаламжийн даатгал” бол–

- гишүүний эрх ашгийг,
- хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг–

-хамгаалахад чиглэсэн зорилготой сангууд байгаа юм.

Тэгээд сангуудын дүүргэлт дээр тодорхой хувь хэмжээнүүдийг бид хийж тооцооллуудыг гаргасан байгаа.

Яг өнөөдрийн хадгаламж, зээлийн хоршооны хувьд 2011 онд батлагдсан Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн дагуу бас өөр өөр дээрээ –

- Нөөцийн сан,
 - Тогтворжуулалтын сан,
 - Хадгаламж, хамгааллын санг –
-

-үүсгээд явсан болохоор шинээр байгуулж байгаа эд биш. Өнөөдрийн хадгаламж, зээлийн хоршоодын “тогтворжуулалт”-ын болон “хадгаламж, хамгааллын сан”-гийн мөнгийг анхан шатын хоршоон дээр нөөцийн сан руу шилжүүлэх зохицуулалтыг хийнэ.

Тэр тохиолдолд хадгаламж, зээлийн хоршооны өөрийнх нь даац, чадавх нь сайжирна. Хууль батлагдсан тохиолдолд... /минут дуусав/

С.Бямбацогт: Товчхон тодорхой хариулна шүү.

Болдын Уянга гишүүн нэмж асууя.

Б.Уянга: Тэр санхүүгийн хоршоог хамгийн багадаа 20 гишүүнтэй байна гэдэг дээр хувь нийлүүлэх хөрөнгийн хэмжээн дээр нь Та нэмээд хариулаад өгөөрэй.

Үүн дээр нэмээд бас нэг тийм сонирхолтой зүйл нь “Санхүүгийн хоршоодын нэгдсэн төв” гэж бий болгох юм билээ.

Тэр нь танай хуулийн төслийн 52.3 дээр Санхүүгийн зохицуулах хороо нийт санхүүгийн хоршоодынхоо 50-иас дээш гишүүдийг нь элсүүлсэн байх юм бол төв байдлаар бүртгэнэ гээд.

Тэгээд ингээд уншаад явж байтал 15.5 дээрээ болохоороо “Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд гишүүн байхыг хориглоно.” гэж. Нэг тийм зөрчилдөөд байгаа юм шиг. Энэ дээр тодруулга авмаар байна.

Угаасаа хоршоо болгон тодорхой өөрийн гишүүн, үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрлөө авсан байж таарна.

Тэгэхээр тийм байхыг нь хориглосон хүн нь гишүүнээр байна гэхээр 15.5, 52.3 хоёр зөрчилдөж уншигдаад байсан. Энэ дээр тодруулаад хариулаад өгөөрэй.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. 4 дүгээр микрофон.

Ц.Алтантуул: Хадгаламж, зээлийн хоршооны хувь нийлсэн хөрөнгийн хувьд бусад санхүүгийн салбараас ялгаатай нь дүрмийн сан шаарддаггүй.

Хадгаламж, зээлийн хоршооны гишүүд өөрсдөө сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, хэдэн төгрөгийн хувь нийлсэн хөрөнгөөр нэгдэх вэ гэдгээ бүх гишүүдийн хурлаараа өөрсдийнхөө дүрмээр тогтоодог. Энэ нь бага хамгийн доод хэмжээ нь өөрсдөө тогтоогоод, хуулиар дээд хязгаарыг нь тогтоосон байдаг нь

нэг хувь нийлүүлэгч нийт хувь нийлсэн хөрөнгийн 10-аас дээш хувийг оруулахыг хориглодог байгаа.

Дараагийнх нь, Нэгдсэн төвтэй холбоотой асуултад хадгаламж, зээлийн хоршоодын нэгдсэн төв гээд олон улсын нэршлээр “Лиг централ” (League Central) гээд дээвэр байгууллагыг байгуулах юм. Дээвэр байгууллага дээр хадгаламж, зээлийн хоршооны гишүүн бүр гишүүнчлэлтэй яваад, түрүүн ярьдаг тогтворжуулалтын сангийн хөрөнгийг дээвэр байгууллага, нэгдсэн төв маань удирдаж явах юм.

Тэгээд гишүүнчлэлийн хувьд заавал гишүүнчлэлтэй, бүтцийн хувьд анхан шатын хоршоотойгоо ижилхэн. Нийт хадгаламж, зээлийн хоршоод... /минут дуусав/

С.Бямбацогт: Баярлалаа. Нэмэлт хариулт Хууль санаачлагч Д.Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Б.Уянгаа гишүүний асуултад нэмж хариулъя.

Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж гишүүнээр байж болохгүй вэ, болохгүй гэдэг заалт орсон бэ гэж.

Өнөөдрийн байгаа жишээн дээр хадгаламж, зээлийн хоршооны гишүүнээр банк бус санхүүгийн байгууллага ордог. Өөрөөр хэлбэл Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авч байгаа банк бус санхүүгийн байгууллага хадгаламж, зээлийн хоршооны гишүүн байхыг хориглож өгч байгаа.

Банкнаас авсан зээлээ Хадгаламж, зээлийн хоршоогоор дамжуулаад хоршооны гишүүн болоод, түүндээ хөрөнгө оруулаад хоршоодоор дамжуулж иргэдэд илүү өндөр хүүтэй мөнгө хүүлэлтийн үйл ажиллагаа яваад байгааг зогсоож байгаа.

Тийм болохоор энэ иргэдэд яг энэ хоршооны эвлэлдэн нэгдэж, өөр өөрсдийнхөө эрх ашгаар хөрөнгөө нийлүүлж орсон гишүүдэд давуу талыг олгох юм.

Нөгөөтээгүүр тэр хувь нийлүүлсэн хөрөнгийн асуудал дээр 10 хувиас хэтрэхгүй байхаар заалт оруулсан. Энэ үнэхээр орохоос өөр арга байхгүй.

С.Бямбацогт: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: Бүгдэд нь өдрийн мэнд.

Ер нь иргэдэд санхүүгийн үйлчилгээ авах хэрэгцээ шаардлага өдөр тутамд гарч байгаа. Банкнаас авч байна. Банк бус санхүү, хадгаламж, зээлийн хоршоо, ломбард, хувь иргэдээс авч байна. Яг тогтмол энэ үйл ажиллагаа хийдэг.

Энэ дээр манай Санхүүгийн зохицуулах хороо яг хүрч ажиллаж байгаа асуудал дээр жоохон хэцүү л байгаа. Орон тооноос эхлээд, орон нутагт салбартай эсэх асуудлаас эхлээд.

Тэгэхээр бид хэд уг нь өмнө нь үйл ажиллагааны хүрээндээ хүрч ажиллах асуудалдаа илүү түлхүү л анхаармаар байгаа юм. Уг нь.

Өнөөдөр хэрэглээний зээлийн хүүг таазыг нь хуулиар тогтоож өгч болдог. Бизнесийн зээл биш. Гэтэл үүнийг нь гаргаж өгсөн санхүү мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах хуулийн тэр заалтыг нь цэц дээр өгөөд гацаагаад байж байгаа байхгүй юу.

Энэ ер нь яг ямар эрх ашиг цаана нь яваад байна? Санхүүгийн зохицуулах хороо энэ хуулийн хэрэгжилтийг хангах асуудал дээр ер нь юу хийж байна. Энэ дээр тодорхой мэдээлэл өгөөч?

Энэ ломбард болон зах худалдааны төвүүд дээр чинь цүнхтэй мөнгө барьчихаад лангуу түрээсэлж байгаа хүмүүсийг маш өндөр хүүтэй зээл өгч “зээлийн шарк” буюу “Loan Shark” ажиллуулж, бараг тэд нарыг доороо ажиллуулж байгаа байхгүй юу. Боолчилж байгаа. Нэг ёсондоо “боолчлол”.

Энэ дээр Санхүүгийн зохицуулах хороо юу хийж байна аа? Энэ хуулийг хэрэгжүүлэх үү, үгүй юу? Нэгдүгээрт, энэ дээр хариулаад өгөөч.

Хоёрдугаарт, хэлэлцэж байгаа хуулийн төсөлтэйтэй холбоотой нэг асуудал нь хуулийн этгээдийн засаглал талаасаа, хэлбэр талаасаа хадгаламж, зээлийн хоршоо хоршоо, ер нь хоршоо ашгийн төлөө бус.

Тэгэхээр ашгийн төлөө бус ийм хуулийн этгээдийн зохион байгуулалт, үйл ажиллагаан дээр илүү үйл ажиллагааг нь тэлж “нэмэлт үйлчилгээнүүд” буюу “факторингийн үйлчилгээ” (Accounts Receivable Factoring).

Энэ чинь “өр худалдаж авах үйлчилгээ” ч гэдэг юм уу, ийм зүйлүүд рүү ингээд орох гэж байгаа нь хэр зохистой юм бэ?

Бид хэд энэ Хадгаламж, зээлийн хоршооноос болоод маш олон гашуун түүхүүд бий. Тэгэхдээ би энэ хуулийн төслийг огтоосоо эсэргүүцээгүй. Ер нь энэ асуудлуудыг хэр бодитой үнэлж байж орж ирж байгаа вэ?

Яг ингээд харахаар дэлхийн энэ хоршоочдын загвар хуулиас гээд л бас нэг орчуулгын талдаа байгаа байхгүй юу. Бусад оронд энэ хоршооллыг жижиг ажлын байр хадгалах тэр секц рүүгээ хоршиж ажиллах, санхүүгээ нэгтгэх тэр үйл ажиллагаа, чиглэл рүүгээ, дэмжих тал руугаа нэлээн түлхүү ажиллаад байх шиг байна.

Тайланд бол аялал жуулчлал, хоол, хүнсний үйлдвэрлэл буюу хоолны экспорт тал руу явуулдаг үйл ажиллагааг эндээс зээл олгох гэдэг юм уу, дэмжих талдаа байгаа байхгүй юу.

Манайх ерөөсөө хэрэглээ. Түрүүн Г.Хосбаяр гишүүн яриад байна лээ. Үнэн шүү дээ. Энэ ерөөсөө тэгээд бас л нэг баахан зээл болоод л, электрон бараа гараад л, гоёл, хувцас болоод л гарна шүү дээ.

Ер нь өнөөдөр, маргаашдаа ийм хэрэгцээ шаардлага байгаад яг үүнийг оруулж ирж байна уу? Энэ дээр бодитой хариулт өгөөч.

Тэгээд хариултаа аваад тодруулъя.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн хариулъя.

Д.Үүрийнтуяа: П.Сайнзориг гишүүний эхний асуултад ажлын хэсэг хариулна. Би хоёр дахь асуултад хариулъя.

Өнөөдөр байгаа нөхцөл байдал гишүүний хэлж байгаа үнэн. Өнөөдөр хадгаламж, зээлийн хоршоодын гишүүд нь тухайн хоршооны удирдлагын үйл ажиллагаанд оролцохоос илүүтэй зээл авахын тулд гишүүн болж байгаа. Зээл авахын тулд очиж гишүүнээр бүртгүүлж зээл авч байгаа. Энэ байдлыг энэ хуулиар хязгаарлаж, зохицуулалтыг хийж өгсөн байгаа.

Нэгдүгээрт, хадгаламж, зээлийн хоршооны гишүүн хадгаламжтай байхыг зааж шаардаж оруулж өгч байгаа. Ингэснээрээ тухайн хадгаламж, зээлийн хоршооны буюу санхүүгийн хоршооны гишүүн маань удирдлагын, засаглалын тогтолцоондоо оролцох эрх нь бүрэн нээгдэх боломжтой. Яг энэ бодит гишүүн байх боломжийг нь нээж өгч байгаа.

Нөгөө талаар яг хөдөлмөрөөрөө хоршиж байгаа энэ үйл ажиллагааг дэмжих чиглэлд нь санхүүгийн эх үүсвэрийг гаргах гэдэг бол өнөөдөр ч манай дээр явж байгаа. Энэ боломжийг нь бид илүү нэмж өгөх үүднээс хуулиар зарим зохицуулалтыг хязгаарлаж өгсөн.

Энэ нь юу вэ гэхээр өнөөдөр зарим хадгаламж, зээлийн хоршоо бол улс орон даяар ёстой лизинг ч бай, юу ч бай бүгдийг нь гаргаж байгаа.

Тэгвэл үүнийг нь хязгаарлаад тухайн орон нутагтаа болон эсвэл мэргэжлээрээ, тухайн салбараараа нэгдэж хоршоо байгуулах боломжийг нь олгож өгч байгаа юм. Тухайлах юм бол “UBCab” таксины үйлчилгээ явуулдаг таксины жолооч нар яг өөрсдийнхөө үйл ажиллагаанд чиглэсэн сонирхол дээрээ нэгдээд хадгаламж, зээлийн хоршоо байгуулаад ажиллаж байна.

Энэ ажлыг нь яг энэ хүрээнд нь тэр чиглэлээр нь дэмжих боломжийг олгож хуулийн зохицуулалтуудыг хүрээ хязгаарыг нь тодорхой болгож оруулж өгсөн байгаа.

Хэрвээ Улаанбаатар хотынх бол Улаанбаатар хотдоо, Говьсүмбэр аймаг, Өмнөговь аймаг гэвэл зөвхөн Говьсүмбэр аймагтаа, Өмнөговь аймагтаа амьдарч байгаа иргэдийг яг энэ хоршооны гишүүн байлгах ийм хязгаарлалтуудыг хийж өгч байгаа нь яг гишүүний ярьж байгаа өнөөдрийн учир дутагдалтай байгаа нөхцөл байдлыг арилгах үүднээс оруулж өгсөн хуулийн зохицуулалт байгаа юм.

Эхний асуултад ажлын хэсэг хариульъя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг. Индрийн 4 дүгээр микрофон.

Т.Жамбаажамц: П.Сайнзориг гишүүний асуултад хариульъя.

Монгол Улсын Их Хурлаас 2022 онд Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуулийг батлаад 2023 оноос хэрэгжсэн.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн гол зохицуулалтын нэг онцлог бол Санхүүгийн зохицуулах хорооны дэргэд “Мөнгөн зээлийн бодлогын зөвлөл” ажиллана. Зөвлөл мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийн зээлийн хүүгийн дээд хязгаарыг тавихаар хуульчилсан байгаа.

Бүрэлдэхүүнд нь –

- Санхүүгийн зохицуулах хороо,
- Хууль зүйн яам,
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газар,
- мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч төрийн бус байгууллагын төлөөлөл–

-зэрэг бүрэлдэхүүнтэй 2023 оноос байгуулагдаад ажилласан.

Анх 2024 оны 1 сард анх удаа Монгол Улсад 4.5 хувиар хүүгийн дээд хязгаарыг Мөнгөн зээлийн бодлогын зөвлөлөөс тогтоосон.

Энэ тогтоосны дараагаар тодорхой мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдүүд төрийн бус байгууллага нь захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргасан. Хоёр шатны захиргааны хэргийн шүүх... /минут дуусав/

С.Бямбацогт: Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулна.

П.Сайнзориг: Т.Жамбаажамц дарга нэмээд хариулаарай.

Энэ хуулийг хийж байгаа нэг зүйл дээр жоохон болгоомжлол байгаа. Ажлын хэсэг гараад явбал сайтар хэлэлцээрэй. Дээвэр холбоо ч гэдэг юм уу, ийм үзэгдлүүд явахаараа нэг хүн эзэн суудаг. Хэсэг бүлэг. Явдаггүй.

Тэгээд манайд би ийм сонгодог жишээнүүд байна шүү дээ.

- Ажил, хөдөлмөр эрхлэгчдийг төлөөлж нэг хэсэг бүлэг хүмүүс явж л байдаг.
- Аж ахуй буюу баялаг бүтээгчдийг төлөөлж нэг хэсэг хүмүүс явж л байдаг.

Тэгээд энд эзэн суух байдлыг болиулж буюу ротац хийдэг. Энэ нь өөрөө солигддог, нийтийн эрх зүйн этгээдэд тавигддаг шаардлагыг нь тавьж өгөхгүй бол үүгээрээ дарамтлаад бусад байгууллага, иргэдэд аж ахуй эрхлэх сонирхолд нь саад болно, чөдөр болно.

Тэгээд ер нь зүгээр “дээвэр холбоо” биш “танхим” байгуулагдах ёстой юм биш үү? Энэ нэгд бизнесийн үйл ажиллагаа.

Тэгэхээр яг бизнесийн үйл ажиллагаа бол энэ Худалдаа, аж үйлдвэрийн танхимынхаа дэргэд санхүүгийн үйл ажиллагаа буюу санхүүгийн хадгаламж, зээлийн хоршоочдын танхим гэдэг юм уу, ийм... /минут дуусав/ Индрийн 4 дүгээр микрофон ажлын хэсэг хариулъя.

Т.Жамбаажамц: Түрүүнийхээ хариултыг гүйцээгээд хариулъя.

2024 оны шийдвэр дээр хоёр шатны захиргааны хэргийн шүүх яваад түдгэлзүүлсэн шийдвэрийг. Тэгээд улмаар Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх “Мөнгөн зээлийн бодлогын зөвлөл”-өөс дахиж шийдвэрлээд 4.5 хувиар тогтоогоод, 2025 оны 2 сард эцэслэж шийдэгдсэн.

Одоо энэ шийдвэр хүчин төгөлдөр үйлчилж байгаа. Өөрөөр хэлбэл мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, хуулийн этгээд 4.5 хувиас дээш хүүтэй зээл олгохыг хориглосон шийдвэр явж байгаа.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хууль бол Үндсэн хуулийн цэц дээр маргаан үүссэн явж байгаа гэж бид бүхэн ойлгож байгаа. Эхний хариулт ийм байна.

П.Сайнзориг гишүүний саналын шинжтэй зүйл байна. Хуулийн төсөл дээр. Ерөнхийдөө ойлгож байна. Бид хэдийн хуулийн төсөлд тусгагдсан гол концепц бол энэ өөрөө мэргэжлийн өөрийгөө зохицуулах байгууллага байх юм. Өөрөөр хэлбэл нөгөө Эс Ар О (SRO) буюу гэж нэрлэдэг Self-Regulatory Organization гэдэг ийм институт манай бусад санхүүгийн салбарын гол хуулиуд дээр байдаг. Тухайлбал, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль дээр холбоо өөрийгөө зохицуулах... /минут дуусав/

С.Бямбацогт: Нэмэлт 1 минут. П.Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Тэгээд бас анхаараарай. Хурлын дарга энэ дээр анхаарч өгч Хууль зүйн байнгын хороотой байдаг юм уу, бусад холбогдох Байнгын хороодоос төлөөлөл орж, ажлын хэсгийг нэлээн өргөн бүрэлдэхүүнтэй ярих нь зөв байх гэж бодож байна.

Тэгээд бас нэг буруу явбал маш олон иргэд хохирдог. Өнөөдөр иргэдийн санхүүгийн боловсрол тэр болгон сайн байхгүй байна. Энэ дээрээ үүсээд бусдын өмнөөс баахан эдийн засаг, санхүүгийн хариуцлага хүлээгээд явах вий гэдэг болгоомжлол байгаа шүү.

Тэгээд тэр дээвэр холбоо энэ тэр дээрээ сайн ярилцъя. Ер нь энэ хоршооны асуудлыг цаашдаа “ашгийн төлөө” байх уу, “ашгийн төлөө бус” байх уу гэдэг энэ суурь концепцыг Иргэний хуультай нийцүүлээд ч гэсэн ярих ёстой. Япон, Германд ч гэсэн олон жилийн маргаан болоод л явж л байна.

Тэгээд бид хэд нэг талд нь гаргая.

Тэгээд наад Ломбардын хуулийнхаа хэрэгжилтийг иргэддээ тэр e-mongolia-гаар бараг мессеж хэлбэрээр хүргээд иргэддээ анхааруулаарай.

Тэгэхгүй бол энэ зах худалдааны төвөөр чинь зээлийн өрөнд орсон, зээлийн энэ атгад орсон жижиг бизнес эрхлэгч зөндөө болоод байна шүү.

С.Бямбацогт: Ер нь нөхцөл байдал тийм байгаа шүү. Хэт өндөр хүүтэй хадгаламж, зээлийн хоршооны зээлд иргэд маш туйлдаж байгаа. Онцгой анхаарах ёстой. Энэ асуудал зохицуулагдах байх гэж найдаж байгаа шүү. Энэ хууль хэлэлцэх нь дэмжигдээд явбал тодорхой хэмжээнд үр дүнгээ өгөх байх.

Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

М.Ганхүлэг: Өдрийн мэнд хүргэе.

Санхүүгийн хоршооны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг дэмжиж байгаа. Орон нутгийн иргэдийн хувьд санхүүгийн үйлчилгээ авах хэрэгцээ маш их байгаа.

ХААН банк, Төрийн банк тэргүүтэй цөөн хэдэн банкуудыг эс тооцвол ер нь санхүүгийн үйлчилгээ авах энэ байдал төдийлөн хүртээмжтэй биш байгаа гэж бодож байгаа.

Хот суурин газар, Улаанбаатар, төвлөрсөн газруудтай харьцуулахад.

Нөгөө талаасаа тодорхой ашгийн хувийг гаднын улсын хөрөнгө оруулалттай байдаг юм уу, тодорхой зээлийн хүү, ашгийн төлөө байгаа байгууллагуудын нөхцөл байдлыг яг энгийн иргэд, малчид маш хүндээр авдаг.

Тийм учраас хоршооны тухай асуудал, тэр дундаа санхүүгийн хоршооны асуудлыг бид нухацтай авч үзэж, нарийвчлан зохицуулах зайлшгүй шаардлагатай.

Монгол Улсын хэмжээнд 2 хувь гэдэг танилцуулгыг Та бүхэн маань өгч байгаа юм байна. Нийт санхүүгийн хоршооны гишүүдийн нийт хүн амын ойролцоогоор 2 хувь байна гэж. Олон улсын түвшинд зарим улсуудад 20-иос 50 хувь, хөгжингүй орнуудад бүр 70 хувь хүртэл иргэд нь хоршоодоор дамжуулж өөрсдийн санхүүгийн үйл ажиллагаагаа авч байгаа юм байна.

Тэгэхээр эхний асуулт нь энэ хуулийн төсөл тодорхой хэмжээнд хэрэгжсэнээрээ 2 хувь дээр ямар өөрчлөлтүүд орох тооцоо мэдээллүүд байна вэ?

Бидэнд байгаа хамгийн гол чухал асуудлын нэг нь өмнөх алдаанууд байгаа юм. Хоршооны асуудал, хадгаламж, зээлийн хоршоодтой холбогдолтой асуудал дээр нэлээн ноцтой асуудлууд үүссэн.

Тэгэхээр энэ хуулийн төсөл дээр энэ алдаагаа давтахгүй байх, хяналт шалгалт, ил тод байдал, гишүүдийн эрсдэлийг даатгахтай холбогдолтой, хамгаалахтай холбогдолтой зохицуулалтуудыг би юуны түрүүнд түрүүлж асууя.

Мөн дээрээс нь нийгэмд байгаа энэ ойлголтыг хэрхэн өөрчлөх вэ? Дэлхий нийтийн хоршоодын хөгжил шал өөр түвшинд очсон байж байдаг. Бид хуучин энэ алдаанаасаа болоод тодорхой ойлголтын зөрүүтэй, итгэх байдал нь нэлээн бага байгааг хэрхэн сайжруулах вэ? Соён гэгээрүүлэх, мэдээлэлжүүлэх энэ чиглэлийн ажлуудыг дэмжих тодорхой заалтууд байгаа юу гэдэг чиглэлээр асууя.

Мөн Хэнтий аймгийн Биндэр сумд үйл ажиллагаагаа явуулдаг Монгол Улсын шилдэг “Сүлдэт өндөр” хоршооноос тодорхой асуултуудыг асуусан.

Мянга орчим гишүүнтэй, 3.2 тэрбум төгрөгийн нийт активтай шилдэг хоршоодын нэг байгаа.

Шинэ хуулийн төсөл дээр тодорхой нэмэлт үйлчилгээний нэр төрлүүд хэрхэн өөрчлөгдөж байгаа вэ гэдэг дээр сая хариулах шиг боллоо.

Дээрээс нь нийт тухайн сум орон нутгийн 50 хувь иргэдтэй холбогдолтой асуудал яригдаж байх шиг байна.

Тэгэхээр гишүүдийн тоо нэмэгдэх тусам тухайн хоршоонд тодорхой илүү давуу байдал олгогдох ийм зохицуулалт юмнууд байна уу гэдэг.

Гурав дахь нь хөдөө аж ахуйн салбарт маш олон хэмжээний “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт”, “Шинэ хоршоо” гээд хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа. Энэ хөтөлбөрүүдийн цаад зорилго нь арилжааны банкуудаар дамжуулж тодорхой хүүгийн хөнгөлөлтийг үзүүлж байгаа.

Эсрэгээрээ бид малчид, жижиг, дунд бизнес эрхлэгч нараа дэмжих зорилгоор энэ хөтөлбөрийг төрөөс явуулахаар арилжааны банкууд илүү хожоотой ийм санхүүгийн схем байгаа юм.

Тэгэхээр энэ байдлыг ер нь хоршоод руу чиглүүлэх, ялангуяа ядуурлыг бууруулах чиглэлээр, нийгмийн болон төсөл, хөтөлбөрүүдийг, орон нутгийг хөгжүүлэх чиглэлийн хөтөлбөрүүдийг санхүүгийн хоршоодоор дамжуулан явуулах боломж байна уу гэдэг ийм 3 асуудлыг н.Насанжаргал дарга уламжилсныг асууя.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа. Батжаргалын Заяабал гишүүн.

Б.Заяабал: Би эхний хэдэн асуултуудыг хариулъя.

Тэгээд манай ажлын хэсгээс нэмээд явах байх гэж бодож байна.

Тэгэхээр олон улсад санхүүгийн хоршооны ойлголт, хөгжил үнэхээрийн урагшаа явсан байгаа.

Дэлхийн World Council of Credit Unions гээд санхүүгийн хоршоодын олон улсын байгууллага байдаг. Энэ байгууллагын гаргасан тоогоор үндсэндээ Хятад, Энэтхэг хоёрыг оруулахгүйгээр гишүүдийн тоог нь аваад үзэх юм бол 411.0 сая гишүүнтэй гэсэн ийм тоо байгаа.

Хятад, Энэтхэг хоёрыг оруулах юм бол үндсэндээ 1 орчим тэрбум хүн санхүүгийн хоршоонд гишүүнчлэлтэй байна гэсэн ийм тоо байгаа. Ингээд дэлхийн түвшинд аваад үзэх юм бол үндсэндээ 8 хүний 1 нь энэ санхүүгийн хоршооны гишүүнчлэлээр явж санхүүгийн үйлчилгээг авдаг гэсэн тоон мэдээ байгаа.

Монгол Улсын хувьд 2 хувь гэдэг бол чамлалттай бага хувь байгаа.

Банк, санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд гэхээр үндсэндээ 4 байгууллага байдаг. Бүгдээрээ мэдэж байгаа.

- ▶ Банк,
- ▶ Банк бус санхүүгийн байгууллага,
- ▶ Мөнгөн зээл буюу ломбард,
- ▶ Хадгаламж, зээлийн хоршоо—

-буюу одоогийн шинэ нэршлээр бид “санхүүгийн хоршоо” гэж оруулж ирж байгаа.

Нийт зах зээл дээр явж байгаа зээлийн чинь 0.5 хувь нь Хадгаламж, зээлийн хоршоогоор явдаг буюу жилдээ 290 орчим тэрбум төгрөгийн зээл хадгаламж, зээлийн хоршоогоор дамжиж хадгаламж, зээлийн хоршооны гишүүдэд санхүүгийн үйлчилгээ очдог гэсэн тоо мэдээ байгаа.

Ялангуяа орон нутагт амьдарч байгаа иргэдийн санхүүгийн үйлчилгээг сайжруулах үүднээс “хадгаламж, зээлийн хоршоо” буюу одоо энэ шинэ нэршлээр “санхүүгийн хоршоо” болгож өмнө нь байсан муу нэрийг нь цэвэрлэж ре-брендинг (re-branding) хийх үүднээс энэ санхүүгийн хоршооны хуулийг шинэчлэн боловсруулж оруулж ирж байгаа гэж ойлгож болно.

Тэгээд энэ санхүүгийн хоршооны хуулийг хэрэгжүүлэхийн тулд бид энэ хуулийг даган мөрдөх хууль дээрээ нэг жилийн хугацаа тавьсан байгаа. Энэ хугацаанд манай Санхүүгийн зохицуулах хорооноос нэлээдгүй сургалт, танин мэдэхүйн ажлууд хийгдэнэ.

Сая таны ярьснаар орон нутагт амьдарч байгаа иргэдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, ядуурлыг бууруулах Засгийн газрын олон зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд аль болох олон нийтийг хамруулсан ийм санхүүгийн хоршоо хэлбэрээр байхыг төрөөс дэмжих үүднээс–

- 50 хувийг хамруулсан байвал,
- тухайн орон нутаг, сумын иргэдийг хамруулсан байвал–

Засгийн газрын холбогдох төсөл, хөтөлбөрүүдийг хамруулж хэрэгжүүлэх ийм нэгж болгож болно гэсэн ийм агуулгаар бас хуулийн төсөлд орсон гэсэн ерөнхий мэдээллийг өгье.

С.Бямбацогт: Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн нэмж хариулъя.

Д.Үүрийнтуяа: Хадгаламж, зээлийн хоршоо үүссэн цаг хугацаанаас хойш 3 том эрсдэлийг давсан байдаг гэж харж байгаа. Түүхийг нь харахаар.

Анх бид ямар нэгэн хууль эрх зүйн зохицуулалтгүй явж байснаас болоод 2004-2005 онд үндсэндээ 26 хадгаламж, зээлийн хоршооны 8.3 мянган иргэн 72.4 тэрбум төгрөгөөрөө хохирсон.

Өнөөдрийг хүртэл 25.6 тэрбум төгрөг төлөгдөөгүй явж байгаа.

Маш бараан хар түүх үлдсэн байдаг. Энэ бол “хадгаламж, зээлийн хоршоо” гэдэг нэрийг үнэгүйдүүлсэн.

Ямар сайндаа л манай 7 дугаар ангийн сурах бичиг дээр өнөөдрийн 7 дугаар ангийн хүүхдүүдийн үзэж байгаа дүрслэх урлагийн сурах бичиг дээр “хадгаламж, зээлийн хоршоонд мөнгө хадгалуулах нь чононд хонь” хадгалуулахтай адилхан гэсэн шог дүрслэл хүртэл байдаг.

Энэ нь өөрөө бид энэ бичил санхүүгийн ойлголтыг үр хүүхдүүддээ 10 жилийнх нь боловсролоос эхлээд ямар түвшинд олгож байгаа вэ гэдгийг л харуулж байгаа юм.

Тийм учраас иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор хуулийн төсөл... /минут дуусав/

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын урилгаар Төв аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн 12-ын “б” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм дүү нартаа сурлагын өндөр амжилтыг нийт Их Хурлынхаа гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. /алга ташив/

Онц сураарай. Удахгүй сургуулиа төгсөх нь байна. Хүссэн дээд сургуульд ороорой. Их сургуульдаа.

Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн нэмж асууя.

М.Ганхүлэг: Үндсэндээ зөвхөн сум орон нутагт санхүүгийн үйл ажиллагаа явуулах гэдгээс гадна соён гэгээрүүлэх гэдэг юм уу, нэгдэж хамтрах маш олон чиглэлийн үйл ажиллагаа үүний цаана байгаа юм.

Тэгэхээр энэ давуу байдал, энэ боломжийг бусад улсуудад оруулсан жишээнүүдийг бид бүхэн олон удаа харсан. Ялангуяа Энэтхэгт бүр 3 сая 500 орчим гишүүнтэй хоршоо “AMUL” (Anand Milk Union Limited) гээд сүүний чиглэлийн хоршоо байх жишээтэй.

Тэгэхээр энэ чиглэлийн төсөл, хөтөлбөр ядуурлыг бууруулах чиглэлийн ажлуудыг хийх ч заалтууд дээрээ гол анхаарлаа хандуулах нь зөв гэж бодож байна.

Дахиад нэмэлт нэг асуулт байгаа нь зөвхөн санхүүгийн хоршооноос гадна хөдөө аж ахуйн чиглэлийн хоршоод, бусад хоршоод байгаа.

Тэгэхээр энэ чиглэлүүд дээр тодорхой ямар зохицуулалтууд байна? Нэг хоршоо өөр олон төрлийн чиглэлийн үйл ажиллагаа явуулах боломжуудыг нээх заалтууд байна уу гэдгийг нэмж асууя.

С.Бямбацогт: Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн хариулт хэлье.

Д.Үүрийнтуяа: М.Ганхүлэг гишүүний ярьж байгаа зүйл үнэн л дээ.

Сумдад тухайлах юм бол түрүүн Санхүүгийн зохицуулах хорооноос хариултад хэлж байсан. Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын хоршоодыг. Идэвхтэй хүн амын 93 хувь нь хамрагдсан байгаа гэж.

Тэгэхээр санхүүгийн хоршоод гишүүдэд үйлчлэх, гишүүдийнхээ санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, нийгэм соёл, соён гэгээрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх энэ боломжийг нь нээх үүднээс Иргэний хуульд заасан хуулийн этгээдийн “хоршоо” гэдэг ангиллаараа явахад татвар төлөхгүй байх ёстой. Энэ татварыг нь энэ үйл ажиллагаандаа зарцуулах боломжийг нь энэ хуулиар хуульчилж оруулж өгч байгаа, зааж өгч байгаа.

Өнөөдөр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 2025 оны статистикаар 14 мянга 021 хоршоо байна. Бүх төрлийн хоршоо. Энэ дотроос санхүүгийн хоршоо 176 байгаа. 176 хоршоо нь бусад 14 мянган хоршоогоо үйл ажиллагаа явуулахад нь санхүүгийн хувьд дэмждэг, хамтарч ажиллах хэлбэр лүү шилжих ёстой гэж бид харж байгаа.

С.Бямбацогт: Ганбатын Очирбат гишүүн асуултаа асууя.

Г.Очирбат: Баярлалаа. 2024 оны байдлаар 178 хадгаламж, зээлийн хоршоонд 75 мянга 252 хүн хамрагдаж байна гэж байна.

Мэдээж энэ хадгаламж, зээлийн хоршоонд гашуун түүх байгаа. Их алдаа, оноо гарсан юмнууд байгаа. Үүнийг засаж залруулаад, сайжруулъя гээд хуулийн төсөл оруулж ирж байгаа Д.Үүрийнтуяа, Б.Заяабал гишүүн хоёр оруулж ирж байна гэж харж байгаа.

Гэхдээ энэ дээр нэлээн тодруулж асуух асуултууд их байгаа юм. Би эхнийхээ асуултыг Монголбанкнаас асууя.

Энэ хуулийн төслөөр санхүүгийн хоршоо зөвхөн гишүүддээ үйлчлэх үүрэгтэй зүгээр нэг ийм банк болоод байгаа юм шиг харагдаад байгаа юм. Жижиг банк.

Тэгэхээр энэ ер нь зөв үү, буруу юу? Би Байнгын хороон дээр ч асууж байсан. Тэр судалгаанууд Монголбанкнаас санхүүгийн үйл ажиллагаанд оролцож байгаа байгууллагаас авсан судалгааны үр дүнг л сонсмоор байгаа юм.

Хоёрдугаарт, хууль санаачлагчаас асууя.

Одоогийн энэ хуульд зааснаар “Хадгаламж, зээлийн хоршоодын холбоо” гэсэн нэршлийг “Санхүүгийн хоршоодын нэгдсэн төв” болгож байгаа.

“Хадгаламж, зээлийн хоршоодын холбоо” гэдэг ашгийн бус үйл ажиллагаа холбооныхоо статусаар явуулж байсан. Одоо үүнийг “Санхүүгийн хоршоодын нэгдсэн төв” болгохоор энэ ашиг болоод цаашаа явах энэ боломж, бололцоо нь нээгдээд явж байна уу, үгүй юу?

Яагаад гэхээр хуулийн төслийн 11.2-ыг харахаар сумын насанд хүрсэн хүн амын 50-иас доош хувийг гишүүнээр элсүүлсэн санхүүгийн хоршоонд орон нутаг хөгжүүлэх зориулалттай сан, ашигт малтмал ашиглах, хайгуул, олборлолт хийх аж ахуйн нэгжийн хандив, тусламжийн мөнгөн хөрөнгийг шилжүүлж тухайн сумыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэж.

11.3 дээр энэ хуулийн 11.2-т зааснаас бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг Санхүүгийн хоршоодын нэгдсэн төвөөр дамжуулна гэж байгаа юм.

Тэгээд бусад гэхээр хаанаас ямар мөнгө татаж авчирч ирж хийх гэж байгаа юм? Аягүй эргэлзээтэй эргэлзээтэй юмнууд энэ дээр харагдаад байгаа юм. Энэ дээр хариултаа авъя.

Хамгийн сүүлийнх нь Санхүүгийн зохицуулах хорооноос. Ер нь Санхүүгийн зохицуулах нь хорооны яг энэ хоршоодын нэгдсэн төвийг. Хэрвээ ийм болгож байвал яг энэ хянан шалгах чиг үүрэг, өөрчлөн байгуулах, тэр татан буулгах гээд олон харилцааг зохицуулдаг.

Тэгээд энэ чиг үүргээ бас энэ Санхүүгийн хоршоодын нэгдсэн төв рүү шилжүүлэх ийм одоо энэ хуулийн төсөл дээр үг, өгүүлбэр оруулж ирэх боломж, бололцоо байгаа юу, байхгүй юу? Хууль санаачлагч нар хариулна биз. Тийм ээ? Баярлалаа. Тэгээд тодруулъя.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуултад хариулъя.

Д.Үүрийнтуяа: Хууль санаачлагчаас асуусан асуултуудад хариулъя.

Холбоо дээвэр байгууллага гэж бид нэрлээд байгаа юм. Нэгдсэн төв гэж.

Тэгэхээр бид одоо байгаа хадгаламж, зээлийн хоршоодын холбоог олон улсын жишигт нийцсэн нэршлийнх нь хүрээнд хуулийн төсөл дээр оруулж ирсэн байгаа. Хадгаламж, зээлийн хоршоо өөрөө яг өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Иргэний хуулийн хуулийн этгээдийн ангиллаар ашгийн төлөө бус хуулийн этгээд, гишүүдийнхээ төлөө үйлчлэх үүрэгтэй хуулийн этгээдээр томъёологдсон байгаа. Тэгээд энэ хүрээнд үйл ажиллагаа явуулах юм.

11.2 дахь заалтыг магадгүй Г.Очирбат гишүүн ээ, томъёолол нь алдаатай, үг, үсгийг нь засаж залруулах, өөрчлөх шаардлага байхыг үгүйсгэхгүй. Энэ

хэлэлцэх эсэх асуудал яригдаж байгаа учраас ажлын хэсгийн хүрээнд өөрчлөх, ярилцах, шаардлагатай хасахыг ч үгүйсгэхгүй.

Гэхдээ энэ орсон гол зорилго нь гишүүдийн асуугаад байгаа хөдөлмөрөөрөө хоршиж байгаа хоршлыг, нэгдлийг дэмжих, нөгөө талаас олон улсын байгууллагуудаас байгаль орчны чиглэлээр орон нутагт хэрэгжүүлэхэд янз бүрийн томоохон төсөл, хөтөлбөрүүд санхүүгийн хоршоодоор дамжуулж, олон улсын жишигт хүрсэн хоршоодоор дамжуулж оруулья гэхэд үүнийг авах боломж өнөөдөр бидэнд байхгүй байгаа юм. Тэгээд энэ боломжийг орон нутагт нээж өгье гэдэг зорилгоор л оруулж ирсэн заалт л даа.

Хэрвээ энэ үнэхээр эрсдэл үүсгэж байна гэвэл манай гишүүд ярилцаад хэлэлцүүлгийн явцад шийдээд явах би бүрэн боломжтой гэж харж байгаа. Таны Байнгын хороон дээр хэлсэн саналын хүрээнд хууль санаачлагчийн зүгээс ажлын хэсэгтэйгээ энэ асуудлыг ярьсан, ярилцсан.

Тэгээд энэ дээр ажлын хэсэг Их Хурлаас гараад ажиллах явцад хэлэлцүүлгийнхээ үед засаж залруулаад явах боломжтой. Таныг саналаа өгөөсэй гэж хүсэж байна. Монголбанкны үйл ажиллагаа гэдэг дээрээ Монголбанк хариулах байх.

Хууль санаачлагчийн хувьд энэ дээр ямар байр суурьтай байгаагаа хэлэх нь зөв болов уу гэж бодож байна.

М.Ганхүлэг гишүүн түрүүн хэлсэн. Орон нутаг, сумдад Төрийн банк, ХААН банк л ер нь байдаг даа. Иргэдийн үйлчилгээ авах боломж тун хязгаарлагдмал.

Ийм нөхцөлд сүлжээтэй, сүлжээгүй олон газрууд байна. Ийм нөхцөлд хадгаламж, зээлийн хоршоо буюу энэ санхүүгийн хоршоод санхүүгийн үйлчилгээг нэмж мөнгөн гүйлгээ, харилцааны хэлбэрийг нэмэгдүүлснээрээ өөрийнхөө гишүүдэд үйлчлэх боломжийг нь л нээж өгч байгаа юм.

Арилжааны банк ашиг бол олох зорилготой. Аүрээ хязгаар хязгаарлагдаагүй. Бүх хүмүүст хуулийн хүрээнд зээл, банкны үйлчилгээ үзүүлж байгаа бол хадгаламж, зээлийн хоршоонд зөвхөн гишүүдийнхээ эрх ашгийн төлөө ажиллах энэ зорилтынхоо хүрээнд. Ялангуяа төрийн үйлчилгээг, санхүүгийн зах зээлийн үйлчилгээг ард иргэдэд илүү ойр хүргэх энэ чиг үүргийн хүрээнд л оруулж ирсэн зохицуулалт байгаа юм.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулах уу? Ажлын хэсэг. Т.Жамбаажамц дарга. 4 дүгээр микрофон.

Т.Жамбаажамц: Г.Очирбат гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье.

Хуулийн төслийн төслөөр хяналт шалгалттай холбоотой асуудлыг маш нарийн зохицуулсан байгаа. Г.Очирбат гишүүн ээ.

Хуулийн төслийн 11 дүгээр бүлгээр маш нарийн зохицуулалттай. Учир нь яагаад энд нарийн хяналт шалгалтын зохицуулалтыг оруулсан бэ гэхээр энд маш олон хадгаламж эзэмшигчдийн мөнгөн хөрөнгө байж байдаг.

Тэгэхээр энэ дээр хамгийн гол эрсдэл энэ хадгаламж эзэмшигчдийн мөнгөн хөрөнгө эрсдэлд орох, дампуурах. Таны түрүүний ярьсан. Бид 20-иод жилийн өмнө үүссэн тэр зүйлийг л дахин давтуулан гаргахгүй байх л зорилготой энэ хуулийн зохицуулалт, тэр хяналт шалгалтын нөхцөлүүд байгаа юм.

Тэгээд энэ дотор яг нөгөө санхүүгийн мэргэжлийн байгууллагад байдаг албадлагын арга хэмжээнүүд хэрэглэгдэнэ. Тусгай зөвшөөрлийнх нь хүрээнд. Тэр хүртлээ наад талын дээвэр холбоо, тогтворжуулалтын сан, нөөц сангаар зохицуулагдаад явна.

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулъя. Хариултаа дуусгая.

Т.Жамбаажамц: Хоршоо татан буугдах харилцааг энэ хуулиар зохицуулсан. Энэ дээр—

- нөхцөлт удирдлага,
- тусгай зөвшөөрлийг хязгаарлах,
- зарим төрлийн үйл ажиллагааг зогсоох.

Тэгээд санхүүгийн томоохон банканд хэрэгждэг бүрэн эрхт төлөөлөгч томилох, эрх хүлээн авагч томилох хүртэл ийм арга хэмжээг төрийн зохицуулагч байгууллага буюу Санхүүгийн зохицуулах хороо хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах энэ хүрээнд хэрэгжүүлэхээр хуулийн төслийн 11 дүгээр бүлгээр нарийвчилж зохицуулсан байгаа. Баярлалаа.

С.Бямбацогт: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя. Алга байна. Монголбанкнаас хүн байхгүй байгаа.

Пүрэвийн Батчимэг гишүүн асуултаа асууя. Алга байна. Ринчинбямбын Сэддорж гишүүн асуултаа асууя. Алга байна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байртай байр суурьтай намын бүлгийг төлөөлж, бүлэгт болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу “дэмжсэн”, “дэмжээгүй” байр сууриа илэрхийлнэ үү. /алх цохив/

Нэрсийг дэлгэцэд өгье. Нэр өгсөн дараалалдаа үг хэлэх зөвшөөрөл. Х.Баасанжаргал гишүүн үг хэлэх нэр өгсөн байна. Алга байна.

Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

М.Мандхай гишүүн нэр өгсөн юм байна. Тийм ээ. М.Мандхай гишүүн нэр өгөгдсөн. Сая дэлгэцэд нь техникээс гарч ирээгүй байна шүү.

М.Мандхай гишүүн үгээ хэлье. Мэндбаярын Мандхай гишүүнийг индэрт урьж байна. 1 дүгээр микрофон.

М.Мандхай: Санхүүгийн хоршоог зарчмын хувьд дэмжиж байгаа.

Байнгын хороод дээр өөрийнхөө тодруулга, асуултаа хэлсэн байгаа. Гэхдээ энэ хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа боловч илүү сайн сайжруулалт боловсруулалт хийхгүй бол ер нь энэ тоо баримттай зорилтот түвшин, хангалттай судалгаа хийгдээгүй байна гэж харж байгаа.

Зээлийн хүүг бууруулна гэж байгаа боловч хэрхэн, яаж, хэдэн хувиар зээлийн хүүг бууруулж, санхүүгийн ямар хүртээмжийг санхүүгийн хоршооны гишүүдэд олгох гэж байгаа юм бэ гэдэг нь нэгд тодорхой бус байгаа.

Дээрээс нь сүүдрийн эдийн засаг, мөнгө хүүлэгчидтэй тэмцэх ийм заалтыг танилцуулгад тусгасан байгаа юм. Энэ нь өөрөө яг ямар эрсдэл дагуулж байгаа, хэрхэн яаж бууруулах вэ гэдэг нь хэмжих үзүүлэлт өөрөө тодорхой бус танилцуулга дээр байгаа.

Ингээд ер нь энд хамгийн чухал асуудал бид санхүүгийн эрсдэлийн асуудлыг ярьж байгаа. Хэрэв санхүүгийн хоршоо эрсдэлд орох, дампуурах, санхүүгийн хоршоог хэн удирдах, засаглалын хувьд ямар байх юм.

Хэрэв санхүүгийн хоршоог чадамжгүй, чадваргүй менежментийн аргаар дампуурах нөхцөлд очих юм бол хууль дээр санхүүгийн хоршоог эрсдэлд орсон зээлдэгч зөвхөн нөхөн төлбөрөө 20 сая төгрөгийг л авахаар ийм заалт тусгасан байгаа.

Тэгэхээр 20 сая гэдгийг ямар үндэслэлээр яаж гаргаж ирсэн бэ гэдэг дээр бас тодорхой хариулт авч чадаагүй.

Тэгэхээр энэ хуулийг маш сайн судалж гаргахгүй бол эргээд нөгөө хадгаламж, зээлийн хоршооноос үүссэн хохирол, эрсдэл, ингээд зээлдэгч нар мөнгөө авч чаддаггүй өнөөдөр хүртэл энэ асуудал яригдсан асуудал маань хэвээр хэр үлдэх вий гэдэг болгоомжлол байгаа.

Тэгээд хууль санаачлагчид дахиад маш сайн хуулиа сайн харах хэрэгтэй байна. Энэ дээр судалгаа тооцоо, дагах тэр үр дүнгийн тооцоо мэдээллүүдийгээ баримтжуулж олгож өгөөрэй гэдгийг хэлэх нь зүйтэй байх.

С.Бямбацогт: Мэндбаярын Мандхай гишүүнд баярлалаа. Гишүүд үг хэлж дууссан.

Санхүүгийн хоршооны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалтыг 4 дүгээр сарын 10-ны Баасан гарагийн үдээс өмнөх хуралдаанаар явуулна.

Санал хураалтыг хойшлууллаа. /алх цохив/ Хуралдаанд оролцсон ажлын хэсэгт баярлалаа. Хэлэлцэх дараагийн асуудалдаа оръё.

Тав.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 17 гишүүн
2025.11.20-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/

Тавдугаар асуудал. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 17 гишүүн 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин танилцуулна.

Х.Тэмүүжин гишүүнийг индэрт урьж байна.

Х.Тэмүүжин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Өнөө цагт парламентын спикер төвч, бие даасан байр сууринаас парламентын хуралдааныг удирдах нь парламентын ардчилал, парламентын дархлааны салшгүй гол зарчим болсон байна.

Дэлхий нийтийн нийтлэг хандлагаар парламентын нийтийн танхимыг олон намын тогтолцоо, олон ургалч байдал бүхий чөлөөт хэлэлцүүлгийн орчин, олонх цөөнхийн бодлогын мэтгэлцээний талбар, улс төрийн зөвшилцөл, ойлголцлын механизмаас гадна нээлттэй, хяналттай төрийн үйл ажиллагаа, иргэний мэдэх эрхийг хангах гол эх үүсвэр байлгах талаас нь парламентын спикер, түүнд тавигдах шаардлага, түүний томилгоо, чөлөөлөлттэй шууд холбоотой гэж үздэг болсон байна.

2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтөөр сонгуулийн холимог тогтолцоотой болсон төдийгүй парламентын давжаа байдлыг засаж, 126 гишүүнтэй болсон.

Үүний үр дүнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар Улсын Их Хуралд 4 нам, 1 эвсэл суудал авч олон намаас бүрдсэн Улсын Их Хурал олонх, цөөнхийн байр сууриас намын лидерүүд нь мэтгэлцэж зөвшилцдөг парламенттай ардчиллаар тулгуур зарчим Монгол Улсад төлөвшин хөгжих боломж нэмэгджээ.

2025 оны 7 дугаар сарын 09-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн өөрчлөлтөөр Улсын Их Хурал асуулгын цагтай болж Ерөнхий сайд сөрөг хүчний лидер бодлогын лидертэй бодлогын мэтгэлцээн хийдэг, гишүүд цаг үеийн асуудлаар Ерөнхий сайдаас шууд асууж, хариулт авдаг улс төрийн шинэ соёл бий болсон билээ.

Улсын Их Хурлын дарга давхар дээл эрхлэхтэй холбоотой хязгаарлалтыг тодорхой болгохгүй бол парламентын ардчиллын олон улсын жишгийн дагуу парламентын спикер төвийг сахиж хуралдааныг удирдах, олонх цөөнхийн мэтгэлцээнийг хөндлөнгийн байр сууриас явуулах, олонх нь шийдвэр гаргах, цөөнхийн хяналт тавих эрхийг баталгаажуулах болон олон намын үзэл баримтлал, бодлогын өрсөлдөөнийг Улсын Их Хуралд хэрэгжүүлэх явдлыг алдагдуулах эрсдэлтэй байна.

Мөн 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулах тухай шинэ зохицуулалт, парламентын хяналтын шинэ механизм бий болсон.

Гэтэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 28.6 дахь хэсэгт ээлжит чуулганы хуралдааны хугацаанд хоёр хүртэл хянан шалгах түр хороо ажиллахаар зааж хязгаарласан нь парламентын шалгалтын үйл ажиллагааг доголдуулсан төдийгүй нийтийн ашиг сонирхол хөндсөн тодорхой асуудал дээр Улсын Их Хурал ажиллаж чаддаггүй, олон нийтийн дуу хоолойг сонсдоггүй, нийтийн төлөө санаа тавих хүсэл зориггүй, Монгол Улс Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадамжгүй гэж олон нийт үнэлэх дүгнэх үр дагавартай байна.

Хуулийн төслийн дагуу үүсэж болох үр дагавартай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсрууллаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хуулийн төслийг дэмжиж хамтран санаачилсан О.Алтангэрэл, Д.Батбаяр, С.Ганбаатар, П.Ганзориг, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, Э.Одбаяр, Г.Очирбат, Ц.Туваан, А.Ундраа, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр, О.Цогтгэрэл, С.Эрдэнэболд гишүүддээ талархал илэрхийлье.

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

С.Бямбацогт: Төслүүдийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар танилцуулна.

Индэрт урьж байна.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Хишигжаргалын Тэмүүжин нарын 17 гишүүнээс 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын **d.parliament.mn** цахим хуудаст байршуулсан бөгөөд хууль санаачлагч Улсын Их Хурлын даргыг Улсын Их Хурлын нийт бүрэлдэхүүний олонход хүлээн зөвшөөрөгдөх төвийг сахисан байдлаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын хуралдааныг сонирхлын зөрчилгүй, намчирхалгүй удирдах, Монгол Улсын Ерөнхийлөгчийн түр эзгүйд Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг Үндсэн хуулийн шаардлага нөхцөлийг ханган хэрэгжүүлэх зэрэг асуудлыг зохицуулах хууль зүйн үндэслэлийг бий болгох төдийгүй, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар хянан шалгах ажлыг үр нөлөөтэй, зүй ёсны хязгаарлалтгүй хэрэгжүүлэх боломж олгохоор хуулийн төслийн боловсруулсан талаар танилцуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед–

- Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр хууль санаачлагчаас уг хуулийн төслийг батлуулах ойлголцолд хүрсэн эсэх талаар, Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаас олон намын төлөөлөл бүхий 126 гишүүнтэй Улсын Их Хурлын хуралдааны дэгийг боловсронгуй болгох чиглэлээр хэрхэн ажиллаж байгаа талаар,
- Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд уг хуулийн төслийн амин сүнс, ач холбогдлыг жирийн иргэдэд ойлгомжтой тайлбарлаж, тус хуулийн төсөл ирээдүйд парламентын соёл, төлөвшилд хэрхэн нөлөөлөх талаар,
- Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар–

► Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын даргаас сонгогдсон тохиолдолд намын гишүүнчлэл болон намын бүтцийн байгууллагын үйл ажиллагаанд оролцохоос бүрэн түдгэлзэх эсэх;

► Парламентын спикер намын гишүүнчлэлээс түдгэлздэг Их Британийн туршлагыг судлахдаа цаад шалтгааныг нь судалсан эсэх тус туршлага манай улсад хэрэгжих боломжтой эсэх;

► Нөгөө талаар спикер намын гишүүнчлэлээс түдгэлздэггүй улс орны туршлагын үндэслэлийг хэрхэн дүгнэсэн, болзошгүй сөрөг үр дагаврыг тооцсон эсэх.

► Мөн намын гишүүнчлэлээс түдгэлзсэн спикерийг дараагийн өрсөлдөгчгүйгээр сонгодог жишиг манай улс төрийн соёл тогтох эсэх талаар,

- Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд дэмжихээ илэрхийлээд* парламентын спикер намын гишүүнчлэлээс түдгэлздэг энэхүү соёл улс төрийн намын хатуу гишүүнчлэлтэй манай улсын хөрсөнд нутагших боломжтой эсэх талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар бусад намаас санал асуусан эсэх, хуулийн төслийн зохицуулалтыг дагаад дэд дарга нарыг намын гишүүнчлэлээс түдгэлзэх эсэх талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Хянан шалгах түр хороо байгуулах тоог тодорхой тогтоох талаар–

асуулт асууж, хариулт авсан болно.

- Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр Энэ хуулийн мөн чанар нь Улсын Их Хурлын дарга парламентын дархлаа, бие даасан хараат бус байдлыг хангахын тулд Монгол Улсын Их Хурлын дарга намын гишүүнчлэлээс түдгэлзэж, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн хурлаас ангид байх, институцийн хувьд парламент нь парламент шиг, Засгийн газар нь Засгийн газар шиг, Ерөнхийлөгч нь Ерөнхийлөгч шиг байх зүйтэй талаар;
- Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд институтийн хувьд хүний сэтгэл хөдлөлд тулгуурласан, улс төрөөс ангид, парламентын урт хугацааны төлөвшлийг дэмжихийн тулд энэ хуулийг дэмжих шаардлагатай бөгөөд засах шаардлагатай саналуудаа нээлттэй хэлэлцэх зүйтэй талаар;
- Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжихийн зэрэгцээ асуудлыг цогцоор нь шийдвэрлэх,

Улсын Их Хурлын гишүүн ард түмний элч төлөөлөгч, нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэгчийн хувьд ард түмний төрд итгэх итгэлийг сэргээх ажлыг эхлүүлэх, Улсын Их Хурлын даргын хэлэлцүүлэггүйгээр шууд сонгодог зохицуулалтыг засаж, эрх үүргийн хариуцлагыг цогцоор нь шийдвэрлэх нь зүйтэй талаар;

- ▶ Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл Ардчилсан намын зарчимд нийцүүлэн Улсын Их Хурлын даргыг намын дарга бус, улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчмыг дэмжих, ээлжит чуулганы хугацаанд Хянан шалгах түр хороо байгуулах хязгаарлалтыг өөрчлөх нь зүйтэй талаар;
- ▶ Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар парламентын засаглалын давуу талыг ашиглан бүх талын байр суурийг судалж, нарийн хэлэлцсэний үндсэн дээр энэ хуулийн төслийг боловсронгуй болгон батлах талаар;
- ▶ Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар 126 гишүүнтэй, 5 нам, 1 эвслээс бүрдсэн парламентын үйл ажиллагаанд Улсын Их Хурал дахь нам, эвслийн оролцоог бодитоор хангах, Улсын Их Хурал цөөн суудалтай нам, эвсэл хэлэлцэж буй асуудлаас завсарлага авах эрхтэй байх, Улсын Их Хурлын гишүүний өргөн мэдүүлсэн хуулийн төслийг цаг алдалгүй хэлэлцүүлдэг байх зэргээр Монгол Улсын Их Хурлын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд тусгах шаардлагатай талаар;
- ▶ Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр уг хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд дэмжихээ илэрхийлж, нэн яаралтай хэлэлцэж батлах нь зүйтэй талаар;
- ▶ Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа 2020 оны 5 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийг Ж.Мөнхбат гишүүн ахалж ажилласан талаар залруулга хэлээд, хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа ч сайтар нягталж батлах нь зүйтэй саналаар төслийн 11.1 дэх хэсгийн зохицуулалт нь хүчин төгөлдөр хуулийн 11.1, 11.2-т нарийвчлан зохицуулсныг орхигдуулсан нь цаашид Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлж чадахгүй нөхцөл үүсэх эрсдэл байгааг, түүнчлэн Улсын Их Хурлын даргыг сонгох саналын босгыг анхаарах нь зүйтэй талаар;
- ▶ Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал олон намын тогтолцоо нь парламентын бие даасан байдлыг хангах үндсэн хүчин зүйл болох спикерийн төвийг сахисан бие даасан байр суурийг баталгаажуулж, Улсын Их Хурал дахь нам, эвслийн дуу хоолойг хүргэх, Улсын Их Хурлын үйл ажиллагаанд бүрэн оролцох, Улсын Их Хурлын хяналтын механизмыг тэнцвэртэй ажиллуулах нөхцөл бүрдэх, парламентын институцийн бэхжүүлэх ач холбогдолтой тул хуулийн төслийг дэмжих нь

зүйтэй талаар;

- ▶ Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Улсын Их Хурлын гишүүдийн ард түмний төлөөлөх эрхийг Улсын Их Хурал дахь намын бүлгийн шийдвэрээр хязгаарлах тохиол л байдаг тул хуулийн төслийг дэмжиж, парламентын бие даасан байдлыг хангаж, Улсын Их Хурлын гишүүн нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах боломжийг бодитоор бүрдүүлэх талаар;
- ▶ Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг парламентын ардчиллыг бэхжүүлэх, энэ парламентын бүрэн эрхийн хугацаанд үлдсэн 2 жилд Улсын Их Хурал дахь нам, эвслийн удирдлагуудыг оролцуулсан ажлын хэсэг байгуулж, төрийн байгуулалттай холбоотой төрийн үйл ажиллагааг журамлаж буй эрх зүйн орчныг цэгцэлж, төрийн үйл ажиллагааг тогтворжуулах шаардлагатай талаар тус тус үг хэлсэн болно.

Байнгын хороо хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулахад –

- Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 82.6 хувийн саналаар,
- Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 82.6 хувийн саналаар,
- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 82.6 хувийн саналаар,
- Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг 82.6 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль өөрчлөлт оруулах тухай, Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. /алх цохив/

Нэрсийг дэлгэцэд өгье. Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Энэ хуулийн төсөлтэй холбоотой ижил агуулгатай судалгааг өнгөрсөн оны 10 сард хийж байсан.

Тэгээд нэг асуудалтай тулгарсан нь ер нь яг ингээд улсуудыг судлаад үзэхээр намын гишүүнээсээ түдгэлздэг орны тоо нь бусад орнуудаасаа харьцуулахад бага цөөн харагдсан. Англи, Канад гэх мэтчилэн орнууд. Тэгээд нэг гишүүн нэг намаас санаачлахаар энэ нь өөрөө асуудалтай юм байна.

Тэгэхээр улс төрийн намуудын төлөөллийг оролцуулаад энэ хуулийг судлах, шаардлагатай бол өөрчлөлт оруулах, хуулийн төсөлд бэлтгэх ажлын хэсэг байгуулах хүсэлтийг өнгөрсөн оны 10 сард Х.Булгантуяа даргад өгч байсан. Гэхдээ энэ асуудал шийдэгдээгүй.

Тэгээд яг энэ тулгарсан асуудалтайгаа холбоотой асуултыг хууль санаачлагчаас асууя.

Намын гишүүнээс нь түдгэлзүүлснээр төв байр суурийг илэрхийлэх, нам ч бус, улс төрөөс ангид байх асуудлыг хангаж чадах уу? Одоо бид хэд ч гэсэн өнөөдрийн асуудалд үе үеийн Ерөнхийлөгч нарыг улс төрийн намаас түдгэлзүүлдэг мөртлөө улс төрд тодорхой хэмжээнд оролцоо нөлөөллүүд нь байгаад байна. Үүнийг энэ хуулиар яаж сайжруулж болохоор вэ? Энэ талаар Таны саналыг сонсьё.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлын дарга. Ер нь энэ хуулийн агуулга нь нам төрийн дээр гараад, төрийн институт, төрийн байгууллагуудад нөлөөлөөд байна гэдгийг тэр эрсдэлийг багасгах зорилготой гэж ойлгож байгаа.

Тэгэхээр бидний хувьд хамгийн том асуудал бол Улсын Их Хурлын дарга гэхээсээ илүү намуудын бүлэг байгаа. Одоо жишээлбэл Ардчилсан нам дээр 3 одтой шийдвэр гарлаа гэхэд Улсын Их Хурлын гишүүн өөрийнхөө бие даасан ард түмний элч гэдэг байр сууриа илэрхийлэх боломжгүйгээр заавал тэр шийдвэрийг дагахгүй бол ямар нэгэн хариуцлага, шийтгэл хүлээлгэх асуудлууд яригддаг.

Улсын Их Хурлын гишүүдийг нэр дэвшээд гишүүн болох үед нь нам нь гэрээ хийдэг. Хариуцлагажуулж оноожуулах иймэрхүү үйл явцууд байдаг.

Тэгээд энэ зохицуулалтыг ер нь Та юу гэж харж байгаа вэ? Үүнийг ер нь хөндөх ёстой юу? Саяын орж ирж байгаа үзэл баримтлалын хүрээнд агуулгын хувьд юу гэж харж байгаа вэ гэдэг нэг асуулт байна.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлын даргыг нам бус болгохтой холбоотой харилцаанууд цаашид Улсын Их Хурлын дарга чинь Улсын Их Хурлын гишүүн байгаа.

Тэгэхээр санал өгөх, Улсын Их Хурлын хэлэлцэж байгаа асуудлууд дээр зарим улсуудын хувьд түрүүчийн дурдсан Англи, Канад зэрэг орнуудад болохоор санал өгөх асуудлыг нь хязгаарладаг. Хэрвээ санал тэнцсэн тохиолдолд санал өгдөг зохицуулалтууд байдаг. Санал хураалттай холбоотой.

Дээр нь Улсын Их Хурал томилгоотой холбоотой асуудлууд байдаг. Жишээ нь,

- Монголбанкны Ерөнхийлөгч,
- Санхүүгийн зохицуулах хорооны дарга,
- Үндэсний аудитын газрын дарга,
- Үндэсний статистикийн хороо–

гэх мэтчилэн иргэд, эсвэл Тамгын газрын даргаа томилоход Улсын Их Хурлын даргын үүрэг ролийг яаж харж байгаа юм бэ?

Үүнийг тэр олон намын төлөөлөл орсон даргын дэргэдэх зөвлөлөөрөө шийдэж явах юм уу, эсвэл үүнийг яах юм гэдгийг таны бодлыг сонсьё.

Дээр нь Улсын Их Хурлын сонгуульд Улсын Их Хурлын нам биш Улсын Их Хурлын дарга маань сонгуульд оролцоход ямар байдлаар явах юм бэ?

Тэгэхээр энэ харилцаануудыг хуулийн төсөлд тусгаагүй учраас ер нь цаашдаа яаж зохицуулсан нь дээр вэ гэдэг талаар, энэ асуудлуудыг яаж харж байгаа вэ гэдэг талаар асуулт байна.

Дээр нь Үндсэн хууль дээр энэ заалттай холбоотойгоор. Яагаад вэ гэхээр бас нэг Улсын Их Хурлын гишүүний эрхийг нь хязгаарлаж байгаа учраас үүнтэй холбоотойгоор Үндсэн хууль дээр өөрчлөлт оруулах шаардлага бий гэж үзэж байгаа юу гэсэн ийм асуултууд байна.

С.Бямбацогт: Хууль санаачлагчдыг төлөөлж Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн хариулна.

Түр хүлээж байгаарай. Улсын Их Хурлын дэд дарга Жадамбын Бат-Эрдэнийн урилгаар Булган аймгийн Бүрэгхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 1986 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Монгол Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн өмнөөс ажлын амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Х.Тэмүүжин гишүүн хариуля.

Х.Тэмүүжин: Сүүлийнхээс нь. Яг одоо Улсын Их Хурлын даргыг төв ч байр суурь дээр байлгах болон улс төрийн намын улс төрөөс ангид байлгах гэдэг энэ зарчмыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах одоохондоо шаардлагагүй гэж үзэж байгаа.

▷ **Нэгдүгээрт,** Улсын Их Хурлын даргыг намаас түдгэлзүүлэх гэдэг хатуу зорилго хууль санаачлагчийн хувьд тавихгүй байгаа.

Хамгийн гол нь төв ч байх ёстой. Олон намын төлөөлөл бүхий парламент.

Тэгээд тэр дундаа парламентын мэтгэлцээн, бодлогын өрсөлдөөний талбарт хэвийн явуулахын тулд төв ч байр суурьтай хүн мэтгэлцээнийг удирдах, зохион байгуулахгүй нэг талд нь орвол мэтгэлцээн бодитой болохгүй.

▷ **Хоёрдугаарт,** Та бүхэн сая жил хүрэхгүй хугацаанд хоёр удаа харлаа.

Улсын Их Хурлын дарга өөрөө намын дотоод сонгууль болон намын улс төртэй хутгалдахаар парламент яаж хямардгийг Та бүхэн маш тодорхой харлаа.

Тэгээд арьс махан дээрээ мэдэрсэн байх. Парламент бол хамгийн тогтвортой институц байх ёстой.

Гэтэл улс төрийн намын дотоод асуудлаас болоод–

- хоёр удаа парламентын спикер нь бууж байна,
- хоёр удаа Засгийн газар нь огцорч байна.

Энэ бол өөрөө тэр дундаа парламентын спикерийг нам ч биш байлгах гэдэг ямар чухал болохын амьдралынх нь түүх, кэйс, шаардлага болсон байх.

Нам Улсын Их Хурал буюу парламентын гишүүний толгой дээр гараад байна гэдэг асуудал намын сахилга бат, намын үзэл баримтлалтай их холбоотой.

Сонгуулиар намын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөрийг дэмжиж сонгуульд орсон хүн нь сахилга баттайгаар тэр амлалтынхаа төлөө сонгогчдодоо хэлсэн үгнийхээ төлөө явах гэдэг бол зарчим.

Түүнийхээ эсрэг яваад байвал нам бол парламент, парламентын ардчилал хөгжсөн улс орнуудад нам тэр мандатынх нь хугацаанд яаж ч чадахгүй.

Харин бүх нийтийн сонгууль болох үед улс төрийн дэмжлэг үзүүлэхгүй ээ, манай нам чамайг дэвшүүлэхгүй ээ гэдэг хатуу байр сууриа л илэрхийлдэг юм билээ. Дунд нь шаардлагаа тавина. Тэр хувь Улсын Их Хурлын гишүүн мандаттай учраас үгүй, үгүй, би сонгогчдынхоо талд зогсох ёстой, энэ намын чинь байр суурь надад таалагдахгүй байна гэх юм бол тэр хүн өөрөө өөрийгөө илэрхийлээд үгээ хэлээд, саналаа өгөх эрхийг хэн ч хязгаарлах боломж байхгүй.

Германд ч хязгаарлахгүй, Монголд ч хязгаарлахгүй.

Ганцхан намын сахилга батаа эвдээд байгаа учраас гэдэг нь дараагийн сонгууль дээр л хариуцлага тооцох асуудал яригдаж байгаа юм.

Спикерийн санал өгөх эрхийн тухай асуудал үнэхээр яригддаг. Санал өгөх эрхээсээ илүүтэйгээр үг хэлэх эрх нь их хатуу юм билээ.

Парламентын спикер тодорхой асуудал дээр... /минут дуусав/

С.Бямбацогт: Тодруулах уу, болсон уу? Дэг барина. Та их дэг ярьдаг шүү дээ. Х.Тэмүүжин гишүүн ээ.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн тодруулж асууя. Тэр дээр хариулъя.

Д.Энхтүвшин: Тийм. Ерөнхийдөө үзэл баримтлалын хувьд энэ хуулийг дэмжиж байгаа.

Парламентыг парламент шиг байлгах, Засгийн газрын Засгийн газар шиг байг байлгах үүднээс энэ зохицуулалтууд байх ёстой гэж бодож байгаа.

Тэгэхдээ яах вэ саяын асуулт дутуу байсан учраас Х.Тэмүүжин гишүүнийг нэмж гүйцээж хариулт өгөхийг хүсэж байна.

С.Бямбацогт: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн гүйцээж хариулъя. Нэмж хариулъя.

Х.Тэмүүжин: Парламентын спикер хуралдаж байгаа хуралдаанаа хөтөлж явуулахгүйн тулд өөрөө байр суурь илэрхийлэхийг хориглодог юм билээ.

Хэрвээ байр суурьтай гэж үзэх юм бол орлогчдоо хурлаа удирдуулаад, өөрөө гишүүнийхээ суудал дээр сууж байгаад үг хэлэх эрхээ олж авдаг юм билээ.

Өмнө нь Та бүхэн Б.Пүрэвдорж гишүүн Улсын Их Хурлыг даргалж байхдаа би байр суурьтай учраас гээд энэ санал руугаа шилжиж ирээд үг хэлээд, дараа нь хуралдааныхаа даргалагчийн суудал руу очиж байсныг санаж байгаа байх.

Энэ жишгийг тогтоогоод авах манай парламентын хувьд дэвшил гэж үзэж байгаа.

Томилгоотой холбоотой асуудал парламентын спикерийн эрх мэдэл огт байдаггүй юм билээ. Парламентаас томилох албан тушаалтнуудын томилгоонд хамгийн хүчтэй санал бодлоо илэрхийлж оролцох субъект нь ерөөсөө Байнгын хороонд. Энэ Байнгын хороодын эрх мэдлийг, чуулганы эрх мэдлийг парламентын спикер буюу Улсын Их Хурлын дарга нь булааж хэрэгжүүлж болохгүй гэдэг зарчим үйлчилдэг юм билээ.

С.Бямбацогт: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултаа асууя.

О.Номинчимэг: Би Х.Тэмүүжин гишүүнтэй олон юман дээр санал нийлдэг.

Гэхдээ парламентын спикер нам бус байх ёстой гэдэг энэ хуулийн төсөл дээр санал нийлэхгүй байгаа.

Яагаад гэвэл энэ хуулийг харах юм бол Та улс бүрийн парламент өөр өөрийн соёлтой, өөр өөрийн түүхэн уламжлал дээр бүрдсэн соёлтой байдаг.

Тэгээд хамгийн онцлог болох Английн жишээг аваад Монголд наах гээд ороод ирсэн байгаа.

Тэгээд Англи өөрийн тэр түүхэн уламжлал болон өөрөө парламентын спикер чуулган дээр хэн ярих, ярихгүйг шийдээд гараараа заагаад ярьдаг ийм уламжлалтай юм.

Тийм ч учраас намаас нь түдгэлзүүлээд “нейтральный” (neutral) бай гэдэг. Дээр нь дараагийн сонгуульд тойрогт дэвшихэд нь бусад нам нь спикер юм чинь гээд “нейтральный” хүн юм чинь гээд өөр хүн дэвшүүлэхгүйгээр ер нь ингээд сонгоод явдаг ийм уламжлалтай.

Зүйрлэж хэлэх юм бол С.Бямбацогт дарга намаасаа түдгэлзэх юм бол Ховдод 2028 онд дэвших юм бол Б.Пүрэвдорж гишүүн бол ерөөсөө дэвшиж болохгүй гэсэн үг. Тэр маань тойргоо алдах ийм л уламжлалтай юм.

Тэгтэл ийм юмыг Монгол энэ хуульдаа оруулаад, дээр нь парламентын тэр спикер маань намаасаа түдгэлзээд 4 жилийн дараа дахиад намаасаа нэр дэвшиж болно гээд оруулж байгаа юм. 4 жилийн дараа намаасаа дэвших гэж байгаа хүн юу гэж, нам ч тэр байдал нь багасах вэ дээ.

Тэгээд “нейтральный байх ёстой” гэдэг, “төв ч байх ёстой” гэдэг энэ зарчим дээр мэдээж санал нэгдэж байгаа.

Гэхдээ шийдэл нь буруу байна. Дахиад л хүнтэй нь зууралдаж байна. Хүнтэй нь биш яг энэ системийг нь гажуудуулаад байгаа “нейтральный” биш болгоод байгаа тэр тогтолцоо, системийг нь бид сайжруулах хэрэгтэй байна гэж харж байгаа.

Ингэхийн тулд бид тэгвэл юуг харах ёстой юм бэ гээд харах юм бол. Та түрүүн ч гэсэн яг өмнөх, үдээс өмнөхийн чуулган дээр харлаа шүү дээ. Бүлэг ямар ч тохиолдолд үг авъя гэдэг байж болно гэтэл манай дэгийн хууль дээр байхгүй байна. Зөвхөн завсарлага авахад гээд.

Тэгээд үнэхээр цөөнх дуу хоолойгоо бас оруулж байя гэх юм бол Улсын Их Хурлын хууль, Улсын Их Хурлын дэгийн хууль дээр энэ боломжуудыг нээх тал дээр бид ажиллах ёстой.

Түүнээс хүний намын батлахыг нь аваад тэр хүн “нейтральный” хандана гээд хүнд нь найдах бол маш гэнэн найдал, итгэл тээж байна гэж би харж байгаа. Яагаад гэвэл миний харж байгаагаар Монгол Улсын улс төр өнөөдөр моралийн тийм өндөр түвшинд очоогүй.

Тэгэхээр энэ шийдэл болж чадахгүй. Энэ хүний намын батлахыг түдгэлзүүлснээр парламент “нейтральный” болж чадахгүй. Энэ дээр бид анхаарах ёстой гэж харж байна.

Тэгээд бид ер нь хэлээд байдаг. Хүнтэй зууралдах биш, хүнийх нь үзэмжид найдах биш, бид систем, тогтолцоог нь жоохон бэхжүүлэх ёстой байна.

Үнэхээр парламентын ардчиллаа хамгаалъя, парламентаа бэхжүүлэе гэвэл бид таны яриад явж байгаа Цэцийн хууль, Цэцийн процессын хууль, Ерөнхийлөгчийн хууль гээд энэ тогтолцоо хоорондоо энэ институциуд яах вэ гэдэг асуудал руугаа ч гэсэн ормоор байна.

Тэгэхгүй бол бид нэг тийм өнгөц дүр үзүүлсэн хууль дээр хамаг нөөц цагаа өнгөрөөх шаардлагагүй. Спикерийн тэр намыг нь түдгэлзүүллээ гээд, тэр гүйцэтгэх засаглалын Ерөнхий сайдын суудлыг энд тавилаа гээд спикер “нейтральный” шууд болохгүй. Гүйцэтгэх засаглалдаа парламент шууд хяналтаа тавьж чадахгүй ээ.

Тэгэхээр ийм өнгөц юмтай битгий зууралдаач ээ. Харин яг тогтолцоо руу чиглэсэн үндсэн юм руугаа цөмөөрөө нөөц цаг боломжоо илүү зарцуулъя гэж хэлмээр байна.

С.Бямбацогт: Үг хэллээ. Жаргалсайханы Золжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Золжаргал: Хуулийн төслийн 11.1-ийг дэмжихгүй. 11.5-ыг дэмжиж байгаа юм.

Тэгээд ямар учиртай гэхээр агуулга нь төвч байр сууриас хурлыг удирдаж зохион байгуулах. Ингэхээр зэрэг мэдээж намын харьяалал бага байх тусмаа л илүү төвч байж чадна гэсэн агуулга.

Тэгэхээр намын дарга байх нь зохимжгүй юм гэж бид сая баахан шуугьсан. Одоо ер нь намын гишүүнчлэлээс түдгэлзэх нь зөв юм биш үү гэж.

Тэгээд яах вэ, ер нь бодит байдал дээр түдгэлзсэн ч гэсэн намаасаа нэр дэвшээд л дарга болж байгаа хүн чинь их бага хэмжээгээр талтай л байж таарна шүү дээ. Тэгээд хүн юм чинь бүрэн арилахгүй байх. Арай дээр болж магадгүй.

Эхний заалт нь яагаад дэмжихгүй байна вэ гэхээр–

- Улсын Их Хурлын даргыг олонхоос нэр дэвшүүлнэ.
— Энэ заалт Үндсэн хуульд байхгүй.

Монгол Улсын Үндсэн хуульд–

- ▶ Улсын Их Хурлын даргыг Улсын Их Хурлын гишүүд дотроос сонгоно.
- ▶ Улсын Их Хурлын дэд даргыг нам, эвслийн бүлгүүдээс нэр дэвшүүлж сонгоно гэж байгаа.

Агуулга нь юу гэж уншигдаж байна гэхээр дэд дарга гэдэг бол тэр намын, тэр бүлгийн эрх ашгийг илэрхийлж байгаа намын мэтгэлцээний клубийн төлөөлөгч мөн. Дэд дарга. Их Хурлын дарга заавал нам, эвслийн байх албагүй. Олонхын ч байх албагүй.

Тийм болохоор анхны чуулган дээр хамгийн ахмад настайг хуралдуулдаг. Дээрээс нь Ерөнхийлөгчийг эзгүйд Улсын Их Хурлын дарга үүрэгт ажлыг нь хариуцдаг ийм зохицуулалт Үндсэн хуульд байгаа. Энэ нь цаанаа юуг илэрхийлж байна гэхээр нөгөө “үндэсний эв нэгдэл” буюу аль нэг нам, аль нэг хэсэг, аль нэг бүлгийн сонирхлыг илэрхийлэхээс илүүтэйгээр төвч байр сууринаас байна гэдэг агуулга нь энд харагдаж байгаа юм.

Тийм болохоор заавал олонх биш, заавал цөөнх биш, “гишүүдийн дотроос нэр дэвшүүлнэ” гэдэг Үндсэн хуулийн агуулгад хуулийн нэмэлт, өөрчлөлтөө нийцүүлэх шаардлагатай болов уу.

2028 онд Ардчилсан нам олонх болохоор манайд энэ нь хэрэгтэй байж магадгүй гэж бодоогүй байх. Одоогийн нөхцөлд энэ нь хүчинтэй байгаа заалт. Үүнийг дахиад үргэлжлүүлээд оруулж байгаа.

Тэгэхээр олонхын дотроос нэр дэвшүүлнэ гэдгийг нь хасаж болох уу? Энэ Үндсэн хуультай таны бодлоор харшлах зүйл байхгүй гэж бодож байна уу? Би Үндсэн хууль дээр энэ агуулгыг нь харахгүй байгаа юм. Нөгөө заалтыг нь агуулгын хувьд болох байх гэж бодож байна.

С.Бямбацогт: Жаргалсайханы Золжаргал гишүүний асуултад хариулья.

Хууль санаачлагч Хишигдэмбэрэлийн Тэмүүжин.

Х.Тэмүүжин: Үнэхээр тийм ээ. Үндсэн хууль дээр “олонх” гэж үг ерөөсөө байхгүй.

“Улсын Их Хурлын гишүүд дотроосоо нэр дэвшүүлж, саналаа ил гарган сонгоно.” л гэдэг үг байгаа.

Тэгэхээр энэ 1 дүгээр заалтыг бараг Үндсэн хуулийнхаа үгээр бичихэд болно. Зүгээр Үндсэн хуулиа тайлбарлах албагүйгээр шууд бичээд хэрэглэж болно. Энд бас намын олонх, бүлгийн олонх, сонгуулиар олонх болсон тухай биш зүгээр Улсын Их Хуралд байгаа тэр олонх болсон гишүүд нэрээ дэвшүүлээд сонгууль гэдэг ийм зарчмыг уг нь бичсэн юм.

Тэгээд бүдэг байдлаар ойлгоод буцаагаад уламжлалт байдлаараа энэ чинь олонх болсон нам руу шилжих юм биш үү гэдэг байдлаар харж байгаа бол зүгээр Үндсэн хуулийнхаа текстийг шууд бичиж болно.

Түрүүн О.Номинчимэг гишүүний үгэн дотор гарсан. Намаас түдгэлзүүлэх гэдгийг бид туйлын утгаар тавиагүй. Бид нарт алтернатив буюу нөгөө хувилбар нь бас байгаа юм. Намаас Улсын Их Хурлын даргыг түдгэлзүүлэхгүй байж болно. Гэхдээ 4 зарчмыг хуульчлах ёстой.

Германд маш тодорхой хуульчилсан байдаг юм билээ.

▷ **Нэгдүгээрт**, парламентын спикер намын бүлэгт харьяалагдахгүй гэж хуульчилсан. Намын бүлэгт орохгүй гэж.

▷ **Хоёрдугаарт**, намын улс төрөөс ангид байна. Намын дотоод сунгаанд оролцохгүй, намынхаа улс төрийн идэвхтэй үйл ажиллагаа явуулахгүй гэж.

▷ **Гуравдугаарт**, хэвлэл рүү болон олон нийт рүү гарахдаа зөвхөн Улсын Их Хурал парламентаа төлөөлнө.

Ямар нэгэн байдлаар намынхаа нэр дэвшигчийг дэмжээд гүйхгүй. Намаа сурталчлаад, намынхаа олон нийтийн үйл ажиллагаанд оролцохгүй. Зөвхөн Улсын Их Хурлын байр суурийг илэрхийлэх үг хэлнэ гэсэн хатуу зарчимтай юм билээ.

▷ **Дөрөвдүгээрт**, энэ зарчмуудыг жоохон зөөлрүүлээд сонгуулийн үр дүнгээр ард түмний мандат буюу олонх, цөөнхөд маргаан үүсгэх бол зөвхөн энэ тохиолдолд бүлэгтээ орж энэ бүлэг олонх юм гэдэг баталгааг бий болгох зорилготой дотор нь орж саналаа өгнө.

Түүнээс бусад үед бүлгийн үйл ажиллагаанд орохгүй гэдэг зарчим дахиад тавьдаг юм билээ.

Тэгээд энэ зарчмуудыг хуульчлах юм бол заавал намаас түдгэлзэцэнэ гэдэг энэ үгийг нэхээд байх шаардлагагүй.

Энэ 4 зарчмаа хуульчлаад энэ 4 зарчим чинь парламентын спикерийг төвийг сахисан, нам ч биш байдал руу явуулах учраас бид хууль санаачлагчийнхаа хувьд заавал хатуу байр суурийг тэр үгэн дээр илэрхийлэхгүй л гэсэн бодолтой байгаа.

С.Бямбацогт: Тийм. Дотроосоо гэдэг чинь тэгээд Их Хурлын гишүүд дотроосоо гэсэн үг болохоос олонхоос биш, цөөнхөөс биш, хаа хамаагүй дундаасаа гэсэн үг биш шүү дээ.

Өөр гаднын гишүүн биш нөхрийг Их Хурлын спикер, дарга болгох вий л гэж тийм агуулгаар Үндсэн хуульд тусгасан юм билээ шүү. Үүнийг зөв тайлбарлах ёстой байх.

Жаргалсайханы Золжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Золжаргал: Тийм. “Олонх Их Хурлын даргад нэр дэвшүүлнэ” гэдэг нь сонгуулийн үр дүнд бий болсон олонхын нам, бүлэг гэсэн үг биш юм байна гэдгийг тодруулъя.

С.Бямбацогт: Х.Тэмүүжин гишүүн хариулъя.

Х.Тэмүүжин: Хуулийн төсөл дээр “олонх” гэж бичсэн нь сонгуулийн үр дүнгээр бий болсон нам, эвслийн бүлгийг яриагүй.

Тухайн нэр дэвшигч дээр олонх болж байгаа гишүүдийн тухай яриа. 126 гишүүний олонхын саналыг аваад нэрээ дэвшүүлж байгаа хүний тухай яриа.

Бид Улсын Их Хурлын даргыг 126 гишүүний тал буюу 64 гишүүний гарын үсэгтэйгээр огцруулдаг. Нэр дэвшилт бас энэ босгыг давж орж ирэх ёстой гэдэг шаардлага Үндсэн хууль дээр яригдаж магадгүй гэдэг агуулга бас ер нь хүмүүсийн үзэл санаанаас гарч ирдэг.

Тэгээд дахиад хэлэхэд Үндсэн хууль дээр маш тодорхой.

- Намчирхаж болдог албан тушаал нь “дэд дарга” гээд бичсэн байгаа. Намын бүлгүүдээс намчирхана.
- Намчирхаж болохгүй албан тушаал нь “Улсын Их Хурлын дарга” байна.

Энэ намчирхдаг, намчирхдаггүй энэ хоёр үйлдлийн тэнцвэрийг олох гэж Үндсэн хууль зохицуулалтаа маш тодорхой илэрхийлсэн байна лээ.

Бид энэ дагуу л явах ёстой.

С.Бямбацогт: Сархадын Зулпхар гишүүн асуулт асууна.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дарга, гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая.

Өнгөрсөн долоо хоногт Х.Тэмүүжин нарын 17 гишүүний санаачилсан Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай энэ хуулийг бид Байнгын хороогоор хэлэлцсэн.

Тэр үед их олон талаас нь бид асуулт асууж, хариултуудаа авсан.

Сая Х.Тэмүүжин гишүүний хариулж байгаа хариулт үндсэндээ тэр үеийн асуултуудад дахин хариулт өгөх байдлаар хууль санаачлагчдын байр суурийг илэрхийлж байна.

Их тийм хатуу байр суурьтай тодорхой хуулийн зохицуулалтууд байсныг бид арай өөрөөр өөрийнхөө төрт ёсны түүх, эсвэл одоо байж байгаа улс төрийн практик, өнгөрсөн 30 гаруй жилийн практиктай уялдуулсан байдлаар эргэн харж болох юм байна гэсэн ийм хариултууд өгч байх шиг байна.

Би үүнийг мэргэшсэн түвшинд асуудалд хандаж байгаа талаас нь их талархан хүлээж авч байна.

Бид ер нь ямар ч хуулийн төслийг оруулаад ирэхэд тал талаас нь хэлэлцээд, түүн дээр хуулиа илүү ажилладаг. Түүнээс гадна одоо жишээ нь үр дүнтэй тодорхой харилцааг зохицуулж чаддаг болох талаас нь ингэж хандаж байгаа нь их сайн гэж бодож байна.

Би яах вэ, дахиад өмнө асуусан асуултуудаа тодруулъя. Яах вэ, олон нийт сонсох үүднээс.

Яг парламентынхаа спикерийг буюу даргыг улс төрийн намаас нь түдгэлзүүлдэг хатуу зохицуулалттай улс дэлхий дээр нэг л байгаа юм билээ. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс. Тэгээд эд нар үүнийг сонгож авсан тодорхой түүхэн шалтгаануудтай юм билээ.

Тэгэхээр энэ асуудлыг Та бүхэн судалсан байх. Гэхдээ энэ сонголтын цаана хязгаарууд байгаа юм. Хязгаарлалтууд байгаа юм. Сул талууд нь байгаа юм. Үүнийг Та бүхэн судалсан байх гэж бодож байна. Нэгдүгээр асуулт.

Хоёр дахь асуулт бол үүнийг сонгоогүй шалтгааныг Та бүхэн бидэнд тайлбарлаж өгөх ёстой. Дийлэнхийг улс орнууд сонгоогүй.

3 улс Х.Тэмүүжин гишүүний хэлсэнчлэн завсрын зохицуулалтууд хийсэн зүйл бий.

Германы зохицуулалт бол ялгаатай зохицуулалт байна лээ. Тэр байж болох зохицуулалт юм шиг байгаа юм.

Сонгоогүй шалтгаан нь. Өөрөөр хэлбэл спикерээ улс төрийн намаас нь түдгэлзүүлдэггүй шалтгаан нь юу юм бэ гэдгийг Та бүхэн судалсан байх гэж бодож байна. Үүнийг Та бүхэн тайлбарлаж өгөөч гэж байгаа юм.

Гурав дахь асуулт. Спикер тухайн улс төрийн намаасаа гишүүнээр байдаг шалтгааныг улс төрийн үйл явцыг илүү үр дүнтэй болгох, улс төрийн шийдвэрүүдийг хурдан гаргаж, тэр нь улс төрийн үйл явцыг үр дүнтэй болгох талаас нь давуу талтай гэж үзээд л эд нар үргэлжлүүлсэн юм билээ. Судалгаагаар.

Тэгэхээр энэ талаас нь Та бүхэн бодож байгаа юу? Хэрвээ спикер маань намаасаа түдгэлздэг. Тэгээд мэдээж хэрэг олонх болсон л улс төрийн хүчин юм чинь бодлогоо явуулахын тулд нэг л ийм хэлэлцсэн парламент болдог. Тэгээд хууль гардаггүй, бодлого гардаггүй ийм байдал үүсэх эрсдэлүүдийг Та бүхэн бас бодож үзсэн үү гэсэн маш тодорхой гурав дахь асуулт байна.

Дөрөв дэх асуулт байгаа юм. Хэрвээ Их Хурлын даргыг бид улс төрийн намаас нь түдгэлзүүлэх юм бол үндсэндээ энэ хүний улс төрийн дараагийн замнал үндсэндээ зогсоно гэсэн үг, хязгаарлагдана гэсэн үг.

Тэгэхээр энэ нөхцөлд Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад ямар зохицуулалт байдаг вэ гэхээр зэрэг дараагийн сонгуульд тэр хүн ороход нь хэрвээ тойрогт нэр дэвших юм бол ямар ч өрсөлдөгчгүйгээр тэр нь тогтсон улс төрийн соёл л доо. Хууль байхгүй.

Тэгээд тэр спикерийг дахин сонгогдох боломжийг нь олгодог практик байгаа юм. Тогтсон улс төрийн сайн практик, сайн туршлага гэж үздэг юм байна. Үүнийг өнгөрсөн Байнгын хорооны хурал дээр Та бид хэлэлцэж байсан. Энэ талаар Та бүхэн ахиж судал ажиллаж үзсэн үү гэсэн ийм асуулт байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуултад хариулъя.

Х.Тэмүүжин: Үнэхээр хатуу зохицуулалттай гэж.

Төв ч байр суурийг улс төрийн намаас бие даасан байх байр суурийг хадгалахын тулд намаас нь түдгэлзүүлдэг, зохицуулдаг дэлхийд 2 улсад л байна л даа.

- ▶ Англи байна.
- ▶ Япон байна.

Хоёулаа парламентыг эзэн хааны дарамт, нөлөөллөөс ангид байлгахын тулд нэлээн хатуу тэмцэл, түүх өрнүүлж, хэд хэдэн спикерийнхээ бараг амь насаар зольж байж олж авсан эрх чөлөө нь байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ 2 улсын түүхийг парламентын спикер, парламентын дархлаа гэдэг дэлхий нийтийн том ололтыг байгуулсан гэж үздэг юм билээ.

Аядуу зохицуулалттай улс орнууд маш их байгаа. Парламентын засаглал бүхий улс орнууд дотор бараг 40-өөд байна. Аядуу зохицуулалттай.

- Намаас нь түдгэлзүүлэхгүй.
- Намын гишүүнчлэл нь хэлбэрийн төдий үлддэг.

Гэхдээ нарийвчилсан тодорхой зохицуулалтыг хийж өгөөд нөгөө “төв ч байх”, “намаас ангид байх” гэдэг шаардлагаа хангаж явдаг улс орнууд Европ тэр чигээрээ байна.

- ▶ Австрали байна.
- ▶ Шинэ Зеланд байна. Гэх мэтчилэн.

Таны болгоомжилж асууж байгаа намын лидер парламентыг удирдахгүй болохоор парламентаас тухайн сонгуулиар ялсан намын бодлого хурдтайгаар шийдвэр болж гарахгүй тийм сул тал байдаг шүү дээ гэж.

Үүнийг сул тал гэж үзэхгүй байна. Улс орнууд. Парламентад тэртээ тэргүй л олонх байгаа нам бол олонхоороо шийдвэрээ гаргана гэдэг бол парламентын зарчим. Харин энэ шийдвэр гаргахаас өмнө цөөнхийнхөө байр суурь, үгийг сонсох гэдэг бол парламентын хэлэлцүүлгийн өөрийнх нь суурь зарчим. Энд хэлэлцүүлэгт зарж байгаа цагийг хурдан шуурхай гаргахгүй цаг авч байна гэж үзэх гэвэл энэ өөрөө парламентын ардчиллыг доголдуулах, хязгаарлах нэг үндэслэл болно гэдэг тийм тайлбарыг дийлэнх нь хийсэн билээ.

Тэгэхээр парламент угаасаа шийдвэр гаргахдаа тодорхой хэлэлцүүлгийн цагтай байна. Тэр цагаа дуусгаж шийдвэр гаргана гэдэг нь илүү хэрсүү, бодитой, алдаа мадаг багатай шийдвэр гарахад тусалж байгаа болохоос биш бодлого хурдан хэрэгжүүлэхэд садаа болж байна гэж үзэхгүй байна.

Монголчууд ч гэсэн хэлдэг шүү дээ. “Бушуу туйлаа борвиндоо баастай” гэдэг шиг.

Сая өнгөрсөн 2 жилийн хугацаанд парламент. Би түрүүн Байнгын хороон дээр хэлсэн. Нэн яаралтай горимоор маш олон асуудлыг хэлэлцсэнээс болоод одоо ард нь ер нь юу гаргачхав гэдгээ эргэж ухахад хүртэл хүрч байгаа байх байхгүй юу.

Тэгэхээр ийм алдаа завхралаас сэргийлэхийн тулд л олон намын төлөөлөл бүхий парламент байгаа. Ард түмний цөөнхийн ч гэсэн дуу хоолой тодорхой хэмжээнд сонсогдож байх ёстой гэдэг ардчиллын зарчим байгаа.

Тэгээд сүүлийн 4 дэх асуулт бол үнэхээр нөгөө хатуу зохицуулалтыг яагаад улс орнууд сонгоогүй вэ гэхээр нөгөө парламентын спикер гэдэг хүний чинь дараагийн улс төрөөрөө бүдгэрдэг учраас тойрог дээр нь буюу дараагийн сонгууль дээр нь баталгаа гаргаж өгөх гэдэг асуудал дээр энэ чинь өөрөө ардчиллыг жүжиг шиг дефект үүсгэнэ.

Тийм учраас ер нь намаас нь түдгэлзүүлэхээс илүүтэйгээр нарийвчилсан зохицуулалтаараа төв ч байр суурь, намын улс төрөөс ангид байх гэдэг хоёр зарчмаа хэрэгжихүйц нарийвчлалтай зохицуулалт хийгээд, тэгээд сонгууль болохоор намынхаа үйл ажиллагаан дотор ороод явдаг тийм тодорхой зохицуулалттай байсан нь зөв байна гэж ихэнх улс орнууд энэ сонголтыг хийсэн юм билээ.

Манайх шиг пропорциональ сонгуулийн элемент бий байгаа улс оронд энэ бүр хялбархан болох байх. Ер нь бол.

Тэгээд бид нэг зүйлийг бас их тодорхой болгох ёстой. Парламентын спикер нь спикер шиг буюу төвч байж чадсан бол аль ч нам нь бас нэг тийм парламентын спикертээ хүндэтгэлтэй ханддаг соёл руу орох ёстой. Дараагийн аль ч сонгуулийн утгаар.

Жагсаалтдаа бичихэд аль нэг байдлаар гоочлохоос илүүтэйгээр үнэхээр төвч байсан бол цөөхөн ч гэсэн хүндэтгээд амаа тодорхой хэмжээнд жимийгээд өнгөрдөг тийм... /минут дуусав/

С.Бямбацогт: Сархадын Зулпхар гишүүн тодруулъя.

С.Зулпхар: Яг одоо иймэрхүү л тодорхой хариултууд аваад бид хэлэлцээд явбал парламентын мэргэшсэн түвшинд асуудлаа хэлж байгаа л хэлбэр л болж байгаа.

Аль ч хуулийн хүрээнд яг тийм л байна. Сая яг үүний өмнө хэлэлцэгдсэн хууль ч гэсэн ингэж хэлэлцэгдлээ шүү дээ. Санхүүгийн салбарын асуудлыг хэлэлцэхэд.

Би нэг зүйлийг дахиж тодруулах гээд байгаа юм. Английн практик бол өөр практик. Тэр Магна Картаг (Magna Carta, 1215 он) баталсны дараа Англид хааны эрхийг хязгаарласан. Түүний дараа парламент бий болсон.

Тэгээд парламент, хаан хоёрын хоорондын харилцааг илүү холбож өгөх үүднээс хаан бас дур зоргын шийдвэр гаргаад байсан юм л даа. Энэ үүднээс парламентын спикерийг улс төрийн намаас түдгэлзүүлээд, тэгээд энэ харилцааг хийх боломжийг олгож байсан юм.

1707 онд Шотландыг нэгтгэсний дараа бас дараагийн улс төрийн намын практик орж ирээд энэ практик аваад явсан.

Тэгэхээр энэ практикаар авч явсан л ганц жишиг байгаа учраас хатууг бид авч болохооргүй юм байна гэдгийг бид бараг ойлгох шиг боллоо шүү дээ. Харин... /минут дуусав/

С.Бямбацогт: Болсон. Хариулт байгаа юу? Үгүй юу? Х.Тэмүүжин гишүүн хариулъя.

Х.Тэмүүжин: Тийм тийм. Яах аргагүй бидний хувьд хаант засаглалын эрх мэдэл, цэрэг арми, цагдаа гээд бүх юм нь тэр гартаа төвлөрсөн. Тэгээд түүгээрээ парламентыг өөрийг нь ер нь айлган сүрдүүлээд өөрийнхөө эрхшээлд байлгах гэж оролдсон нэг сөрөн зогссон л ард түмний бослого шүү дээ. Парламентын энэ бие даасан дархлаатай байх гэдэг.

Тэгээд манайд арай тийм түвшинд байхгүй байна.

Тийм учраас хатуу зохицуулалтыг сонгох бидний хувьд жоохон эргэлзэх ёстой хандлага байхыг үгүйсгэхгүй. Хууль санаачлагчид ч гэсэн бид туйлын утгаараа энэ хатуу зохицуулалтыг бид санал болгохгүй байна. Аядуу зохицуулалтаар тодорхой нарийвчилсан зохицуулалтаа хийгээд явах юм бол зүгээр хэлбэрийн төдий намын гишүүнчлэлтэйгээ, тэгээд төвийг сахиад, намын улс төрөөс ангид байх спикертэй болох юм бол парламентын ардчилал, Монгол Улсын парламентын дархлаа сайжрах юм байна гэдэг дээр итгэл үнэмшилтэй байгаа юм.

С.Бямбацогт: Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Үндсэн хуулийн 24 дүгээр зүйл. Нэг. “Улсын Их Хурлын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж болно.” гээд.

Ж.Золжаргал гишүүн Та хоёр болон С.Бямбацогт гишүүн сая яг энэ заалтыг ярих шиг боллоо.

Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын дэгийн тухай хууль яг хэн нэр дэвшүүлж явах вэ, олонх дэвшүүлэх үү, үгүй юу гэдгийг сая маргаад. Ер нь Үндсэн хууль дээр олонх дэвшүүлсэн гэсэн үг биш гэх шиг боллоо. Би андуураагүй бол.

Тэгээд би андуураагүй бол энэ чинь тэгээд Үндсэн хуулийн бус аргаар одоог хүртэл Улсын Их Хурлын даргаа сонгоод байсан хэрэг үү?

Тэгэхээр хэдүүлээ бас энэ ойлголтуудаа нэг цэгцтэй ярихгүй бол өнөө цагт чинь ер нь юм л бол Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын дэгийн тухай хууль чинь Үндсэн хуульдаа нийцээгүй гэсэн ийм дүгнэлтүүд гар гээд байна шүү дээ. Нөхөд минь.

Би олонх бүрдээгүй буюу Улсын Их Хуралд 126 гишүүнтэй, олонх буюу 64 гишүүний суудлыг авсан нам, эвсэл байхгүй бол араас нь “бусад намтай эвсэл болон зөвшилцөн хамгийн олон суудал авсан эвсэл байж болно” гэдэг энэ агуулга чинь зөв гэж бодож явдаг шүү дээ.

Тэгээд Та бүхний өргөн барьсан хууль дээр “зөвхөн олонх л Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлнэ” гээд одоогийн байгаа зохицуулалт буюу 64 суудал авч чадаагүй тохиолдолд хэн нэр дэвшүүлэх вэ гэдэг энэ агуулга чинь хаагдсан байгаа учраас дараад нь юу болох вэ? Үүнийг та хэд бодож албаар зөвхөн 64 суудал авсан улс төрийн нам, эвсэл л нэр дэвшүүлэх эрхтэй, 64 суудал аваагүй бол өөр хэн нэгэн дэвшүүлэхгүй зөвхөн энэ заалнаасаа байх юм байна гэж мэдэж энэ заалтуудыг Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын дэгийн тухай хууль дээр авав уу, эсвэл зүгээр хараагүй, зүгээр л олгох гээд яаран өргөн барив уу гэдэг нэг ийм асуулт байна.

Хоёр дахь нь, ер нь парламентын засаглалыг бид бэхжүүлэх тал дээр бүгдээрээ л парламентын засаглалаа төгөлдөржүүлье гэж ярьдаг. Их хамгаалдаг хүмүүс.

Манай улсын хувьд яг парламентын засаглалтай юм уу гэхээр бас ч тийм биш. Хагас Ерөнхийлөгчийн засаглалтай, хагас парламентын засаглалтай гэдгийг олон улсын болон манай дотоодын судлаачид ярьдаг.

Тэгээд энэ нь юутай холбоотой юм бэ гэхээр Ерөнхийлөгчийн ард түмнээс сонгодог, Ерөнхийлөгч нь өөрөө мөрийн хөтөлбөртэй байдаг. Эргээд тэгсэн мөртлөөсөө улсын төсөв болоод сайд нар гэдэг юм уу, Ерөнхий сайдтайгаа, гүйцэтгэх засаглалтайгаа зөрчилдөөн үүсээд байдаг учраас төрийн байгууллагын хямрал яваад байна гэдгийг л уг нь судлаачид дүгнээд байгаа шүү дээ. Өнөө цагийн үйл явдлууд ч гэсэн үүнийг нотлон харуулаад байгаа.

Тэгэхээр яг энэ төрийн байгууллын юу гэдэг юм хүндрэлийг давахын тулд бид парламентын засаглалаа л төгөлдөржүүлэх ёстой юм гэдгийг л уг нь бид ярих ёстой. Гэтэл дотооддоо нэг л жоохон Улсын Их Хурал руугаа л өөрсдөө ингээд

чулуу шидээд байх юм гэдэгтээ жоохон сэтгэл гонсгор байна гэдгийг хэлмээр байна.

Улсын Их Хурлын даргаа сонгох тэр босгыг ч гэсэн Та хэд маань илүү юу болгосон байх юм. Олонх буюу 64 хүнээр сонгоно гэдгээр нь босгыг нь илүү чангалаад, чөлөөлөхийг нь болохоор хуралд оролцсон олонх буюу чөлөөлөх босгыг нь бууруулаад Ерөнхий сайдаасаа өөр болгосон байгаа байхгүй юу. Ерөнхий сайдыг бид хуралд оролцсоны олонхоор нь сонгоод, нийт гишүүдийнхээ олонхоор нь чөлөөлдөг шүү дээ.

Тэгээд өөрсдөө парламентын засаглалаа бэхжүүлэе гэж байгаа мөртлөөсөө Улсын Их Хурлын даргынхаа дархлааг нь улам сулруулсан ийм хууль орж ирээд байгааг ямар учиртай вэ? Үүнийг мэдэж ийм юм оруулав уу, мэдсэнгүй оруулав уу гэдгийг.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Х.Тэмүүжин гишүүн хариулъя.

Х.Тэмүүжин: Тэр чөлөөлөхтэй холбоотой Улсын Их Хурлын чуулганд оролцсон гишүүдийн олонх гэдэг үг одоо хүчин төгөлдөр байгаа хууль дээр байгаа.

Энэ Улсын Их Хурлын тухай хуулийг 2024 оны сонгуулийн дөнгөж өмнөхөн нэг сарын өмнө батлахдаа маш олон зүйлийг бодож төлөвлөж харалгүйгээр сэтгэл хөдлөлөөрөө баталсан юм шиг байна лээ.

Тийм учраас тэр хэсгийг өөрчлөх бидний эрх хэмжээний хүрээнд байгаа, байгаа.

Нэг сонин түүх. 1992 оны Үндсэн хуульд заасан энэ заалт 1999 онд өөрчлөлт орсон юм. Гэхдээ эхний хэсэг дээр өөрчлөлт ороогүй. Улсын Их Хурлын дэд даргыг тухайн сонгуулиар олонх, цөөнх болсон бүлгээс байна гэдэг тэр өөрчлөлтийг оруулсан.

Яагаад 1999 онд тэр өөрчлөлт орсон бэ гэхээр 1992 оны Үндсэн хуулийн дараа Улсын Их Хурлын тухай хууль дээр энэ “олонх” гэж үг ерөөсөө байгаагүй юм. “Олонхын бүлэг” гэж.

Тухайн үед гишүүд чөлөөтэй нэр дэвшүүлдэг эрхтэй байсан юм. Үндсэн хууль өөрчлөгдөөгүй байгаа шүү.

1992 оны Үндсэн хуулийн дараа Улсын Их Хурал Улсын Их Хурлын даргаа сонгоход 2, 3 хүн нэр дэвшиж дундаас нь Улсын Их Хурал сонгодог байсан юм.

Гэтэл одоо “намын бүлэг Улсын Их Хуралд оруулна” гэж хэлээд зөвхөн нэг хүн оруулж ирж томилуулдаг болсон байхгүй юу.

Тэр нэг хүн оруулж ирж томилуулдаг үйл явц чинь Үндсэн хуультай зөрчилдөж байна гэж үзэж байгаа юм. Ер нь би хувьдаа.

- 1992 оны Үндсэн хуулийн дараа байгуулагдсан Улсын Их Хурал сонгож байсан байна.
- ▶ 2-оос дээш хүн нэрээ дэвшүүлж байсан байна.
- ▶ Намын бүлэг нэр дэвшүүлээгүй байсан байна.
- ▶ Гишүүд гарын үсгээрээ баталгаажуулаад “энэ хүнийг бид дэвшүүлж байна” гээд өөрсдөө дэвшүүлдэг байсан байна.

Гэхдээ харьцангуй олонхын тухай яриа байсан.

Өнөөдөр Ардын нам 30, 38-аараа хуваагдсан байгаа үед олонх чинь бодитойгоор, Улсын Их Хурал дээр олонх чинь 42 гишүүнтэй Ардчилсан нам байгаа байхгүй юу.

Засаг байгуулахад танайх албан ёсоор олонхын бүлэг мөн боловч Улсын Их Хурал дээр Улсын Их Хурлын даргын асуудлыг ярихад олонх биш байгаа байхгүй юу. Яг бодитойгоор.

Ийм нөхцөл байдал үүсдэг учраас, Улсын Их Хурал гэдэг бол 126 гишүүний асуудал учраас Улсын Их Хурлын даргын асуудлыг шийдвэрлэхдээ “гишүүд бүрэн эрхтэй шүү” гэдэг үгийг Үндсэн хууль дээр бичсэн байна. “Нам бүрэн эрхтэй” гэж ерөөсөө бичээгүй байна шүү.

Тэгээд үүнийг бид зөв ойлгох ёстой.

Улсын Их Хурал бол хэзээ ч гацдаггүй. Анхны чуулганыг Ерөнхийлөгч нээдэг. Улсын Их Хурлын даргаа сонгож чадахгүй бол хамгийн ахмад настай хүн нь удирдаад явдаг.

С.Бямбацогт: Аюушийн Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Одоо тэгээд Үндсэн хуульд нийцсэн байна уу, үгүй байна уу гэдгийг алдарт Г.Занданшатар даргын үгээр “Та бид хоёр шүүхгүй” гэдэг шиг магадгүй С.Бямбацогт гишүүнийг Улсын Их Хурлын даргаас сонгосон энэ процедур, процесс нь “Үндсэн хуульд нийцээгүй байна” гэж хэн нэгэн Үндсэн хуулийн цэцэд хандаж, тэд зөрчсөн байна уу, зөрчөөгүй байна уу гэдэг дүгнэлт гаргаж байж магадгүй энэ яриа эцэслэгдэх байх. Тэгэхээр энэ яриагаа түр орхъё.

Би Х.Тэмүүжин гишүүнд юу гэж хэлмээр байна вэ гэхээр би ер нь Х.Тэмүүжин гишүүнийг яг энэ Үндсэн хуулийн цэц, цэцийн өөрийнх нь тэр процессын хууль, тэгээд л ер нь энэ Үндсэн хууль байгуулал, энэ бүхэн дээр маш мэргэжлийн хүн гэж боддог учраас Та арай томоор харж, түрүүний миний хэлсэн

төрийн байгууллагын зөрчлийг арай том агуулгаар нь харж хууль тогтоомжоо өргөн баривал илүү сайн байна гэж хэлмээр байна.

С.Бямбацогт: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Надад нэг л асуулт байгаа юм. Сая хэлэлцсэн хуультай адилхан, хуулийн процесстой адилхан нэг зүйл харагдаад байна.

Ерөнхийлөгч улс төрийн намаасаа татгалзах ёстой, түдгэлзэх ёстой. Гэтэл Ерөнхийлөгчийн алба тэр чигээрээ улс төрийн намын харьяалалтай байна.

1992 оны Үндсэн хууль, Үндсэн хуулийг хэлэлцэх үеийн тэмдэглэл гээд олон зүйлийг үзлээ. Ерөнхийлөгчийг яагаад заавал намаас нь түдгэлзүүлэх болов, ямар учир шалтгаан цаана нь байв гээд харахаар хамгийн гол нь “үндэсний эв нэгдлийг сахигч” гэдэг маш том чиг үүрэг Үндсэн хуулиараа хүлээсэн байгаа юм.

Тэгэхээр парламент дээр аливаа ард түмний хооронд, үндэсний олонх, цөөнхийн хооронд гэх мэтээр маш олон олон зөрчлүүд үүсэж болзошгүй үед эв нэгдлийг сахин хамгаалах том чиг үүргийг Ерөнхийлөгчийн институци, Ерөнхийлөгч өөрөө хүлээдэг.

Тийм учраас Ерөнхийлөгчийг намаас нь түдгэлзүүлэх ийм заалт Үндсэн хууль дээрээ оржээ. Зүгээр товчхон хэлбэл.

Энэ удаа бид парламентыг, Их Хурлын даргыг яг адилхан намаас түдгэлзэх ёстой гээд оруулж байна.

Сайнаар бодоод баталъя гэхэд бодит байдал дээр яг хэрэгжих үү? Яг түдгэлзэх үү? 30 гаруй жил бид Ерөнхийлөгчийг намаас нь түдгэлзүүлэх ийм заалттай. Бодит байдал дээрээ түдгэлзсэн гэж байгаа боловч бодит байдал дээрээ түдгэлзээгүйг энэ олон Ерөнхийлөгч, үе үеийн Ерөнхийлөгч нар бүгд үйлдлээрээ харуулсан. Тэгээд бүгдээрээ л үүнийг мэдэж байгаа. Тийм ээ.

- Тэгэхээр энэ асуудлыг яах вэ?
- Улс төрийн шинжтэй үйлдэл хийвэл яах вэ?
- Үүнийг яаж ялгаж салгах вэ?

Яг бодит байдал дээр, амьдрал дээр хэрэгжих хууль мөн үү, үгүй юу гэдэг дээр эргэлзээд байна гэсэн үг. Тэгэхээр энэ асуултыг асууя.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн хариулъя.

Х.Тэмүүжин: Чухал асуулт. Түрүүн О.Номинчимэг гишүүн болон А.Ариунзаяа гишүүний арай том дүр зургаар харвал гэдэг.

Өглөө Ерөнхийлөгчийн санаачилсан хууль орж ирсэн. 66 дугаар зүйлийн 2.3, 2.4-ийг амилуулах хэрэгцээ байна гэж. Би Ерөнхийлөгчтэй санал нэг байгаа.

Энэ 66 дугаар зүйлийн 2.3, 2.4 дүгээр хэсгийг амилуулах ёстой.

2.4 дээр ийм үг байгаа. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнээр эгүүлэн татах үндэслэл байгаа эсэхээр Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргана.

Сая Улсын Их Хурлын гишүүнийг л оруулж ирсэн. Ерөнхийлөгчийг эгүүлэн татах үндэслэл нь юу юм бэ. Үндсэн хууль дээр маш тодорхой байна.

Намаасаа түдгэлзэх. Намаасаа түдгэлзсэн албан тушаалтан намчирхаад явж байгаа бол үүнийг Үндсэн хуулийн цэцэд хэн гомдол гаргах вэ?

Герман болон бусад улс орнуудад парламентын гишүүд гомдол гаргадаг юм билээ. Гэхдээ манай зохицуулсан шиг олонх биш, цөөнх гаргадаг юм билээ. Бид цэцэд хүсэлт гаргах эрхийг олонход өгсөн.

Яг энэ зүйл, заалтыг амилуулъя гэвэл Улсын Их Хурлын дарга бас.

- Улсын Их Хурлын дарга ямар тохиолдолд Үндсэн хууль зөрчсөн гэж огцрох ёстой вэ.

Улсын Их Хурлын даргыг Үндсэн хуулийн цэцэд олонх хэзээ ч өгөхгүй. Хэн өгдөг вэ гэвэл цөөнх өгдөг.

Энэ цөөнхийн эрхийг бид одоо нээх цаг болсон. Үндсэн хуулийн цэцэд Улсын Их Хурлын нэрийн өмнөөс хүсэлт гаргадаг цөөнхийн эрхийг.

Герман яг ингэж шийдвэрлэдэг. Улсын Их Хурлын дарга ямар нөхцөлд Үндсэн хууль зөрчих юм бэ гэвэл одоо яг өнөөдөр бид ярьж байна. Германд төвж байх зарчмаа эвдээд бүлгийн хуралд орсон нь баригдах юм бол шууд Үндсэн хуулийн шүүхэд өгдөг юм билээ.

Намчирхаад, сонин хэвлэлээр нэг намынхаа нэр дэвшигчийг магтан дуулах юм бол шууд Үндсэн хуулийн цэцэд дуудагддаг юм билээ. Тэгээд огцордог юм билээ. Тэгэхээр бид энэ зохицуулалтыг хийх ёстой.

- Ерөнхий сайд явал огцордог вэ.

Парламентын бүрэн эрхээрээ халдвал Ерөнхий сайд шууд огцрох, Үндсэн хуулийн цэцэд дуудагдах үндэслэл үүсдэг юм билээ.

Тухайлбал, Ерөнхий сайд парламентын тархин дээр гарч ирээд энэ сууж байгаа чинь Үндсэн хуулийн зөрчил байхгүй юу. Үүгээрээ үе үеийн Ерөнхий сайд огцрох байхгүй юу. Хэрвээ парламентын цөөнх цэцэд гомдол гаргаад, цэц нь Үндсэн хуулийн шүүх шиг шүүхтэй байсан бол парламентынхаа тархин дээр суудаг Ерөнхий сайд парламентаа хуралдуулахгүй гэж бойкот зарладаг Ерөнхий сайд байх боломжгүй байхгүй юу.

Үүнийг бид цогцоор нь шийдэх ёстой. Тэр шийдлийн нэг нь өнөөдөр энд явж байна. Шийдлийн нөгөөдхийг нь Ерөнхийлөгч өргөн барьсан байна 3 дахийг нь бид өргөн барих ёстой.

- ▶ Ямар нөхцөлд Ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн гэж тооцогдох юм бэ,
- ▶ Ямар нөхцөлд Ерөнхий сайд Үндсэн хууль зөрчигдсэн гэж тооцогдох юм бэ–

-гэдгийг Улсын Их Хурал өргөн бариад, хэлэлцээд үүнийг цогц... /минут дуусав/

С.Бямбацогт: Жуковын Алдаржавхлан гишүүн асуултаа асууя. Алга байна. /алх цохив/

Хууль санаачлагчаас гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж гишүүд үг хэлнэ. /алх цохив/

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн. Алга байна. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн. Алга байна. Ингээд үг хэлэх гишүүд байхгүй учраас гишүүд үг хэлж дууссанд тооцъё. /алх цохив/

Одоо Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг дэмжих эсэх талаар.

Яах юм? Аан? Санаа зовоод байна уу? Тийм ээ тийм. Санаа зоволтгүй. Маргааш болгоод хойшлуулъя.

Тэгээд маргаашийн үдээс өмнөх хуралдаанаар санал хураалтыг явуулъя.

Зөв ойлгоорой. Сая хэвлэл мэдээллээр буруу ойлголт явж байна. Өчигдөр Ардчилсан намын их хурал болсон. Ардчилсан намын их хурал болоод, түүнтэй холбоотойгоор манай Улсын Их Хурлын Тамгын газрын буруу төлөвлөлтөөс болж хуралдах ёстой 5 Байнгын хорооноос 4 Байнгын хороо хуралдаж чадаагүй.

Өнөөдөр Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооны хурал болж байгаа. Ардчилсан нам парламент дахь хамгийн олон суудалтай цөөнх, сөрөг хүчин. 42 суудалтай. Энэ гишүүд оролцож байгаа учраас өнөөдрийн хуралдаанд санал хураалт явуулахад ирц нэлээн цөөн байгаа. Х.Тэмүүжин гишүүний санаачилсан хуулиас авхуулаад унах эрсдэлтэй байгаа.

Тийм учраас санал хураалтын цагийг 4 дүгээр сарын 10-ны Баасан гарагийн үдээс өмнө болгож өнөөдрийн 4 асуудлын санал хураалтын цагийг хойшлуулсан байгаа шүү. Санал хураалтыг маргааш явуулахаар шийдвэрлэлээ. /алх цохив/

Та бүхэнд хойшлуулж байна гэдгийг дуулгая. Тэгээд үндэслэлийг нь буруу, зөрүү мэдээлэл хэвлэлээр нэлээн явж билээ.

Ингээд өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Баасан гарагийн 10.00 цагаас буюу маргааш 10.00 цагаас чуулганы нэгдсэн хуралдаан санал хураалтаар үргэлжилнэ.

Тийм болохоор гишүүдийг чуулганы хуралдаандаа идэвхтэй оролцохыг уриалж байна. /алх цохив/

Хуралдаан 5 цаг 45 минут үргэлжилж, 16 цаг 41 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД